



ASIA PACIFIC FORUM
ADVANCING HUMAN RIGHTS IN OUR REGION

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ




ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ГАРЫН АВЛАГА



ASIA PACIFIC FORUM
ADVANCING HUMAN RIGHTS IN OUR REGION

Хүний эрхийн боловсрол



Хүний эрхийн үндэсний байгууллагуудын гарын авлага

DDC 323
Х-828

ТЭМДЭГЛЭЛ

Энэхүү гарын авлагад тусгасан агуулга, илэрхийллээр дамжуулан Ази, Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулган нь аливаа улс орон, бүс нутаг болон хотын хууль эрх зүйн байдал, түүний хил хязгаар, үзэл баримтлал, бодлогын талаар өөрийн байр сууриа ямар нэг байдлаар илэрхийлээгүй болно.

ISBN 978-0-9873578-8-5 (хэвлэмэл)

ISBN 978-0-9873578-9-2 (цахим)

ISBN 978-99962-3-361-6 (монгол хэл дээрх хэвлэмэл)

Хүний эрхийн боловсрол: Хүний эрхийн үндэсний байгууллагуудын гарын авлага

© Ази–Номхон далайн бүс нутгийн Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Чуулган зохиогчийн эрхийг эзэмшинэ.
2013 оны 7 дугаар сар

АНДХЭҮБЧ нь энэхүү гарын авлагын хэсгээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авсан тохиолдолд дахин хэвлэхийг зөвшөөрөх бөгөөд уг хэсгийг агуулсан хэвлэлийг дараах хаягаар илгээнэ үү.

Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулган

Шуудангийн хайрцаг 5218

Сидней Эн Эс Дабьлю 1042

Австрали

Энэхүү номыг хэвлүүлэхэд санхүүгийн туслалцаа үзүүлсэн Швейцарийн Хөгжлийн Агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн хамт олонд талархал илэрхийлье.

Орчуулсан: Г.Агар–Эрдэнэ, Ч.Алтангэрэл, Б.Болорсайхан

Хянасан: Ц.Адъяахишиг, Ө.Ундрах, Г.Золзаяа

НҮБ–ын гэрэл зургууд нь НҮБ–ын өмч бөгөөд тэдгээрийг ашиглахтай холбоотой бүх эрхийг мөн агуулна.

Нүүрний гэрэл зургууд:

Зүүн хэсгийн зураг: Мьянмар Улсын цэцэрлэгийн хүүхэд, Кибас Парк, НҮБ–ын зураг

Дунд хэсгийн зураг: Энэтхэг Улс дахь насанд хүрэгчдийн сургалтын хөтөлбөр, НҮБ–ын зураг

Доод хэсгийн зураг: Афганистан, Кабул хотын ахлах сургуулийн сурагчид Бүх нийтийн чанартай, төлбөргүй боловсролын төлөөх Олон улсын кампанит ажлын долоо хоногийн сүүлийн өдрийн арга хэмжээг дэмжин оролцож байна. Фардин Ваези, НҮБ–ын зураг

АГУУЛГА

Өмнөх үг

Талархал

Товчилсон үгсийн жагсаалт

Хэрэглэгч танаа

Нэгдүгээр хэсэг	Хүний эрхийн боловсролын оршил	1
	Бүлэг 1: Хүний эрх: үндсэн ойлголт	2
	Бүлэг 2: Хүний эрхийн боловсрол: үндсэн ойлголт	9
	Бүлэг 3: Хүний эрхийн үндэсний байгууллагууд ба хүний эрхийн боловсрол	21
Хоёрдугаар хэсэг	Хүний эрхийн боловсролын онол, зарчим, хандлагууд	31
	Бүлэг 4: Хүний эрхийн боловсролын онол, зарчмууд	32
	Бүлэг 5: Хүний эрхийн боловсролын хандлага	39
Гуравдугаар хэсэг	Хүний эрхийн боловсрол – Практикт	49
	Бүлэг 6: Хүний эрхийн боловсролын төлөвлөлт ба загвар	50
	Бүлэг 7: Хүний эрхийн боловсролыг хэрэгжүүлэх нь	63
	Бүлэг 8: Хүний эрхийн боловсролыг үнэлэх нь	72
	Бүлэг 9: Хэвлэл мэдээлэлтэй ажиллах нь	79
	Бүлэг 10: Сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол	91
	Бүлэг 11: Зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдал дахь хүний эрхийн боловсрол	103
Дөрөвдүгээр хэсэг	Арга, аргачлалууд	111
	Арга № 1: Хүчний талбайг задлан шинжлэх	116
	Арга № 2: Хариу үйлдлийг үнэлэх шугам	118
	Арга № 3: Гудамжны судалгаа	119
	Арга № 4: Шүрэн хадаар задлан шинжлэх	120
	Арга № 5: Олон нийтийн зураглал хийх нь	122
	Арга № 6: Зурган дуу хоолой	123
	Арга № 7: Эрэмбэлэх	124
	Арга № 8: Зохион байгуулагч тойрог	125
	Арга № 9: Суралцахуйн давалгаа	126
	Арга № 10: Чиглүүлэх техник	128

Арга № 11: Оюуны зураглал	131
Арга № 12: “Мод” диаграмм	132
Арга № 13: Театр	133
Арга № 14: Дүрслэх урлаг	135
Арга № 15: Хүний эрхийн түгээмэл тунхаглалын тухай жишиг уулзалт	136
Арга № 16: Туршлага солилцох уулзалтын тойм:	138
Арга № 17: Туршлага солилцох уулзалтын тойм:	139
Арга № 18: Туршлага солилцох уулзалтын тойм:	141
Арга № 19: Туршлага солилцох уулзалтын тойм:	142
Арга № 20: Тэгш эрх: хөзрийн тоглоом	143
Арга № 21: Дэлхийн кафе	145
Арга № 22: Галт бөмбөг тоглоом	146
Арга № 23: Үйл ажиллагааны тэмдэглэлийн дэвтэр	147
Арга № 24: Үнэлгээний дартс	148
Арга № 25: Үнэлгээний дугуй	149
Дүгнэлт	151
Хэрэгцээт эх сурвалжууд	155
Нэр томъёоны тайлбар	160
Хавсралт	163
Хавсралт 1: Ази–Номхон далайн бүс нутгийн хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд холбогдох Логик загварууд	165
Хавсралт 2: Хүний эрхийн боловсролын тохирох аргыг сонгох нь	174
Хавсралт 3: Бичлэгийн зорилгууд	177
Хавсралт 4: Логик загварын хянах хуудас	178
Хавсралт 5: Үр дүнтэй чиглүүлэх чадварууд	180
Хавсралт 6: Суралцахуйн хэв маяг, туршлагын дөрвөн ангилал	182
Хавсралт 7: Сэтгэхүйн хэв маягийн дөрвөн төрөл	183
Хавсралт 8: Өөрийн болон үе тэнгийн үнэлгээ, Хөндлөнгийн үнэлгээ	184
Хавсралт 9: Хүний эрхийн боловсролын зарчмуудад нийцэж буй эсэхийг үнэлэхэд баримтлах асуултууд	185
Хавсралт 10: Эрхийг хүндэтгэгч сургуулийн талаарх НҮБ–ын Хүүхдийн сангийн үйл ажиллагааны хүрээ	186
Хавсралт 11: Боловсролын талаарх “4А” зарчим ба олон улсын хүний эрхийн баримт бичгүүд	189
Хавсралт 12: Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ–ын тунхаглал	190

ӨМНӨХ ҮГ

Хүмүүс эрхээ шаардах, зөрчигдсөн үед сэргээн эдлэхийн тулд юуны өмнө эрхээ ойлгож мэдэх шаардлагатай. Төр, түүний байгууллага, үүрэг хүлээгчид нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүний эрхийг зохих ёсоор хүндэтгэж, хангаж, хамгаалахын тулд сургалтад хамрагдах, мэргэжил дээшлүүлэх шаардлагатай болдог.

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн зөрчлөөс насан туршид урьдчилан сэргийлж чадна. Хүний эрхийг дээдлэх соёлыг бүтээх нь шударга, зүй ёсны нийгмийг байгуулах чухал хөрөнгө оруулалт юм.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд (ХЭҮБ) нь өөрийн улсдаа хүний эрхийн боловсролыг хөгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх бөгөөд энэ нь тэдний бүрэн эрхийн нэг хэсэг юм.

Парисын зарчимд хүний эрхийн үндэсний байгууллагууд нь “хүний эрхийг ерөнхий боловсролын сургууль, их сургууль, мэргэжлийн байгууллагуудад хэрэгжүүлэх судалгаа хийх, сургалт зохион байгуулахыг дэмжих” чиг үүрэг хүлээнэ гэж заасан байдаг.

Саяхан батлагдсан НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглалд хүний эрхийн үндэсний байгууллагууд нь “хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн болон төрийн бус оролцогчдыг татан оролцуулах зэргээр хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжихэд шийдвэрлэх, зарим тохиолдолд зохицуулах үүргийг гүйцэтгэнэ” хэмээн зааж өгсөн байдаг.

Ази–Номхон далайн бүс нутаг дахь хүний эрхийн үндэсний байгууллагууд өргөн хүрээний оролцогчдод хүний эрхийн боловсрол олгож ирсэн арвин баялаг туршлагатай билээ. Зарим байгууллагууд хүний эрхийн эрх зүйн чиглэлээр, зарим нь цэрэг, цагдаа зэрэг хууль сахиулах ажилтнуудад сургалт зохион байгуулдаг. Мөн үндэсний хэмжээний сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн хөтөлбөрийг нэгтгэх ажлыг хэрэгжүүлдэг. Мэдээж хүний эрхийн төлөө нөлөөллийн ажил зохион байгуулах, эрх нь зөрчигдсөн иргэдэд туслахын тулд иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх олон тооны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Шинэ технологи хөгжихийн хирээр, хүний эрхийн үндэсний байгууллагууд хүний эрхийн мэдлэг, чадвар, түүх болон цаашдын чиг хандлагыг дэвшилтэт арга замар түгээн дэлгэрүүлэх, бусад бүлгүүдэд хүргэх ажил үргэлжилсээр байна.

Энэхүү гарын авлага нь үр дүнтэй хүний эрхийн боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай зарчим, практикийг хамтдаа эрж хайх зорилготой билээ. Үүгээр дамжуулан хүний эрхийн үндэсний байгууллагуудад хүний эрхийн боловсролын хөтөлбөрөө төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай онол арга зүйг түгээх, мөн Ази–Номхон далайн бүс нутаг дахь хүний эрхийн талаарх сайн туршлагуудыг хуваалцахыг зорьж байна.

Миний бие энэхүү гарын авлага нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрхэм чухал ажил үйлсэд ихээхэн тус нэмэр болно хэмээн найдаж байна.



Кирен Фицпатрик,

Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын
чуулганы захирал,

Талархал

Энэхүү гарын авлагыг Шинэ Зеландын Хүний эрхийн комиссын Хүний эрх ба яс үндэс хариуцсан ахлах зөвлөх, доктор Жилиан Крисп боловсруулсан болно. Доктор Крисп боловсролын чиглэлээр мэргэшин зэрэг хамгаалсан бөгөөд Шинэ Зеланд болон олон улсын түвшинд сургагч багшаар ажиллаж байсан болно. Комисст ажиллах болсноор хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүд боловсруулж, хэрэгжүүлэх, Комиссын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, мөн үндэсний сурч боловсрох эрхийн хөтөлбөрийг удирдаж байсан болно. Тэрээр одоогоор тус Комиссын хүний эрхийн сургагч нарын ахлах зөвлөхөөр ажиллаж байна.

Уг гарын авлагын ерөнхий бүтэц, агуулгыг боловсруулах төслийг эхлүүлэхэд хүний эрхийн үндэсний байгууллагуудын мэргэжилтнүүдийн баг ажилласан болно. Гарын авлагыг боловсруулах явцад санал өгч, хувь нэмрээ оруулсан мэргэжилтнүүдийн багт Чулуунбаатарын Ариунаа (Монгол), Кристина Рикки (Австрали), Ика Танлайн (Индонези), Жайдееп Сингх Кочер (Энэтхэг), Марк Титус Цибрерос (Филиппин), Шрийрам Адхикари (Балба) болон Викторио Алериа (Филиппин) нар ажилласан болно. Мөн Австрали, Энэтхэгийн хүний эрхийн үндэсний байгууллагууд, Номхон далайн арлуудын бүс нутгийн хүний эрхийн нөөцийн багийн Сандра Бернклау нар, Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулганы Крис Сидоти, Жеймс Лиффе, Кирен Фицпатрик, Лиза Томпсон, Сурайна Паша нар уг гарын авлагыг боловсруулахад ихээхэн хувь нэмэр оруулсан болно.

Товчилсон үгсийн жагсаалт

АНДХЭҮБЧ	– Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган
ТББ	– Төрийн бус байгууллага
ХЭҮБ	– Хүний эрхийн үндэсний байгууллага
НҮБХЭДКГ	– НҮБ–ын Хүний эрхийн дээд комиссарын газар
НҮБХС	– НҮБ–ын Хүүхдийн сан

Хэрэглэгч танаа

Гарын авлагын зорилго

Хүний эрхийн боловсролын гарын авлагыг сургагч багш нар болон хүний эрхийн үндэсний байгууллагуудад хүний эрхийн боловсролын сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахад нөөц хэрэглэгдэхүүн болгон ашиглахад зориулсан болно. Тиймээс шинэ хийгээд туршлагатай багш нарт бүгдэд нь Хүний эрхийн боловсролын онолын болон практик чиглэлээр дэмжлэг үзүүлэхийг зорьсон болно. Уг Гарын авлага нь Хүний эрхийн боловсролын шууд даган мөрдөх загвар бус, мөн түүнийг хамгийн сайн зохион байгуулах арга замыг ч зааж буй хэрэг биш юм. Харин Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах олон арга замыг тодорхойлж, оролцогчид болон тэдгээрт гарах үр дүнг харгалзан тохиромжтой арга хэлбэрийг сонгохыг санал болгож байна.

Гарын авлагын тухай

Гарын авлага нь дөрвөн хэсэгтэй. Эхний хэсэгт хүний эрх, хүний эрхийн боловсрол болон энэ чиглэлээр хүний эрхийн үндэсний байгууллагуудын чиг үүрэг, эрх хэмжээг танилцуулна. Хоёр дахь хэсэгт хүний эрхийн боловсролын онол, арга зүйн үндэс, түүний философи, зарчмыг авч үзнэ. Мөн бусад хүний эрхийн боловсролын онолын хүрээ болон түүний практик хандлагуудыг авч үзнэ. Гурав дахь хэсэгт сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, загвар боловсруулах үйл явц ба арга зүй, түүнийг хэрэгжүүлэх, үр дүнг нь үнэлэх, хэмжих тухай асуудалд анхаарсан болно. Энэ хүрээнд бага боловсрол дахь бага насны хүүхэд, мөргөлдөөний үед болон мөргөлдөөний дараах бүс нутагт анхаарвал зохих асуудлыг тусгасан болно. Сүүлийн хэсэгт хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд хэрэглэж болох олон тооны арга, аргачлалуудыг нэгтгэн авч үзлээ. Гарын авлагын бүлэг бүрийн төгсгөлд тухайн бүлгийн гол дүгнэлтүүд, ашигласан эх сурвалжийг орууллаа. Тодорхой бүлгүүдэд шаардлагатай мэдээлэл, НҮБ-ын Хүний эрхийн боловсролын тухай тунхаглал зэргийг хавсралтаар тус тус орууллаа.



Нэгдүгээр хэсэг

Хүний эрхийн боловсролын оршил



Бүлэг 1: Хүний эрх: үндсэн ойлголт

Бүлэг 2: Хүний эрхийн боловсрол: үндсэн ойлголт

Бүлэг 3: Хүний эрхийн үндэсний байгууллагууд ба хүний эрхийн боловсрол

БҮЛЭГ 1:

ХҮНИЙ ЭРХ: ҮНДСЭН ОЙЛГОЛТ

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД

- Хүний эрх гэж юу вэ?
- Хүний эрх хаанаас эхэлдэг вэ?
- Хүний эрхийн талаар олон улсын ямар баримт бичгүүд байдаг вэ? Тэдгээрт ямар эрхийг агуулсан байдаг вэ?
- Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүрэг юу вэ?



Хүн төрөлхтөний ам бүлийн гишүүн хэн бүхэнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөнийг иш үндэс болгон¹...



1. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭН ШИНЖ²

Хүний эрх бол түгээмэл, хүнээс салшгүй, заяамал хэмээн бид ярилцдаг. Хүн төрөлхтөний нэг нь болж төрсний хувьд хүний эрх хүнд угаас заяасан юм. Мөн хүнээс түүнийг нь булаан авах, өөр бусдад өгөх боломжгүй тул салшгүй юм. Таны хэн гэдгээс үл хамааран бүх хүнд хамаарах тул түгээмэл юм.

Хүний эрх гэдэг бол бүх хүн төрөлхтөнд угаас заяасан суурь эрх, эрх чөлөө юм. Энэ нь хувь хүн бусадтай хэрхэн харилцах, нийгэмд амьдрах болон төртэй хэрхэн харилцах, төр хүнийг хэрхэн хамгаалахыг тодорхойлдог. Хүний эрх нь хүн бүр ямар нэгэн ялгаварлалгүйгээр эрхээ адил тэгш эдлэхийг ойлгоно. Мөн удирдуулж байгаа болон удирдаж буй талуудын хоорондын харилцааны зарчмыг тодорхойлдог.³ Хүний эрх нь хүний нийгмийн байр суурь болон амьдралын нөхцөлөөс үл хамааран хүн бүрийн эрхэм зэргийг хүлээн зөвшөөрч, хамгаалахыг зорьдог.⁴

Хүний эрх – түгээмэл, хүнээс салшгүй.

Хүний эрх нь хүн бүрийн эрхэм зэрэг, үнэ цэнийг хүндэтгэх байдалд тулгуурладаг. Тиймээс ч хүний эрх бүх хүнд хамааралтай. Аливаа хүн хууль зөрчиж, мөн хуульд заасан үндэслэлээр эрхээ хязгаарлуулахаас бусад тохиолдолд эрхийг нь салган авах ёсгүй.

¹ Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Оршил,

² ХЭДКГ, Хүний эрх гэж юу вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.ohchr.org/en/issues/Pages/WhatAreHumanRights.aspx

³ ШЗХЭК, Хүний эрх гэж юу вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.hrc.co.nz/human-rights-environment/what-are-human-rights

⁴ Шинэ Зеланд дахь Хүний эрх – Өнөөдөр, Нга Тика тангата О Тед Моту, ШЗХЭК: 2004 он, (2 дугаар бүлэг, Олон улсын хүний эрхийн тогтолцоо)



Хүний эрх – харилцан хамааралтай, хуваагдашгүй.

Хүний эрх нь хүн бүрд хамаатай бөгөөд хэн нэгэн бусдаасаа давуу байх боломжгүй. Зарим эрхийг илүү хүндэтгэх, бусдыг нь орхигдуулах боломжгүй юм. Аливаа эрхээ эдлэх нь бусад эрхээ хэрхэн эдэлж буйгаас шууд хамааралтай. Үүний хамт аль нэгэн эрхийг зөрчих нь мөн бусад эрхэд сөргөөр нөлөөлнө. Мөн аль нэг эрхийн хүртээмжийг нэмэгдүүлснээр бусад эрхэд эерэгээр нөлөөлнө.

Хүний эрх – тэгш бөгөөд ялгаварлан гадуурхахгүй байна.

Хүний эрх нь хүний аль нэгэн шинж чанарт үндэслэн ялгаварлан гадуурхахыг хориглодог. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим нь хүний бүх эрх, эрх чөлөөнд хамаатай. Уг зарчим нь хүн бүр эрхэм зэрэг, эрх чөлөөнийхөө хувьд адил тэгш төрсөн хэмээн үздэг тэгш эрхийн зарчимтай шууд уялдан холбогдоно.

Хүний эрх – эрх, үүргийн нэгдэл байна.

Хүний эрх нь хүн бүрд хамаатайн адил хүн бүрийн үүрэг хариуцлага байна. Хүн бусадтай харилцахдаа, нэг бүлэг нөгөө бүлэгтэй харилцахдаа эрх, үүргийн харилцаанд ордог. Ялангуяа олон улсын хүний эрхийн хуульд зааснаар, төр нь хүний эрхийг хангаж, хамгаалах үүрэг хариуцлагыг өөртөө хүлээдэг.

2. ХҮНИЙ ЭРХИЙН ТҮҮХ

Хүний эрх нь хүн төрөлхтөнтэй хамт үүсэн хөгжсөөр иржээ. Дэлхий дахины тэргүүлэх шашин, соёлууд болон гүн ухаантнууд хүний эрхийн тухай үзэл санааны олон хэлбэр, агуулгыг хүлээн зөвшөөрч, хэлэлцэж ирсэн байна. Энэ бүгдийн үндсэн дээр хүний эрхийн түүх бүрэлдэн тогтсон аж. Нийтлэг түгэн дэлгэрсэн хүний эрхийн зарим гэрээг авч үзье. Энд дурдан буй жишээнүүд бүрэн бүтэн жагсаалт бишээ. Үүний хамт тухайн хүний эрхийн сургагчийн ажиллаж буй орон нутаг, хамт олонд хамаарах өөр бусад жагсаалтууд байх болно..

ХҮНИЙ ЭРХИЙН ОН ДАРААЛАЛ. МЭӨ 1750 – МЭ 1919⁵

МЭӨ 1750–д он: Вавилон улсын Хаммураби хааны хууль: Тэрээр Вавилон улсын анхны хаан байсан бөгөөд хүн төрөлхтөний түүхэнд мэдэгдсэн хамгийн анхны бичмэл хуулийг боловсруулжээ. Үүнд буруутгагч тал нь яллаж буй хүнийхээ гэм бурууг нотлох хүртэл тухайн яллагдагч гэм буруугүй гэж үзнэ гэсэн санааг агуулсан байдаг.

МЭӨ 1200–100 он: Хуучин гэрээ: Үүнийг мөн Еврей Библи, Танак буюу Еврей нартай Бурханы хэлэлцсэн яриа хэмээн нэрлэдэг. Хуучин гэрээ нь Арван сургаалийн хамт хүний амь нас хийгээд өмчийн эрхийг хамгаалах (тухайлбал, амь насыг бүрэлгэхгүй байх үүрэг) нотлогдоогүй байхад гэм буруугүйд тооцох, сүмээс өршөөл үзүүлэх гэх мэт зарчмуудыг агуулсан байдаг.

МЭӨ 551–479 он: Күнзийн сургааль: Үүнд тулгуур зарчим болох “бусдаас хүсч буй зүйлээ бусдад хандуулан үйлд, бусдаас хүсэхгүй зүйлээ бусдад хандан бүү үйлд” гэсэн зарчмыг агуулсан байдаг.

МЭ 40–100 он: Шинэ гэрээ: Үүнд Есүс болон түүний шавь нарын амьдрал, номлол сургаалийг өгүүлсэн байдаг. Эдгээрт уучлан өршөөх сэтгэл, Бурхны өмнө хүн бүр тэгш байх, бодь сэтгэлтэй байх зэрэг үндсэн зарчмуудыг тодорхойлжээ.

МЭ 644–645 он: Коран судар: Муслим шашны ариун судар бөгөөд Бурхны үгсийг Зөнч Мухамедаар дамжуулан 23 жилийн турш олон түмэнд дамжуулан хэлүүлсэн гэдэг. Үүнд Библид байх олон түүх тухайлбал Нуахын хөлөг онгоц, Израйль, Египетийн шүтээнүүдийн тухай өгүүлдэг. Мөн хүний эрхэм зэрэг, эрх чөлөө, тэгш байдал болон хувийн нууцтай байх зэрэг зарчмуудыг тусгасан байдаг.

1215: Магна Харта: Английн хаан I Жон өөрийн улсын язгууртан, ноёдын шахалтаар гарын үсэг зурсан Эрх чөлөөний тухай хууль юм. Үүнд (habeas corpus) буюу зөвхөн хуулийн дагуу шийдвэрлэх, мөн хожим нь Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн Хуулийн гол зарчим болсон “төлөөлөлгүй бол татвар төлөхгүй” зэрэг үзэл санаа тусгагджээ.

1400–д он: Незахаулкоуотийн хууль: Тексококийн (одоогийн Мексик улс) олноо хүндлэгдсэн хаан өөрийн хаант улсдаа хуулийн засаглал, урлаг болон эрдэм ухааныг их дэмжиж байжээ. Тухайн цагт тэрээр санхүүгийн, дайны, хуулийн болон соёлын зөвлөлүүдийг байгуулж, эрх мэдэл хуваарилсан хууль батлан мөрдүүлжээ.

1648 он: Вестфалийн гэрээ: Тухайн цагт Протестант болон Католик шашинтнуудын хооронд өрнөсөн Гуч болон Найман жилийн дайн уг гэрээний дагуу төгсгөл болжээ. Энэ нь өөрсдийн харъяатын шашин шүтлэгийг хүлээн зөвшөөрснөөр үндэсний бүрэн эрхт байдлаа хадгалахыг эрх баригчдад сануулсан үйл явдал болов. Мөн уг гэрээгээр сүсэг бишрэлийн зарим эрх чөлөөг шашны цөөнх болох хүмүүст олгожээ.

1689 он: Английн эрхийн тухай тунхаг: Уг баримт бичгийг Жеймс II хаан ширээнээсээ бууснаар Парламент баталжээ. Үүнд парламентын зөвшөөрөлгүйгээр хуулийн үйлчлэлийг зогсоох, татвар ногдуулах мөн сонгуульд саад хийхийг хаант засаглалд хоригложээ. Мөн парламентын түвшинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан байна.

1776: Америкийн Нэгдсэн Улсын Тусгаар тогтнолын тунхаглал: Америкийн хувьсгал эхэлснээр батлагдаж, амьдрах эрх, эрх чөлөөтэй байх, аз жаргалынхаа төлөө эрмэлзэн тэмцэх эрхийг зарлан тунхаглажээ.



⁵ ШЗХЭК, Олон улсын хүний эрхийн тулгуур асуудлууд, 2008 он, Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.hrc.co.nz/hrc_new/hrc/cms/files/documents/10-Mar-2009_10-14-9_International_Milestones_Final.pdf.

1789: Хүний ба иргэний эрхийн тухай Францын тунхаглал: Франц улс хэмжээгүй эрхт хаант засгаас татгалзаж, ардчилсан засаглалтай болох шилжилтийн үндсийг бүрдүүлсэн. Мөн эрх чөлөөтэй, өмчтэй, аюулгүй байх эрх болон эрхээ аливаа дарамт шахалтаас хамгаалуулах жам ёсны эрхийг тодорхойлжээ. Хааны эрх хэмжээг хүн бүр хуулийн өмнө эрх тэгш хэмээх зарчмаар хязгаарлажээ.

1863: Чөлөөлөлтийн тунхаг: Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Авраам Линкольн боолчуудын эрх чөлөөтэй болсныг зарлан тунхаглажээ.

1893: Чөлөөлөлтийн тунхаг: Шинэ Зеланд эмэгтэйчүүдийн сонгох эрхийг хүлээн зөвшөөрсөн анхны улс болжээ.

1919: Үндэстнүүдийн холбооны гэрээ: Дэлхийн I дайн дуусмагц улс орнуудын хамтын ажиллагааг дэмжих, мөргөлдөөнөөс зайлсхийхийг уриалж батлагдсан. Лигийн гишүүн улсууд нь асуудлыг тайван замаар шийдвэрлэх арга замыг олох хүртэл дайн эхлүүлэхгүй байхыг уриалжээ. Уг гэрээнд АНУ нэгдээгүй, мөн Япон, Итали, Герман улс гэрээнээс гарснаар хүчин чадал ихэд суларжээ.



Нью-Йорк дахь НҮБ-ын үзэсгэлэн, 1943 оны 3 дугаар сар, Улс үндэснүүдийн төрийн сүлд болон тамгыг байрлуулсан байна. Фото зургийг Маржори Коллинс,

3. ОЛОН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТОГТОЛЦОО

Хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хуульчлах алхмууд хийгдсээр байлаа. Дэлхийн 2-р дайны үед тохиолдсон зүйлс нь олон улсын хамтын нийгэмлэгийг хүний эрхийг хамгаалах олон улсын нийтлэг хэм хэмжээ боловсруулахыг уриалсан гол алхам болов.

1945 онд НҮБ-ын дүрмийг баталсан бөгөөд үүнд энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, мөн нийгэм, эдийн засгийн, соёлын болон хүмүүнлэгийн асуудлыг шийдвэрлэхэд хамтран ажиллахыг үүрэг болгожээ. Ердөө гурван жилийн дараа, 1948 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг⁶ баталжээ. Тунхаглалыг батлахад 48 гишүүн улс оролцож санал өгсний⁷ олонх нь Өрнийн бус соёлтой улсууд байсан бөгөөд

⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.un.org/en/documents/udhr/index.shtml.

⁷ Дараах орнууд Тунхаглалыг батлахад санал өгжээ. Афганистан, Аргентин, Австрали, Бельги, Боливи, Бразил, Бирм, Канад, Чили, Хятад, Колумб, Коста Рика, Куба, Дани, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Эквадор, Египет, Эл Сальвадор, Этиоп, Франц, Грек, Гватемал, Гаити, Исланд, Энэтхэг, Иран, Ирак, Ливан, Либери, Люксембург, Мексик, Голланд, Шинэ Зеланд, Никарагуа, Норвеги, Пакистан, Панам, Парагвай, Перу, Филиппин, Тайланд, Швед, Сири, Турк, Их Британи, АНУ, Уругвай болон Венесуэл

найм нь санал өгөхөөс түдгэлзсэн байна. Түүнээс өөр ямар нэгэн саад бэрхшээл гараагүй байна.

Тунхаглалыг дагалдан хүний эрхийн хоёр суурь гэрээг 1966 онд НҮБ-аас баталжээ. Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт⁸-д амьд явах, эрх чөлөөтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, хуулийн өмнө эрх тэгш байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг эрхийг баталгаажуулсан байна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт⁹-д нийгэм, соёлын амьдралд оролцох эрх, сурч боловсрох, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, хэл соёлоо хамгаалах, амьжиргааны зохистой түвшинд амьдрах зэрэг эрхийг баталгаажуулсан байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактуудад баталгаажуулсан хүний эрхийн зарчим, хэм хэмжээг цаашид тодорхой бүлгийн асуудлаар дагнан гарсан гэрээ, конвенцуудад нарийвчлан тодорхойлсон билээ.

Дүрвэгсдийн статусын талаарх конвенц 1951¹⁰:

Конвенцоор дүрвэгч гэж хэн болох, дүрвэгч ямар эрхтэй болохыг тодорхойлсон. Тухайлбал шилжин суурьших, шашин шүтэх, сурч боловсрох, хөдөлмөрлөх, аяллын баримт бичигтэй байх зэрэг эрхтэй бөгөөд хүлээн авагч орны төрийн зүгээс хүлээх үүргийг тодорхойлжээ.

Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц 1965¹¹:

Конвенцоор төрд арьс үндсээр алагчлахтай тэмцэх, мөн бүх хэлбэрээр арьс үндсээр алагчлах үзлийг устгахыг төр, засгийн газруудад уриалсан байдаг. Мөн ялгаа бүхий арьс, үндэстний бүлгүүд харилцан ойлголцол, хүндэтгэлийг нэмэгдүүлэхийн тулд боловсролыг чухалчлан үздэг.

Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц 1979¹²:

Эмэгтэйчүүдийн улс төр, нийгмийн амьдралд оролцох эрхийг хүлээн зөвшөөрөхийн хамт эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрхийг баталгаажуулсан хүний эрхийн цорын ганц баримт бичиг юм. Мөн соёл, уламжлал нь нийгэм дэх жендэрийн үүрэг болон гэр бүлийн харилцааг тодорхойлох гол хүчин зүйл болохыг тодорхойлжээ.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц 1984¹³:

Төр нь өөрийн хууль тогтоомжийн хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Конвенц шаарддаг. Мөн аливаа хүн эрүү шүүлтэд өртөх магадлал байгаа тохиолдолд тухайн хүнийг аль нэг оронд дамжуулан өгөхийг хориглодог.

Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989¹⁴:

1959 оны Хүүхдийн эрхийн тухай тунхаглалын заалтуудыг хэрэгжүүлэх хуулийн чиг үүргийг уг конвенцоор хүлээлгэсэн байдаг. Үүнд хоол хүнстэй байх, цэвэр усаар хангагдах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртэх, үнэ төлбөргүй суралцах, хөгжих, оролцох, өөрийн соёл, хэл, уламжлалтай байх зэрэг заалтуудыг хэрэгжүүлдэг. Мөн хүүхдийг цэрэгт элсүүлэх болон бага хөлсөөр ажиллуулахыг хориглодог билээ.

улсууд болно.

⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CCPR.aspx

⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CESCR.aspx

¹⁰ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/StatusOfRefugees.aspx

¹¹ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CERD.aspx

¹² Дэлгэрэнгүй мэдээллийг: www.un.org/womenwatch/daw/cedaw

¹³ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CAT.aspx

¹⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CRC.aspx

Цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц 1990¹⁵:

Конвенцоор цагаач ажилчид нь уугуул үндэстний нэгэн адил ажлын байртай байх, адил тэгш хандуулах эрхийг баталгаажуулахыг зорьдог. Үүний хамт бүх цагаач ажилчид нь наад захын хамгаалалтын жишиг хэм хэмжээнд хамгаалагдах ёстой гэсэн байр суурийг илэрхийлдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц 2006¹⁶:

Конвенцоор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хандив тусламж, эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын үйлчилгээний “объект” бус эрх бүхий нийгмийн идэвхитэй гишүүн “субъект” хэмээн үзэх сэтгэлгээний өөрчлөлтийг авчирсан. Үүнд тэд бол эрхээ шаардаж, өөрсдийнхөө амьдралын төлөө шийдвэр гаргах чадвартай гэдгийг онцолсон байдаг.

Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхаглал 2007¹⁷:

Колоничлолын явцад газар нутаг, бусад эд баялаг, нөөцөөсөө салан түүхийн шударга бус явдалтай тулгарч буй уугуул ард түмнийг уг Тунхаглалаар тодорхойлжээ. Өөрсдийн түүхэн соёл, уламжлал, бүтцээ хадгалан үлдэх, хөгжүүлэх, өөрсдийн хэрэгцээ, хүсэл тэмүүлэл авч үлдэх уугуул хүмүүсийн эрхийг тодорхойлсон байдаг.



Уугуул хүмүүсийн талаарх НҮБ-ын Чуулганы 11 дэх хуралдааны нээлтэд Австралийн уугуул үндэстний төлөөлөл оролцож байгаа нь. НҮБ-ын фото зургийг Девра Беркович

3.1 Олон улсын хүний эрхийн тогтолцоо – Практикт

Аливаа гэрээ нь тодорхой дүрмийн хүрээнд улс орнуудын харилцан тохиролцсон баримт бичиг юм. Олон улсын гэрээ нь конвенц, пакт, дүрэм, протокол, гэрээ зэрэг ялгаатай нэр бүхий олон төрөл байдаг. Гэрээ нь түүнд нэгдэн орсон улс орнуудад гэрээнд заасан зүйлийг зөвшөөрснөөр үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэлбэртэй болдог буюу өөрөөр хэлбэл тухайн улс орнууд хүлээн зөвшөөрснөөр “гэрээний тал” болдог.¹⁸

¹⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CMW.aspx.

¹⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/HRBodies/CRPD/Pages/ConventionRightsPersonsWithDisabilities.aspx.

¹⁷ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/Issues/IPeoples/Pages/Declaration.aspx.

¹⁸ “Хүний эрхийг бүх нийтэд”, НҮБ, Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу: www.un.org/en/globalissues/briefing-papers/humanrights/index.shtml.

Аль нэгэн улс тухайн гэрээний тал биш боловч, эрүү шүүлтийг хориглох гэх мэт асуудлаар олон улсын заншлын эрх зүй, олон улсын хүний эрхийн эрх зүйн дагуу тодорхой гэрээний заалтыг дагаж мөрдөх болдог. Хэрвээ тухайн улс аль нэгэн гэрээнд нэгдэн орсон бол тухайн гэрээний заалтуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс улс орнуудын тайлан, Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг зэргээр гэрээний хэрэгжилтийг хянадаг байна.¹⁹

Олон улсын хүний эрх ба олон улсын хүний эрхийн тогтолцоо: ХЭҮБ–уудад зориулсан гарын авлага нь олон улсын хүний эрхийг хамгаалах тогтолцооны тухай ойлголт авахад чухал эх сурвалж болно.²⁰

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хүний эрх нь бүх хүн төрөлхтөнд угаас заяасан эрх, эрх чөлөө юм. Энэ нь хувь хүн бусадтай хэрхэн харилцах, нийгэмд амьдрах болон төртэй хэрхэн харилцах, нөгөө талаас төр хүнийг хамгаалах ямар үүрэг хариуцлага хүлээж буйг тодорхойлдог.
- Хэдийгээр хүний эрх нь хүн төрөлхтөн үүссэнээр түүнтэй хамт байсаар ирсэн боловч хүний эрхийг хамгаалах нийтлэг хэм хэмжээ, үйл ажиллагааг бүрдүүлэх үйл явц 1900–аад оны дунд үеэс эхэлсэн гэж үздэг. Дэлхийн нийтлэг шашин, соёл, гүн ухааны сургаалд хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх үзэл санаа тусгагдаж иржээ.
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал 1948 онд батлагдсан нь олон улсын анхдагч тулгуур баримт бичиг юм. Тунхаглалыг дагалдан иргэний ба улс төрийн эрхийн тухай, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын суурь пактууд батлагджээ. Мөн тодорхой бүлгийн эрхийг хамгаалсан бусад олон улсын гэрээнүүд батлагдан үйлчилж байна.
- Төрийн зүгээс иргэдийн эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг хариуцлага хүлээдэг.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Олон улсын хүний эрх ба олон улсын хүний эрхийн тогтолцоо:

ХЭҮБ–уудад зориулсан гарын авлага; АНДХЭҮБЧ; 2012 он

Олон улсын хүний эрхийн тулгуур асуудлууд; Шинэ Зеландын Хүний эрхийн комисс; 2008 он; Дэлгэрэнгүй мэдээллийг: www.hrc.co.nz/hrc_new/hrc/cms/files/documents/10-Mar-2009_10-14-19_International_Milestones_Final.pdf

“Хүний эрх гэж юу вэ?”; ХЭДКГ; Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/en/issues/Pages/WhatAreHumanRights.aspx



¹⁹ Хүний эрхийн ээлжит дүгнэлт хэлэлцүүлгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.ohchr.org/en/hrbodies/upr/pages/uprmain.aspx.

²⁰ Уг гарын авлагыг АНДХЭҮБЧ 2012 онд хэвлүүлсэн болно. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.asiapacificforum.net/support/resources.

БҮЛЭГ 2:

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ: ҮНДСЭН ОЙЛГОЛТ

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД

- Хүний эрхийн боловсрол гэж юу вэ?
- Олон улсын хүний эрхийн тогтолцоонд хүний эрхийн боловсролыг хэрхэн авч үздэг вэ?
- Хүний эрхийн боловсрол нь ямар зорилготой вэ?
- Хүний эрхийн боловсрол хэнд чиглэдэг вэ?



Хүний эрхийн түгээмэл тунхаглал, холбогдох бодлогын баримт бичиг, гэрээнд зааснаар хүний эрхийн боловсрол нь дараах зарчмууд дээр тулгуурладаг.

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн, олон улсын, бүс нутгийн, үндэсний түвшний хүний эрхийн түгээмэл хэм хэмжээ, зарчмуудыг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх болон мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;
- Чөлөөт, ардчилсан, олон ургальч, тэгш хамруулсан нийгмийн үүрэг хариуцлага бүхий хувь хүний хөгжлийг дэмжих, бусдыг эрхийг хүндэтгэхийн хамт өөрийн эрх, үүргээ ухамсарлан ойлгодог хүний эрхийн түгээмэл соёлыг бүрдүүлэх;
- Тэгш байдал, хүлцэн тэвчил, ялгаварлан гадуурхахгүй байхыг эрхэмлэн, хүний бүхий л эрхийг бодитой хэрэгжүүлэхэд эрмэлзэх;
- Аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр хүн бүр өөрийн эрх, эрх чөлөөний стухай суралцаж, боловсрох тэгш боломжийг бүрдүүлэх;
- Арьсны үзэл, хэвшмэл ойлголт, дорд үзэх, сөрөг хандлага зэрэг бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхах, алагчлах байдалтай тэмцэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.²¹



1. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

1.1 Хүний эрхийн боловсрол ба хүний эрхийн олон улсын тогтолцоо

Төр, засгийн газрууд нь хүний эрхийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээдэг болохыг олон улсын хүний эрхийн гэрээнүүдэд өргөнөөр тусгаж, эрх хэмжээг нь тодорхойлж өгсөн байдаг. Хүний эрхийн боловсрол нь уг үүрэг хариуцлагыг хангах үндсэн хэрэгсэл юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын оршилд "...хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүхэн эл Тунхаглалыг байнга бодолцон, суралцаж боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахихад дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстой..." хэмээн заасан байдаг. Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26 дугаар зүйлд "... Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой" хэмээн тодорхойлсон байдаг.

²¹ НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын 4 дүгээр зүйл

Хүний эрхийн боловсролын тухай асуудал хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд, тухайлбал:

- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц 1965 (7 зүйл),²²
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт 1966 (13 зүйл),²³
- Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц 1979 (10 зүйл),²⁴
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц 1984 (10 зүйл),²⁵
- Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989 (29 зүйл),²⁶
- Цагаач ажилчид ба тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай конвенц 1990 (33 зүйл),²⁷
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц 2006 (4 ба 8 дугаар зүйл)²⁸
- Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын Тунхаглал 2007 (14 ба 15 дугаар зүйлүүд)²⁹ зэрэгт тусгалаа олсон байдаг.

Хүчин чармайлтын үр дүнд хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих асуудал Венийн Тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөрийн³⁰ нэг хэсэг болсон бөгөөд улмаар Нэгдсэн үндэстний байгууллагын олон санаачлагууд³¹,³² тухайлбал, НҮБ-ын Хүний эрхийн боловсролын 10 жил (1995–2004) зэргийн гол цөм болсон билээ.

2004 оны 12 дугаар сарын 10–ны өдөр НҮБ-ын Хүний ХҮАХ ххромир Ерөнхий Ассамблей Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг санаачилсан билээ. Уг хөтөлбөр нь хүний эрхийн боловсролын суурь зарчим, арга зүйн талаар нийтлэг ойлголтод хүрэх, үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр, чиглэлийг тодорхойлох зорилготой байв. Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн нэгдүгээр шат (2005–2009) нь бага болон дунд боловсролын тогтолцоонд, хоёрдугаар шат (2010–2014) нь дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол буюу багш, сургагч, төрийн албан хаагч, хууль сахиулах болон цэргийн албан хаагчид руу чиглэсэн болно.³³

Хүний эрхийн боловсролын түүхэнд нэгэн тулгуур болох үйл явдал бол хүний эрхийн боловсрол, сургалтын НҮБ-ын тунхаглалыг³⁴ 2011 онд баталсан явдал юм. Уг тунхаглалаар өмнө батлагдсан хүний эрхийн гэрээнд туссан зарчим, хэм хэмжээг дахин баталгаажуулахын хамт бүхий л эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд хүний эрхийн боловсрол чухал ач холбогдолтой болохыг тодорхойлон тусгасан билээ.

²² НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын 4 дүгээр зүйл

²³ Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/law/cescr.htm.

²⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/law/cedaw.htm.

²⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/law/cat.htm.

²⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/law/crc.htm.

²⁷ Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/law/cmw.htm.

²⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/law/disabilities-convention.htm.

²⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/EN/Issues/IPeoples/Pages/Declaration.aspx.

³⁰ I дүгээр хэсэг, 33–34 дахь зүйл, II дугаар хэсэг 78–82 дахь зүйлийг үзнэ үү.

³¹ Арьсны үзэл, арьсны өнгөөр ялгаварлах, ксенофоби болон бусад ялгаварлалын эсрэг Дэлхийн бага хурлын үйл ажиллагааны хөтөлбөр ба Тунхаглал: Тунхаглалын 95–97 дугаар зүйл, Үйл ажиллагааны хөтөлбөрийн 129–139 дахь зүйлийг үзнэ үү.

³² Дурбаны дүгнэлтийн бага хурал, Үр дүнгийн баримт бичиг, 22 ба 107 дахь зүйлийг үзнэ үү.

³³ “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр” ХЭДКГ; Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/issues/education/training/programme.htm.

³⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг: www2.ohchr.org/english/issues/education/training/UNDHREducationTraining.htm.



“Аотираагийн талаарх миний мөрөөдөл” Шинэ Зеландын Жисборны охидын ахлах сургуулиас

“Аотираагийн талаарх миний мөрөөдөл” Шинэ Зеландын Жисборны охидын ахлах сургуулиас: Фото зургийг Карен Йохансен, Тунхаглалын оршилд хүний эрхийн боловсрол, сургалтын талаарх Төр, засгийн газруудын үүрэг амлалт, хүчин чармайлтыг өргөжүүлэхийг тусгасан байдаг. Тунхаглалын 14 дүгээр зүйлд:

- Хүний эрхийн боловсрол, сургалтад хамрагдах эрх
- Хүний эрхийн боловсрол, сургалтын цар хүрээ
- Хүний эрхийн боловсрол, сургалтыг тодорхойлогч зарчмууд
- Хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төр болон бусад оролцогчдын хүлээх хариуцлага
- Олон улсын хамтын нийгэмлэгийн боловсруулсан хэрэгжилтийг хангах заавар, журмууд зэргийг тодорхойлсон байдаг.

1.2. Хүний эрхийн боловсролын тодорхойлолтууд

Хүний эрхийн боловсролын талаар олон тооны тодорхойлолт байх бөгөөд эдгээр нь оролцоо, гэгээрэл, мэдлэг ойлголт болон хүсэл эрмэлзлэл зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулдаг.

Эмнести интернейшнл: Хүний эрхийн боловсрол нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн зарчмуудад нийцсэн мэдлэг, чадвар, хандлагыг дэмжих замаар хувь хүн, бүлэг, олон нийтийг гэгээрүүлэх зорилго бүхий зөвлөлдөх, оролцооны үйл явц юм.³⁵

Азийн бүс нутгийн хүний эрхийн боловсролын төв (2003): Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн мэдлэг, үнэт зүйлс, ур чадварт тулгуурлан өөрийн амьдралаа авч явах, үйл ажиллагаагаа ухаарч, танин мэдэхэд чиглэсэн суралцахуйн болон оролцооны үйл явц мөн.³⁶

³⁵ “Хүний эрхийн боловсрол гэж юу вэ?” Дэлгэрэнгүй мэдээллийг: www.amnesty.org/en/human-rights-education.

³⁶ “Хүний эрхийн боловсролын багц”; Азийн бүсийн Хүний эрхийн боловсролын нөөцийн төв; 2003 он, 22 дахь тал.

Хүний эрхийн боловсролтой танилцах нь. Нэгдүгээр хэсэг:

Балбын хүний эрхийн үндэсний комисс нь Балба улсын орон нутаг, анхан шатанд ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдыг дэмжих сургалтын хөтөлбөр боловсруулжээ. Үндсэн гурван хэсэг бүхий тав хоногийн сургалтын хөтөлбөр нь дараах агуулгатай байна. Үүнд:

- Хүний эрхийг хангаж, хамгаалах үндэсний ба олон улсын тогтолцоо
- Хүүхэд, эмэгтэйчүүд, үндэсний цөөнх зэрэг Балбын эмзэг бүлгийн иргэдийн эрх
- Хорих байгууллага, шорон, хүүхдийн асрамжийн төв зэрэг газруудад ажиллах үеийн Хүний эрхийн нөхцөл байдал

Уг хөтөлбөр нь хүний эрхийг хамгаалагчдын үүрэг, үйл ажиллагаа, хүний эрхийг хамгаалах тогтолцоо, хүний эрхийн нөлөөлөл, яриа хэлэлцээр, хүний эрхэд суурилсан хандлага зэрэг сэдвүүдийг хамааруулдаг. Мөн хөтөлбөрт оролцогчид нь хүний эрхийн зөрчлийг баримтжуулах, илтгэл боловсруулах зэрэг чадвараа дээшлүүлдэг байна.

2012 онд Балбын хүний эрхийн үндэсний комисс тус улсын 11 дүүргээс олон тооны иргэний нийгмийн байгууллагуудыг төлөөлөх 26 хүний эрхийг хамгаалагчдыг сургалт зохион байгуулжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбоосноос танилцана уу.

www.asiapacificforum.net/news/nepal-nhrc-develops-new-training-course-for-human-rights-defenders.



Фелисса Тиббитс, Хүний эрхийн боловсролын холбооны Гүйцэтгэх захирал: Хүний эрхийн боловсрол нь ХЭТТ болон бусад хүний эрхийн гэрээ конвенцоор баталгаажсан хүний эрхийг дэмжих, мөн тэдгээр эрхийн зөрчлийг арилгах үйл ажиллагаанд чиглэсэн олон улсын хөдөлгөөн юм.³⁷

Йорданы Хүний эрхийн Үндэсний Төв: Хүний эрхийн боловсрол нь хүний эрх, үүрэг хариуцлага, үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлэх сургалтын үйл явцыг хэлнэ.³⁸

Хүний эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ): Хүний эрхийн боловсрол нь хүн бүр эрхээ эдэлж, бусдын эрхийг хүндэтгэхэд чиглэсэн үнэлэмж, хандлага, итгэл үнэмшлийн цогц юм. Энэ нь хүний эрхийг орон бүрт бодит үйл хэрэг болгох нийтлэг үүрэг хариуцлагыг хөгжүүлдэг.³⁹

Латин Америкийн Ардчилал судлалын төв (ЛААСТ): Хүний эрхийн боловсрол нь эрх мэдлийн харилцаа, эрх мэдлийн бүтцийг ойлгуулахад чиглэсэн шүүмжлэлт сэтгэлгээ, ёс зүйн эргэцүүлэл, туршлага болохын хувьд нийгэмд өөрчлөлт хийх, хүний эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл ба үйл явц юм.⁴⁰

Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын тунхаглал: Хүний эрхийн боловсрол гэдэгт хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх, бүх нийтээр хүндэтгэх байдлыг дэмжихэд чиглэсэн боловсрол, сургалт, мэдээлэл, суралцахуйн бүхий л үйл ажиллагааг ойлгоно. Мөн энэ нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхүйц мэдлэг ойлголт, чадвартай болж, өөрийн зан үйл, хандлагаа төлөвшүүлэх, улмаар хүний эрхийн түгээмэл соёл бүрдүүлэхэд хүн бүр хувь нэмрээ оруулахад чиглэдэг.⁴¹

³⁷ “Хүний эрхийн боловсролын салбар дахь олон улсын хөгжил”, Фелисса Тиббитс, Олон улсын, Харьцуулсан боловсролын нийгэмлэгийн сэтгүүл (No. 151); 2009; Дэлгэрэнгүй мэдээллийг: www.cies.us/newsletter/sept%2009/Tibbits.html

³⁸ 2004 онд зохион байгуулсан “Хүний эрхийн боловсрол” сургалтад зориулан гаргасан.

³⁹ Хүний эрхийн дээд комиссарын газар, “Хүний эрхийн боловсрол, сургалт” Дэлгэрэнгүй мэдээллийг www2.ohchr.org/english/issues/education/training/index.htm.

⁴⁰ “Хүний эрхийн боловсролын заах арга зүйн төлөө”, “Хүний эрхийн боловсролын заах арга зүйн асуудлаарх олон улсын зөвлөлдөх уулзалт”, Дэлгэрэнгүй мэдээллийг: www.pdhre.org/dialogue/costarica.html.

⁴¹ Өгүүлэл 2.

Хүний эрхийн төв, Миннесотагийн их сургууль: Хүний эрхийн боловсрол гэдэг нь хүний эрхийн олон улсын хэм хэмжээг үндэс суурь болгон хүн бүр эрхээ мэдэх, баталгаажуулахын төлөө зохих мэдлэг, чадвар, үнэлэмжид суралцах үйл явц мөн. Үүний хамт хүний эрхийн боловсролыг гэгээрүүлэх чиг хандлагаар дараах байдлаар тодорхойлсон байдаг. Зохих цогц чадамж, боломжуудыг дэмжин хөгжүүлснээр хүний эрхийн боловсрол нь хүн байхын утга учрыг тодорхойлдог. Иймд боловсрол нь улс төрийн, эдийн засгийн, нийгэм соёлын бүх үйл ажиллагаанд нийгмийн бүрэн эрхт гишүүний хувьд оролцох боломжийг хүн бүрт бүрдүүлэх гэгээрлийн үйл явц юм.⁴²

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр: Хоёр дахь шатны Үйл ажиллагааны хөтөлбөр (2012–2014):

Хүний эрхийн боловсрол гэдэгт хүний эрхийн түгээмэл соёл бүрдүүлэхэд чиглэсэн боловсрол, сургалт, мэдээллийн үйл ажиллагааг ойлгоно. Үр дүнтэй хүний эрхийн боловсрол нь хүний эрх болон түүнийг хамгаалах тогтолцооны тухай мэдлэг олгоод зогсохгүй, өдөр тутмын амьдралдаа хүний эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, хөхиүлэн дэмжих чадвар хандлагыг хөгжүүлдэг. Мөн хүний эрхийн боловсрол нь нийгмийн бүх гишүүдийн хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэх хандлага, зан үйлийг дэмждэг.⁴³

1.3. Хүний эрхийн боловсролын хэлбэрүүд

Хүний эрхийн боловсрол нь бүх түвшинд, бүх насны хүмүүст хамааралтай насан туршийн үйл явц юм. Мөн бүх төрлийн боловсрол, сургалт, суралцахууд хамаарах бөгөөд төрийн, хувийн, албан ба албан бус хэлбэрүүдээр дамжин хэрэгжинэ.

- Албан боловсрол (**Formal education**) нь сургуулийн өмнөх боловсролоос эхлэн бага, дунд, дээд боловсролын түвшинд хөтөлбөрт суурилсан ерөнхий эрдмийн, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтаар хэрэгждэг.
- Албан бус боловсрол (**Non-formal education**) нь албан боловсролын тогтолцоонд хамаарахгүй боловч зохион байгуулалт бүхий боловсролын үйл ажиллагааг ойлгоно. Өөрөөр хэлбэл, тодорхой зорилтот бүлэгт сургалтын тусгайлсан хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах явдал юм. Үүнд ажлын байрны сургалтын хөтөлбөр, насанд хүрэгчдийн болон орон нутгийнханд чиглэсэн хөтөлбөр, хүний эрхийн нөлөөлөл ба иргэдийг чадавхжуулах зэрэг сургалтууд орж болно.
- Албан бус боловсрол (**Informal education**) нь хувь хүн өөрийн дадлага туршлага, суралцахуйн нөлөө, хүрээлэн буй орчны зүйлсээс өөрт шаардлагатай мэдлэг, чадвар, үнэт зүйлс, хандлагад суралцах тодорхой зохион байгуулалтгүй, насан туршийн үйл явцыг хэлнэ.

1.4. Хүний эрхийн боловсролын зарчмууд

Хүний эрхийн боловсролын зарчмууд нь албан ба албан бус хэлбэрээс үл хамааран хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны бүх хэлбэр, түвшинд хамаардаг. Гэвч хүний эрхийн боловсролын сургалтын явцад сургагчийн зүгээс тодорхой хандлагыг баримталж болно. Энэ гарын авлагын хүрээнд дараах зургаан зарчмыг баримтлана.

Хүний эрхийн боловсрол нь:

- Оролцоонд суурилсан, оролцогчид хамааралтай байх
- Түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхүйц байх
- Оролцогчдыг сургагч хэмээн хандах
- Мэдлэг, туршлагыг хөгжүүлэхэд эрмэлзэх
- Нийгмийн өөрчлөлт зорилгот үйлдлээс эхлэлтэйг зөвшөөрөх
- Үл ялгаварлах, тэгш байдлыг хангах, тэгш хамруулах хүний эрхийн зарчмуудыг дэмжих зэрэг болно.

⁴² “Модуль 20: “Гэгээрлийн төлөөх боловсрол” Дэлгэрэнгүй мэдээллийг: www1.umn.edu/humanrts/edumat/IHRIP/circle/modules/module20.htm

⁴³ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.ohchr.org/Documents/Publications/WPHRE_Phase_2_en.pdf.

Дөрөвдүгээр бүлгийн хүрээнд эдгээр зарчмуудыг дэлгэрүүлэн үзнэ.

1.5. Хүний эрхийн боловсролын практик

Хүний эрхийн боловсролын практик нь хүний эрхийн болон боловсролын үндсэн зарчим, хэм хэмжээнд нийцсэн, тэдгээрт уялдсан байна. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны үр дүнд оролцогчдын эрхэм зэрэг, хүний эрхийг хүндэтгэх, сургалтын үйл явцад тэдний идэвхитэй оролцоог хангах ёстой.

Хүний эрхийн боловсролын практик нь:

- Хүний эрхэм зэрэг, тэгш байдал, тэгш хамруулах, үл ялгаварлах зэрэг зарчмуудыг хэрэгжүүлэх
- оролцооны арга зүй, үнэлгээ, үйл явц, техникийг хэрэглэх
- оролцогчдод төвлөрүүлэн үзэх
- сургалтын олон төрлийн орчин нөхцөлд дасан зохицох чадвартай, шинэчлэгч шинжтэй байна.
- оролцогчдын оюун санааны, соёлын, зан үйлийн, шашны зэрэг хүчин зүйлсэд нийцсэн байх,
- оролцогчдын ялгаатай байдлыг хүндэтгэж, түүнийг баяжуулах
- тодорхой туршлага, үйл явдлыг хүний эрхийн үүднээс тусган хэлэлцэх
- Эмзэг бүлгийн хүмүүсийн онцлог хэрэгцээ, хүлээлт, саад бэрхшээл зэргийг нэн тэргүүнд авч үзэхийг чухалчлах
- Шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх хандлагыг дэмжих
- Орон нутгийн санал санаачлагыг дэмжихдээ үндэсний болон олон улсын хүний эрхийн арга хэрэгслүүдийг хэрэглэх зэрэг болно.

2.1. ЯАГААД ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ЧУХАЛ ВЭ?

Хүний эрхийн боловсрол нь өөрөө хүний эрх болохын хамт хүний эрхийг хамгаалах байдлыг ямагт ахиц дэвшилд хүргэдэг.

(НҮБ–ын Хүний эрхийн Дээд Комиссарын Газар, 1996)

2.1. Хүний эрхийн олон улсын баримт бичгүүд

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал нь хүний эрхийн боловсролын гүйцэтгэх үүргийг чухалчлан үздэг. Уг баримт бичгийн Оршилд "... хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүхэн ... гэгээрч боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахихад дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстойг, түүнчлэн үндэсний болон олон улсын хэмжээнд дэвшилтэт арга хэмжээ авах замаар эдгээр эрх, эрх чөлөөг ... бүх нийтээр үр нөлөөтэй хүлээн зөвшөөрүүлж, дагаж мөрдөх явдлыг хангахад тус дөхөм үзүүлэхийг эрмэлзэх ёстой" хэмээн тунхагласан байна.

НҮБ–ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын 1 дүгээр зүйлд хүний эрхийн боловсролын зорилгыг мөн тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Хүн бүр хүний эрх, суурь эрх чөлөөний тухай мэдээлэл мэдэх, хайх, хүлээн авах эрхтэй бөгөөд хүний эрхийн боловсрол, сургалтад хамрагдана.
2. Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүний эрхийн түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай байх зарчимд заасны дагуу хүний бүх эрх, аливаа хүний суурь эрх чөлөөг түгээмэл байдлаар хүндэтгэх, мөрдөх явдлыг хөхиүлэн дэмжихэд амин чухал үндэс болно.

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг газар бүр, өргөн утгаараа нийгэмд бүхэлд нь хэрэгжүүлэх хүн бүрийн нийтлэг үүрэг хариуцлагыг дэмжин хөгжүүлэх зорилготой. Энэ утгаараа хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн зөрчил, мөргөлдөөнөөс байнга сэргийлж, тэгш байдал, тогтвортой хөгжлийг дэмжин, ардчилсан тогтолцоон дахь шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоог хангадаг билээ.⁴⁴

⁴⁴ "Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр" (А/НRC/15/28; 1 дэх зүйл)–ийн Хоёрдахь шатны (2010–2014) үйл



Афган дүрвэгч охид Иран улсын Варамин дахь сургуульдаа Афган дүрвэгч охид Иран улсын Варамин дахь сургуульдаа: НҮБ. Фото зургийг Эскиндер Дебебе

2.2. Хүний эрхийн боловсролын зорилгууд

Хүн бүр өөрийн хийж буй үйлдэл, үйл ажиллагаагаа хяналтдаа байлгах зорилгоор дадал, туршлагаа ухамсарлан ойлгох шаардлагатай байдаг. Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлэх, бодит үйл хэрэг болгохын тулд хувь хүн, бүлэг нийтлэг, улс орон, ард түмнийг сэдэлжүүлэх, хувь нэмрээ оруулахуйц болгох мэдлэг, чадвар, хандлага, зан үйлийг хөгжүүлэх зорилготой.⁴⁵

Иймд хүний эрхийн боловсрол нь гурван үндсэн зорилготой. Энэ нь хүний эрхийн тухай суралцах, хүний эрхээр суралцах, хүний эрхийн төлөө суралцах хэмээх хандлагуудыг оролцогчдод төлөвшүүлэх зорилготой.

Хүний эрхийн тухай суралцах – энэ нь хүний эрхийн хэм хэмжээ, үнэт зүйлс, зарчим, түүнийг хамгаалах тогтолцооны тухай ойлгон ухаарахад чиглэдэг. Хүний эрхийн боловсролд суралцагч, оролцогч нь олон улсын хүний эрхийн тогтолцооны түүхэн хөгжил, бүтэц, гэрээ конвенц зэрэг баримт бичгүүдийн талаарх мэдлэг ойлголтыг бүрдүүлдэг. Мөн хүний эрх нь хүн бүрийн амьдрал үйл ажиллагаанд хэрхэн холбогдох, өөрийн болоод бусдын амьдралд хэргэжүүлэх, ялангуяа эрх нь зөрчигдсөн нөхцөлд эрхээ хамгаалах чадварыг төлөвшүүлэхэд тусална. Хүний эрхийн тухай суралцах нь хүний эрхийн үнэт зүйлсийг ойлгох, хэрэгжүүлэх байдлыг хөхиүлэн дэмждэг.

Хүний эрхээр суралцах – Энэ нь Хүний эрхийн боловсрол олгох үйл явцыг хүний эрхийн зарчим, стандартад нийцүүлэн зохион байгуулахыг ойлгодог. Үүнд багш ба сурагчийн, сургагч ба суралцагчийн хоорондын харилцаа, тухайн сургалтын үйл явц, орчин, сургалтад хэрэглэгдэж буй хэрэглэгдэхүүн, түүний хүрэлцээ, тухайн агуулгад нийцсэн байдал зэргээр хэмжигдэнэ.

ажиллагааны төлөвлөлтийн төслөөс авсан тодорхойлолт, Уг төлөвлөгөөг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2010 оны 10 сарын 30-ны өдрийн 15/11 тоот тогтоолоор баталжээ.

⁴⁵ НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын 2.2 дугаар зүйл

ЭНЭТХЭГИЙН АХЛАХ СУРГУУЛИУДАД ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН КЛУБУУД БАЙГУУЛАГДЛАА.

Залуу хойч үеийнхний дунд хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Энэтхэгийн Керала мужид 145 ахлах сургуульд хүний эрхийн боловсролын клубуудыг Парламентын харилцааны хүрээлэн санаачлан байгуулж байна. Энэ нь сургууль бүрт клуб, зохицуулагчийн хамт ажиллаж эхэлсэн анхны муж болж байна. Мөн эдгээрийн хамт төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг хариуцсан дүүргийн зохицуулагчдыг томилон ажиллуулдаг. Клуб нь одоогоор 145 сургууль дээр ажиллаж байгаа бөгөөд цаашид 250 сургууль болж өргөжинө. Энэ нь залуу үеийнхнийг өөрсдийн тухай сайн мэдлэг ойлголттой болгоход чиглэсэн санаачлага билээ. Сургууль бүр дэх клубыг хариуцах багш нар нь сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгуулдаг. Каннур дүүргийн зохицуулагч Сижо Ж Арракал 'Бид хүний эрхийн талаар сурагчдын зохион байгуулж буй кампанит ажлууд, олонтаа хэлэлцэгдэж буй асуудлаар мужийн хэмжээний үзэсгэлэн зохион байгуулна. Мөн хүний эрхийн зөрчлүүдийг тодорхойлон харуулсан гудамжны жүжигчилсэн тоглолтууд зохион байгуулахаар төлөвлөж байна' хэмээн өөрийн ажлаа танилцууллаа.

Каннур сургуулийн нэгэн клуб дэлхийн өнцөг булан бүрд тохиолдож буй хүний эрхийн гол зөрчлүүдийн тухай гэрэл зургуудыг цуглуулах төсөл санаачилсан. Улмаар тэд хүүхдийн эрх хэрхэн зөрчигдөж байгаа тухай мэдлэг ойлголтыг илүү шинэлэг арга хэлбэрээр дамжуулж байна' хэмээн Сижо онцлон хэллээ.

"Хүний эрхийн боловсролын клубууд 145 ахлах сургуулиудад байгуулагдлаа", The New India Express (2013-04-21); Дэлгэрэнгүймэдээллийг дараах холбоосноос танилцана уу. newindianexpress.com/states/kerala/HR-education-clubs-to-be-launched-in-145-high-schools/2013/04/21/article1554691.ece



Хүний эрхийн төлөө суралцах – Энэ нь хүн бүр өөрийн эрхээ мэдэх, хэрэгжүүлэх, мөн бусдын эрхийг хүндэтгэх, сахин хамгаалах чадвар, хандлагыг илэрхийлдэг. Үүнд хүний эрхийн зөрчлийн талаар хариу арга хэмжээ авах, үүнд шаардлагатай арга, хэрэгслүүдийг хэрхэн ашиглах тухай заан сургах зэрэг үйл ажиллагааг хамруулж ойлгоно. Ерөнхийдөө хүний эрхийн боловсрол нь хувь хүний, бүлэг нийтлэгийн, тодорхой орчин нөхцөлийн, өргөн утгаараа нийгмийн амьдралыг өөрчлөх байдлыг дэмжин баталгаажуулдаг.

Хүний эрхийн боловсролын тусгай зорилтуудыг дор тодорхойлсон болно:

- хүний эрхийн тухай мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх
 - ХЭТТ болон олон улсын хүний эрхийн баримт бичгүүд
 - хүний эрхийн талаарх дотоодын хууль тогтоомж
 - хүний эрхийг хангаж, хамгаалахад холбогдох түүхэн үйл явц
 - зарим эмзэг бүлгийн эрх, эрх чөлөө
 - хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэх механизмууд
 - эрх мэдлийн харилцаа ба нийгмийн хүчин зүйлс
- хувь хүмүүсийн чадавхийг бэхжүүлэх
 - хүний эрхийн мэдлэг, ойлголтыг өөрсдийн нөхцөл байдалд хэрэглэх
 - олон улсын хүний эрхийн стандартуудыг үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжүүлэх
 - НҮБ-ын эрх зүйн болон техникийн баримт бичгүүд, үзэл баримтлалыг холбогдох нөхцөлд хувирган хэрэглэх

- аливаа бүтэц, тогтолцоог хүний эрхийн өнцгөөс тодорхойлох
- хүн бүр өөрийн үйлдэл, зан үйлийн үр дагаврыг эргэцүүлэх, дахин хянах
- аливаа бүлэг, нийтлэг, нийгмийн өмнө хамгийн их тулгамдаж буй хүний эрхийн асуудлыг ялган тодорхойлох,
- хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх стратегиудыг боловсруулах
- Хувь хүн бүлгүүдийн хүний эрхийн төлөө үр дүнтэй үйл ажиллагаа явуулах талаар бэхжүүлэх

3. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ХЭНД ЧИГЛЭДЭГ ВЭ?

Хүний эрхийн боловсрол нь хүн бүрийн үйл хэрэг билээ. Хүний эрхийн боловсролын зорилтот бүлгүүдийг дараах гурван бүлэгт хувааж үзэж болно.

- **эрх эдлэгч** – эрх нь зөрчигдөж болзошгүй хүмүүс
- **үүрэг хүлээгч** – бусдын эрхийг хангах болон зөрчиж болзошгүй хүмүүс
- **нөлөөлөгчид** – бусдын үзэл бодол үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэх боломж бүхий хүмүүс

Зарчмын хувьд хүн бүхэн эрх эдлэгч, үүрэг хүлээгч, нөлөөлөгчид байх боломжтой. Гэвч тодорхой нөхцөл байдалд тухайн хувь хүн болон бүлэг нь аль нэгэн байр суурийг нийтлэг байдлаар илэрхийлдэг, өөрчлөгдөхүйц байр суурийн цогц байдаг. Бүтцийн дүн шинжилгээний арга зүйн үүднээс авч үзэхэд,⁴⁶ ‘энэхүү ангилал нь тухайн нөхцөл байдалд хэн эрх мэдлийг эзэмшиж байгаа болон эзэмшээгүй байгаагаас хамаардаг’ байна.

Өмнө нь бид ямар эрхтэй эсэхээ мэддэггүй байсан тул үргэлж айж, санаа зовдог байсан. Хэдийгээр зарим нь бидэнтэй зүй бусаар харьцсан ч бидэнд айдас байдаг болохоор эрхийнхээ төлөө тэмцэж чаддаггүй байсан. (Сама Дилаут, Бажау, Филиппин)

Эрх эдлэгч нь хүний эрх, эрх чөлөө болон тэдгээрийн хамгаалалтыг эдлэх боломж бүхий хүмүүс юм. Тодорхой хувь хүний тохиолдолд авч үзвэл, эрх эдлэгч нь үүрэг хүлээгчтэй зохих харилцаанд орсноор тухайн байр суурь тодорхойлогдоно. Тухайлбал, хүүхэд эцэг эх, багш сурагч, эрэгтэй ба эмэгтэй хүн, хөгжлийн бэрхшээлтэй ба хөгжлийн бэрхшээлгүй хүн, багш ба сургуулийн удирдлага, цэрэг ба генерал, Засгийн газар ба үндэстэн дамнасан корпорац зэргийн хооронд үүсэх харилцаа юм.

Нийгмийн хувьд авч үзэхэд, бусдаас ялгаварлагдан, эмзэг байдалд байгаа бүлгүүд нь эрх эдлэгч болж болно. Зарим хүний эрхийн гэрээ нь эмэгтэйчүүдийн, хүүхдийн, залуучуудын, үндэстний цөөнхийн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн, цагаачдын, дүрвэгсдийн, уугуул хүмүүсийн болон хоригдож буй хүмүүс зэрэг тодорхой бүлгийн эрх ашгийг тусгасан байдаг. Эдгээрээс гадна тусгайлсан гэрээгээр эрхийг нь хамгаалаагүй ахмад настнууд, ядуус, бэлгийн цөөнх зэрэг бүлгүүдийн эрхийг хүний эрхийн суурь баримт бичгүүдээр тусган хамгаалдаг.⁴⁷ Эдгээр бүлэгт хамаарах хүмүүс аливаа нэг ялгаварлан гадуурхалт, эмзэг байдалтай тулгарч байгаагүй ч тухайн хамаарч буй бүлгийн хамгаалалт мөн хамааралтай байна.

ЭРХ ЭДЛЭГЧ НЬ:

- **эрхээ эдлэх боломжтой байх**
- **эрхээ шаардах боломжтой байх**
- **үүрэг хүлээгчийг үүргээ хариуцлагаа биелүүлэхийг шаардах**
- **бусдын эрхийг хүндэтгэх үүрэг хариуцлага хүлээнэ.**⁴⁸



⁴⁶ “Бүтцийн шинжилгээ” – г 35 дахь хуудсанд тайлбарласныг үзнэ үү.

⁴⁷ Мөн ЛГБТ хүмүүсийн эрхийн талаарх Жогжакартийн зарчмууд зэрэг тодорхой бүлгийн хүмүүсийн эрхийн талаарх олон улсын зарчмууд байдаг.

⁴⁸ Хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх нь Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан зааварчилгаа: Данийн Хүний эрхийн хүрээлэн, 2007 он



Филиппиний Зэвсэгт хүчин, Филиппиний Үндэсний цагдаагийн алба хаагчид 2008 оны Хүний эрхийн өдөрт: Филиппин улс, Минданао, Эсперанза Фото зургийг Жилл Крисп

Үүрэг хүлээгч нь эрх эдлэгчийн эрхийг хангах, хамгаалах талаар тодорхой хариуцлага хүлээсэн байгууллага, хувь хүн байна. Эрх эдлэгч болон үүрэг хүлээгчийн хоорондын харилцаа нь эрх мэдлийн ялгаатай байдлаас үүсдэг. үүрэг хүлээгч Байгууллагын хувьд тухайн байгууллага нь бусдын хүний эрхийг сахин хамгаалах чиг үүрэг, чадавхи бүхий байна.

Цэргийн албан хаагч болохын хувьд, энэхүү төсөл миний ажил үүрэгт холбогдох хүний эрхийн тухай цогц ойлголт өгч, хүн бүрийн эрхийг хэрхэн хамгаалах талаар сургасан болно. (Филиппин Улс)

Төр болон түүний хууль ёсны үүрэг хүлээгчид нь хүний эрхэд холбогдох нийтлэг үүрэг хариуцлагыг ханган биелүүлэх чиг үүрэгтэй байдаг. Энэ нь парламент, яамд, орон нутгийн эрх баригчид, шүүгч болон хууль, шүүхийн байгууллагууд, цагдаа, цагаачлалын алба, зэвсэгт хүчин, сургуулийн багш нар зэрэг төрийн бүх байгууллага, албад нь хууль ёсны үүрэг хүлээгчид болно. Эрх эдлэгчийн эрхэд нөлөөлөх боломж, чадавх бүхий бусад байгууллага, хувь хүн нь ёс суртахууны үүрэг хүлээгч болно. Бизнесийн салбар, хувийн хэвшлийн компани, орон нутгийн манлайлагчид, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, өрхийн тэргүүн зэрэг нь бүгд ёс суртахууны үүрэг хүлээгчид хамаарна.

Нөлөөлөгчид: эрх эдлэгч өөрийн эрхээ мэдэх, шаардах болон нөгөө талаас үүрэг хүлээгчид өөрийн үүргээ ханган биелүүлэхийг шаардах, чиглүүлэх өвөрмөц үүрэг бүхий оролцогчдыг нөлөөлөгчид гэнэ. Үүнд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, шашны, овог аймгийн тэргүүнүүд, үйлдвэрчний эвлэл, төрийн бус байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллага, хүний эрхийг хамгаалагчид ордог.⁴⁹

Хүний эрхийн боловсрол чиглэх шаардлагатай бүлгүүдийг дараах байдлаар жагсаав.⁵⁰

⁴⁹ Боловсролын байгууллагууд мөн энэ ангилалд орж болно. Гэхдээ хүүхэд, залуучуудыг сургуулиар дамжуулан сургах үндсэн чиг үүргийг үүнд тооцохгүй болно.

⁵⁰ Хүний эрхийн боловсрол гарын авлага: Суралцахуй, үйлдэхуй, өөрчлөлтийн төлөө үр дүнтэй практикууд; Нэнси Фловуэр нар, Хүний эрхийн нөөцийн төв, Миннесота их сургууль; 2000 он Номоос өөрчлөн оруулав.

Бага насны хүүхдүүд, гэр бүл:

Олонх тохиолдолд эцэг эх, өвөө эмээ болон бусад насанд хүрэгчид нь хүүхдийн анхны багш нар нь байдаг. Боловсролын судалгаа⁵¹–ны үр дүнд хүүхэд насны эхний арван жил нь хүүхдэд хүний эрхэм зэрэг ба тэгш байдлын тухай хандлага төлөвшин тогтох маш чухал үе шат болохыг тогтоосон байна. Иймд хүүхдийн гэр бүл, орчны хүмүүс нь хүний эрхийн тухай, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх тухай мэдэх нь ихээхэн чухал юм.

Багш нар, сургагчид болон сургуулийн удирдлагууд

Багш нарын хувьд хүний эрхийн талаар юуг, хэрхэн зааж сургах тухай суурь ойлголттой байх шаардлагатай тул энэ тухай мэдэх нь чухал. Багш нар өөрсдийн зааж буй хичээлдээ хүний эрхийн асуудлыг үр дүнтэй тусгахын тулд боловсролын тогтолцооны ерөнхий дэмжлэг, баталгааг авах шаардлагатай байдаг.

Эмч, сувилагч, хуульч, шүүгч, нийгмийн ажилтан, сэтгүүлч, цагдаагийн болон цэргийн албан хаагчид

Эдгээр мэргэжилтнүүдэд тэдний биелүүлэх ёстой үүрэг хариуцлага, байр суурь болон эрх хэмжээ байх тул хүний эрхийн тухай зайлшгүй мэдэх шаардлагатай. Иймд хүний эрхийн сургалтын хөтөлбөр нь анагаах ухааны, хуулийн сургууль, их сургуулиуд, цэргийн болон цагдаагийн академи, бусад мэргэжлийн сургалтын байгууллагуудын хөтөлбөрийн нэгэн суурь бүрэлдэхүүн байх ёстой.

Эмзэг бүлгүүд

Хүний эрхийн боловсрол нь зөвхөн албан ёсны сургалтаар хязгаарлагдах ёсгүй. Олон тооны хүмүүс суралцах боломжгүй байдаг. Мөн олон тооны хүмүүс Засаг захиргааны төвөөс алс хол амьдардаг. Иймээс дүрвэгсэд, үндэстний цөөнх, цагаач ажилчид, уугуул хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй эсхүл ядуу хүмүүс ямар нэгэн эрх мэдэлгүй, мөн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй байдаг. Эмзэг бүлгийн хүмүүс өөрсдийн эрхээ хамгаалах, ахиц гаргахын тулд эрх, эрх чөлөө, түүний хамгаалалтын тогтолцоо, арга хэрэгслүүдийн талаар мэдэх шаардлагатай.

Идэвхтнүүд ба ашгийн бус байгууллагууд

Хүний эрхийн тэмцэгчдийн үйл ажиллагаа нь хүний эрхийн тогтолцооны нэгэн чухал үндэс суурийг бэхжүүлдэг. Мөн хүний эрхийн төлөөх хөдөлгөөнийг хөгжүүлэх стратеги нь хүний эрхийн талаарх онолын судалгааг бэхжүүлдэг. Мөн зарим төрийн бус байгууллагад ажиллагчид өөрсдийгөө хүний эрхийн төлөө ажиллаж байгаагаа сайн ялгаж ойлгодоггүй. Тухайлбал, шударга цалин хөлс, эрүүл мэнд, орон байрын асуудлаар ажиллаж буй хүмүүс уг асуудал нь хүний эрхийн нөхцөл байдал, ерөнхий тогтолцоонд ямар байдлаар холбогдохыг мэдсэнээр зорилгоо хэрэгжүүлэхэд нь туслах болно. Мөн магадгүй нийгэм, эдийн засгийн тэгш байдлын төлөө ажиллаж буй бусад хүмүүстэй нэгдмэл нэг зорилготой болохоо мэдэхгүй байж болзошгүй.

Сонгогдсон буюу томилогдсон төрийн албан хаагчид

Нийтийн эрх ашгийн төлөө ажиллаж буй төрийн албан хаагчдын хувьд хүний эрхийн тухай ойлгож мэдэх, түүнийг дэмжин ажиллах нь ихээхэн чухал юм. Аливаа сонгуульд нэр дэвшигчид нь хүний эрхийн талаар олон нийтийн өмнө үүрэг амлалт өгөх, мөн шинэ албан тушаалтны ажлын байрны чиг баримжаа олгох, мэргэжлийн сургалтад хүний эрхийн асуудлыг тусган хэрэгжүүлэх шаардлагатай.

⁵¹ Анхны жилүүд, амьдрах боломж ба тэгш байдал: Бүтээлийн дүгнэлт шүүмж; Пол Жонсон Юлия Коссух, Хязгаарын эдийн засаг; Тэгш байдал, хүний эрхийн комисс, 2008 он; Дэлгэрэнгүй мэдээллийг www.equalityhumanrights.com/uploaded_files/research/7_earlyyears_lifchances.pdf. Хүүхдийн асуудлаарх зөвлөгөө, Хүүхдийн асуудлаарх Сайдын ажлын алба (Ирланд); 2006; Дэлгэрэнгүй мэдээллийг www.dcy.gov.ie/documents/childcare/diversity_and_equality.pdf.

Эрх мэдлийг хэрэгжүүлэгчид

Үүнд бизнесийн, банкны төлөөлөгчид, газар эзэмшигчид, шашны тэргүүд зэрэг олон хүний амь амьдралд нөлөөлөхүйц бодлого, шийдвэр гаргах эрх мэдэл бүхий хүмүүс орно. Эрх мэдлийг хэрэгжүүлэгчид нь хүний эрх нь тэдэнд өөрсдөд нь болон нийгмийн бүлгүүдэд хэрэгтэй, мөн хүний эрхийг удаан хугацаанд тогтвортой хөгжүүлэх нь чухал хэрэгцээ болохыг ойлгох ёстой. Хүний эрхийн боловсрол нь ерөнхийдөө бусдын эрхийг хэрхэн хамгаалах талаар үүрэг хүлээгчдийн чадавхийг бэхжүүлэх зорилготой байдаг. Нөгөө талаас эрх эдлэгчид өөрсдийн амьдралаа хэрхэн хяналтдаа байлгах талаар гэгээрүүлэхийг хүсдэг. Тиймээс үр дүнтэй хүний эрхийн боловсролын арга хэлбэр, сургах үйл явц нь оролцогчдын эрх мэдлийн дүн шинжилгээнд суурилбал зохино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэрэгсэл мөн. Энэ нь бүх насны хүмүүсийг хамруулсан, бүх түвшний, олон талт сургалт, боловсрол, суралцахуйн үйл ажиллагаа бүхий насан туршийн үйл явц юм. Хүний эрхийн боловсрол нь төрийн болон хувийн хэвшил, албан ба албан бус зэрэг бүх байгууллага, тогтолцоонд хэрэгжинэ.
- Хүний эрхийн боловсрол нь олон тооны олон улсын хүний эрхийн гэрээ, тунхаглалуудад агуулагддаг. Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай НҮБ-ын тунхаглал нь хүний эрхийн гэрээнд туссан зарчим, хэм хэмжээг дахин баталгаажуулсан байдаг.
- Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, эрхээ амьдралд хэрэгжүүлэх, хүний эрхийг үр дүнтэй, бодит үйл хэрэг болгох хувь хүмүүсийн болон нийгмийн чадавхийг бэхжүүлэх зорилготой болно.
- Хүний эрхийн боловсрол нь хүн бүрийн үйл хэрэг мөн. Үүнд оролцогчдыг эрх эдлэгч, үүрэг хүлээгч, нөлөөлөгчид хэмээх гурван үндсэн бүлэгт хуваан үздэг.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Хүний эрхийн боловсролын багц: Хүний эрхийн боловсролын Азийн бүсийн нөөцийн төв, 2003 он, хоёрдахь хэвлэл,

Хүний эрхийг ойлгохуй: Хүний эрхийн боловсролын гарын авлага; Волфганг Бенедик, Хүний эрх, ардчиллын Европын сургалт, судалгааны төв; 2012 он

Хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх нь—Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан зааварчилгаа: Данийн Хүний эрхийн хүрээлэн, 2007 он

Хүний эрхийн боловсрол гарын авлага: *Суралцахуй, үйлдэхүй, өөрчлөлтийн төлөө үр дүнтэй практикууд*; Нэнси Фловуэр, Марсиа Бернбаум, Кристи Руделиус–Палмер, Жоул Толман нар, Хүний эрхийн нөөцийн төв, Миннесота их сургууль; 2000 он



БҮЛЭГ 3:

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУД БА ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД

- Олон улсын хүний эрхийн тогтолцоонд хүний эрхийн үндэсний байгууллагуудын хүний эрхийн боловсрол олгох үүрэг, эрх хэмжээний тухай хэрхэн тодорхойлдог вэ?
- Хүний эрхийн боловсролын чанартай хөтөлбөр хэрэгжүүлэхийн тулд Хүний эрхийн үндэсний байгууллагууд юу хийх шаардлагатай вэ?
- Ази–Номхон далайн бүс нутагт хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн талаарх ямар жишээ байдаг вэ?



“...Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжих, мөн хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдыг дайчлан оролцуулах, шаардлагатай тохиолдолд зохицуулах үүрэгтэй байх зэргээр чухал үүрэг гүйцэтгэнэ”.⁵²



1. ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРХ ХЭМЖЭЭ БА ҮҮРЭГ⁵³

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын эрх хэмжээний үндсэн цөмийг бүрдүүлдэг. Парисын зарчмууд⁵⁴ нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын үйл ажиллагааны эрх хэмжээ, чиг үүрэгт холбогдох наад захын жишиг хэм хэмжээг тодорхойлдог. Парисын зарчмуудад нийцсэн байдал нь НҮБ–ын Хүний эрхийн зөвлөл болон олон улсын хүний эрхийн бусад тогтолцоо, механизмын хэлэлцүүлэгт оролцох зэрэг эрх бүхий байх магадлан итгэмжлэлийн үндсэн шалгуур нь болдог. Парисын зарчимд заасанчлан, хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийг хөхиүлэн дэмжихтэй холбогдох дараах гурван зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.


- хүний эрхийн тухай мэдээллээр хангах, сургах
- хүний эрхийг хүндэтгэхэд чиглэсэн үнэт зүйлс, хандлагыг дэмжих
- хүний эрхийн зөрчлөөс хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх

Парисын зарчимд нийцэн тохирсон хүний эрхийн үндэсний байгууллагууд нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх талаар мөн шийдвэрлэх үүрэгтэй оролцдог.

⁵² НҮБ–ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын 9 дүгээр зүйл

⁵³ Хүний эрхийн үндэсний байгууллагууд Гарын авлага; АНДХЭҮБЧ; 2013 номын 4 дэх бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

⁵⁴ Хүний эрхийн үндэсний байгууллагуудын статусын талаарх зарчмууд (Ерөнхий Ассемблейн шийдвэр 48/134). Парисын зарчмуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.asiapacificforum.net/members/international-standards.



“Аотираогийн талаарх миний мөрөөдөл” Шинэ Зеландын Жисборны охидын ахлах сургуулиас “Саяхны АНДХЭҮБЧ-ны цагаач ажилчдын эрхийн талаарх сургалтын оролцогчид: Фото зургийг Сурайна Паша, АНДХЭҮБЧ,

Хүний эрхийг хөхиүлэн дэмжих чиг үүргийн хүрээнд хүний эрхийн үндэсний байгууллагууд нь:

- өөрийн зорилго, чиг үүрэг, үйл ажиллагааны тухай олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх
- хүний эрхийн талаарх практикийн болон хавсарга ойлголтыг бүрдүүлэх, бусдыг хүний эрхийн төлөө зүтгэгч, хамгаалагч болгохын төлөө дайчлах
- нийгмийн бүх түвшинд, бүх салбарт хүний эрхийг дэмжих соёлыг бүрдүүлэх үндэсний байр сууриа ашиглах

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь өөрийн үндэсний өвөрмөц онцлогт нийцүүлэн зохистой арга хэлбэрээр хүний эрхийн боловсролын арга хэмжээг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. Үүнд:

- хүний эрхийн тухай мэдээллийг болвсруулах, түгээн дэлгэрүүлэх
- олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах
- зохих оролцогчдод тусгайлсан сургалт зохион байгуулах
- хүний эрхийн тухай мэдлэг, ойлголт болон өөрсдийн ажил үүргийг дэмжихэд хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах
- Сургуулиудад хүний эрхийг заан сургахын төлөө ажиллах зэрэг үндсэн хэлбэрүүдтэй.⁵⁵

Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн хоёрдугаар шатны⁵⁶ Үйл ажиллагааны хөтөлбөрт хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөрийг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх явцад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах үндсэн байгууллага болохыг зааж өгсөн байдаг. Мөн хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, түүний ахиц дэвшлийн талаар хүний эрхийн гэрээний тайлагналтын тогтолцоогоор дамжуулан НҮБ-д тайлан илгээх үүрэгтэй байдаг.

⁵⁵ Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010 хуудас. 73.

⁵⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг www.ohchr.org/Documents/Publications/WPHRE_Phase_2_en.pdf

2. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ТАЛААРХ ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮНДСЭН ШААРДЛАГУУД

Хүний эрхийн боловсрол нь олон төрлийн хандлага, үйл ажиллагаанд хамааралтай болохыг дараах бүлэгт авч үзнэ. Хүний эрхийн боловсрол нь нийгмийн бүх давхаргад хамаарах насан туршийн суралцах үйл явц юм. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хараат бус байгууллага болохын хувьд нийгмийн бүх салбарт хүний эрхийн боловсролыг түгээх боломжтой.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь боловсролын хөтөлбөр болон бусад үйл ажиллагаагаараа хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг дэмжинэ. Энэ нь хүний эрхийн тухай суурь мэдээллээс эхлээд хүний эрхийн үзэл баримтлал ба эрх зүйн асуудлыг тайлбарлах зэргээр үргэлжилнэ. Иймд уг ажил нь зурагт болон хэвлэмэл хуудас, мөн тайлан хэвлүүлэх зэргээс илүү ихийг буюу албан ба албан бус боловсролын хөтөлбөрөөр дамжуулан хувь хүнийг хөгжүүлэх, харилцаанд оролцуулахыг шаарддаг.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь зан үйлийг өөрчлөх гэсэн саад бэрхшээлтэй тулгардаг бөгөөд тодорхой туршлага хуримтлуулсан байдаг. Тэдгээрийн олонх нь амжилтад хүрдэг. Зан үйлийг өөрчлөх нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахаас илүүтэй хүнд ойлголт юм. Энэ нь хүний эрхийн зөрчлийн талаар хяналт шалгалт явуулах зэрэг ердийн ажлуудтай мөн уялдан гардаг. Хүмүүс эрх нь зөрчигдсөн, энэ талаар тодорхой туршлага хуримтлуулах үедээ өөрийн болоод бусдын зан үйлийг өөрчлөх талаар ихээхэн асуудал дэвшүүлдэг. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын ажлын дийлэнх хувь нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа байх ёстой. Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь энэ асуудлаар маш тодорхой байр суурьтай байх бөгөөд бүх үйл ажиллагаа, хөтөлбөр нь хүний эрхийн боловсролын бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Хүний эрхийн зөрчлийн талаар хяналт шалгалт хийх зэрэг ажиллагааны үед уг ажлын үндсэн зорилго болон арга зүй нь хүний эрхийн боловсрол олгох явдал болно.⁵⁷

Австралийн хүний эрхийн комисс, Сиднейн олон нийтийн сантай хамтран өөрсдийн болоод бусдын амьдралыг өөрчлөхөд хуулийг хэрхэн ашиглаж болохыг харуулсан богино хэмжээний 20 кино хийжээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг алагчлахын эсрэг Холбооны хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн амьдралын аль нэг салбар хүрээнд бусад хүмүүсээс ялгаатай байдлаар хандсан тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдний садан төрөл, холбоод гомдол гарган шийдвэрлүүлэх боломжийг олгосон байна.

“Бид өдөр тутам сургуульд явж, автобусанд сууж, кино үзэх бөгөөд байшин барилгад нэвтэрдэг. Гэхдээ бидний зарим маань энэ бүгдийг хийхэд маш их хүндрэлтэй тулгардаг” хэмээн Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг алагчлах асуудлыг хариуцсан Комиссар Грэйм Иннес хэлжээ. Мөн тэрээр “Австраличуудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй байгаа нь өөрөө хүндрэл биш, харин хөгжлийн бэрхшээлтэй хүнд сөргөөр хандаж буй нь гол бэрхшээл болохыг эдгээр кино харуулсан юм” хэмээн нэмж өгүүлжээ.

Нээлтийн ёслол дээр Австралийн Амбан захирагч хатагтай Куйнтин Брюс АС СВО “эдгээр кино нь ихээхэн гүн утга бүхий зөвлөгөө, практик ач холбогдолтой бөгөөд цаашид хэрхэн урагшлах талаарх мэдээллийг агуулсан” хэмээн онцолжээ.

“Хорин жил: Хорин түүх” Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.humanrights.gov.au/twentystories/index.html.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах цахим хуудсаар танилцана уу. www.asiapacificforum.net/news/australia-videosshowcase-achievements-of-people-with-disabilities.



Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь өөрсдийн хүний эрхийн боловсролын хөтөлбөр нь тодорхой үйл ажиллагаанд чиглэж, зохих үр дүнд хүрч буй эсэхийг магадлах шаардлагатай. Хүний эрхийн үндэсний

⁵⁷ Дэлгэрэнгүй мэдээллийг, Хүний эрхийн зөрчлийн нийтлэг хэлбэрүүдийн талаар үндэсний хяналт шалгалт зохион байгуулах гарын авлага, АНДХЭҮБЧ, Хүний эрх, хүмүүнлигийн эрх зүйн Раоул Валленбергийн хүрээлэн; 2012.

байгууллагуудын зүгээс хүний эрхийн төлөө дараах үйл ажиллагаа хийхийг холбогдох этгээдэд уриалах талаар ажиллана. Үүнд:

- хүний эрхийн боловсролын хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлж болох үйл ажиллагааг санал болгох
- үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар суралцах, хүний эрхийн боловсролын хөтөлбөрөө эргэн нягтлах
- хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн үр дүнд хэрэгжүүлж болох төслүүд боловсруулахад нь туслах
- Хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд суралцсан мэдлэг, чадвараа хэрэгжүүлэхэд нь суралцагчдад дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь иргэд хүний эрхийн тухай яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд туслахуйц материалууд боловсруулбал зохино. Зарим материал нь мэдээлэл өгөх, зарим нь сургалтын гарын авлага, модуль зэрэг суралцахуйн хэрэглэгдэхүүнүүд байж болно.

Мөн хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн сургагч багш нарыг бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлбэл зохино. Бусдыг хүний эрхийн сургагч болгон бэлтгэх нь Хүний эрхийн үндэсний байгууллагууд өөрсдийн хязгаарлагдмал нөөц бололцоог дээд зэргийн үр ашигтайгаар зохицуулах хамгийн үр дүнтэй арга юм. Өөрөөр хэлбэл Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн боловсролыг хүн бүрт шууд хүргэх боломжгүй бөгөөд харин хүний эрхийн талаарх мэдээлэл, харилцааг дэмжвэл зохино. Иймд бусдыг уг зүйлийг хэрэгжүүлэх боломжтой болгох нь хүний эрхийн боловсролыг өргөжүүлэх хамгийн үр дүнтэй, зохистой хэлбэр юм. Ийнхүү бусдыг хүний эрхийн төлөө үйлдэх, сургагч багш болгон бэлтгэх явдал нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны нэгэн бүрдэл хэсэг болно. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын зүгээс зохион байгуулсан, дэмжигдсэн Хүний эрхийн боловсролын хөтөлбөр нь дараах 3 үндсэн шаардлага буюу стратегиудыг баримталбал зохино.

- Төлөвлөгөө, стратеги, зохих нөөц бүхий хүний эрхийн боловсролын хөтөлбөр
- Чадварлаг хүний эрхийн сургагч багш нар
- Зохистой нөөц

2.1. Төлөвлөгөө, стратеги, зохих нөөц бүхий хүний эрхийн боловсролын хөтөлбөр

Амжилттай хүний эрхийн боловсролын хөтөлбөр нь хувь хүмүүсийн мэдлэгийг үйл ажиллагаа болгон хувиргадаг. Уг зорилгыг хангахын тулд тухайн хөтөлбөр нь зохих, стратегитай, хамтын зарчмаар хэрэгжих замаар өөрийн дотоод нөөц бололцоог ашигладаг байвал зохино.⁵⁸ Аливаа хүний эрхийн үндэсний байгууллагууд нь тухайн орны хүний эрхийн боловсролын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц санхүүгийн нөөцтэй байх боломжгүй байж болно. Иймд хүний эрхийн боловсролын хөтөлбөр нь тэргүүлэх чиглэлүүдийг сонгон тодорхойлох, бусад байгууллагуудтай түншлэх, мөн бусдыг хүний эрхийн сургагч болгон сэдэлжүүлэх зэрэг чиглэлийг баримталбал зохино. Сайн хүний эрхийн боловсролын хөтөлбөр нь дараах үндсэн шинжүүдийг өөртөө агуулбал зохино. Үүнд:

- тэргүүлэх чиглэлд багтсан, судлагдсан, үнэлэгдсэн хүний эрхийн асуудлуудад чиглэх
- Хүний эрхийн үндэсний байгууллагуудын стратегийн төлөвлөлт, тэргүүлэх чиглэлд чухал хувь нэмэр оруулж чадах, шийдвэрлэх үр нөлөө гаргахуйц асуудлыг сонгох
- Албан болон албан бус боловсролын аль аль тогтолцоонд анхаарлаа хандуулах
- хүний эрхийн сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн нь сонсогчдод зориулагдсан, сайтар судлагдсан, мөн зохих байдлаар хянан магадлагдсан байх
- Албан болон албан бус боловсролын арга зүй, хэрэглэгдэхүүнд дотоод хяналт, зөвлөгөө хийх
- Хүний эрхийн үндэсний хөтөлбөр, хүний эрхийн боловсролын үндэсний хөтөлбөр боловсруулах зэргээр албан болон албан бус түншлэлийн хүрээнд хамтран ажиллах
- Эрх эдлэгч, үүрэг хүлээгч, нөлөөлөгчид нарт чиглэх
- Иж бүрэн хяналт, шинжилгээ үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх⁵⁹ зэрэг болно.

⁵⁸ Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010; хуудас. 55.

⁵⁹ Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл нь сургалтын хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэх аргачлал боловсруулсан байна. Энэ талаар Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үр дүнг үнэлэх нь; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2005 он хуудас. 35–38-ийг үзнэ үү.

2.2 Чадварлаг хүний эрхийн сургагч багш нар

Хүний эрхийн сургагч багшийн үүрэг бол судалж буй асуудлыг төөрөгдөлд оруулж, суралцагч хүмүүсийг сорилтод бэлтгэх байдал юм.

Мао Зэдун

НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглалыг батлах үеэр хүний эрхийн сургагч нарыг олон улсын хэмжээнд нийцүүлэн стандартчлах шаардлагатай эсэх талаар өргөн хэлэлцүүлэг өрнөсөн байна. Олон тооны байгууллагууд хүний эрхийн сургагч нарын баримтлах чадамжийн тогтолцоог санал болгож байв. Чадамжийн тогтолцоог зааварчилга болгох зорилгоор дор хавсаргав. Үүнд төслийн удирдлага, үр дүнг хэрэгжүүлэх, манлайлал, шүүмжлэлт сэтгэлгээ, мэдээлэл, харилцааны технологи, хувийн менежмент, харилцааны менежмент зэрэг ерөнхий чадамжуудыг оруулаагүй болохыг анхаарна уу.

Мэдлэгийн чадамжууд	Хүний эрхийн мэдлэгийн хувьд: - хүний эрхийг хангах, хамгаалах ерөнхий ойлголт - хүний эрхийн талаарх олон улсын, үндэсний тогтолцоо, хууль тогтоомж - хүний эрхэд суурилсан хандлагууд⁶⁰ - эрх эдлэгч, үүрэг хүлээгч, нөлөө үзүүлэгчдэд хамаарах хүний эрх - хүний эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдох нийгмийн чиг үүрэг Боловсрол сургалтын хувьд: - боловсролын ерөнхий онол, зарчмууд, тухайлан хүний эрхийн боловсролын боловсролд холбогдох бүх насныханд, албан ба албан бус тогтолцоонд хамаарах сургалтын арга зүй, хэрэглэгдэхүүн,
Техникийн болон мэргэжлийн практик чадамжууд	- хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх - албан ба албан бус боловсролын тогтолцооны тухайн нөхцөлд тохирсон хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх - олон талт хүний эрхийн боловсролын арга зүй, хэрэглэгдэхүүнийг тухайлбал сургалт зохион байгуулах, чиглүүлэх, мэдээлэл түгээх, хүний эрхийн нөлөөллийн ажил зохион байгуулах, олон нийтийг чадваржуулах гэх мэт - олон талт бүлгүүд, хамт олонтой ажиллах
Хувийн чадамжууд	- мэргэжлийн практик чадвараа хөгжүүлэх, эргэн харах - хувийн ялгаатай байдал, онцлогоо ялган таних, бусдад үзүүлэх нөлөөллийг үнэлэх - олон улсын болон орон нутгийн хэмжээнд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих байдлыг урамшуулах

2.3. Хүний эрхийн боловсролын зохих нөөц

Хүний эрхийн үндэсний байгууллагууд хүний эрхийн боловсрол олгоход тавигдах гурав дахь үндсэн шаардлага бол зохих нөөцтэй байх явдал юм. Хамгийн чухал нөөц бол хүний нөөц буюу хүний эрхийн сургагч, багш нар юм. Хүний эрхийн үндэсний байгууллага бүр өөрийн хуулиар тогтоосон эрх хэмжээгээ хангахын тулд зохих ёсны санхүүгийн болон хүний нөөцтэй байх үүрэг хүлээнэ. Ази-Номхон далайн бүс нутаг дахь олонх хүний эрхийн үндэсний байгууллагууд нь хүний эрхийн боловсролын чадварлаг баг, мэргэжилтнүүдтэй байдаг. Мөн зарим байгууллагууд нь хяналт шалгалт хийх, гомдол шийдвэрлэх, бодлогын шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагааны бусад чиглэлүүдэд боловсролын чадамжийн түвшнийг нэмэгдүүлэхэд анхаардаг.

Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь боловсрол, сургалтын зорилгоор тодорхой материалууд боловсруулдаг. Энэ төрлийн материалын агуулга, чанар, хэрэглээ нь тухайн сургалтын зорилго, чиглэлээс хамаарч олон янз байдаг. Үүнээс сургалтын үндсэн материалууд нь дараах шинжийг агуулсан байна.

- Хүний эрхийн үндэсний байгууллагуудын тухай, түүний үйл ажиллагаа, харилцааны талаарх ерөнхий мэдээлэл

⁶⁰ “Хүний эрхэд суурилсан хандлага” –г 45 дахь хуудсанд тайлбарласныг үзнэ үү.

- хүний эрхийн зарчмуудын тухай ерөнхий мэдээлэл
- тодорхой хүний эрх, тодорхой бүлгүүдэд чиглэсэн зорилтот мэдээлэл
- хүний эрхийн үндэсний байгууллагуудын зарим үйл ажиллагаа, тухайлбал боловсрол, нөлөөлөл, тайлагналт зэргийн талаарх хэвлэл, ном
- хэвлэгдэн нийтлэгдсэн судалгаа, хяналт шалгалт, дүн шинжилгээний үр дүн бүхий нөөц хэрэглэгдэхүүн
- мэдээллийн хуудас, цахим хуудас, нийгмийн харилцааны хэрэгслүүд зэрэг тодорхой сэдэв, агуулгад холбогдох байнгын болон шинэчилсэн мэдээлэл
- хүний эрхийн боловсролын загвар хөтөлбөр, хүний эрхийн сургалтын гарын авлагууд зэрэг болно. Эдгээрээс гадна захиргааны, мэдээлэл харилцааны, технологийн, тоног төхөөрөмжийн зэрэг нөөцийн бусад хэлбэрүүдийг харгалзан үзэх шаардлагатай.

3. АЗИ–НОМХОН ДАЛАЙН БҮС НУТГИЙН ЗАРИМ ЖИШЭЭ

Ази–Номхон далайн бүс нутаг дахь зарим хүний эрхийн үндэсний байгууллагуудын хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдээс жишээ болгон танилцуулж байна.

3.1. Австрали Улсын Хүний эрхийн Комисс⁶¹

Австралийн Хүний эрхийн комиссын олон нийттэй харилцах болон хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүд нь гэр бүл, сургууль, ажлын байр, олон нийтийн дунд хүний эрхийг хүндэтгэх, мэдлэг ойлголтыг бүрдүүлэхэд чиглэдэг. Австралийн Засгийн газрын Хүний эрхийн баримт бичигт заасны дагуу, Комисс нь ойрын дөрвөн жилийн хугацаанд (2010–2014) олон нийттэй харилцах болон сургалтын үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоор санхүүжилт авсан байна. Энэ нь:

- Боловсролын үндэсний шинэ хөтөлбөрийг боловсруулах явцад сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг нэгтгэхийг дэмжих. Энэ хүрээнд багш, сурагчдад хүний эрхийн мэдээлэл өгөх rightsED сургалтын материал боловсруулж, хангасан байна.
- Хүний эрхийн асуудлуудаар Австралийн олон нийтийг оролцуулах, тодорхой үйл ажиллагааг өрнүүлэхэд нийгмийн харилцааны хэрэгслүүдийг ашиглах⁶²
- Хүний эрхийн зарчмуудыг бизнес болон үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ялангуяа өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болгох талаар ажиллах
- Ажил олгогчид хуулиар хүлээсэн үүргээ ойлгон хэрэгжүүлэх, ялгаварлан гадуурхалтгүй ажлын байр бүрдүүлэх стратегийг нэвтрүүлэх талаар ажиллах
- Тэгш хамруулсан, аюулгүй, шударга спортыг дэмждэг үндэсний хэмжээний “Дүрмийн дагуу тоглохуй” хөтөлбөрийг дэмжих

3.2. Филиппин Улсын Хүний эрхийн Комисс⁶³

Өөр бусад байгууллагуудын анхааралд байсан хүний эрхийн анхаарал татсан асуудал, сорилтуудын талаар овог бүлгийнхээ дотоодод итгэлтэй ярих боломжтой болсон. (Хигаонон, Филиппин улс)

Филиппин улсын Хүний эрхийн комиссын эрхэм зорилго нь «албан ба албан бус боловсрол, олон нийтийн дунд салбар–дундын, өргөн агуулга бүхий, тогтвортой үргэлжлэх хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэх замаар хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх» хэмээн тодорхойлсон байдаг.

⁶¹ Дэлгэрэнгүй мэдээллийг www.humanrights.gov.au/human-rightseducation-and-community-engagement хуудсаас танилцана уу

⁶² Тус Комиссын нийгмийн харилцааны санаачлагуудын тухай www.tellmesomethingidontknow.gov.au болон www.somethingincommon.gov.au хуудсаас танилцана уу.

⁶³ Филиппин улсын Хүний эрхийн боловсролын арван жилийн төлөвлөгөө: 1998–2007 Салбарын нэгдсэн мэдээлэл; Филиппиний Хүний эрхийн комисс, Дэлгэрэнгүй мэдээллийг www.chr.gov.ph хуудсаас танилцана уу.

3.3. Индонез Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (Комнас НАМ)⁶⁴

Комнас НАМ нь боловсрол, мэдээллийн чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх хэмжээ, үүргийг тодорхойлж өгсөн байдаг. Үүнд:

- Индонезийн иргэд, олон нийтэд хүний эрхийн зарчим, бусад мэдээллийг түгээн дэлгэрүүлэх
- Албан ба албан бус боловсролын тогтолцоо, бусад боломжит хэлбэрээр хүний эрхийн тухай олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх
- Хүний эрхийн салбар дахь үндэсний, бүс нутгийн, олон улсын байгууллагууд, бусад оролцогч талуудтай хамтран ажиллах

3.4 Йордан Улсын Хүний эрхийн үндэсний төв⁶⁵

Йорданы Хүний эрхийн үндэсний төвийн 2010–2012 оны Стратеги төлөвлөгөөнд “мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх хөтөлбөр, боловсрол, сургалт, мэдээлэл харилцаагаар дамжуулан хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах зорилготой” хэмээн заасан байдаг. Энэ нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

- хүний эрхийн боловсролыг аль болох өргөн хүрээнд түгээн дэлгэрүүлэх
- хүний эрхийн салбар дахь сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлэх, хөхиүлэн дэмжих
- төрийн алба, төрийн албан хаагчдын дунд гомдол шийдвэрлэх дотоодын механизмыг дэмжих
- хүний эрхийн боловсролыг албан ба албан бус боловсрол, мөн их сургуулийн боловсролын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх
- хүний эрхийн боловсролын сургалтын материалыг боловсруулах, хөгжүүлэх
- ойлголт нэмэгдүүлэх болон боловсролын кампанит ажлуудыг идэвхижүүлэх



Йордан улсын Мафракийн ойролцоох газарт хүүхдүүд хичээллэж байна. НҮБ: Фото зургийг Марк Гартен,

⁶⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг www.komnasham.go.id

⁶⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг www.nchr.org.jo/english/AboutUs/StrategicPlan/StrategicPlan20102012.aspx

3.5. Энэтхэг Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

Энэтхэгийн Хүний эрхийн үндэсний комисс нь нийгмийн хэсэг бүрт хамаарах хүний эрхийн асуудлаар иргэдийг мэдээллээр хангах, хүний эрхийн анхан шатны ойлголтыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий сургалтын хэлтэстэй. Хэлтсийн чиг үүрэг нь голлон олон нийтэд чиглэх боловч аль болох бүх нийтийн хүний эрхийг хамгаалах зорилгоо биелүүлэх, мөн хүний эрхийн асуудлаар нийгмийн ойлголт хандлагыг бүрдүүлэх зорилгоор сургууль, коллеж, их сургуулиуд дахь сурагч, оюутнуудад хүрч ажиллахаар чармайдаг.

Комиссын хувьд цагдаагийн алба хаагчдын зан үйл, хандлагаас шалтгаалсан олон тооны өргөдөл, гомдол хүлээн авдаг тул цагдаа нарт чиглэсэн хүний эрхийн боловсролын хөтөлбөр томоохон байр суурь эзэлдэг. Мөн шүүх, хорих байгууллагын ажилтнууд, төрийн албан хаагчид, эмч, сувилагч болон уламжлалт эмчилгээний мэргэжилтнүүд, цэргийн албан хаагчид, гэрээт цэргүүд, багш, захирал, боловсролын мэргэжилтнүүд зэрэг нийтийн албаныханд хүний эрхийн мэдлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Энэ хөтөлбөрт мөн хэвлэл мэдээллийн ажилтнууд болон хүний эрхийг хамгаалагчид хамрагддаг байна.⁶⁶

3.6. БНСУ-ын Хүний эрхийн Үндэсний Комисс⁶⁷

БНСУ-ын Хүний эрхийн үндэсний комисс нь мөн хүний эрхийн тухай олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх хүний эрхийн боловсрол, сургалт зохион байгуулах эрх хэмжээтэй. Комисс нь:

- Бага, дунд, их сургууль болон бусад боловсролын хөтөлбөрт хүний эрхийн зарчмуудыг нэгтгэн хэрэгжүүлэх талаар санаачлан ажиллах
- Төрийн албаны шалгалт зэрэг сонгон шалгаруулалт, үнэлгээнд хүний эрхийг чухал шалгуур болгох талаар үйл ажиллагаа санаачлан хэрэгжүүлэх
- Соёлын бүтээл, ном хэвлэлээр дамжуулан нийгэмд хүний эрхийн соёл бүрдүүлэх
- Хүний эрхийн тухай мэдээллээр хангах хүний эрхийн номын сан ажиллуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.

Комисс мөн дараах үйл ажиллагааг санал болгодог. Үүнд:

- Прокурор, хорих байгууллага, цагдаагийн албан хаагчдад хүний эрхийн боловсрол олгох
- Хүний эрхийн судалгааны сургууль, төвийг ажиллуулах
- Хүний эрхийн боловсролын төвийг ажиллуулах
- Хүний эрхийн тухай кино, хүүхэлдэйн киног боловсруулах, түгээх зэрэг болно.

3.7. Шинэ Зеланд Улсын Хүний эрхийн Комисс

Шинэ Зеландын Хүний эрхийн Комисс өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хүний эрхийн боловсрол чухал үүрэг гүйцэтгэнэ хэмээн тодорхойлсон байна. Үүнд:

- Хүний эрхийг хүндэтгэх, сахин хамгаалах, олон нийтэд чиглэсэн мөн сургалт боловсролоор дамжуулан хүний эрхийг тууштай хамгаалагч байх,
- Вайтангийн гэрээний хүний эрхийн үзэл санаа болон олон улсын ба үндэсний хүний эрхийн хуульд нийцсэн хүний эрхийн тухай ойлголтыг судалгаа, сургалт, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хөхиүлэн дэмжинэ хэмээн тодорхойлжээ.

Комисс нь үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдээ хэрэгжүүлэхдээ баримтлах гурван үндсэн хандлагын нэг нь олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа байна. (уг үйл ажиллагааны гол хандлага нь хүний эрхийн боловсрол байна).⁶⁸

⁶⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг www.nhrc.nic.in/Documents/TrgGuidelinesdated17Dec2012.pdf

⁶⁷ Дэлгэрэнгүй мэдээллийг www.humanrights.go.kr/english/activities/education01.jsp

⁶⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг www.hrc.co.nz/human-rights-environment/human-rights-education



Шинэ Зеландын Хүний эрхийн үндэсний комиссын Те Хуйа Билл Хамилтон, Сама Дилаут омгийн ахлагч Панлима Бухали Булака Ажилани нар Маори Хонги хэмээх уламжлалт хэлбэрээр (хамраа нийлүүлэн) мэндчилж байгаа нь: Фото зургийг Жилл Крисп,

3.8. APF – Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган⁶⁹

Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын чуулган сургагч багш нарыг сургах тусгайлсан сургалтыг 2012 онд анх удаа, улмаар 2013 онд дахин зохион байгуулсан. Үүний үр дүнд тус бүс нутгийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын ажилтнууд хүний эрхийн сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үндсэн мэдлэг, чадвартай болж бэлтгэгдсэн байна. Уг хөтөлбөр нь цахим сургалт болон танхимд хамтран суралцахуйг хослуулсан “зорилтот–суралцахуй” хэлбэрээр зохион байгуулагддаг. Хөтөлбөрт оролцогчдыг АНДБХНЭҮБЧ–ы ахлах сургагч багш нараас шавилан суралцах “Мастер сургагч багш”–ийн хөтөлбөрт үргэлжлүүлэн хамруулах, дараа зохион байгуулагдах АНДБХНЭҮБЧ–ы сургалтуудад сургагчаар ажиллуулах зэргээр чадавхийг нь бэхжүүлдэг байна.

⁶⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг: www.asiapacificforum.net/support/training/training-of-trainers

ГУРАВДУГААР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийн Үйл ажиллагааны хөтөлбөр, Парисын зарчмууд зэрэгт хүний эрхийн боловсрол олгох нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн хэсэг мөн болохыг тодорхойлсон байдаг.
- Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь чанартай хүний эрхийн боловсролын хөтөлбөр олгохдоо дараах 3 шаардлагыг баримталбал зохино. Үүнд төлөвлөгөө, стратеги, зохих нөөц бүхий байх, чадварлаг сургагч багш нар байх, зохистой хүний эрхийн боловсролын нөөц хэрэглэгдэхүүнтэй байх зэрэг шаардлага орно.
- Ази–Номхон далайн бүс нутаг дахь олонх Хүний эрхийн үндэсний байгууллагууд нь үр дүнтэй, чанартай хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үр дүнг үнэлэх нь; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2005 он

Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010

Хүний эрхийн үндэсний байгууллагууд Гарын авлага; АНДХЭҮБЧ; 2013



Хоёрдугаар хэсэг
Хүний эрхийн боловсролын онол,
зарчим, хандлагууд



Бүлэг 4: Хүний эрхийн боловсролын онол, зарчмууд

Бүлэг 5: Хүний эрхийн боловсролын хандлага

БҮЛЭГ 4:

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ОНОЛ, ЗАРЧМУУД

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД

- Хүний эрхийн боловсрол нь хэрхэн гэгээрүүлж, өөрчлөн хөгжүүлдэг вэ?
- Хүний эрхийн боловсролын талаар онолын ямар үзэл баримтлал байдаг вэ?
- Хүний эрхийн боловсролын чиглүүлэгч үндсэн зарчмууд юу вэ?



Боловсрол нь улс төрийн үйл явц бус хэдий ч бусдыг энэрэн хайрлахуйн болон шударга, зүй ёсны нийгмийг байгуулах мэдрэмжид тулгуурлан бий болдог. Бидний хайр хэмээн томъёолж буй энэ зүйл маань хайр сэтгэлийн тухай бус харин бидний адил хүн төрөлтнүүдийн амьдралын муу нөхцөлийг ахиулан дээшлүүлэх тийм хайрын тухай ойлголт юм. Улс төр бол хүнлэг бус, шударга бус нөхцөлүүдийг ахиулан өөрчлөхийн төлөө хүмүүс хамтдаа зүтгэх хайр энэрэл юм. Энэ нь мөн хүний эрхэм зэрэг, шударга ёсны төлөө тэмцлийн зүй ёсны эрэл хайгуулын нэг хэсэг юм.⁷⁰



Энэ бүлгийн хүрээнд аливаа боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх онол арга зүй, зарчмын үндсийг хэлэлцэх болно. Боловсролын талаар олон тооны онолууд байдаг. Тэдгээр онолууд нь хүний эрхийн мэдлэг, чадвар, хандлага, зан үйлийг хөгжүүлэх замаар хувь хүний болон нийгмийн өөрчлөлтийг дэмжихэд чиглэдэг. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх ажлууд нь энэ зорилгыг хэрэгжүүлэхийг эрмэлздэг.

Энэ бүлгийн эхний хэсэгт тэгш байдал, шударга ёс, гэгээрлийн талаар сургагч багш нарын зарим байр суурийг нэгтгэн авч үзнэ.⁷¹

Бүлгийн хоёр дахь хэсэгт хүний эрхийн боловсролын зарчмын талаар авч үзсэн болно.

1. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙН ХҮРЭЭ

Боловсрол нь хүмүүсийг гэгээрүүлэх, нийгмийн идэвхитэй, хариуцлагатай гишүүн болгон төлөвшүүлдэг. Энэ зорилго нь мөн хүний эрхийн боловсролд хамааралтай. Хүний эрхийн боловсрол нь эрх чөлөө, шударга ёс, энх тайвны төлөө ажилладаг бөгөөд мөн хүний эрхийн зөрчил зэрэг сорилтуудтай тулгардаг. Түүнчлэн хүний эрхийн боловсрол нь нийгмийн бүх салбар, нэгж түвшнүүдэд эерэг өөрчлөлтийг бий болгох, хөгжүүлэхийн төлөө үйл ажиллагаагаа өрнүүлдэг.

Боловсрол нь гэгээрүүлэх болон өөрчлөгч шинжтэй хэмээн үздэг онолын үзэл баримтлалыг дор танилцуулж байна. Эдгээрийн олонх үзэл баримтлал нь 'нийтийн боловсрол' (educazgo popular)–ын хөдөлгөөнөөс үүдэлтэй бөгөөд ядуу, хүнд нөхцөлд амьдарч буй хүмүүсийн амьдрал, аж байдлыг өөрчлөхөд чиглэдэг.

⁷⁰ Фернандо Карденал, Никарагуа дахь бичиг үсэгт тайлагдалтын кампанит ажлын удирдагч, 1980


⁷¹ Энэ хэсэгт Силвиа Аштон–Варнер, Август Боал, Франз Фанон, Пауло Фрере, Мишель Фуко, Иван Иллич, Малколм Ковлес, Мариа Монтессори, А.С.Нейл нарын боловсролын онолчдын бүтээлээс дурдсан болно.

Хураагч боловсрол:⁷²

Зарим боловсролын үйл ажиллагаа нь зөвхөн мэдээлэл дамжуулах арга хэлбэрт түшиглэдэг. Ийм төрлийн боловсролд сургагч багш нь мэдлэгийг эзэмшигч гэж харагддаг. Суралцагчдын хувьд тухайн сургалтад өөрийн хувь нэмрээ оруулах мэдлэг, туршлагагүй гэж үзнэ. Хүний эрхийн боловсрол нь зөвхөн мэдээлэл дамжуулах аргыг ашиглаж буй тохиолдолд «мэдлэг хураагч боловсрол» болох эрсдэлтэй байдаг.

Дээрээс доош–Доороос дээш хандлага: “Дээрээс доош – доороос дээш хандлага” нь аливаа хувь хүн, бүлгийн зан үйлийг бусад бүлгийн хүн, бүлгийн үзэл бодолтой харьцуулж тодорхойлдог. Ялангуяа эрх мэдэлд суурилсан, шатлан захирах шинжтэй харилцааны үед нийтлэг ажиглагддаг. Дээрээс–доош чиглэх хандлага нь боловсролын байгууллагад илүү үр дүнтэй бөгөөд бүх багш нар өөрсдийн хөтөлбөртөө хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэхээр шийдвэрлэж болно. Хүмүүс хүний эрхийг өөрсдийн ойлголтоор ойлгон, зан үйл, үйл ажиллагаагаа түүнд нийцүүлэн өөрчлөн шинэчлэхийг «доороос–дээш» хандлагад тулгуурласан, үр дүнтэй хүний эрхийн боловсрол гэж үзнэ.

Зураг: 3.1: Дээрээс доош – доороос дээш хандлага



Шүүмжлэлт заах арга зүй:⁷³

Суралцагчдыг өөрсдийн нөхцөл байдлын талаар эргэцүүлэн бодож, өөрт тохиолдсон асуудал, хувийн туршлагаа өргөн хүрээнд авч үзэхэд уриалгаараа шүүмжлэлт сэтгэлгээ нь нэн чухал юм. Боловсролын бүтээлч заах арга зүй нь аливаа үзэгдэл, үйл явцын талаар гүн гүнзгий эргэцүүлэн бодохыг шаарддаг. Үүнд мөн үйл ажиллагаа зохион байгуулах асуудал орно. Энэ тохиолдолд хүний эрхийн сургагч багш нь нийтлэг асуудлыг ялган тодорхойлох, дүн шинжилгээ хийх, практик шийдлийг санал болгох үүрэг гүйцэтгэдэг.

Харилцан ярианы боловсрол: Хүмүүс хоорондоо харилцаж, бусдыг сонсож, өөрийн туршлага, үзэл бодол байр сууриа солилцож буй үед л жинхэнэ сургалт зохион байгуулагдана. Зөв зохион байгуулсан сургалтын үед хүн бүр суралцагч бас багш болно. Хүний эрхийн сургагч багш нь оролцоог хангаж, хүн бүр бусдаасаа суралцах боломжийг бүрдүүлснээр «жинхэнэ суралцахуйн хамт олон»-ыг бүрдүүлж чадна.

Хүний эрхийн боловсролын заах арга зүй:⁷⁴ Хүний эрхийн боловсрол нь тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, шударга ёсны төлөө байх бөгөөд сургагч багш нар боловсролын үйл ажиллагаандаа оролцож буй хүн бүрийн эрхэм зэргийг хүндэтгэвэл зохино. Өөрөөр хэлбэл, боловсролын агуулга, үйл явц хоёр нь хувийн ба хамтын гэгээрэл, өөрчлөлтийн үйл явц байна.

Дотогш ба гадагш харахуй:⁷⁵ Хүний эрхийн боловсрол нь оролцогчдын үүрэг оролцоо болон хувь нэмрийг чухалчлан үздэг. Гадагш болон дотогш харахуйн үзэл баримтлал нь хүний эрхийн боловсрол олгох, хөгжүүлэх үйл

⁷² Пауло Фрерийн “Дарлагдсан сурган хүмүүжүүлэх зүй” номд хэрэглэгдсэн нэр томъёо, 1968 он.

⁷³ Мөн тэнд.

⁷⁴ Сурган хүмүүжүүлэх зүй нь бүх насныханд чиглэсэн боловсролын тухай ойлголт. Гэвч үүнийг эртний Грек хэлний “хүүхэд” гэсэн үгнээс гаралтай, мөн зарим нь “насанд хүрэгчдийн сургалт” гэсэн утгатай хэмээн тайлбарлах нь бий.

⁷⁵ Жилл Крисп, “Маранга май!, Хүний эрхийн төлөө орон нутгийн хөгжил”, Австралийн шинэ орон нутаг сэтгүүлийн дугаар (Vol.9, №1), 2011 оны намар,

явцын динамикийг тайлбарлах нэгэн арга хэлбэр юм. Энэ хандлагаар оролцогчид бол “дотогш харагчид” бөгөөд тухайн сургалтын үйл явцын оролцдог. Харин тухайн сургалтад оролцохгүй байгаа хэсэг нь “гадагш харагчид” юм. Гадагш харагчид нь тухайн сургалтын үйл ажиллагаанд хууль ёсны ашиг сонирхолтой, эсвэл хөрөнгө оруулсан байж болох ч заавал тийм байх шаардлагагүй юм. Хүний эрхийн сургагчийн зорилго нь “дотогш харагчид”-ын мэдлэг, туршлагаар уг сургалтыг чиглүүлэх явдал юм. Зарим үед, тухайлбал залуучуудын бүлэгтэй ажиллаж буй залуу хүн, цагдаагийн алба хаагчдад сургалт хийж буй цагдаагийн алба хаагч буюу хүний эрхийн сургагч нь тухайн оролцогчдын хувьд “дотогш харагч” нь болдог. Харин уугуул хүмүүсийн бүлэгтэй ажиллаж буй уугуул бус бүлгийн төлөөлөгч, эмэгтэйчүүдэд сургалт хийж буй эрэгтэй сургагч багш бол тухайн оролцогчдын хувьд “гадагш харагч” нь болдог. Гэхдээ уг харилцаа нь “дотогш харагч” хандлага төлөвших чухал түлхэц болдог.

Палестины хараат бус хүний эрхийн комисс Баруун эрэг болон Газын оршин суугчдад нөхөн үржихүйн эрх болон түүнийг орон нутгийн түвшинд хэрхэн хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулав. Энэ нь 2011 оны 6 дугаар сард болсон бүс нутгийн зөвлөлгөөний үр дүнг хэрэгжүүлэх үйл ажиллагаа болсон байна. Хоёр удаагийн сургалтаар Комиссын ажилтнууд нөхөн үржихүйн эрхийн зарчим, үзэл баримтлалын талаар хэлэлцэж, Комиссын ажилд хэрхэн нийцүүлэх талаар зарим санал зөвлөмжүүд гаргажээ. Үүнд:

- НҮБ-ын Хүн амын сантай хамтарсан судалгааны төсөл хэрэгжүүлэх
- Хууль тогтоомжийн төслүүдэд нөхөн үржихүйн эрхийн үүднээс дүн шинжилгээ хийх
- Сургалтын хөтөлбөрүүдэд нөхөн үржихүйн эрхийн асуудлыг тусган нэвтрүүлэх зэрэг болно.



Мөн тус Комиссын зүгээс Палестины нутаг дэвсгэрт эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн асуудалд анхаарал хандуулах зорилготой сургалтыг зохион байгуулжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.asiapacificforum.net/news/palestine-building-awareness-of-reproductive-rights

Илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах цахим хуудсаар танилцана уу.

www.asiapacificforum.net/news/australia-videosshowcase-achievements-of-people-with-disabilities.

Оролцооны хандлага: Сургалтын үйл явцыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд оролцогч, дэмжигчдийн хувь нэмрийг оруулах нь хүний эрхийн боловсрол дахь оролцооны хандлага юм. Үүний үр дүнд дараах үр дүнд хүрнэ.

- Бүлгийн, байгууллагын чадавхийг бэхжүүлнэ.
- Үр ашигтай, сайн хөтөлбөрүүд боловсрогдоно.
- Мэдээлэл, чадвар, туршлагыг солилцох замаар хоёр тал харилцан суралцана.
- Хүний эрхийн асуудлуудын талаарх ойлголт, мэдлэг нэмэгдэнэ.
- Хөтөлбөр, үйл ажиллагаанд өргөн дэмжлэг үзүүлнэ.
- Мэдлэг, туршлагын давуу талыг харуулна.
- Асуудлын зөрчилт талыг ялган харуулах бөгөөд хамтын зөвшилцөлд хүрэх, өөр өнцгөөс асуудалд хандах зэрэгт туслана.⁷⁶

Практик: Аливаа үйл ажиллагааг эргэцүүлэх болон дахин нягтлах нь үр дүнтэй байдаг. Практик нь зөвхөн үйлдэхүй бус, харин түүний талаарх сэтгэхүйг мөн өөртөө агуулдаг. Мөн нөгөө талаас зөвхөн сэтгэхүй бус түүний үндсэн дээрх үйлдэхүй юм.

⁷⁶ Никки Слокум, “Оролцооны аргын хэрэглэгдэхүүн Сургагчийн гарын авлага” Бадуйн хааны сан, НҮБ-ын их сургуулийн хамтарсан бүтээл, 2003 он, бүтээлээс өөрчлөн оруулав.

Хамааралтай байх: Хүмүүс өөрт хүчтэй нөлөөлж буй зүйлсийн талаар анхаардаг. Хэрвээ сэтгэл хөдлөл болон үйлдлийн сэдэл хоёрын хооронд шууд холбоо байгаа бол тухайн сургалт нь оролцогчдын хувьд ихээхэн чухалд тооцогдоно. Тиймээс хүний эрхийн сургагч нь сургалтаа оролцогчдод илүү хамааралтай болгохын тулд уг асуудлын талаар суралцах шаардлагатай.

Бүтцийн шинжилгээ: Энэ хандлага нь хүний эрхийн нөхцөл байдлыг эерэгээр өөрчлөхийн тулд тухайн нийгэм дэх бүтцийн болон хүчний харилцааг шинжлэхийг чухалчилдаг.

Өөрчлөгч боловсрол: “Хураагч боловсрол”-ын эсрэг ойлголт бөгөөд оролцогч хүмүүсийн болоод олон нийт, орчин, нийгмийн өөрчлөн хувиргахыг эрмэлздэг. Хүний эрхийн сургагч нь хүн бүр өөрчлөлтийг хэрэгжүүлэх чадвар, хүсэл зоригтой болоход анхаардаг. Өөрчлөгч боловсрол нь мөн гэгээрүүлэх чиг үүрэгтэй.

2. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН АРГА ЗҮЙН ПРАКТИК ЗАРЧМУУД

Хүний эрхийн боловсролын зарчмууд нь тухайн сургалт албан ба албан бус салбарт хамаатай эсэхээс үл хамааран бүх түвшинд хэрэгжинэ. Хэдийгээр тусгай нөхцөл бүр нөлөөлөх хэдий ч сургагч нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагаандаа дараах зарчмуудыг удирдлага болгоно.

2.1. Хүний эрхийн боловсролын зургаан зарчим

Уг гарын авлагад дурдан буй хүний эрхийн боловсролын 6 зарчмыг Ази–Номхон далайн бүс нутгийн ХЭҮБ–уудын хүний эрхийн сургагч, боловсролын онолчдын оролцоотойгоор тодорхойлсон болно.

Зураг 4.2: Хүний эрхийн боловсролын 6 зарчим



Зарчим 1: Оролцогчдод хамааралтай байх

Хүний эрхийн боловсрол нь оролцогч төвтэй, тэдэнд хамааралтай байна. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь ямар нэгэн тусгаарлагдмал зүйл биш бөгөөд танхимд болон интернетэд суурилсан эсэхээс үл хамааран тодорхой орчин, цаг хугацаанд болдог. Оролцогчдын хувьд өөрсдийн үзэл бодол, хандлага, туршлага, суралцахдаа эрхэмлэх арга, мэдлэгийн түвшин зэрэг нь нөлөөлдөг. Мөн сургалтад хамааралтай бүтэц, харилцаа зэрэг нөлөөлдөг. “Оролцогчдод хамааралтай байх” зарчим нь Хүний эрхийн сургагч нь оролцогчид хэн болох, ямар нөхцөлд амьдардаг, хүний эрхийн ямар асуудлуудтай тулгардаг, хэрхэн суралцдаг зэргийн талаар ойлголттой байвал зохино. Хүний эрхийн сургагч нь түүний сургалт оролцогчдод хамааралтай, утга учиртай байхын тулд дасан зохицогч, мөн шинэчлэгч байх шаардлагатай.

Зарчим 2: Хамтрах

Хүний эрхийн боловсрол нь түншлэл, хамтын ажиллагаанд суурилна. Хүний эрхийн боловсролыг оролцогчдод хамааралтай, тэдэнд үр дүнтэй болгохын тулд сургагчийн зүгээс бусдын мэдлэг, харилцаа холбоог ашиглана. Иймд оролцогчид бол түншлэгчид, хамтрагчид юм. Хамтын ажиллагаа нь зарим тохиолдолд хамтын ажиллагааны гэрээгээр, тухайлбал ХЭҮБ болон цагдаагийн байгууллага хамтран хүний эрхийн сургалт зохион байгуулах зэргээр хэрэгжинэ. Гэвч олонх тохиолдолд сургагч, ХЭҮБ болон бусад туршлага бүхий оролцогчдын хоорондын албан бус холбоон дээр явагдана. “Хамтрах” зарчим нь Хүний эрхийн сургагчийн зүгээс оролцогчдыг түнш, хамтрагчаар сонгон, идэвхижүүлэхийг шаарддаг.

Индра Гандийн нэрэмжит Үндэсний нээлттэй их сургууль **Энэтхэгийн Хүний эрхийн Үндэсний Комисс**–той хамтран цагдаагийн алба хаагчдад хүний эрхийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулав. 2009 оны 12 дугаар сард уг их сургууль болон Комиссын хооронд Хамтран ажиллах санамж бичиг байгуулж, туслах байцаагчдын анхан шатны, дунд түвшний офицеруудын ахисан түвшний, мөн сургагч багш нар бэлтгэх хэмээх гурван түвшний хөтөлбөр боловсруулжээ. Сургалт нь зайны буюу цахим сургалт, түүний дараа оролцоо бүхий сургалтын хэлбэрээр боловсруулагджээ. Нээлттэй их сургуулийн хувьд оролцооны үндсэн дээр өөрөө бие даан суралцах агуулга, техникийн тусламж үзүүлэх төв бүхий хүний эрхийн сургалтын цахим орчинг хөгжүүлжээ. Комиссын хувьд багц сургалтыг боловсруулах, хэвлүүлэх, аудио болон видео материалыг боловсруулах зэргээр нөөцөөр хангах ба дэмжлэг үзүүлж байна.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах цахим хуудсаар танилцана уу.

www.asiapacificforum.net/news/india-nhrc-to-launch-human-rights-training-for-police.html



Зарчим 3: Оролцоог хангах

Хүний эрхийн боловсрол нь хүмүүс боловсролын үйл ажиллагаанд бүрэн оролцохыг дэмжинэ. Оролцогчдын эрхэмлэх зүйлс, үзэл бодол, асуулт зэрэг нь үнэлэгдэж, суралцахуйн үйл явцад хувь нэмрээ оруулж буй бол тэр жинхэнэ боловсрол юм. Хүний эрхийн сургагч нь оролцогчдод хүндэтгэлтэй хандан, өөрийн хувийн шинжээ харуулахыг дэмжинэ. Боловсрол дахь оролцоог хангах хандлага нь дараах шинжүүдтэй байна.

- Оролцогчид өөрсдийн туршлагаа хуваалцахын хирээр мэдлэг нь хөгжил, хөдөлгөөнд оршиж, байнга өсөн тэлэх
- Суралцахуйн үйл явцад хүмүүс идэвхитэй оролцох
- Хүмүүс өөрсдийнхөө тухай суралцах
- Сургагч нь мэдлэг түгээгч бус харин чиглүүлэгч байх
- Хоёр талын идэвхитэй харилцаанд суурилсан байх
- Давтах байдлаар мэдлэгийг цээжлэх бус харилцан үйлдлийн явцад суралцах
- Баримт мэдээллээс илүүтэй задлан шинжлэх, дүгнэх, хэрэгжүүлэх үйлд анхаарах⁷⁷ зэрэг болно.

Оролцоог хангах зарчим нь оролцогчдыг хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд бүрэн, идэвхитэй оролцуулах шаардлагыг сургагч багшид тавьдаг.

Зарчим 4: Магадлах

Хүний эрхийн боловсрол нь мэдлэг, туршлагыг улам хөгжүүлэн гүнзгийрүүлдэг.

Хүний эрхийн боловсрол нь оролцогчдын ойлголт, туршлагыг нээн илрүүлж, харилцан солилцдог. Оролцогчдын хувьд ч өөрийн мэдлэг туршлагаа ярих, юмс яагаад тийм байгаа талаар өөрийн харьцуулалтыг хийдэг. “Магадлах зарчим” нь оролцогчдыг хүний эрхийн асуудлыг гүнзгийрүүлэн судлуулахад чиглэсэн үйл ажиллагаа, арга хэрэглэгдэхүүнийг ашиглахыг сургагч багшаас шаардана.

Зарчим 5: Ухаалаг үйлийн зарчим

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн талаар эргэцүүлэн бодож, ухамсарлан үйлдэхийг эрхэмлэнэ. Хүний эрхийн боловсрол нь үйлдэхүй ба эргэцүүлэхүйг хамтад нь агуулдаг. Мөн шүүмжлэлт сэтгэлгээ ба асуудал шийдвэрлэхийг хамтад нь авч үздэг. Тухайлбал, оролцогчид өөрсдийн хийж буй зүйлээ эргэцүүлэн, шүүмжлэн харах нь сургалтын нэг үр дүн гэсэн үг. Бүтээлч эргэцүүлэл нь түүнээс урган гарах үр дагаврын талаарх шүүмжлэлт тусгал болж чадсан тохиолдолд илүү үр дүнтэй үйлдэхүй болно. Аливаа үйлдэл үгүй эргэцүүлэл нь хоосон үг болно. Харин эргэцүүлэл үгүй үйлдэл нь үр дүнгүй ажил болно.⁷⁸

Зураг 4.3: Ухаалаг үйл



“Ухаалаг үйлийн зарчим” нь өөрийгөө болон оролцогчдыг юу үйлдэж, ямар үр нөлөө гаргаж буйг эргэцүүлэн бодох арга замуудыг боловсруулахыг сургагч багшаас шаардана.

⁷⁷ Хүний эрхийн боловсролын багц: Хүний эрхийн боловсролын Азийн бүсийн нөөцийн төв, 2003 он, хоёрдахь хэвлэлээс өөрчлөн оруулав. Хуудас 36.,

⁷⁸ Пауло Фрейрийн “Дарлагдсан сурган хүмүүжүүлэх зүй” номоос авав. (Уг ном 1970 онд Англи хэлээр орчуулагджээ)

Зарчим 6: Гэгээрүүлэх зарчим

Хүний эрхийн боловсрол нь тэгш байдал, оролцоо болон ялгаварлан гадуурхахгүй байдлыг уриалж, энэ талаар гэгээрэл олгодог.

Хүний эрхийн боловсрол нь тэгш байдал, оролцоо болон ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг хүний эрхийн зарчмуудад тулгуурладаг. Шинэчлэгч боловсрол нь оролцогчид өөрсдийн нөхцөл байдлаа хүний эрхийн үүднээс дүн шинжилгээ хийж, хүний эрхийн тэргүүлэх асуудлыг тодорхойлж, эдгээрийг шийдвэрлэх боломжтой хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд нийцсэн стратегийг боловсруулахад эрмэлздэг. “Гэгээрүүлэх зарчим” нь тухайн боловсролын үйл ажиллагааны агуулга, үйл явц нь гэгээрэл олгох явдал болохыг хангахыг сургагч багшаас шаардана.

Гарын авлагын дараагийн бүлгүүдэд эдгээр зарчмыг практикт хэрхэн нэвтрүүлэх талаар заавар зөвлөмжийг дэлгэрүүлэн авч үзнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хүний эрхийг хамгаалахад хүний эрхийн боловсролын хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор
- Оролцогчдод хамааралтай байх
- Зохио хувь хүн, бүлгүүдийн хамтын ажиллагаа, түншлэлийг дэмжих
- Оролцогчид сургалтын үйл явцад чухал хэвь нэмэр оруулагчид болохыг, нөгөө талаас сургагч багш нь өөрөө “суралцагч” болохыг хүлээн зөвшөөрөх
- Оролцогчдын мэдлэг, туршлагыг гүнзгийрүүлэх, хөгжүүлэх
- Үнэлгээ, дүгнэлтийн явцаар дамжуулан эргэцүүлэл ба үйлдэхүйг хослуулах
- Хувь хүний болон нийгмийн гэгээрэл, шинэчлэлд анхаарвал зохино.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Жорж Андреполиус, Ричард Пиер Клауд нар, “XXI зууны Хүний эрхийн боловсрол” 1997 он номын “Хүний эрхийн боловсрол бол гэгээрэл болох нь: сурган хүмүүжүүлэх зүйн эргэцүүлэл” өгүүлэл, Зохиогч Гарет Мейнтжес,

Жорж Андреполиус, Ричард Пиер Клауд нар, “XXI зууны Хүний эрхийн боловсрол” 1997 он

Хүний эрхийн боловсролын Азийн бүсийн нөөцийн төв, Хүний эрхийн боловсролын багц: 2003 он, хоёрдахь хэвлэл

Жилл Крисп, “Маранга май!, Хүний эрхийн төлөө орон нутгийн хөгжил”, Австралийн шинэ орон нутаг сэтгүүл, дугаар (Vol.9, №1), 2011 оны намар

Никки Слокум, “Оролцооны аргын хэрэглэгдэхүүн Сургагчийн гарын авлага” Бадуйн хааны сан, НҮБ-ын их сургуулийн хамтарсан бүтээл, 2003 он,

Пауло Фрер, “Дарлагдсан сурган хүмүүжүүлэх зүй” 1968 он, (1970 онд Англи хэлээр орчуулагджээ)



БҮЛЭГ 5:

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ХАНДЛАГА

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД

- Хүний эрхийн боловсролын хамгийн зохистой хандлагыг сонгоход ХЭҮБ–ын үүрэг юу вэ?
- Зорилго, нөхцөл болон оролцогчдын олон талт байдалд нийцүүлэн хүний эрхийн боловсролыг хэрхэн төлөвлөж, хэрэгжүүлж, үнэлэх вэ?
- Хүний эрхийн боловсролын хандлагыг бэхжүүлэх ямар хүрээ байх вэ?



Боловсрол гэдэг нь бид суралцахуйгаар дамжуулан амьдралын чанараа сайжруулах үйл явц юм. Суралцахуй нь ямагт туршлагад үндэслэн явагддаг. Туршилтын үр дүнд дараах нөхцөлийг тогтоожээ.

Уншсан зүйлийнхээ 10 хувийг сурдаг.

Сонссон зүйлийнхээ 20 хувийг сурдаг.

Харсан зүйлийнхээ 30 хувийг сурдаг.

Харж, сонссон зүйлийнхээ 50 хувийг сурдаг.

Хэлэлцсэн зүйлийнхээ 70 хувийг сурдаг.

Өөрийн туршсан зүйлийнхээ 80 хувийг сурдаг.

Өөрөө бусдад заасан зүйлийнхээ 95 хувийг сурдаг.⁷⁹



Энэ бүлэгт олон талын хэрэгцээ, нөхцөл болон давуу тал болон үр дүнд нийцэхүйц хүний эрхийн боловсролын хандлагыг танилцуулна. Үүнд өмнөх бүлгийн хүрээнд ярилцаж байсан Хүний эрхэд суурилсан хандлага, “4А” хандлага болон Суралцахуйн пирамид зэрэг үндсэн гурван хандлагын үзэл санаа, зарчмыг тодорхойлж авч үзнэ.

1. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ОЛОН АРГАТ ХАНДЛАГА⁸⁰

Олон аргат хандлага нь ХЭҮБ–уудад олон төрлийн арга зүйг хэрэглэн тэдгээрт тохирсон зохистой практик нэвтрүүлэхийг дэмждэг. Энэ нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд удирдлага болохуйц боловсролын онол, арга зүй болон хүний эрхийн хэм хэмжээг хамтатган авч үзэхийг ойлгоно. Олон аргат хандлага нь ХЭҮБ–уудын бусад чиг үүрэгт тохирох бөгөөд цаг хугацааны хувьд нийцдэг. Олон аргат хандлага нь ХЭҮБ–уудын дараах чиг үүргийг хүлээн зөвшөөрдөг.

- Эрх эдлэгчдийн эрхээ шаардах чадварыг дэмжих
- Үүрэг хүлээгчдэд хүний эрхийг хүндэтгэх, хангах, хамгаалах үүргийг нь сануулах

⁷⁹ Виллиам Глассер, Дэлгэрэнгүй мэдээллийг www.wglasser.com

⁸⁰ Энэ хандлагын талаарх мэдээллийг Шинэ Зеланд Улсын Хүний эрхийн комиссын хүний эрхийн боловсролын талаарх байр суурьт үндэслэн оруулав. 2006.

Олон аргат хандлага нь Бүлэг 4-т авч үзсэн хүний эрхийн боловсролын үзэл баримтлал, зарчмыг хэрэглэдэг. Уг хандлага нь ялгаварлан гадуурхахгүй байх, оролцоог хангах, хариуцлагатай байх, гэгээрүүлэх зэрэг хүний эрхийн үндсэн зарчмуудад тулгуурладаг. Олон аргат хандлага нь хүний эрхийн боловсрол олгох дараах 6 арга хэлбэрийг авч үздэг.

1.1. Мэдээлэл дамжуулах: Хүний эрхийн мэдээллийг түгээх

Мэдээлэл дамжуулах гэдэг нь хүний эрхийн тухай мэдээллийг хувь хүн, бүлэг, олон нийтэд түгээх явдал юм. Мөн хувь хүн, бүлэг, олон нийтэд хүний эрхийн ямар асуудлуудад анхаарал хандуулах тухай мэдээллийг ХЭҮБ-д хүргэх явдлыг оруулдаг. Хүний эрхийн сургагч нь хүний эрхийн тухай мэдээллийг зорилтот бүлгийнхэнд хамгийн зохистой хэлбэрээр хүргэх, мэдээллийг түгээх “харилцаа”-ны үүргийг гүйцэтгэнэ.

1.2. Сургалт: Хүний эрхийн мэдлэг, чадварыг хуваалцах

Сургалт нь хүмүүс эрхийнхээ тухай мэдээллийг хэрэглэх, хүний эрхийн үүднээс аливаад хандах чадвартай болгоход эрмэлзэнэ. Үүний тулд сургалтын явцад хүрвэл зохих үр дүнг багцлан тодорхойлбол зохино. Хүний эрхийн сургагч нь хүний эрхэд холбогдох агуулга, чадварыг хүмүүст үр дүнтэй заан сургах, шаардлагатай арга зүй, туршлагыг дэмжих “багшийн” үүргийг гүйцэтгэнэ.

Малайз Улсын Хүний эрхийн комисс (SUHAKAM) 2009 онд хууль бусаар хил зөрчсөн болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нарт хэрхэн туслах талаар 30–50 цагаачлалын ажилтнуудад сургалт зохион байгуулжээ. Ийнхүү цагаачлалын мэргэжилтнүүд харилцан ярилцах, харилцах, зөвлөлгөө тусламж өгөх чадварт суралцсан байна. Үүний үр дүнд тухайн оронд хууль бусаар зорчсон болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүмүүсийг ялган таних чадвартай болсон гэж Малайз Улсын Хүний эрхийн комиссын дарга Тан Сри Хашми Агам хэлжээ. Тэрээр “хэрвээ Засгийн газрын зүгээс Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх 2007 оны хуульд хууль бус хил нэвтрэгчдийн асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулна гэвэл сургалт зохион байгуулах шаардлагатай” гэжээ.

Малайз Улсын Хүний эрхийн комисс нь хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг, улмаар хохирогч болсон болон болох эрсдэлтэй хүмүүсийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилго бүхий Англи, Бахаса хэл дээрх мэдээллийн хуудас боловсруулжээ. Уг мэдээллийн хуудсыг Азийн бусад хэлнээ орчуулж, Малайз ба АСЕАН-ы орнууд, элчин сайдын яамд, Засгийн газрын байгууллагууд, нисэх буудал, шүүх зэрэг газарт түгээх ёстой хэмээн Хашми мэдэгджээ.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах цахим хуудсаар танилцана уу.

www.asiapacificforum.net/news/malaysia-suhakam-totrain-officials-on-human-trafficking.html



1.3. Чиглүүлэх: Хүний эрхийн төлөө бусдын үйл ажиллагааг дэмжих, бэхжүүлэх

Чиглүүлэх гэдэг нь үйл явц болон агуулгад суурилсан байдаг. Олон аргат хандлагын хувьд “Чиглүүлэх” гэдэг нь суралцагчид хувийн ба бүлгийн гэгээрэлд тулгуурлан өөрийн болон бусдын туршлагыг үнэлэх, улмаар хүний эрхийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг дэмждэг. Иймд хүний эрхийн сургагч нь хүмүүс өөртөө болон бусдад нөлөөлж буй хүний эрхийн асуудлыг ялган таних, шийдвэрлэх арга замыг олоход нь дэмжлэг үзүүлэх “чиглүүлэгч”-ийн үүргийг гүйцэтгэнэ.

1.4. Харилцааны менежмент: Хүний эрхийг үр дүнд хүргэхийн төлөө хамтран ажиллах

Харилцааны менежмент гэдэг нь хүний эрхийн төлөө эерэг үр нөлөө үзүүлж чадах хувь хүн, бүлэг, байгууллагуудтай хүсэл зоригийн үндсэн дээр, үр дүнд суурилсан хамтын ажиллагааг бүрдүүлэх явдал юм. Уг харилцаа нь харилцан бие биедээ үр дүнтэй байх нэг болон түүнээс дээш тооны талуудын хооронд болно. Иймд сургагч багш нь эрх эдлэгч ба үүрэг хүлээгч зэрэг гол оролцогчдыг тодорхойлох, тэдэнд холбогдох хүний эрхийн асуудлыг шийдвэрлэхэд “холбогч”-ийн үүрэг гүйцэтгэнэ.

1.5. Хүний эрхийн нөлөөллийн ажил:⁸¹ Хүний эрхийн үнэ цэнэ, ач холбогдлыг дэмжих, бусдыг уриалах

Хүний эрхийн нөлөөллийн ажил нь олон хэлбэртэй бөгөөд ихэвчлэн нийгмийн шударга ёсны төлөө, мөн эмзэг бүлгийн хүмүүсийг чадавхижуулах, бүтцийн өөрчлөлт хийх явцтай таарч тохирдог. Хүний эрхийн сургагч нь эмзэг бүлгийн иргэд эрхээ хүндэтгэх, хамгаалах, хангах чадвартай болох, эрхийнхээ төлөө үйл ажиллагаа зохион байгуулахыг дэмжих “дэмжигч”-ийн үүргийг гүйцэтгэх ёстой.

Австралийн хүний эрхийн комисс 2012 оны 6 сард цахим доромжлолд өртсөн үе тэнгийнхэндээ дэмжлэг үзүүлэхийг залуучуудад уриалсан үндэсний кампанит ажлыг санаачилжээ. “BackmeUp” кампанит ажил нь цахим доромжлолд өртсөн хүмүүст чиглэсэн эерэг алхам хийхэд уриалах үндсэн зорилготой юм. Цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд гэрч чухал үүрэгтэй. Уг хэрэгт өртсөн хүмүүст туслах аяныг өрнүүлснээр тэд нийгмийн болон сэтгэцийн эрүүл мэндийн хувьд хохирохгүй байх, улмаар сургууль дахь аюулгүй байдлын мэдрэмж нь сайжрах зэрэг сайн талтай гэж Комиссын хэвлэлийн төлөөлөгч Др. Хелен Шзоке мэдэгджээ. “BackmeUp” кампанит ажил нь Эдит Кован их сургуулийн Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих судалгааны төвийн профессор Донна Кросс, Лаура Томас зэрэг тэргүүлэх эрдэмтдийн хийсэн судалгаанд тулгуурлажээ. Судалгааны үр дүнд доромжлол нь олонхи тохиолдолд гэрч болон бусдын нүдэн дээр үйлдэгдэж байсан бөгөөд тэд энэ тохиолдолд ямар ч эрх мэдэлгүй гэж өөрсдийгөө мэдэрч байжээ.

“BackmeUp” кампанит ажил нь цахим доромжлолд өртсөн хүмүүст туслахыг уриалсан видео хийх тухай өсвөр үеийнхний дунд уралдаан зохион байгуулжээ. Уг кампанит ажлыг олон тооны түншүүд дэмжин ажиллаж байна.

“BackmeUp” кампанит ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй дараах цахим хуудсаар танилцана уу. www.facebook.com/2012backmeup.



1.6. Олон нийтийн хөгжил: Хүний эрхийн төлөө олон нийтийг чадавхижуулах нь⁸²

Хүний эрхийн төлөө олон нийтийн хөгжил гэдэг нь хүний эрхэд холбогдох асуудлыг таних, хяналт шинжилгээ хийх, чухал асуудлуудаар хүний эрхийн төлөө нөлөөллийн ажил хийх зэрэгт олон нийтийг чадавхижуулах явдлыг ойлгоно. Уг ажил нь гэгээрүүлэх, оролцоог хангах, тэгш хамруулах, өөрийгөө тодорхойлох, хамтын ажиллагааг дэмжих зарчмуудад тулгуурладаг. Хүний эрхийн сургагч нь төслийн менежмент, манлайллын хөгжил, дагуулж заах, чиглүүлэх, багшлах, холбох, нөлөөлөх, мэдээлэл харилцааны зэрэг “олон чиг үүрэг”-ийг хэрэгжүүлэх шаардлагатай болно.

⁸¹ Хүний эрхийн үндэсний байгууллагууд “нөлөөлөл” гэх ойлголтыг бодлого, практикт тодорхой өөрчлөлт оруулах зорилгоор үүрэг хүлээгчдэд чиглэсэн лобби хэмээн үздэг. Энэ арга нь хүний эрхийн боловсролоор дамжуулан нөлөөлөл хийх гэсэн хандлагыг агуулсан болно. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг ФелисаТиббитсийн “Хүний эрхийн боловсролын шинэ загварууд” номноос танилцана уу. Дэлгэрэнгүй мэдээллийг www.hrea.org/index.php?doc_id=558.


⁸² “Олон нийт” хэмээх энэхүү ойлголтыг тодорхой салбарын эсхүл газарзүйн байршлаар нэгдсэн бүлэг хүмүүс, тухайлбал ажлын хамт олон, сургуулийнхан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нэг гудамж, тосгон, бүс нутгийн хүмүүс гэх байдлаар авч үзсэн. Үүнд эрх эдлэгч, үүрэг хүлээгч, нөлөөлөгчид хамтдаа багтана.

Дээр дурдсан арга бүр өөрийн арга зүй, практик зарчмуудтай бөгөөд зарим арга нь бусад аргуудтай бүхэлд нь буюу хэсэгчлэн холбогддог байна. Тухайлбал, Хүний эрхийн төлөө олон нийтийн хөгжил нь сургалт хийх, мэдээлэл дамжуулах, харилцааны менежмент хийх зэрэг сургалтын болон нөлөөллийн ажил зэрэг бүхий л аргуудыг өөртөө агуулдаг. Долдугаар бүлгийн хүрээнд эдгээр аргыг хэрэглэх явцад сургагч багшийн хүлээх үүрэг хариуцлагын талаар авч үзнэ. Олон талт аргын хандлагын үед эдгээр аргууд нь хэрэглэгдэх хүний эрхийн боловсролоос ангид байдаггүй билээ. Эдгээр аргын зарим нь ХЭҮБ-ын бусад үйл ажиллагаанд мөн хэрэглэгддэг. Тухайлбал, олон нийттэй харилцах, мэдээлэл харилцаанд “мэдээлэл хуваалцах”, “нөлөөллийн үйл ажиллагаа”-г, бодлогын шинжилгээ, эрх зүйн нөлөөлөлд “нөлөөлөл”, “чиглүүлэх”, “мэдээлэл хуваалцах” зэрэг аргыг ашиглаж болно. Мөн “харилцааны менежмент” нь энэхүү байгууллагын бүх чиг үүргийн хувьд хэрэглэгдэнэ.



Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах Цагаан туузтаны өдөр: Шинэ Зеланд, Зүүн эрэг, Фото зургийг Жилл Крисп

Зураг 5.1: Хүний эрхийн боловсролд Олон талт аргын хандлагыг хэрэглэх аргууд



Зураг 5.2: Хүний эрхийн боловсрол дахь Олон талт аргын хандлага



Хүний эрхийн боловсрол дахь Олон талт аргын хандлага нь хүний эрхийн боловсрол олгох явцдаа аливаа сургалтын аргыг тухайн зорилго, нөхцөл байдалд нийцүүлэхийг сургагч багшид уриалдаг.

Гуравдугаар хэсэгт Олон талт аргын хандлагыг практикт хэрхэн хэрэглэхийг тайлбарласан болно.

2. ОЛОН ТАЛТ АРГЫН ХАНДЛАГЫН ОНОЛЫН ХҮРЭЭ

Энэ гарын авлагад хүний эрхийн боловсрол дахь Олон талт аргын хандлагыг хэрэглэхэд удирдлага болгох онолын дараах 3 хүрээг тодорхойлж байна. Үүнд:

- “4 А” онолын хүрээ
- Хүний эрхэд суурилсан хандлага
- Суралцахуйн пирамид

2.1. “4 А” ОНОЛЫН ХҮРЭЭ

НҮБ–ын сурч боловсрох эрхийн Тусгай илтгэгч асан (1998–2004) Катарина Томашевски сурч боловсрох эрхийн хэрэгжилтийг үнэлэхдээ баримтлах дөрвөн үндсэн шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна. Хэдийгээр 4А онолын шалгуурыг сурч боловсрох эрхийн хүрээнд хэрэглэхээр бичсэн байдаг ч хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой юм.

- **Хүрэлцээтэй байх:** Хүний эрхийн боловсрол нь төрөөс зохицуулж буй албан боловсрол, мөн бусад оролцогчдын албан бус боловсролын тогтолцооны хүрээнд олгогдох, мөн чадварлаг сургагч багш нар бэлтгэгдсэн байвал зохино.
- **Хүртээмжтэй байх:** Хүний эрхийн боловсрол нь ямар нэгэн ялгаваргүйгээр бүх хүнд хүртээмжтэй байна. Ялангуяа нийгмийн эмзэг бүлгийнхнийг хамруулах зохих алхмуудыг хэрэгжүүлбэл зохино.
- **Хүлээн зөвшөөрөгдсөн байх:** Хүний эрхийн боловсролын агуулга нь чанар, соёл, үнэт зүйлсийн хувьд нийцтэй, ялгаварлан гадуурхалтгүй, сургалтын орчин аюулгүй, сургагч багш нар мэргэжсэн байвал зохино.
- **Цаг үетэйгээ зохицсон байх:** Хүний эрхийн боловсрол нь тухайн нийгмийн өөрчлөгдөн буй хэрэгцээнд нийцсэн, тэгш байдлыг тогтооход чиглэсэн, орон нутгийн өвөрмөц нөхцөл байдалд тохирсон байвал зохино.

83


2004–2005 онд хийгдсэн Шинэ Зеландын хүний эрхийн үндэсний үнэлгээгээр дамжуулан уг стандарт бүрийн шалгуурыг тодорхойлох томоохон ажил хийгдсэн хийгдсэн байна. (Зураг 5.3–ыг үзнэ үү)

4А онолын дагуу, албан боловсролын хувьд төр бол үндсэн үүрэг хүлээгч хэмээн үздэг. Гэвч бусад оролцогчдод мөн үүрэг хариуцлага хүлээлгэнэ. “Сурч боловсрох эрхийн хувьд хүүхэд нэн тэргүүний эрх эдлэх бөгөөд заавал эзэмшвэл зохих боловсролын шаардлагад нийцүүлэн хүүхдийн эцэг эх, мөн мэргэжлийн хүмүүс буюу багш нар үүрэг хүлээгчид болно” хэмээн заасан байдаг.⁸⁴ ХЭҮБ нь төр болон бусад оролцогчдыг чанартай, үр дүнтэй хүний эрхийн боловсрол олгоход нь дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Энэ нь чанартай хүний эрхийн боловсрол эзэмших эрхийг онцолдог “боловсрол дахь хүний эрх” хэмээх хандлага юм. Мөн хүний эрхийг өргөн утгаар хэрэгжүүлэхэд хүний эрхийн боловсролын ач холбогдлыг чухалчлан үздэг “боловсролоор хүний эрхийг” хэмээх хандлага байдаг. 4А онолын хүрээний анхдагч түвшин нь энгийн хялбар боловч хувиран хэрэглэгдэх боломж өндөртэй стандартыг тодорхойлдог. Хүний эрхийн сургагч нь хүний эрхийн боловсролын хөтөлбөр боловсруулахдаа түүнд тохирох арга, нөөц хэрэглэгдэхүүнийг ашиглахад хялбар болдог. Хоёрдахь түвшний шалгуур үзүүлэлт нь бүрэн цогц хүний эрхийн боловсролын хөтөлбөр боловсруулахад чиглэдэг. Саад бэрхшээлийг арилгах, чанарын шаардлагад нийцүүлэх, ялгаатай байдлыг анхаарах зэрэг бусад хувийн шалгуурууд нь үйл ажиллагааны загварчлалд мөн чухал нөлөөтэй байдаг.

⁸³ Энэ гарын авлагын зорилгод нийцүүлэн үндсэн эх сурвалжийг бага зэрэг өөрчлөн оруулав. Үндсэн эх бичвэртэй дараах холбоосоор дамжуулан танилцах боломжтой. www.right-to-education.org/node/226.

⁸⁴ Сурч боловсрох эрх Төслийн талаар дараах цахим хуудастай танилцана уу. www.right-to-education.org

Зураг 5.3: Хүний эрхийн боловсролын 4А онолын хүрээ



2.2. Хүний эрхэд суурилах хандлага

2000 оны эхэн үеэс эхлэн олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс хүний эрхэд суурилах хандлагыг боловсруулж эхэлжээ. Үүнд хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын Хүний эрхийн гэрээ конвенцид агуулагдсан хүний эрхийн нийтлэг хэм хэмжээг тусган тодорхойлох болжээ.⁸⁵ Эдгээр хэм хэмжээ нь:

- Түгээмэл бөгөөд салшгүй байх
- Хуваагдашгүй байх
- Харилцан хамааралтай, харилцан нөхцөлдсөн байх
- Тэгш эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих
- Оролцоог хангах ба тэгш хамруулах
- Гэгээрүүлэх
- Үүрэг хариуцлагатай ба эрх зүйт ёс

Олон улсын хөгжлийн баримт бичгүүдэд анх дурдаж байсан ч хүний эрхэд суурилах хандлага нь одоо ихээхэн нийтлэг хэрэглэгдэх болжээ. Хүний эрхийн боловсролд хүний эрхэд суурилах хандлагын холбогдох зургаан бүрэлдэхүүн хэсгийг дараах зургаар харуулъя.⁸⁶

⁸⁵ Хүний эрхэд суурилах хандлагын тухай “Нийтлэг ойлголтын мэдэгдэл”-ийг олон байгууллагуудын хамтарсан уулзалтын хүрээнд 2003 онд боловсруулжээ. НҮБ-ын Хүний эрхэд суурилсан хөтөлбөрийн талаар дараах цахим хуудсаас дэлгэрэнгүй танилцана уу. <http://hrbportal.org>.

⁸⁶ Энэхүү агуулгыг НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас гаргасан “Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага” 2007 он номоос оруулав.

Зураг 5.4 Хүний эрхэд суурилсан хандлагын 6 зарчим

Шийдвэр гаргалт ба хүний эрхийн стандарт Хүний эрхийн боловсролын явцад гарч буй шийдвэрүүд нь олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцсэн эсэх?	Оролцоог хангах Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд оролцогчид нь уг ажлаа төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх зэрэгт идэвхтэй, утга төгөлдөр оролцож чадсан эсэх, мөн оролцох боломжтой байсан эсэх?
Тэгш эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтыг үл тэвчих Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь: - Хүн бүр ямар нэгэн ялгаварлалгүйгээр эрхээ эдэлж чадаж байна уу? - Эмзэг бүлгийнхнийг тэргүүлэх байр суурь авч үздэг үү? - Эрх мэдлийн тэнцвэргүй харилцааг анхаардаг уу?	Гэгээрүүлэх Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь: - Хүмүүс эрхээ эдэлж, шаардаж чадсан уу? - Үйл ажиллагаандаа хариуцлагатай байсан уу? - Өөрийн болон бүлэг, олон нийтийн амьдралыг өөрчлөн сайжруулах, нөлөөлөх боломжтой байсан уу?
Үүрэг хариуцлагатай ба эрх зүйт ёс Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь үүрэг хүлээгчид үүргээ биелүүлэх, мөн эрх эдлэгчид эрхээ шаардах чадварыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн үү?	Харилцан хамааралтай, харилцан нөхцөлдсөн байх Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь: - Хувийн ба бүлгийн эрхийг адил тэгш авч үзсэн үү? - Хүн бүрийн эрхийг хүндэтгэх, зөрчигдөж буй эрхийг хамгаалахыг эрмэлзсэн үү? - Эмзэг бүлгийнхний эрхийг хамгаалахыг тэргүүлэх чиглэлээ болгодог уу?

2.3. Суралцахуйн пирамид

Суралцахуйн пирамид нь Курт Левины бүтээлд⁸⁷ дурдагдсан бөгөөд тэрээр ялгаатай байдлыг хамруулах, нээлттэй үзэл санааг дэмжсэн, идэвхижүүлэлттэй бүлгийн харилцан яриа нь суралцахуйг илүү үр дүнтэй болгодог хэмээх байр суурийг дэвшүүлж байв. Мөн лекц сонсох, гүйлгэн унших зэрэг мэдээлэл хүлээн авах аргатай харьцуулахад туршлагад үндэслэсэн суралцахуй нь зан үйлийг өөрчлөх хамгийн зохистой арга хэмээн үзжээ.

Суралцахуйн пирамид үр дүнгийн өөр түвшин бүхий долоон боловсролын үйл ажиллагааг тодорхойлсон байдаг. Уг хандлагыг боловсруулахад чиглэсэн судалгааны үр дүнд суралцахуйн явц дахь идэвхитэй оролцоо нь давтан суралцах, нэгтгэн дүгнэх зэрэг ажлыг илүү үр дүнтэй болгодог байна. Уг хандлагын хувьд хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь оролцогчдыг сургалтын үйл явцад идэвхтэй оролцуулахыг чухалчилдаг байна.

Хүний эрхийн сургагч багш нарын үйл ажиллагаанд дэмжлэг болгох үүднээс Суралцахуйн пирамидыг хүний эрхийн боловсролын дараах гурван загвартай холбог авч үзье.⁸⁸

- **Үнэт зүйлс** ба ойлголтын загвар нь хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг хуваалцах, ерөнхий ойлголт хандлагыг дээшлүүлэхэд гол ач холбогдол өгдөг. Энэ загварын голлох арга зүй нь лекц унших, мэдлэг, мэдээлэл түгээх, мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, олон нийтийн кампанит ажил өрнүүлэх зэрэг болно. иймд уг хандлага нь чадвар хөгжүүлэх, зан үйлийг өөрчлөх зэрэгт төдийлөн анхаардаггүй байна.
- **Хариуцлагын загвар** нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих болон хамгаалах үйл ажиллагаанд оролцож буй хүмүүсийн чадавхийг бэхжүүлэхэд голлон анхаардаг. Ялангуяа хүний эрхийн мэргэжилтнүүд, үүрэг


⁸⁷ Курт Левиный талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу. www.psychology.sbc.edu/Kurt%20Lewin.htm

⁸⁸ Энэ тухай Хүний эрхийн боловсролын холбооны захирал Фелиса Тиббитс боловсруулсан болно. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Хүний эрхийн боловсролын шинэ загварууд” номноос танилцах буюу дараах цахим хуудсаас авна уу www.hrea.org/index.php?doc_id=558

хүлээгчдийг чадавхижуулахад төвлөрдөг. Агуулгын хувьд хүний эрхийн эрх зүй, хамгаалалтын механизм, лобби хийх, нөлөөллийн үйл ажиллагаа зэрэг сэдвүүд байх бөгөөд шүүгч, цагдаа, цэргийн зэрэг төрийн албан хаагчид, мөн сургагч багш нар, хуульчид, эрүүл мэндийн ажилтнууд гэх мэт мэргэжлийн бүлгийнхэнд чиглэдэг.

- **Шилжилтийн загвар** нь хувь хүн, бүлгүүд хүний эрхийн зөрчлийг таньж, түүнээс урьдчилан сэргийлэх талаар гэгээрүүлэхийг зорьдог.

Зураг 5.5:–д олон нийтийн боловсролд хэрэглэгдэх “анхдагч түвшний аргууд”, мөн хувийн болон нийгмийн түвшний шинэчлэлт хийхэд чиглэсэн “дээд түвшний аргууд”–ыг үзүүлэв. Хэрвээ зорилтот бүлгийн тоо цөөн бол хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд үнэт зүйлс, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх “харах, сонсох” аргууд ихээхэн хэрэглэгддэг. Суралцахуйн пирамид нь боловсролын туршлагаа нэмэгдүүлэх, оролцоог хангах, тогтвортой байнга өөрчлөгдөн шинэчлэгдэх үр дүнд хүрэхийг хүний эрхийн сургагч нараас шаарддаг.



ТАВДУГААР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- ХЭҮБ-ууд нь тухайн сургалтын зорилго, нөхцөл байдал, оролцогчдын ялгаатай байдлаас хамааран хамгийн зохистой хүний эрхийн боловсролын хандлагыг сонгон тодорхойлох үүрэг хүлээнэ.
- Боловсрол дахь олон талт аргын хандлага нь мэдээлэл хуваалцах, сургалт, чиглүүлэх, харилцааны менежмент, хүний эрхийн төлөө нөлөөллийн ажил, олон нийтийн хөгжил хэмээх зургаан үндсэн арга зүйг агуулдаг байна.
- Олон талт аргын хандлага нь “4 А”, Хүний эрхэд суурилсан хандлага, Суралцахуйн пирамид хэмээх онолын гурван хүрээгээр тодорхойлогддог.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага: НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, 2007 он

Хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх нь: Иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан зааварчилгаа: Данийн Хүний эрхийн хүрээлэн, 2007 он

Нийгмийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх нь: Хэрэгжүүлэгчдийн сэтгүүл, Зан үйлийн хавсарга шинжлэх ухааны хүрээлэн, Үндэсний сургалтын лаборатори, www.ntl-psc.org цахим хуудаснаас үзнэ үү.

4А онолын хүрээнд суурилсан сурч боловсрох эрхийн шалгуур: Үзэл баримтлал, Gauthier de Beco Сурч боловсрох эрхийн төсөл, 2009 он, Сурч боловсрох эрхийн төслийн тухай www.right-to-education.org цахим хуудаснаас үзнэ үү.

Хүний эрхэд суурилсан хандлагын тухай НҮБ-ын Нийтлэг суралцахуйн багц:

Энэ талаар <http://hrbportal.org/archives/resource-types/learning-trainingmaterials/> цахим хуудаснаас үзнэ үү.





Гуравдугаар хэсэг

Хүний эрхийн боловсрол – Практикт



Бүлэг 6: Хүний эрхийн боловсролын төлөвлөлт ба загвар

Бүлэг 7: Хүний эрхийн боловсролыг хэрэгжүүлэх нь

Бүлэг 8: Хүний эрхийн боловсролыг үнэлэх нь

Бүлэг 9: Хэвлэл мэдээлэлтэй ажиллах нь

Бүлэг 10: Сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол

Бүлэг 11: Зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдал дахь хүний эрхийн боловсрол

Бүлэг 6:

Хүний эрхийн боловсролын төлөвлөлт ба загвар

Түлхүүр асуултууд

- Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, загварчлах гол элементүүд юу вэ?
- Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөж, загварчлахад Логик загварыг хэрхэн хэрэглэх вэ?



Хэрэв та хаашаа явж байгаагаа мэдэхгүй байгаа бол аль ч зам таныг тэнд хүргэхгүй. Өмнөхөөс илүү нь аль замаар та явж байна, яагаад гэдгийг мэдэх.⁸⁹



1. ТАНИЛЦУУЛГА

Том, жижгээс үл хамааран хүний эрхийн боловсролын бүхий л үйл ажиллагаа гурван гол үе шат болох төлөвлөлт ба загварчлал, хэрэгжилт болон үнэлгээг хамардаг. Энэ бүлгээр эхний шат болох төлөвлөлт ба загварчлалын талаар авч үзнэ. Хүний эрхийн боловсролын нэг үйл ажиллагаа үргэлж бусад үйл ажиллагаа руу хөтлөгдөж байдаг тул доорх зурагт эдгээр гурван үе шатыг эргэх холбоонд харууллаа. Энэ үйл явц болж өнгөрснөөр өмнөх үйл ажиллагааг үнэлэх ажил дараагийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх явдлыг сайжруулна. Үргэлжилсэн сайжруулалт, харилцан холбоо, үр дүнг бий болгоно.

Зураг 6.1: Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг дахь төлөвлөлт ба загвар



⁸⁹ Нөхцөл байдлын дүн шинжилгээ: Төсөл, хөтөлбөрийн талаар шинжилгээ хийх хандлага ба аргууд, Даян дэлхийн мониторинг, үнэлгээний санаачлага; Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудсаас авна уу http://cmsdata.iucn.org/downloads/approach_and_method.pdf

Хүний эрхийн боловсролыг тусгаарлагдмал нөхцөлд түгээдэггүй. Хүний эрхийн боловсролын бүх үйл ажиллагаа олон тооны, мөн заримдаа зөрчилдөөнтэй хүчин зүйлсийн нөлөөлөл дор явагддаг. Хүний эрхийн багш нь төлөвлөх, загварчлах үйл явц дахь эдгээр хүчин зүйлс болон үйл ажиллагааны үед гарч болох нөлөөллийг анхаарч байх нь чухал.


Боломжтой бол төлөвлөх, загварчлах үйл явцад оролцогчдыг хамруулж болно. Үүнийг энгийн аргаар, жишээлбэл, оролцогчдыг нэн тэргүүний хэрэгцээг тодорхойлох үнэлгээ хийхэд оролцохыг хүсч болно. Эсхүл бүрэн гүйцэд утгаар нь оролцогчдоор өөрсдийнх нь сурах арга туршлагыг төлөвлүүлэх, загварчлуулах ажлыг хийлгэж болно. Ихэнх хүний эрхийн боловсрол эдгээрийн хаа нэгтээ болж байдаг.

Зарим үйл ажиллагааны хүрээнд, тухайлбал, презентаци тавих, семинар удирдах, хэвлэл мэдээлэлд ярилцлага өгөх гэх мэтээр төлөвлөх, загварчлах үйл явц богинохон байж болно. Нөгөө талаар хөдөлгөөн өрнүүлэх, орон нутгийг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэх гэх мэтээр илүү урт ч байж болно.

2. ЛОГИК ЗАГВАР⁹⁰

Төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үнэлгээний хэрэгсэл болохын хувьд Логик загвар нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа, хөтөлбөрүүдэд хэрэгтэй хэрэгсэл болно. Энгийнээр авч үзвэл Логик загвар нь боловсролын үйл ажиллагааны элементүүдийг холбох системчилсэн ба нүдэнд харагдахуйц арга хэлбэр бүхий ерөнхий бүдүүвч юм. Энэ нь боловсролын үйл ажиллагаанаас ямар үр дүн хүлээж байгаа болон хэрхэн түүнд хүрэх тухай түүхийг бүтээдэг. Үүнд дөрвөн элемент бий: нөхцөл байдлын дүн шинжилгээ, орц, гарц ба үр дүн.

Зураг 6.2: Логик загвар



⁹⁰ Мөн "Оролцооны уялдаа" болон "Өөрчлөлтийн онол" гэж нэрлэдэг.

Логик загвар нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны гурван үе шат бүрийг чиглүүлдэг.

- **Төлөвлөлт, загварчлалын үе шатанд** Логик загвар нь ямар үйл ажиллагаа зохион байгуулах, түүний үр дүн, эх үүсвэр, цаг хугацаа ямар байхыг тодорхойлоход тусалдаг.
- **Хэрэгжилтийн үе шатанд** Логик загвар нь менежментийн төлөвлөлтөөр хангадаг. Сургагч багш нь үйл ажиллагаа өөрийн зорилгодоо хүрсэн эсэхийг хянах, хэрэв үгүй бол шаардлагатай зохицуулалтыг хийх боломжтой байдаг.
- **Үнэлэх үе шатанд** Логик загвар нь ололт амжилтаа илтгэх, мэдээллийг зохион байгуулах, тайлан бэлтгэх, төлөвлөсөн үйл ажиллагаа болон бодит үйл ажиллагааны хоорондын үл нийцлийг тодорхойлоход тусалдаг.

Логик загвар хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны олон түвшинд хэрэгжиж чадна. Үүнд: үндэсний түвшинд, орон нутгийн түвшинд, байгууллагын түвшинд, төслийн төлөвлөгөө, урт хугацааны семинар, хувийн ажлын төлөвлөгөө зэрэг орно. Гол элементүүдээ агуулахын сацуу, Логик загварыг үйл ажиллагаанд хамрагдсан хүмүүс болон боломжит эх үүсвэрийг хамгийн сайнаар ашиглах аль ч хэлбэрээр биежүүлж болдог. Жишээлбэл, Логик загварыг флипчарт дээр наадаг цаастай хамт, эсхүл компьютер дээр болон өөр бусад хэлбэрээр дүрслэн зурж болно. Гэхдээ нэгэнт бий болгосон бол үйл ажиллагааны туршид хэрэглэх боломжтой байх ёстой.

Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны төлөвлөлтийн үе шатанд хийгдсэн Логик загвар нь мөн хянах, үнэлэх арга хэрэгсэл болдог.

3. БОЛОВСРОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ЗАГВАРЧЛАХАД ЛОГИК ЗАГВАРЫГ ХЭРЭГЛЭХ НЬ⁹¹

Төлөвлөлт, загварчлалын үе шатанд Логик загвар нь хүний эрхийн үйл ажиллагаа ямар амжилтад хүрэх ёстойг, хэрхэн гүйцэтгэхийг тодорхойлоход тусалдаг. Энэ нь эх үүсвэр, оролцогчид, боломжит оролцогч талуудыг тодорхойлдог. Мөн энэ нь хяналт шинжилгээ болон үнэлгээний үйл явцад хэрэглэх арга хэрэгслийг шийдэж өгдөг.



Логик загварын **нөхцөл байдлын дүн шинжилгээ**⁹²–ний бүрэлдэхүүн хэсэг нь тодорхой хүний эрхийн асуудал, эсхүл үйл ажиллагааны нөхцлийг үнэлдэг. Холбогдох хувь хүн, бүлгүүд, нийгэмлэгүүдийн талаарх ерөнхий мэдээллийг үүгээр цуглуулдаг. Мэдээллийг хэрэгцээ, давуу тал, бэрхшээл, дэмжлэг зэргийг тодорхойлоход хэрэглэдэг. Энэ нь нөхцөл байдлын тухай мэдлэгийг бий болгодог ба үүн дээр үйл ажиллагаа хэрэгждэг. Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь доорх асуултыг тавьж болно.

Энэ нөхцөл байдалд хүний эрхийн ямар тэргүүлэх чиглэл юу вэ?	Нөхцөл байдалд нөлөөлж болох ямар гадаад хүчин зүйлс байна вэ?
Үйл ажиллагаагаар шийдвэрлэх хүний эрхийн ямар асуудлууд байна вэ?	Асуудал болон оролцогчдын хувьд хүний эрхийн ямар үйл ажиллагаа хамгийн их хамааралтай вэ?
Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд хэн хамрагдвал зохих вэ? Оролцогчид?	Оролцогч бүлгүүдийн шинж чанарууд юу вэ? Тэдний үүрэг роль, туршлага, урьдын мэдлэг, учирч болох бэрхшээл, хувь нэмэр.
Оролцогч бүлгийн хүлээлт, хэрэгцээ, давуу тал нь юу вэ?	Оролцогч бүлгийн хүлээлт, хэрэгцээ, давуу тал нь юу вэ?

⁹¹ Логик загварын шалгах хуудас нь Хавсралт 4 дээр бий. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, загварчлахад Логик загварыг хэрэглэх үед анхаарах асуудлын жагсаалт юм.


⁹² Үүнийг мөн “судалгаа тооцоо”, “хэрэгцээний үнэлгээ” гэж нэрлэдэг.

Хүний эрхийн асуудал, эсхүл гол хэсэгт хэний оролцоо байна вэ? Оролцогч талууд?	Хэн голлон тоглогчид нь вэ? Хүний эрхийн асуудлыг шийдвэрлэхэд хэнийг оролцуулах вэ?
Хэнийг хамтрагчаараа татан оролцуулбал үр дүнтэй вэ?	

Эдгээр асуултын хариулт нь боловсролын үйл ажиллагаа болохоос өмнөх нөхцөл байдлын талаарх суурь мэдээллийг багшид өгнө. Энэ нь ямар амжилтад хүрэх, хэрхэн түүнд хүрэхээ төлөвлөхөд хэрэглэх мэдээллийг өгнө. Үйл ажиллагааны үр нөлөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардагдах жишгийг нөхцөл байдлын дүн шинжилгээнээс гаргаж авсан мэдээллээр хангадаг.

Нөхцөл байдлын дүн шинжилгээг хийх хэд хэдэн арга бий. Хамгийн тохиромжтой нь оролцогчид болон бусад хамтрагчид үнэлгээнд хамрагдах явдал юм. Ингэснээр энэ нь багш дээр бус оролцогч дээр төвлөрч байна. Үр дүнтэй хүний эрхийн боловсролыг бусад руу бус, харин бусадтай хамтран зохион байгуулдаг. Хүний эрхийн ойлголтоо харилцан солилцох, тэдгээрийг шийдвэрлэх хүсэл зориг, чадвар, мөн нааштай өөрчлөлтийг авчрах магадлал илүү ихэснэ.

Нөхцөл байдлын дүн шинжилгээнд оролцогчид болон хамтрагчдыг үргэлж бүрэн татан оролцуулах боломжгүй. Ялангуяа үйл ажиллагаа богино, мөн эрчимтэй бус тохиолдолд. Энэ шатан дахь эх үүсвэр, цаг хугацааны асуудал нь үйл ажиллагааны далайц, нарийн төвөгтэй байдал зэргээс хамааран янз бүр байна. Хүний эрхийн багшид тулгарах асуудал гэвэл оролцогчдыг аль болох татан оролцуулах арга, үйл ажиллагааг бий болгох явдал юм. Мэдээллээр хангаж чадах хэн нэгэнтэй цахим шуудан, утасны дугаараа солилцох, эсхүл фокус групп, олон нийтийн уулзалт, тайлан унших гэх мэтээр илүү эрчимтэй оролцоо, судалгааг хийж бас болно.



Логик загварын **орц** хэсэг нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай эх үүсвэрийг илрүүлдэг.

Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны хамгийн чухал эх үүсвэр нь хүмүүс буюу хүний эрхийн багш нар, удирдлага, харилцаа холбооны хүмүүс, хамтран оролцогчид болон бусад мэргэжилтнүүд юм. Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр хувь хүн, нийгэмлэг, эсхүл байгууллага дахь чадавх, хүчин чадлыг тодорхойлдог. Эдгээр хүмүүстэй хамтран ажиллах нь үйл ажиллагаанд чиглэмж, дэмжлэг үзүүлэх, хамтран оролцох зэрэг сайн талтай байж болох юм. Тэдний санаа бодлыг сонсох, бусадтай үйл ажиллагаа явуулахдаа харгалзах, цаг хугацаа гарган тэдний санал бодлыг авах нь эдгээр харилцааны хүч чадал, чанарыг сайжруулдаг бөгөөд эргээд үр дүнд хүрэхэд эерэг нөлөө үзүүлдэг.

Бусад эх үүсвэрийг энд авч үзвэл:

- санхүүгийн эх үүсвэр
- тогтолцооны дэмжлэг, үүн дотор захиргаа, хэл (жишээ нь, орчуулга, дохионы хэл, ярианы хэл) ба орчуулагчид
- судалгаа ба мэдээлэл
- эд материал, хэрэглэгдэхүүн, технологи, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог хангах эх үүсвэр
- цаг хугацаа

- орчны шаардлага, тухайлбал, хүртээмжтэй байр танхим, хүүхэд асаргаа, зууш, ажлын байр гэх мэт.
- харилцаа холбооны асуудал.

Хүний эрхийн боловсрол олон төрлийн орчинд явагддаг. Ялангуяа хүний эрхийн боловсролын ихэнх загваруудад тохирдогчлон багш нь өөрөө оролцогчдынхоо байгаа газарт очиход бэлэн байдаг. Боломжит эх үүсвэрийг бүтээлчээр ашиглах нь багшаас өөрөөс нь хамаарна. Үйл ажиллагааг байгаа эх үүсвэрийн хяналтад зохион байгуулах, эсхүл хамтрагчид, оролцогчдоос эх үүсвэр татах замаар, мөн санхүүжилт хүсч нэмэлт эх үүсвэр олох шаардлагатай байж болно.

Боловсрол, хөхиүлэн дэмжих ажиллагаа нь хүний эрхийн үндэсний байгууллагын гол бүрэн эрх учраас наад зах нь хүний эрхийн боловсролын үндсэн түвшний хөтөлбөрт шаардагдах хангалттай дотоод эх үүсвэртэй байх ёстой. Хэрэв эх үүсвэр хязгаарлагдмал байвал үйл ажиллагаа, түүний хүлээлтийг дэмжих, эсхүл өөрчлөх донорыг хайх шаардлага гарч мэднэ.



Логик загварын гарцын хэсэг нь 2 асуудлыг багтаадаг: Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг өөрийг нь болон түүнд хамрагдаж буй хүмүүс. Төлөвлөх, загварчлах шат нь ямар төрлийн үйл ажиллагаа (арга, хэрэгсэл) хэрэглэхийг шийдвэрлэх, мөн оролцогчдыг тодорхойлох асуудлыг багтаадаг. Нөхцөл байдлын дүн шинжилгээгээр цугларсан мэдээллийг энд ашиглана.

3.1. Хүний эрхийн ямар үйл ажиллагаа зохион явуулах вэ?

Хүний эрхийн боловсролын олон төрлийн үйл ажиллагаа байдаг бөгөөд энэ нь хязгааргүй юм. Ихэнх үйл ажиллагааг багшийн бүтээлч үйл ажиллагаанаас хамаарч өргөн хүрээнд, эсхүл хязгаарлагдмал түвшинд байлгаж болно. Харамсалтай нь хүний эрхийн боловсролыг “загварчилж” чадна. Боловсрол ижил агуулга, үйл явцыг хүн бүрт хэрэглэж болно. Ялангуяа сайн семинар зохион байгуулж, хүчирхэг илтгэл тавьж, үр дүнтэй эх үүсвэрийг хөгжүүлсэн багшийн хувьд ижил төрлийн хандлагыг ахин дахин хэрэглэх нь хуурмаг зүйл шиг санагдаж болно.

Төлөвлөж, загварчлах тохиромжтой цаг хугацааг олох нь хэцүү байж болно. Хэдий тийм ч үзэл санаагаа хөгжүүлэх, үйл явцад хувь нэмрээ оруулах оролцогчдод итгэж найдах үед энэ ямар үр дүнтэй болох нь гайхалтай юм.

Боловсролын үйл ажиллагааг загварчлах хамгийн эхний алхам нь хүний эрхийн асуудлыг хамгийн үр нөлөөтэй шийдвэрлэх тохиромжтой арга зүй, эсхүл бүлэг арга зүйг шийдвэрлэх явдал юм. Тавдугаар бүлэгт олон төрөлт аргачлалаар хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг зохион байгуулах зургаан арга замыг тодорхойлсон билээ. Эдгээр нь мэдээлэл солилцох, сургах, хөнгөвчлөх, харилцааны менежмент, хүний эрхийн сурталчилгаа ба олон нийтийн хөгжил юм.

Дараагийн алхам нь хэрэглэж болох үйл ажиллагааны хэлбэрийг шийдвэрлэх явдал болно. Жишээлбэл, хэвлэлийн мэдээ бэлтгэх, хөдөлгөөн зохион байгуулах, холимог сургалт явуулах, сүлжээ үүсгэх, хүний эрхийн чадавхыг бий болгохын тулд олон нийттэй ажиллах, презентаци хийх гэх мэт. Хавсралт 2-т хамгийн сайн холбогдох арга, үйл ажиллагааг оруулсан. Үйл ажиллагаа нь мөн зорилгуудыг багтааж байдаг.

Зорилгууд үр дүнд хүрч зорилгодоо хүрэх төлөвлөгөөг тайлбарлах тодорхой, богино хугацааны тодорхойлолт юм. Тэд үр дүнд хүрэхэд шаардлагатай үйл ажиллагаа, аргууд дээр төвлөрдөг.

Ялангуяа тэдгээрийг оролцогчидтой хамтран хийж байгаа тохиолдолд үр дүнтэй зорилтуудыг бичихэд цаг хугацаа шаардлагатай. Чанарын зорилго, үр дүнг бий болгох нийтлэг хэрэглэгддэг арга хэрэгсэл бол **"SMART"** юм. Энэ хураангуй үг нь чанарын зорилгын таван элементийг тодорхойлдог.

Тодорхой	– Бид хэнтэй хамт, хэнд зориулж, чухам юу хийх вэ? Зорилгууд тодорхой, сайтар тодорхойлогдсон байна уу?
Хэмжихүйц	– Үйл явцыг үнэлэх, зорилгууддаа хэзээ хүрэх нь мэдэгдэж байна уу? Үр дүн нь харагдахуйц байна уу?
Хүрч болохуйц	– Зорилгууд нь эх үүсвэр, мэдлэг, цаг хугацааны боломжит хүрээнд тодорхойлогдсон уу?
Харилцан хамааралтай	– Зорилгууд оролцогчид болон бусад хамааралт бүлгүүдэд тохиромжтой, хүлээн зөвшөөрөгдөхүйц, мөн ач холбогдолтой байна уу?
Цаг хугацаатай	– Зорилго нь бодитой, хүрч болохуйц хугацаатай юу?

Сурах зорилгыг хүчтэй үйл үгээс эхлэх нь үйл ажиллагааны боловсруулалтыг чиглүүлэхэд тусалж чаддаг. Яагаад гэвэл энэ нь оролцогчид юуг хийж, харуулж чадах вэ гэдэг дээр анхаарлаа хандуулдаг. Хавсралт 3–д боловсролын зорилгуудын талаарх Блумын системчлэлийн бүтцийг хэрэглэсэн ба сурах хүрээг үйл үг болон холбогдох үйл ажиллагаануудтай хослуулсан болно⁹³.

Нэмж хэлэхэд, "SMART" байх гэдэг нь оролцогчид болон хамааралт бүлгүүдийн өөрчлөгдөн буй хэрэгцээ, төвлөрлөлтөд хариу үйлдэл үзүүлдэг, уян хатан зорилгуудтай байхыг хэлдэг. Сургууль дахь хүний эрхийн сургалтын хөтөлбөрийн хангалт гэх мэт албан ёсны үйл ажиллагааны зорилгуудыг урьдчилан тодорхойлж, өөрчилж болдог. Хэдий өөрийн харьяалагдах нийгэмлэгээс өөрчлөлтийг эрж хайж байгаа бүлгийн хувьд зорилгууд нь бүрэн уян хатан, хэлэлцэн тохиролцож болохуйц, хариу үйлдэл үзүүлэхүйц байх шаардлагатай байхын зэрэгцээ хэвлэл мэдээллийн кампанит ажлыг боловсруулах зорилгууд нь илүүтэй өөрчлөгдөж болдог.

Нэгэнтээ хүний эрхийн боловсролын ерөнхий аргачлал, хэлбэрийг сонгогчиж, зорилгуудаа биччихсэн бол дараагийн төлөвлөх ажлууд бий.

Агуулга

Ямар үйл ажиллагааг багтаах нь тухайн сэдвээс хамаарна. Агуулгыг боловсруулахдаа хүний эрхийн багш дараах асуудалд анхаарна:

- Үйл ажиллагаагаар ямар үр дүнд хүрэхийг эрмэлзэж байна вэ?
- Хүүхдүүд, эмэгтэйчүүд, шашны цөөнхийн гишүүд, уугуул иргэдийн удирдагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, мөргөлдөөний дараах сэргээн босголтод оролцож буй хамт олны гишүүд, эсхүл засгийн газрын албан тушаалтнууд зэрэг ямар оролцогчид байх вэ?
- Оролцогчдын одоогийн мэдлэг, чадвар
- Цаг, эх үүсвэрийн хуваарилалт

⁹³ Дараах номоос өөрчлөн оруулав. Боловсролын зорилгуудын таксономи: Боловсролын зорилтуудын ангилал; Гарын авлага I: Когнитив домайн; Бенжамин Блум болон бусад; 1956 он.

Балба Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрхийг хамгаалагчдад зориулсан сургалтад багтсан зорилгууд

Тус улсын Хүний эрхийн Үндэсний Комисс Балба дахь анхан шатны түвшинд ажиллаж буй хүний эрхийг хамгаалагчдад зориулсан арга зүйн сургалтын хөтөлбөр боловсруулжээ. Уг хөтөлбөр нь гурван хэсэгт хуваагддаг. Эхний хэсэг хамгаалагчдыг хүний эрхийг ерөнхийд нь хамгаалахад сургахад чиглэжээ. Дараагийн хэсэг нь эмэгтэйчүүд, хүүхэд, цөөнх, эмзэг бүлгийнхэн зэрэг тодорхой бүлгийн хүмүүсийн эрхийг хамгаалах хамгаалагчдыг дэмжихэд чиглэсэн байна. Гурав дахь хэсэг нь энэ салбар дахь практик хүрээний сургалтад анхаарсан байна.

Сургалтын зорилгууд

Энэхүү сургалтын эцэст хүний эрхийг хамгаалагчид нь:

- Хүний эрхийн асуудлууд, түүнчлэн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний болон олон улсын тогтолцооны талаарх тойм ойлголттой болох
- Эмэгтэйчүүд, хүүхэд, үндэстний цөөнх зэрэг Балбын тодорхой эмзэг бүлгийнхний эрхийг тодорхойлох
- Шорон, цагдан хорих газар, хүүхдийн асрамжийн болон бусад газруудад газар дээр нь очиж танилцсанаар хүний эрхийг бодитой тайлбарлах
- Хүний эрхийг хамгаалагчид, хүний эрхийг хамгаалах тогтолцоо, хүний эрхийн диалог, сурталчилгаа, хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагын үүрэг роль, чиг үүргийг хэлэлцэх
- Хүний эрхийн зөрчлийг үр дүнтэй баримтжуулах чадвартай болно.



Нэмэлт мэдээлэл дараах вэб сайтад бий. [http://nhrcnepal.org/nhrc_new/doc/newsletter/NHRC%20Newsletter%20March%20issue16Apr_2012\(1\).pdf](http://nhrcnepal.org/nhrc_new/doc/newsletter/NHRC%20Newsletter%20March%20issue16Apr_2012(1).pdf).

Бүтэц

Энэ бол үйл ажиллагааны агуулга, түүний үйл явцын төлөвлөгөө юм. Энэ нь мөн тодорхой семинарын хэсэгчилсэн төлөвлөгөө, вэб сайтын тойм мэдээлэл, бичмэл эх сурвалж, хурлын хөтөлбөр зэрэг байж болно. Гарын авлагын 4 дүгээр хэсэгт энэхүү үйл ажиллагааг бүтэцчилэх хэд хэдэн техникийг авч үзсэн болно.

Орчны асуудал

Энэ нь үйл ажиллагааг хаана зохион байгуулах, ингэснээр тухайн орчин үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаарх ойлголтууд юм. Ямар боломжийг тухайн орчин санал болгож байна вэ?, Зарим хүмүүст оролцооны саад бэрхшээл байна уу?

Логистик

Энэ нь үйл ажиллагааны саадгүй байдлыг хангахад чиглэсэн бүх асуудлыг хамарна. Хамтран ажиллагч хэсгийнхэнтэй албан ёсны хэлэлцээр хийх, зохион байгуулах газраа захиалах, хоол бэлтгэх, оролцогчид тухайн газар хэрхэн хүрэхийг мэдэгдэх, үйл ажиллагааныхаа талаар хэвлэлийнхэнд мэдэгдэх, төлөвлөлтийн багийнхантай уулзалт зохион байгуулах зэрэг байж болно.

Багш нь тухайн үед олон зүйл дээр анхаарлаа хандуулж байдаг. Хэдийгээр төлөвлөлтийн маш олон арга хэрэгсэл байдаг ч үйл ажиллагаанд юу хэрэгтэй байгаа, энэ нь хэзээ хэрэгтэй болох, хэн үүнийг хийх гэсэн үндсэн жагсаалт байхад л хангалттай.

Мэдээлэл солилцоо, тайлагналт

Энэ хэсэгт үйл ажиллагааны талаар хэн мэдэж байх ёстой, хэрхэн, хэзээ тэдэнд мэдэгдэх ёстой, хэн энэ ажлыг хийх асуудлыг зохицуулна. Мэдээлэл солилцоо нь харилцан хамааралтай, хүртээмжтэй байвал зүгээр. Түүнчлэн үйл ажиллагааны бүхий л шатанд хамааралтай байж болох мэдээллийг багш хүлээн авч байхыг баталгаажуулах тухай юм⁹⁴.

Хяналт шинжилгээ ба үнэлгээний төлөвлөгөө

Хүссэн үр дүндээ чиглэсэн үйл явцын дагуу явагдаж байгаа эсэхийг мэдэх асуудал юм. Үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах нь үйл ажиллагааг загварчлах үе шатны чухал хэсэг юм. Үйл ажиллагааны үр дүн, шалгууруудаар эдгээрийг шийднэ. Энэ нь агуулга, үйл явцад тохиромжтой арга, хэрэгслийг багтаана⁹⁵.

3.2. Хэнтэй хамтран ажиллах вэ?

Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд хамрагдаж болох гурван бүлэг бий:

- **Эрх агуулагчид**, хүний эрхийн зөрчилд хамгийн өртөмтгий хэсэг
- **Үүрэг хүлээгчид**, бусдын эрхийг хамгаалах, эсхүл зөрчих боломжтой хэсэг
- **Нөлөөлөгчид**, бусдын үзэл бодол, үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц хэсэг⁹⁶

Оролцогчид нь уг үйл ажиллагаанд оролцож буй хүмүүс юм. Тэд сэтгэн бодох, мэдлэг ба шийдвэр гаргахад хувь нэмрээ оруулдаг идэвхитэй оролцогчид байж болно. Төслийн багийн гишүүд, олон нийтийн хурал, семинарт оролцогчид, онлайн хэлэлцүүлэгт оролцогчид гэх мэт. Түүнчлэн ямар нэгэн нөлөө үзүүлэхгүйгээр мэдээллийг хүлээн авч байдаг идэвхигүй оролцогчид ч байж болно. Тухайлбал сонины уншигч, презентацийн үзэгчид, жагсаал



Цагдаа нарт сургалт хийж байгаа нь. Гэрэл зургийг Малдивын Хүний эрхийн Комисс


⁹⁴ Мэдээлэл солилцоо нь дотоод болон гадаад оролцогчдын хүрээнд, мөн гадагш болон дотогш чиглэсэн байдалтай байж болно. Хэлбэр, бүтцийн түвшин нь тухайн үйл ажиллагааны мөн чанараас хамаарна. Томоохон үйл ажиллагаа нь нарийн тодорхой мэдээлэл солилцооны төлөвлөлт шаардаж болох бол оюутнуудын хичээлийн нэг хэсэгт зөвхөн и-мэйл л шаардагдаж болно. Хүний эрхийн сургагч багшийн мэдээлэл солилцооны нэг чухал тал бол хувь хүмүүс, байгууллагууд, нийгэмлэгээс цуглуулсан хүний эрхийн талаарх чухал мэдээллийг өөрийнхөө ХЭҮБ дахь менежертээ тайлагнах явдал юм.

⁹⁵ Мониторинг хийх, түүнийг үнэлэх асуудлаарх нэмэлт мэдээллийг 8 дугаар бүлэгт оруулсан.

⁹⁶ Эдгээр 3 хэсгийг 2 дугаар бүлэгт авч үзсэн.

Оролцогч талууд нь тухайн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийж буй хүмүүс юм. Тэд үйл ажиллагаанд нөлөөлж болно, мөн үйл ажиллагаа ч тэдэнд нөлөөлж болно. Тухайлбал, үйл ажиллагааг зохион байгуулж байгаа газрын орон нутгийн эрх мэдэлтэн, ажил олгогчийн боловсролын үр дүнд нөхцөл нь өөрчлөгдөж болох үйлдвэрийн ажилтнууд гэх мэт. Оролцогч талууд нь боловсролын үйл ажиллагаанд оролцогчид байж ч болно, үгүй ч байж болно.

Хэдийгээр оролцогчдын бүлгийг тодорхойлсон ч энэхүү гарын авлага үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд оролцох тэдний ач холбогдлыг хангалттай гарган илэрхийлж чадахгүй. Энэ бол *“Бидний тухай асуудлыг бидэнгүйгээр хэлэлцэх боломжгүй”* гэсэн үг.



Логик загварын **үр дүнгийн** бүрэлдэхүүн хэсэг нь тухайн үйл ажиллагаанаас хүсч буй үр дүнг тодорхойлоход оршдог. Төлөвлөлтийн шатанд хүний эрхийн багш нь үйл ажиллагаа ямар амжилтад хүрэх, үр дүнг хэмжих ямар арга хэрэгслийг авч хэрэгжүүлэх вэ гэдгийг боловсруулдаг.

Зорилго, зорилт, үр дүнгийн тодорхойлолт янз бүр ба зарим тохиолдолд зөрчилтэй, ойлгомжгүй байдаг. Гарын авлагад нэр томъёог дарааг аргаар хэрэглэлээ.

Үр дүн нь хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны үр дүнд бий болгохыг хүссэн өөрчлөлтийг харуулдаг. Эдгээр нь хэрэв үйл ажиллагаа амжилттай болвол үр дүн ямар байх, уг амжилтыг хэрхэн хэмжихийг тодорхойлдог.

Үр дүнг үргэлж удаан хугацааны зорилгод чиглэж боловсруулдаг. Энэ бол **зорилго**. Зорилгууд нь үйл ажиллагааг урамшуулагч тэрхүү алсын харааг бүтээдэг өргөн хүрээний, товч тодорхойлолтууд юм. Зорилгодоо ерөнхий байдлаар хүрээгүй байхад ямар стратеги, үйл ажиллагааг зохион байгуулж болох үр дүн болон зорилтуудыг тохируулах бүтцийг тэд өгдөг.

Хэрэв хүний эрхийн тэргүүлэх зэргийн зорилго нь “хүний эрхийн амжилтыг бүх хүнд” гэвэл, хүний эрхийн боловсролын ерөнхий зорилго нь хүний эрхийг бүх хүнд бодитой болгоход хувь нэмрээ оруулах хувь хүмүүс, бүлгүүд, нийгэмлэгүүд болон үндэстнүүдийг урамшуулах суурь мэдлэг, ур чадвар, хандлага, зан үйлийг хөгжүүлэх” гэж тодорхойлж болно.

2 дугаар бүлэгт авч үзсэнчлэн, хүний эрхийн боловсрол нь гурван зорилготой. Энэ нь оролцогчдыг хүний эрхэд суралцах, хүний эрхээр дамжуулж суралцах, хүний эрхийн төлөө суралцах туршлагаар хангахад чиглэдэг⁹⁷. Эдгээр зорилгууд дээр үндэслээд хүний эрхийн багш үйл ажиллагааны хөтөлбөр тус бүрийн тодорхой үр дүнг бий болгох үүрэг хүлээдэг. Үндсэндээ энэ нь оролцогч болон оролцогч бүлгүүдийн хамтын ажиллагааны үр дүнд бий болно.

Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн үндэсний байгууллагуудын хэрэгжүүлсэн хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны зорилгуудаас жишээ болговол,


- **Дүүргийн түвшинд ажиллаж байгаа хүний эрхийг хамгаалагчдын чадавхийг нэмэгдүүлэх.** Балбын хүний эрхийн үндэсний Комисс⁹⁸
- **Катарын сургуулиуд дахь хүний эрхийн соёлыг ерөнхийд нь, хүүхдийн эрхийг тухайлан.** Катарын хүний эрхийн хороо⁹⁹
- **Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, хөгжлийн бэрхшээлийн асуудлыг Номхон далайн бүст хариуцах Засгийн газрын төлөөлөгчдийн ур чадварыг нэмэгдүүлэх.** Австралийн Хүний эрхийн Комисс¹⁰⁰

⁹⁷ НҮБ–ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал, 2.2 дахь зүйл.

⁹⁸ Непал Улсын Хүний эрхийн үндэсний комисс: Хүний эрхийн хамгаалагчдын сургалтын зааварчилгаа; 2012.

⁹⁹ Катар Улсын Хүний эрхийн үндэсний хороо: Сургуулиуд дахь Хүний эрхийн боловсролын хөтөлбөр; 2012.

¹⁰⁰ Австрали Улсын Хүний эрхийн комисс: үйл ажиллагааны тайлан: Номхон далайн бүс нутгийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд болон төрийн албаны төлөөлөгчдийн хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, чадавхийг бэхжүүлэх нь; 2012.



Зорилго нь үр дүнг боловсруулах хөтөч болдог. Энэ нь үйл ажиллагааны үед, эсхүл үйл ажиллагаа дууссан үед болон зорилтууддаа хүрсэн үед хүний эрхийн нөхцөл байдал ямархуу байх вэ гэдгийг тодорхойлдог¹⁰¹. Үр дүнг гаргахад “SMART” загвар мөн л хэрэгтэй.

“Одоо, цэргүүд сахилга баттай бөгөөд хүчирхийлэл цаашид гарахгүй болсныг тэмдэглэж байна. Иргэний зэвсэгт хүчний газарзүйн ангийн гишүүд нийтийн дунд зэвсэгтэй явахгүй.” (Хигаонон, Филиппин)

Хэрэв хүний эрхийн үйл ажиллагааг удаан хугацаанд хэрэгжүүлбэл үр дүнг богино, дунд, урт хугацаагаар ангилж болно. Үр дүнгээс гарах амжилт, ололтыг цаг хугацаагаар тодорхойлох хэцүү. Гэхдээ удирдлага болгож болох зүйлс бий:

- Богино хугацааны үр дүн нь шинэ мэдлэг, мэдлэг ойлголт нэмэгдсэн үр дүнг гаргахыг зорьдог
- Дунд хугацааны үр дүн нь ур чадвар нэмэгдсэн байх, хандлага, зан үйл, шийдвэр, бодлого өөрчлөгдсөн байхыг зорьдог.
- Урт хугацааны үр дүн нь нөхцөл байдал дахь өөрчлөлтийг харахыг зорьдог.

Боловсролын бүх үйл ажиллагаа дунд хугацааны, эсхүл урт хугацааны үр дүнг багтаадаггүй. Харин өргөн хэмжээний цогц үйл ажиллагаа, жишээлбэл, цагаач ажилчдын эрхийн талаарх мэдлэгийг үндэсний хэмжээнд нэмэгдүүлэх үйл ажиллагаа гэх мэт нь бүх үр дүнгийн түвшинг багтааж болно. Цогц бус шинжтэй үйл ажиллагаа, жишээлбэл, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн талаар хэсэг орон нутгийн ажилтнуудад танилцуулга хийх гэх мэт нь зөвхөн богино хугацааны үр дүнтэй байж болно. Доорх загварт богино, дунд, урт хугацааны үр дүнгийн зарим ялгааг жишээ болгов.

¹⁰¹ Энд дурдсан хандлагуудыг дараах номоос хялбаршуулан оруулав. Логик загвар дасгал; Шинэчлэлийн сүлжээ; Дэлгэрэнгүй мэдээллийг www.innonet.org/client_docs/File/logic_model_workbook.pdf.

СУРГУУЛЬ ДЭЭРХ БАГШААС ОЮУТНАА, ОЮУТАН НЬ НЭГ НЭГИЙГЭЭ ДЭЭРЭЛХЭХ БАЙДАЛ¹⁰²

Үйл ажиллагаа: Хүний эрхийн үндэсний байгууллага нь бусдыг дээрэлхэх асуудлын хүний эрхийн талаарх мэдээллээр сургуулиудыг хангана.

Богино хугацааны үр дүн: Сургууль оюутнуудын хүний эрх ба дээрэлхэлтийг шийдвэрлэх үүрэг хариуцлагаа мэдэх

Үйл ажиллагаа: Хүний эрхийн үндэсний байгууллага нь сургуулийн удирдлагууд болон оюутнуудтай хамт сургууль дээр дээрэлхэхээс сэргийлэх ур чадвар, хандлага, зан үйлийг хөгжүүлэхээр ажиллах

Дунд хугацааны үр дүн: сургууль дээрэлхэлтээс сэргийлэх стратегийг боловсруулах ур чадвартай болох

Үйл ажиллагаа: Хүний эрхийн үндэсний байгууллага сургуулиудтай хамтран дээрэлхэлтээс сэргийлэх стратегийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх ажлыг хийх

Урт хугацааны үр дүн: Сургууль үйл ажиллагаа явуулж, дээрэлхэлт багасна.



3.3. Шалгуур үзүүлэлтийг боловсруулах нь

Нэгэнт үр дүнгээ гаргачихвал, эдгээр үр дүн нь амжилттай болж уу гэдгийг хэмжих арга замыг боловсруулах нь чухал. Дээрх загвар дээр жишээг нь харууллаа:

- Сургууль оюутнуудын хүний эрх ба дээрэлхэлтийг шийдвэрлэх үүрэг хариуцлагаа мэдэх
- Сургууль дээрэлхэлтээс сэргийлэх стратегийг боловсруулах ур чадвартай болох
- Сургууль үйл ажиллагаа явуулж, дээрэлхэлт багасна

Үүнийг хийх нэг арга зам нь **шалгууруудыг** хэрэглэх юм. Шалгуурууд нь тухайн үйл ажиллагаа өөрийнхөө үр дүнд хэр чиглэж байгаа талаарх мэдээллийг өгөх хэмжүүр, чиглүүлэгч юм. Шалгуурууд цогц байх шаардлагагүй. Тэд энгийн, бодитой байдаг.

Тооны болон чанарын гэсэн үндсэн хоёр төрлийн шалгуур бий.

Тоон шалгуурууд нь тоологдохуйц зүйлийг хэмжинэ. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаатай холбоотойгоор тоон шалгууруудын дараах төрлүүд байж болох юм:

- Хүний эрхийн боловсролын семинарт хамрагдсан оролцогчид
- Нийгэмлэгийг хөгжүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг болгох хүний эрхийн хөтөлбөр боловсруулсан байгууллагууд
- Залуучуудын эрхийн цахим хуудас дээрх сэтгэгдлүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сүлжээнд хамрагдсан байгууллагууд.

Чанарын шалгуурууд нь хэмжигдэж байгаа өөрчлөлтийн чанарыг үнэлдэг. Хүмүүсийн үзэл бодол, шүүлт, байр суурь зэрэгтэй холбогддог тул тодорхойлоход хэцүү байдаг. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаатай холбоотой чанарын шалгууруудын дараах жишээ байж болно:

- Хүний эрхийн боловсролын семинарын талаарх оролцогч бүлгийнхний зөвлөгөө
- Нийгэмлэгийг хөгжүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг болгон боловсруулсан хүний эрхийн хөтөлбөрийн биелэлт
- Залуучуудын эрхийн тухай цахим хуудасны талаарх олон нийтийн сэтгэгдлийн агуулга
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн сүлжээнд хамрагдсан байгууллагуудын хэлбэрүүд

¹⁰² Боловсролын салбарт хүний эрхийн бүлгүүдийг байгуулах нь – He Whakatu Tika Tangata–a–Iwi Whānui; Эмнести Интернейшнл, (Шинэ Зеланд), Хөгжлийн нөөцийн төв, Шинэ Зеланд Улмын Хүний эрхийн комисс, Хүүхдийн асуудал хариуцсан Комиссарын ажлын алба, Энхийн төлөө сан; 2007.

Тоон болон чанарын шалгуурууд өөрийн давуу ба сул талтай. Чанарын шалгууруудыг тодорхойлох нь илүү хэцүү ч илүү үнэтэй мэдээллийг өгдөг. Эдгээрийг доорхийн адил хослуулан хэрэглэх нь зохистой.

- Семинарын төгсгөлд авах санал асуулгаар оролцогчдын хүний эрхийн боловсролын семинарын талаар “сэтгэл маш ханамжтай” эсхүл “ханамжтай” гэж хариулсан хувь.
- Нийгэмлэгийг хөгжүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг болгож хүний эрхийн хүрч болохуйц хөтөлбөр боловсруулсан байгууллагуудын тоо
- Залуучуудын эрхийн тухай цахим хуудасанд ирсэн сэтгэгдлүүдийн тооноос илүү үр дүнтэй арга хэмжээ авахыг сонирхож байгааг илтгэх хувь хэмжээ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн сүлжээнд хамрагдсан байгууллагуудаас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн удирдаж, ажиллуулдагынх нь хувь хэмжээ

Цаглабар

Хугацаа сунган хэрэгжүүлж байгаа хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа нь “цаглабар”-тай байж болно. Цаглабар нь цаг хугацаан дахь чиглүүлэгч юм. Эдгээр нь тодорхой хугацаанд тухайн үйл ажиллагааны үр дүнд ямар амжилтад хүрэв гэдгийг хэлж өгнө. Цаглабарыг хэрхэн хэрэглэх жишээг доорх баримтаар үзүүлэв.¹⁰³ Өмнөд Солонгос Улсын Хүний эрхийн Комисс Ансан дахь гадаадын оршин суугчдын төвийн цагаач ажилтнуудтай уулзах аялалыг хийсэн байна. Энэхүү жишээнд, цаглабар нь төслийг төлөвлөх шатанд тодорхойлогдсон үр дүнтэй холбоотой байна.

ӨМНӨД СОЛОНГОС УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС: АНСАНЫ ГАДААД ОРШИН СУУГЧДЫН ТӨВ ДЭХ ЦАГААЧ АЖИЛЧИДТАЙ УУЛЗАХ НЭЭЛТТЭЙ АЯЛАЛ


Зорилтот үр дүн:

- Цагаач ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хүний эрх, хөдөлмөрийн хууль болон зохицуулалттай холбоотой зөвлөгөө өгөх
- Улс орон дахь цагаач ажилчдын хүний эрхийн нөхцөл байдлыг ойлгох, нэмэгдүүлэх зорилготой бодлогын дүн шинжилгээ, судалгаанд ашиглах мэдээллийг цуглуулах

Цаглабарын шалгуурууд:

- **[Богино хугацааны огноо]**, хуульчид, хөдөлмөрийн маргааны өмгөөлөгчид, Цагаачлалын алба, ажил эрхлэлт, хөдөлмөрийн яамны төрийн албан хаагчдыг хамруулсан олон нийтийн хурлуудын [тоо], тухайн хурлуудад оролцсон хүмүүсийн [тоо].
- **[Дунд хугацааны огноо]**, Цагаачлалын алба болон Ажил эрхлэлт, хөдөлмөрийн яаманд хүргүүлсэн тайланд дурдагдсан тухайн аялалаас цуглуулсан мэдээлэл
- **[Урт хугацааны огноо]**, Засгийн газрын бодлогод хамаарах дүн шинжилгээний талаарх мэдээлэл

Дэлгэрэнгүй мэдээллийг: www.asiapacificforum.net/news/south-korea-outreach-tour-targets-migrant-workers.



¹⁰³ Энэхүү кэйсээр хангасан явдалд БНСУ-ын Хүний эрхийн Үндэсний комисст талархаж байна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хүний эрхийн нөхцөл байдлыг тодорхойлж, үнэлэх, хүний эрхийн боловсролын ямар үйл ажиллагаа тухайн нөхцөл байдалд нөлөөлж болохыг тогтоох асуудлыг хаарсан хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, загварчлах
- Логик загвар нь энэхүү зорилгод тохирох хэрэгтэй арга хэрэгсэл юм. Энэ нь дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг хамардаг:
 - Нөхцөл байдлын дүн шинжилгээ – хүний эрхийн нөхцөл байдлын үнэлгээ
 - Орц – Үйл ажиллагааг зохион явуулж, үнэлэхэд хэрэглэгдэх эх үүсвэр
 - Гарц – Хамрагдаж буй үйл ажиллагааны хэлбэр болон оролцогчид, оролцогч талууд
 - Үр дүн – Үйл ажиллагаанаас хүссэн үр дүн
- Логик загвар нь хүний эрхийн боловсролын олон түвшинд хэрэглэгдэж болно. Үндэсний, нийгэмлэгийн эсхүл байгууллагын үйл ажиллагаа, төслийн төлөвлөгөө, нэг цагийн семинар эсхүл хувь хүний ажлын төлөвлөгөө гэх мэт.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага: НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, 2007 он

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үр дүнг үнэлэх нь; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2005 он

Камбожийн хүний эрхийн иргэний нийгмийн байгууллагууд дахь оролцоонд суурилсан албан бус боловсролыг сайжруулах нь, Ричард Пьер Клауд Азийн сан, 1999 он, Дэлгэрэнгүй мэдээллийг www.hrea.org/erc/Library/research/TAFreport.html

Эрүүл мэндийг дэмжих төлөвлөлтийн үндэс; Эрүүл мэнд, мэдээлэл харилцааны нэгж, Эрүүл мэндийг дэмжих төв, Торонто их сургууль; 2001 он

ОУХБ-ын Жендерийн стратегийн мониторинг, үнэлгээний тоон болон чанарын шалгуурууд; Таяа Бастиа; 2000 он; Дэлгэрэнгүй мэдээллийг www.womensnet.net/wp/library/Methodology%20Indicators.pdf

Нөхцөл байдлын дүн шинжилгээ: Модуль 1; НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс; Дэлгэрэнгүй мэдээллийг www.unescap.org/stat/meet/rrg3/twsa-module1.pdf

Хүний эрхийг ойлгохуй: Хүний эрхийн боловсролын гарын авлага; Волфганг Бенедик, Хүний эрх, ардчиллын Европын сургалт, судалгааны төв; 2012 он (3 дахь хэвлэл)



БҮЛЭГ 7:

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД:

- Хүний эрхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үед хүний эрхийн багшийн анхаарах гол асуудлууд юу вэ?
- Хүний эрхийн багшийн гүйцэтгэх үүрэг, роль юу вэ?
- Олон төрлийн сурах арга барилуудыг хүний эрхийн багш хэрхэн зохицуулах вэ?
- Үйл ажиллагааны идэвхитэй байдлын ач холбогдол юу вэ?
- Үйл ажиллагааны хэрэгжилтэнд хэл хэрхэн нөлөөлж чадах вэ?
- Хүний эрхийн багш үйл ажиллагаа зорилго руугаа чиглэж байгаа эсэхийг хэрхэн мэдэх вэ?



Хувиралт өөрчлөлт нь хүмүүсийн тулд бус, тэдэнтэй хамт хэрэгжсэнээрээ хүлээн зөвшөөрөгддөг. Чөлөөлөлт нь хүүхэд төрөхтэй адил өвтгөдөг. Дахин дарлаж, эсхүл дарлагдахгүй шинэ хүн болж төлөвшиж байгаа хүн нь эрх чөлөөг олж авах үйл явцын дунд байгаа хэрэг.¹⁰⁴



Хэрэгжилтийн шатанд, багш нь тухайн үйл ажиллагааг хүний эрхийн боловсролын зарчим, хандлагууд дээр суурилан төлөвлөж, загварчилчихсан байх болно. Энэхүү үйл ажиллагаа нь оролцогч бүлгийн хэрэгцээ, асуудал, анхаарал зэрэгтэй холбоотой байх болно. Албан болон албан бус хамтын ажиллагааны хүрээнд бусад хүмүүс үйл ажиллагааг загварчлах ажилд хамрагдана.

Зураг 7.1: Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны хэрэгжилтийн шат



¹⁰⁴ Пауло Фрерийн “Дарлагдсан сурган хүмүүжүүлэх зүй” номоос авав. Хуудас. 25, 43 (Уг ном 1970 онд Англи хэлээр орчуулагджээ)

Энэ бүлэг хэрэгжилт дээр анхаарлаа хандуулна. Тодруулбал, хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны загвар бус, харин амжилттай хэрэгжүүлэх арга ажиллагаан дээр төвлөрөх болно. (Боловсролын хөтөлбөрт оруулах санаа сэдлийг хайж байгаа бол 4-р хэсэгт төрөл бүрийн сэдвийн хүрэн дэх хэд хэдэн үйл ажиллагаануудыг багтаасан болно.) Энэ үед 5 дугаар бүлэгт авч үзсэн хүний эрхийн боловсролын зарчмыг эргэж харах хэрэгтэй байж мэднэ.

Өмнөх шатууд шиг оролцогчдыг боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахад оролцуулах нь зүйтэй. Тухайн боловсролын хүрэнээс хамаарч цар хэмжээ нь янз бүр байх болно. Жишээлбэл, коллежийн төгсөлт дээрх шинэ багш нарын цугларалт дээр танилцуулга хийх, хүний эрхээрээ ижил төсөөтэй гэдгээ оролцогчдод нотлохын тулд гар гараа харуулах, эсхүл хажуудаа сууж байгаа хүнтэй хүний эрхийн асуудлаар нэг минут хэртэй яриа өрнүүлэх гэх мэтээр боломжит оролцооны хэлбэрээ байж болно. Нөгөө талаас жендэрийн ялгаварлан гадуурхалтаар туршлагажсан нийгэмлэг дэх хэсэг эмэгтэйчүүдтэй семинар хийх нь бүрэн биш хэдий ч ихэнхдээ олон талыг хамарсан, оролцооны аргыг хамарсан байж болно.

Үр дүнтэй оролцооны үйл явцыг ашиглах нь хүнд нөхцөлд байгаа хувь хүмүүс, бүлгийнхнийг өөрсдийн эрхээ мэдэж, шаардах явдлыг нь эрх мэдэлжүүлж, үүрэг хүлээгчдийн өөрсдийн үүрэг хариуцлагаа ухамсарлах талаарх мэдлэг, ур чадварыг нь хүчирхэгжүүлэхэд чухал нөлөөтэй гэдгийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрсөн байдаг.

Энэ бүлэг хүний эрхийн боловсролыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай, оролцоог дээд зэргээр хангах элементүүд дээр анхаарлаа хандуулах болно.

Эдгээр элементүүд нь:

- *Хүний эрхийн багшийн зохистой үүрэг*, ролийг тодорхойлж, хэрэгжүүлэх
- *Олон төрөлт сургалтын хэв маягийг* таньж мэдэх
- *Үйл ажиллагаанд зориулсан үр дүнтэй сургалтын орчинг* бүрдүүлэх
- *Үйл ажиллагааг хурдасгах*
- Бичмэл болон ярианы харилцаанд *хэл, зурвас* зэргийг хэрэглэх
- Үйл ажиллагааны явцыг *хянаж, дүгнэх*
- Хүний эрхийн багшийн аливааг *тусган авах дадал, удирдлага, өөртөө тавих анхаарал*

Эдгээр элементүүдийг хүний эрхийн боловсролын аливаа үйл ажиллагаанд хэрэглэх боломжтой ч тодорхой нөхцөлд тэднийг хэрэглэхдээ бүтээлчээр хандах шаардлага гарч ирнэ. Жишээлбэл, боловсролын ном товхимол нь олон төрөлт сургалтын хэв маягтай хэрхэн нийцэж, үр дүнтэй сургалтын орчныг бий болгож байгааг та хэрхэн баталгаажуулах вэ?, Олон нийтийн сүлжээний томоохон бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн онлайн курстэй хүний эрхийн боловсролын үүрэг ролийг хэрхэн ойлгомжтой тодорхойлох вэ?

1. ХҮНИЙ ЭРХИЙН БАГШИЙН ҮҮРЭГ, РОЛЬ

Хүний эрхийн боловсрол нь багшаас олон тооны үүрэг, роль шаарддаг: мэдээлэл дамжуулагч, сургагч багш, чиглүүлэгч, сүлжээ бүрдүүлэгч, хүний эрхийг өмгөөлөгч, хамт олныг хөгжүүлэгч гэх мэт. Тус бүр нь олон янзийн ур чадвар шаарддаг ба өөр өөр үр дүн авчирдаг. 6-р бүлэгт тоймлосон төлөвлөх ба загварчлах шат нь хүний эрхийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай эх үүсвэрийг тодорхойлж, хүний эрхийн боловсролын арга зүй, оролцогчид нь хэн байх, ямар үйл ажиллагаа явуулах шаардлагатай зэргийг тогтчихсон байх болно.

Үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд багш хүсч буй зорилго, зорилт, үр дүндээ хүрэхэд шаардагдах хамгийн тохиромжтой ролийг тодорхойлох шаардлагатай болно.

Хүний эрхийн сургагч багшийн ерөнхий роль нь хүний эрхийн мэдлэг, ур чадвар, хандлага, зан үйл ба үйл ажиллагааг дэмжих явдал юм. Үүнийг үр дүнтэй хийхийн тулд хүний эрхийн багш уян хатан байж, хүний эрхийн боловсролын аргачлалын хүрээнд гүйцэтгэж байгаа үүрэг ролио тухай бүр өөрчлөх ёстой.

Дор жагсаасан ролиуд нь 5-р бүлэг болон хавсралт 2-т авч үзсэн олон төрөлт арга зүйн хандлагын 6 арга зүйтэй холбогдоно.



Иемэний Ходайдах эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлт, эрүүл мэндийн боловсрол олгож байгаа нь.
Гэрэл зургийг НҮБ-ын хүн амын сан /Поуад Ал-Харази

1.1. Мэдээлэл дамжуулагч

Мэдээллийг дамжуулагч нь хүний эрхийн мэдээллийг шүүн тунгааж, зорилтод хүмүүст хамгийн үр дүнтэй түгээх арга хэмжээ авна. Бусад хүмүүстэй мэдээллийг үр дүнтэй солилцох харилцааны ур чадвартай байхыг энэ роль шаарддаг. Өгөгдсөн мэдээллийг сонсох, мэдээллийг дамжуулах зэрэг үндсэн харилцааны ур чадварууд багтана. Харилцаа нь аман болон аман бус хэлбэртэй байж болох ба хувь хүмүүс, эсхүл хязгаарлагдмал тооны хүмүүсийн дунд явагдана.

Хүний эрхийн багш нар харилцааны төрөл бүрийн техник, үйл ажиллагааг ойлгодог, хэрэглэдэг байх нь зүйтэй.

Энэ нь олон нийтийн хэвлэл мэдээллийн хурдацтай өөрчлөлттэй хөл нийлүүлэх, санаа бодлоо солилцох аргуудыг шаарддаг ба мөн энэ зуур олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах боломжгүй хэсгийнхэнтэй бүтээлч арга замаар харилцах гарцыг олох хэрэгтэй. 9 дүгээр бүлэгт авч үзсэнчлэн харилцааны техникүүд нь хэвлэл мэдээлэл, аудио-визуал материалууд, ардын театр, бүжиг, хүүхэлдэйн үзүүлбэр, яруу найраг гэх мэт уламжлалт үйл ажиллагаануудыг ч багтаана.

1.2 Сургагч багш

Хүмүүст хүний эрхийн агуулга, ур чадварыг хамгийн үр дүнтэй заах тэрхүү арга зүй, туршлагыг зохистойгоор хөгжүүлж буй хүн бол сургагч багш юм. Түүний роль нь хувь хүмүүсийг хүний эрхийн мэдлэг олж авах, тодорхой ур чадвар, зан үйлийг сургахад чиглэсэн туршлагыг төлөвлөх асуудлыг хамардаг. Сургагч багш нь агуулга шинжээч бөгөөд сургалтын үр дүнд оролцогчдыг дэмжих шинэ арга аргачлал, техник, хэрэгслийг тасралтгүй хөгжүүлж ажилладаг. Сургагч багш бодитой, бие даасан ажлын гүйцэтгэл, үүрэг даалгавар дээр төвлөрдөг ба хэрэгжүүлэх, сургалтын өмнөх болон дараах үнэлгээний дүн шинжилгээнд оролцож болдог.

1.3 Чиглүүлэгч

Чиглүүлэгч нь оролцогч өөрсдөд нь болон бусдад үзүүлж болох хүний эрхийн нөлөөлөл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох үйл явцыг боловсронгуй болгодог. Чиглүүлэгч суралцагчдын мэргэн санааг гарган илэрхийлүүлж, хүний эрхийн ашиг сонирхолынх нь хүрээнд тэдний оролцох, харьцуулах, шүүн тунгаах, шийдвэр гаргах, сонгох, үйл ажиллагаа явуулах чадавхийг босгож өгдөг. Эрх мэдэлжүүлж, эерэг харилцааг хангахад дэм болдог арга, техникүүдийг бүтээх, шударга, хүндэтгэлтэй, хариуцлагатай байдлаар өөр хоорондоо харилцах явдлыг бүлгийн гишүүдэд олгох зэргээр чиглүүлэгч нь үйл явцын шинжээчийн үүрэг гүйцэтгэдэг. Чиглүүлэгч агуулгын шинжээч байх шаардлагагүй, харин бүлгийн үйл явцын олон төрөл хэлбэрт шинжээч нь болдог. Хавсралт 5-ыг үзнэ үү.

1.4 Сүлжээ бүрдүүлэгч

Сүлжээ бүрдүүлэгч нь мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг бий болгох, хэвийн ажиллагааг хангаж, тодорхой хувь хүмүүс, байгууллагуудыг холбодог. Сүлжээ нь нүүр тулсан уулзалт, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр, хэвлэмэл бүтээгдэхүүн, теле коммуникаци болон интернэтээр дамжин хэрэгжинэ. Сүлжээ бүрдүүлэгчийн үүрэг роль нь мэдээллийн солилцоог чиглүүлэх, санаа, сэдлийг хөгжүүлэх, олон нийтийн хамарсан үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг болно.

1.5 Өмгөөлөгч

Зам тавих, гүүр барих зэрэг дэд бүтцийн төслүүдийн хяналт шинжилгээний ажилд оролцуулах замаар хэрхэн оролцооны зарчмыг хэрэгжүүлэхэд бид суралцсан. (Канкана. Филиппин)

Өмгөөлөгч нь хувь хүмүүс, бүлгийг өөрсдийн хүний эрхээ хэрэгжүүлэхийг дэмжихийн тулд, мөн тэднийг үйл ажиллагаа явуулахыг урамшуулахын тулд боловсролыг ашигладаг. Хүний эрхийн багш нар өмгөөлөл, сурталчилгааны ажил гүйцэтгэж байх үед, тэд ихэнхдээ хүний эрхийн талаар илүү ихийг мэдэж авах замаар болон хүний эрхийн асуудлаар хэрхэн дэмжлэг хайхыг мэдэж авах замаар нөхцөл байдлаа дээшлүүлэх талаар бусаддаа тусалдаг.

1.6 Хамт олныг хөгжүүлэгч

Хамт олныг хөгжүүлэгч нь олон нийтийн хэмжээнд ажиллах эрэх мэдэлжүүлэх загварыг хэрэглэдэг ба олж тогтоох шаардлагатай хүчин чармайлтыг нь дэмжиж, тэдэнд нөлөөлж буй асуудлыг шийдвэрлэдэг. Хамт олныг хөгжүүлэгч нь хувь хүмүүс, бүлгүүд тухайн бүс нутгийнхаа хүний эрхийг урвуулан ашиглаж буй байдлыг олж тогтоодог, шинжилдэг, шийдвэрлэдэг, хяналт шинжилгээ хийдэг өөрийн хүч чадлаа мэдэрсэн, нэг нэгэндээ хүндэтгэлтэй олон нийтийг урамшуулах, мөн тухайн олон нийтийн хүний эрхийн тэргүүлэх чиглэлийг бодитой болгох нөлөөлөл сурталчилгааг хийхэд чиглэсэн хүний эрхийн зарчим, хандлагуудыг хэрэглэдэг. Түүний үүрэг нь тэгш бус байдлыг шийдвэрлэхэд олонтаа хэрэг болдог ба соёлын хувьд, эдийн засгийн хувьд мөн газар зүйн хувьд эмзэг байдалтай болсонд тооцож болох олон нийтийг анхаарч, илэрхийлэхэд оршдог. Түүнчлэн хамт олныг хөгжүүлэгч нь тухайн олон нийтийг орон нутгийн засаг захиргаа, бусад төрийн байгууллагуудтай холбоход тусалж чадна.

2. ТӨРӨЛ БҮРИЙН СУРГАЛТЫН ХЭЛБЭРҮҮДИЙГ ТАНЬЖ ОЛОХ

Хүмүүс олон төрлийн арга замаар суралцдаг ба эдгээр хүмүүс зорьж буй сургалтын хэлбэрээ хэрэглэж суралцсан тохиолдолд илүү ихийг амжилттай сурч чаддаг болохыг судалгаа харуулж байна.

Хүний эрхийн багш нь оролцогчдын сургалтын олон төрөл хэлбэрийн талаар анхаарч, тэднийг бүрэн дүүрэн хамруулах замаар үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллах хэрэгтэй. Түүнчлэн хүмүүсийн мэдээллийг ямар хэлбэрээр хүлээж авахыг илүүд үзэж байгааг багтаана.

Эдгээр сургалтын хэлбэрүүдийг харуулах олон загваруудыг хөгжүүлж байна. Хоёр загварыг хавсралтуудад оруулав.

Лоусоны сургалтын дөрвөн хэлбэр (Хавсралт 6), Грегоркийн сэтгэлгээний дөрвөн хэлбэр (хавсралт 7). Хувь хүний загвар дээр анхаарлаа хандуулдаг бусад бүтцүүдийг боловсрол хариуцсан хүмүүс хэрэглэдэг. Тухайлбал, Карл Жунгийн Майерсын Шалгуур¹⁰⁵ ба Рудолф Штайнерын дөрвөн темперамент зэрэг болно.¹⁰⁶ Нэмээд хэлэхэд Колб болон Фрай нарын боловсруулсан Сургалтын хэлбэрийн хэрэгсэл¹⁰⁷ болон Нел Флеминг¹⁰⁸ болон Хоуард Гарднерын¹⁰⁹ боловсруулсан мэдээллийн олон төрөлт загваруудыг дурдаж болно.

Семинар, презентаци, төсөл гэх мэт боловсролын нүүр тулсан арга хэлбэрүүдийг хэрэглэхдээ оролцогчдын сурах олон янзын хэлбэрт тохирох техник, аргачлалыг тохируулах илүү амар байдаг. Бичмэл эх сурвалж бэлтгэх, хэвлэл мэдээллийг хэрэглэх зэрэг боловсролын шууд бус арга зүйг хэрэглэж байгаа үед илүү хэцүү байдаг. Гэсэн хэдий ч сургалтын ялгаатай хэлбэрүүдэд тохирох өөр өөр эх сурвалжийг үүнд ашиглах боломжтой байдаг.

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТОХИРОХ ҮР ДҮНТЭЙ СУРГАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ

Үйл ажиллагааг хэрэгжүүлж байхдаа хүний эрхийн багш сургалтын орчныг анхаарах нь зөв. Боловсролын үйл явц болон сургалтын хамт олныг хэлбэржүүлэхэд орчин хэр зэрэг нөлөөтэйг судалгаа харуулж байна.¹¹⁰

Бодитой, хиймэл орон зайн аль алиныг хамруулж олон төрлийн орчныг багш нар хэрэглэж болно. Хүний эрхийн багшийн даалгавар нь оролцогчдын хэлхээ холбоонд орчны үзүүлж болох нөлөөллийг үнэлэх, хэрэв ямар нэгэн сөрөг нөлөөлөл байгаа бол түүнийг бууруулах явдал юм.

Бодитой ба хиймэл сургалтын орчныг бий болгоход тусалж чадах хүчин зүйлсэд дараах зүйлс багтана:

- Өөр хоорондоо болон багштай харилцах оролцогчдын харилцаа
Оролцогчид үнэлэгдэж, хүлээн зөвшөөрөгдөж, хүндлэгдэж байгаагаа мэдэрдэг үү?
Тэд ялгаатай байдлыг агуулж байна уу?
- Орчны хүртээмж
Зарим талаар оролцоог хязгаарлах хүчин зүйлс бий юу?
- Орчны хүлээн зөвшөөрөгдөх байдал, орон зайн чанар, харагдац, мэдрэмж
Тухайн нөхцөл байдалд дээд зэргээр боломжтой байна уу?
Тухтай, зочломтгой юу?
Хэлхээ холбоог урамшуулдаг уу?
Тухайн нөхцөлд аюулгүй, найдвартай юу?
Хоол тухайн үйл ажиллагааны нэг хэсэг бол олон үндэстний хоол, итгэл үнэмшлээр хүлээн зөвшөөрөгдөхүйц үү?
- Орчны дасан зохицох байдал
Орчин нь тухайн сэдэв, үйл ажиллагааны зорилготой нийцэж байна уу?
Оролцогчид болон тэднийг дасан зохицуулахад анхаарч байна уу?

¹⁰⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг http://en.wikipedia.org/wiki/Myers-Briggs_Type_Indicator.

¹⁰⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг http://en.wikipedia.org/wiki/Myers-Briggs_Type_Indicator http://en.wikipedia.org/wiki/Four_temperaments.

¹⁰⁷ “Туршилтын сургалтын хавсарга онол руу” Бүлэг болох үйл явцын онолууд; Кари Купер, хянасан; 1975. “Давид.А “Туршилтын сургалтын колб” М.К.Смит; 2001; Дэлгэрэнгүй мэдээллийг <http://infed.org/mobi/david-a-kolb-on-experiential-learning/>.

¹⁰⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг http://en.wikipedia.org/wiki/Neil_D._Fleming.

¹⁰⁹ Хэл шинжлэлийн, логик-математикийн, харааны-орон зайн, хөгжмийн, бие махбодын-хөдөлгөөний, “нийгмийн”, интраперсонал буюу “зөн билгийн” зэрэг олон төрлийн мэдээллийн хэлбэрүүд бий. Дэлгэрэнгүй мэдээллийг www.infed.org/thinkers/gardner.htm.

¹¹⁰ Жишээлбэл, Мария Монтессорин талаар уншиж болно. (http://en.wikipedia.org/wiki/Montessori#Prepared_environment) болон Перри Эмили en.wikipedia.org/wiki/Reggio_Emilia_approach#The_Environment_as_a_third_Teacher).

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМТ ОЛНЫГ БИЙ БОЛГОХ НЬ

“Миний хүний эрх” нь хүний эрхийг хөхиүлэх дэмжихээр олон нийттэй хамтран ажилладаг **Шинэ Зеландын Хүний эрхийн Комисс**ын үүсгэл санаачлага юм. Хамгийн багадаа сүүлийн гурван жил тодорхой олон нийттэй хэлхээ холбоо тогтоохын тулд хүний эрхийн хамт олныг хөгжүүлэх хандлагыг хэрэглэжээ. Хүний эрхийн асуудлыг өөрсдийнх нь хувьд хамгийн ач холбогдолтой зүйл гэж ойлгуулах зорилгоор тус Комисс хувь хүмүүс, байгууллага, агентлагуудтай ажилладаг. Эдгээр бүлгүүд нь тухайн хөтөлбөрт оролцож хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх хамгийн боломжтой гэж үзсэн хүмүүсийн нэрийг нь дэвшүүлдэг.

Оролцогчид Хүний эрхийн талаарх ойлголт, чиглүүлэх ур чадвараа бүтээх зорилгоор өргөжүүлсэн чадавх бий болгох курсэд оролцох замаар Таку Манавад хамрагдаж эхэлдэг. Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шинж чанар нь энэхүү курст агуулагддаг ба Комисс нь энэхүү хөтөлбөрийн нэг хэсэг болгож орон нутгийн гуравдагч байгууллагатай хамтран ажилладаг.

Курс эхэлснээс хойшх эхний нэг жилд Таку Манавагийн хүний эрхийн ажилтнууд тэдний цохон тэмдэглэсэн бүс нутагт үйл ажиллагаагаа хүргэж, хамгийн чухал гэж үзсэн хүний эрхийн асуудлыг олж илрүүлдэг. Олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хувь хүмүүс, бүлгүүдийн өмнөөс өмгөөллийн үйл ажиллагаа явуулах, хүний эрхийн зарчмыг тэдний төлөвлөлтийн нэг хэсэг болгох зорилгоор байгууллагуудтай хамтран ажиллах зэрэг үйл ажиллагаанууд багтдаг. Гол зорилго нь хүний эрхийн үүрэг хариуцлагаа ухамсарлаж үйл ажиллагаа явуулах итгэлцэл, чадавхыг бий болгох явдал юм. Комисс практик зөвлөгөө, бас үйл ажиллагааны зардлын төсвийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг.

Эхний жилийн төгсгөлд Таку Манавагийн хүний эрхийн ажилтнууд болон байгууллагууд хүний эрхийн илүү гүнзгийрүүлсэн хэмжээний төслүүдийг хэрэгжүүлэхээр сонгож болно. Комисс дор хаяж дараагийн хоёр жилийн үйл ажиллагаанд дэмжлэг, зөвлөгөө өгч, төсөв, эх үүсвэрийг үргэлжлүүлэн үзүүлдэг.

Таку Манавагийн ажилтнуудын харилцаа нь харилцан дэмжлэг, эх үүсвэр солилцооны тусламжтай өсөн нэмэгддэг. Хүний эрхийн үйл ажил илүү бие даасан байдалтай явагддаг олон нийтийн чадавх бий болохын зэрэгцээ энэхүү санаачлагын тусламжтайгаар Комисс болон олон нийтийн харилцаа бэхждэг.

Комисс хүний эрхийн олон нийтийг хөгжүүлэх ажлыг 2003 оноос хийж байна. Таку Манава нь одоо зургаан бүст ажиллаж байна. Энэхүү санаачилга хэрэгжиж эхэлснээс хойш өөр өөр газрын 114 олон нийтийн оролцогчид Таку Манавагийн хүний эрхийн ажилтнууд болоод байна. Семинар, презентац зэрэг энгийн үйл ажиллагаанаас өгсүүлээд олон нийтийн фестивал зэрэг илүү цогц үйл ажиллагаануудыг багтаасан 600 гаруй хамт олонд суурилсан үйл ажиллагаануудыг Комисст тайлагнажээ.

Бусад Дэлгэрэнгүй мэдээлэл, бусад кейсүүдийг www.hrc.co.nz/wp-content/uploads/2011/09/Taku-Manawa-Building-Human-Rights-Communities-2011.html цахим хуудсаас уншина уу.



4. ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭМНЭЛЖҮҮЛЭХ

Бүх оролцогчид тогтсон цаг хугацаатай, эсхүл уян хатан байдлаар оролцож байгаа эсэхээс үл хамааран боловсролын үйл ажиллагаа нь тодорхой хугацаатай явагддаг ба оролцогчид өөрсдийн хэмнэлээр оролцдог. Арга зүй болон оролцогчдын ялгаатай сурах хэлбэрүүдэд тохируулдаг тул багш нь агуулга болон үйл явц нь харилцан тэнцвэртэй

байгааг анхаарах үүднээс үйл ажиллагааны цаг хугацааг хянаж байх шаардлагатай. Интернетэд суурилсан технологиуд нь сурагчдад өөрийн хэмнэлээр сурах боломж олгодог виртуал сургалтыг бий болгох нь ихэсч байна.

5. БИЧГИЙН БОЛОН ЯРИАНЫ ХАРИЛЦААНД ХЭРЭГЛЭХ ХЭЛ БА БИЧИГ

Хэл нь сэтгэлгээ, итгэл үнэмшил болон соёлын талаарх мэдээллийг илэрхийлдэг. Энэ нь оролцогчдод үнэлэгдсэн, нууцыг хадгалсан нээлттэй болоод нууц мэдээллийг агуулж болно. Сонсогчтой зөвшөөрөгдөх хэлбэрээр холбогддог ба тэдний хүлээн авах, хүлээн авахгүй байх мэдрэмжийг нь өргөжүүлж чаддаг.

Жишээ нь Англи, Франц, Испани хэл нь жендэрийг тодотгосон олон үгсийг агуулдаг ба, эм хүйснийхээс илүү эр хүйсний нэр томьёонд эрх дарх олгосон гэж маргаан дагуулдаг. Жишээлбэл, англи хэлнээ “man” гэдэг үг ерөнхий нэр томьёонд тогтмол хэрэглэгддэг. “Chairman”, “policeman” болон “congressman” зэрэг үгс нь эмэгтэйчүүдэд биш, эрэгтэйчүүдэд хамаарах үүрэг роль болохыг дам илэрхийлдэг. Арьсны өнгийг тодорхойлоход бас л хэлийг хэрэглэж болно. Англи хэлэнд “whitewash” гэдэг үг ямар нэг муу зүйлийг далдлах, халхлах гэсэн тга илэрхийлдэг бол “black mark” гэдэг үг хэн нэгэн хүн ямар нэг зүйлийг буруу хийснийг цохон тэмдэглэж, цаашид үүнийг нь санаж байхыг илэрхийлдэг.

Түүхийн номонд тэмдэглэгдсэн, Шинэ Зеландын сургуулиудад олон арван жилийн турш заасан буруу мэдээллийн нэг нь “Ахмад Кук Шинэ Зеландыг нээсэн” гэх мэдээлэл юм. Энэ нь өмнө энэ газарт амьдарч асан уугуул иргэдийг үл ойшоосон хэрэг. Хүний эрхийн багшийн хэл, мэдээлэл, түүнчлэн хэрэглэсэн материал зайлшгүй нарийн нягт боловсруулсан байх ёстой ба хууль бус, нотлогдоогүй мэдээллийг өгөхгүй байхаар хянагдсан байх ёстой.

Хүний эрхийн хэл нь нийтлэг бус нэр томьёо, ойлголтуудаар дүүрэн байдаг. Багшид тулгардаг нэг асуудал бол тухайн хэрэглэж буй хэл нь хам сэдэвтэйгээ тохирч, нийцэж байгаа эсэхийг анхаарах явдал юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зүйл заалтыг энгийн ойлгомжтой хэлээр орчуулсан зарим жишээг дор харуулав.¹¹¹

Хүний эрхийн түгээмэл тунхаглал	Энгийн хэлээр илэрхийлсэн нь
Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй. (7-р зүйл)	Хууль хүн бүрт ижил үйлчилнэ.
Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааны нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй. (12-р зүйл)	Таны сайн сайханд хор учруулах, гэрт тань нэвтрэх, захидлыг таны нээх, таныг, эсхүл таныг гэр бүлийг ямар нэг сайн шалтгаангүйгээр зовоох гэж оролдвол хамгаалуулах хүсэлт тавих эрхтэй.
Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх эрхтэй. Энэхүү эрхэнд шашин буюу шүтлэгээ өөрчлөх эрх чөлөө, бие даан буюу бусадтай хамтран нийтийн өмнө болон хувийн журмаар хичээл заах, хурал мөргөл хийх, шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх зэргээр шашин буюу шүтлэгээ номлох эрх чөлөө багтана. (18-р зүйл)	Та өөрийн хүссэнээр болон бусадтай хамтран шашныг чөлөөтэй номлох, үүнийгээ өөрчлөх эрхтэй.
Хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй. (24-р зүйл)	Хүн бүр амрах эрхтэй тул ажлын өдөр урт байх ёсгүй ба амралтын өдрүүдээр цалинжих эрхтэй.

¹¹¹ “НҮБ-ын Хүний эрхийн тухай тунхаглал: Хялбаршуулсан хувилбар; НҮБ Кибер сургууль-Автобус; дэлгэрэнгүй мэдээллийг www.un.org/cyberschoolbus/humanrights/resources/plain.asp.



Үйл ажиллагаа нь хүний эрхэд суурилсан хамт олон. Оптоки, Шинэ Зиланд. Гэрэл зургийг Жилл Крисп

6. ҮЙЛ ЯВЦЫГ ХЯНАЖ, НЯГТЛАХ НЬ

Бүлэг 8 нь үнэлгээний техникүүд дээр төвлөрсөн болно. Гэсэн ч хянаж, нягтлах нь хэрэгжүүлэх үйл явцын нэг чухал хэсэг болохыг тэмдэглэх нь чухал. Өмнөх бүлэгт тодорхойлсон Логик загвар нь тухайн үйл ажиллагаа хүрэхийг хүсч байсан үр дүндээ хүрсэн эсэхийг үнэлэх бүтцээр хангадаг.

Төлөвлөлтийн шат нь үр дүнд чиглэсэн үйл явцыг үнэлэхэд хэрэглэж болох шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах асуудлыг хамардаг. Үйл явц хийгдэж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийх, үр дүндээ хүрэхэд ямар нэг эрсдэл байгаа эсэхийг тодорхойлох явдлыг хэрэгжүүлэх үед цагт баригдах шаардлагагүй. Хэрэв хяналтын үйл явц үр дүнтэй хэрэгжиж байвал үйл ажиллагааны явц болон агуулгад зарим өөрчлөлт хийснээр үр дүнд хүрэх магадлал их.

Хяналтын үр дүнг баримтжуулах нь эцсийн үнэлгээний үр дүнг баримтжуулахтай адил чухал зүйл. Энэ нь хийгдчихээд байгаа үйл явцыг илтгэн харуулах чухал мэдээллийг цуглуулахад тус болдог ба эцсийн үнэлгээнд шаардагдах мэдээлэлд хувь нэмрээ оруулдаг.

7. АЛИВААГ ТУСГАН АВАХ ДАДАЛ, УДИРДЛАГА, ӨӨРТӨӨ ТАВИХ АНХААРАЛ

Хүний эрхийн боловсролын ажил нь хүч чадал шаардсан, хариуцлага өндөр, чадлыг шавхаж чадна. Багшийн хувьд өөрийн ажлын гүйцэтгэлээ үнэлэх, өөрийгөө хөгжүүлэх, амжилтаа ахиулах боломжийг хянах, өөртөө хангалттай анхаарал тавих нь чухал. Энэ бол аливааг тусган авах дадлын нэг хэсэг.

Эдгээрийг хийх олон янзийн арга зам байдаг ба багш нар тухайн нөхцөлд аль хандлага хамгийн тохиромжтой байгааг сонгоно. Стратегиуд нь хариу зөвлөгөө хүсэх, хувь хүмүүсийн эсхүл бүлгийн хяналтыг хэрэгжүүлэх, тусгалт сэтгүүл зүй, стресс удирдлагын техникүүдийг хэрэглэх, хөгжих, амрах цагийг хуваарилах зэрэг байж болно.

ДОЛДУГААР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

Хүний эрхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хүний эрхийн багшийн анхаарах ёстой гол асуудлууд нь:

- Багшийн тодорхой үүрэг ролийг тодорхойлох
- оролцогчдын ялгаатай сурах хэлбэрүүдэд таньж мэдэх, хариу үйлдэл үзүүлэх
- сургалтын үр нөлөөтэй орчныг бий болгох
- тухайн сэдэв болон оролцогчдын үйл ажилагааны хэмнэлийг тохируулах
- бүхнийг хамарсан, ойлгомжтой хэл хэрэглэх
- үйл ажиллагааны явцыг хянах
- хувийн ажлын ачаалал, бусад стрессын талаар анхааралтай байж, хэрэг болсон үед тохиромжтой дэмжлэгийг эрж хайх.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Бүгд ялгаатай – Бүгд тэгш: Боловсролын багц; Европын зөвлөл; 1995 он

Олон нийтийн зохион байгуулагчдын гарын авлага; Ардчилал, хөгжлийн төлөө боловсрол, сургалтын төв; Дэлгэрэнгүй мэдээллийг www.etu.org.za/toolbox/docs/building/webtraining.html

Үр өгөөжийн төлөөх сургалтыг идэвхижүүлэх нь; Train4Dev; 2011 он

Хувь хүний өөрчлөлтийг чиглүүлэх чадвар; Рон Крэйбилл, Зөрчилдөөний менежментийн Берхоф судалгааны төв; 2004 он

Идэвхижүүлэгчийн гарын авлага; Хүүхдийн эрхийн төлөөх үйл ажиллагаа / Хүрч ажиллах нь; 2005 он; Дэлгэрэнгүй мэдээллийг https://icvanetwork.org/system/files/versions/ro_28_toolkit.pdf

Цагдаад зориулсан Хүний эрхийн боловсролын арга зүй: БНСУ-ын Хүний эрхийн үндэсний комисс; 2008 он

Дахин дуугарсан дуу хоолой; Ази Номхон далайн бүсийн оролцооны аргуудын судалгаа; Ази-Номхон далайн бүсийн хүний эрхийн боловсролын нөөцийн төв; 2004 он

Өөрчлөлтийн төлөө сургалт. Олон нийтийн ажилтнуудын гарын авлага; Анне Хопе, Салли Тиммел нар; 1, 2, 3 дахь номууд (1984) 4 дэх ном (1999)

Бид зааж байсан аргаараа заана, Эсхүл бид бусдын сурах аргын дагуу заана; Сьерра Сургалтын холбоод; 2007 он; Дэлгэрэнгүй мэдээллийг <http://sph.bu.edu/otlt/teachingLibrary/Learning%20Theory/adultlearning.pdf>



БҮЛЭГ 8.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ҮНЭЛЭХ НЬ

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД

- Үнэлгээ гэж юу вэ, энэ нь хүний эрхийн боловсролд яагаад чухал вэ?
- Үнэлгээний шалгуур нь юу вэ?
- Үнэлгээг хэрхэн явуулдаг вэ?
- Үнэлгээний үр дүнг хэнд, хэрхэн тайлагнадаг вэ?



Хүний эрхийн боловсролын дадлага туршлага бүхий хүн болохын хувьд боловсролын үнэлгээний үүргийг шинэлэгээр ойлгож хэвших нь чухал. Бидний ажилд боловсролын үнэлгээ ашиг тусаа хэрхэн өгч чадах вэ? Хэрэв оролцогчид ямар нэг зүйл сурч авсан бол хүний эрхийн сургалтын төгсгөлд санал асуулга тараан өгөх нь хангалттай юу, эсхүл үнэлгээ хийх нь үүнээс илүү үүрэг рольтой юу? Боловсролын үнэлгээний үзэл баримтлалыг хайн илрүүлэх нь үнэлгээ гэж чухам юу болох, энэ нь манай хүний эрхийн боловсролын ажлыг хэрхэн өргөжүүлж чадавхыг талаарх бидний санааг тэлж чадна.¹¹²



Хүний эрхийн боловсролын практик дахь гурав дахь үйл явц бол үнэлгээ юм. Үйл ажиллагааны дундуур, эсхүл дараа ялгаагүй үр дүн, гүйцэтгэлийн ахиц дэвшилд хувь нэмрээ оруулдаг мэдээллийг цуглуулах ажлыг үнэлгээ хамардаг.

Энэ бүлэгт үнэлгээний зорилго, хэлбэрүүдийг тодорхойлж, хүний эрхийн боловсролын төрөл бүрийн үйл ажиллагаанд зориулсан арга зүй, техникүүдийг санал болголоо.

Зураг 8.1: Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаан дахь үнэлгээний үе шат



¹¹² Хүний эрхийн сургалтын үйл ажиллагааг үнэлэх нь: Хүний эрхийн сургагч багшийн гарын авлага; ХЭДКГ болон Эквитас; 2011 он хуудас. 17.

1. ҮНЭЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Хүний эрхийн боловсролын үнэлгээ нь түүнийг хэрэгжүүлж байхад болон дуусах үед урьдаас төлөвлөсний дагуу хийгдэх үнэлгээний ажил юм. Үнэлгээ нь зорьж буй үр дүндээ хүрэхэд тухайн боловсролын үйл ажиллагааны оруулах хувь нэмрийг үнэлэх боломжийг багшид олгодог. Энэ нь хэрэглэж болохуйц дараах мэдээллээр хангана. Үүнд:

- Үйл ажиллагааны үйл явц ба үр дүнг сайжруулах
- Үйл ажиллагааг ирээдүйд сайжруулахад хувь нэмрээ оруулах
- Хүний эрхийн багш нарын практикийг өргөжүүлэх
- Боловсролын үйл ажиллагаагаар хангаж буй хүний эрхийн үндэсний байгууллага зэргийг оролцуулан санхүүжүүлэгчдийн хариуцлагыг баталгаажуулах
- Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа явуулах бусад хүмүүст хэрэгцээтэй байж болох мэдээллээр хангах

Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа бүрт үнэлгээг хийхээр загварчлах, үйл ажиллагааны дундуур болон төгсгөлд нь үнэлгээг зохион байгуулах нь чухал. Үйл ажиллагааны дундуур үнэлгээ хийгдэж байгаа бол эдгээрийг явцын үнэлгээ, хяналт шинжилгээ, тойм дүгнэлт гэж нэрлэж болно. Үйл ажиллагааны төгсгөлд хийгдэж байвал нэгтгэн дүгнэх үнэлгээ гэж нэрлэж болно.

Явцын үнэлгээ нь үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад байнга, тогтмол хийгддэг. Үүнд:

- үйл ажиллагааны хэрэгжилтийн үйл явцыг болон энэ нь төлөвлөсөн үр дүнд хүрэх магадлалтай эсэхийг үнэлэх
- үйл явцыг сайжруулахын тулд үйл ажиллагааны загвар, хэрэгжилт, багшийн практик зэрэгт хэрэг болж мэдэх өөрчлөлтийг тодорхойлох

Нэгтгэн дүгнэх үнэлгээг үйл ажиллагааны төгсгөлд хийнэ. Үүнд:

- Үр нөлөө, үр дүнгийн түүхийг ярьж өгөх
- Ирээдүйн сургалтын үйл ажиллагааны үр нөлөөг хэрхэн сайжруулах талаарх мэдээллээр хангах.¹¹³

Үнэлгээ нь үйл ажиллагааны үр нөлөө, түүнчлэн багшийн ажлын гүйцэтгэл, төлөвлөлт, хэрэгжилтэд оролцсон хүний эрхийн үндэсний байгууллагыг анхаардаг. Урт төсөлтэй нэгэн ажилтай нэгэн адил богино хэмжээний презентаци тавихад ч хамаатай. Үр дүнтэй үнэлгээний цор ганц загвар гэж байхгүй. Үнэлгээ хийх ур чадвар нь багшид шаардлагатай мэдээллийг өгөх, мөн үйл ажиллагаа явуулах багш болон бүлэг, байгууллагад хүргэх боломжийн аль алиныг сонгох үйл явц юм.

2. ҮНЭЛГЭЭ ХИЙХ

Хэдийгээр хүний эрхийн боловсролыг үнэлэх олон арга байгаа ч олон төрлийн аргачлалын хэрэглэж болох үйл явц байдаг. Хүний эрхийн дээд Комиссарын газар болон Эквитасын боловсруулсан хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд үнэлгээ хийх гарын авлагад дараах таван шатыг санал болгожээ:

- Шаардлагатай өөрчлөлтийг ойлгох
- Хүсч буй өөрчлөлтийг тодорхойлох
- Үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх /явцын үнэлгээ/
- Бий болсон өөрчлөлтийг үнэлэх /нэгтгэн дүгнэх үнэлгээ/

¹¹³ Хүний эрхийн сургалтын үйл ажиллагааг үнэлэх нь: Хүний эрхийн сургагч багшийн гарын авлага; ХЭДКГ болон Эквитас; 2011 он, хуудас. 33.

- Үнэлгээний үр дүнгүүдийн харилцан хамаарлыг тогтоох.¹¹⁴

Үнэлгээний үйл явц нь төлөвлөлт, загварчлалын үйл явцтай нягт холбоотой. 6-р бүлэгт авч үзсэн Логик загвар нь үнэлгээний үйл явцыг төлөвлөлтийг чиглүүлдэг. Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь хүний эрхийн нөхцөл байдлын талаарх болон хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны загварчлалд хэрхэн нөлөөлөх тухай мэдээллийг өгдөг.

Үр дүн нь үйл ажиллагааны хүлээгдэж буй дүнг тодорхойлдог. **Орц** ба **гарц** нь үр дүнд хэрхэн хүрч болохыг тодорхойлно.

Үнэлгээг загварчлах, хэрэгжүүлэх үедээ хүний эрхийн багш нь шалгуур үзүүлэлт, арга зүйгээ шийдэх хэрэгтэй болно.

2.1. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хүний эрхийн боловсролыг үнэлэх нийтлэг шалгуур үзүүлэлтийг дор жагсаав. Хэдийгээр эдгээр шалгуур үзүүлэлтийг бүхий л үйл ажиллагаанд ашиглах боломжгүй ч энэ нь хэрэгтэй удирдамж болно.

Хамаарал	Үйл ажиллагаа нь оролцогч бүлэг, бусад оролцогч талуудын тэргүүлэх чиглэлтэй уялдаж байна уу?
Зохист байдал	Тухайн хэрэгжиж байгаа хам сэдэв, оролцогчдын шинж чанартай үйл ажиллагаа уялдаж байна уу?
Үр нөлөө	Үйл ажиллагаа зорилго, үр дүндээ хэр зэрэг сайн хүрсэн бэ?
Үр ашиг	Үйл ажиллагааны төлөвлөлт, загварчлал, хэрэгжилтэд гаргасан хүчин чармайлт болон нөөц нь байж болох нөлөөллийн түвшинтэй нийцэж байна уу?
Үр дагавар	Хүний эрхийн ерөнхий зорилгодоо хүрэхэд тухайн үйл ажиллагаа хэр зэрэг хувь нэмэр оруулсан бэ?
Тогтвортой байдал	Тухайн үйл ажиллагааны турш бий болсон үр дүн нь эцсийн мөч хүртлээ үргэлжилж чадах уу? ¹¹⁵

2.2. Үнэлгээний арга зүй

Үнэлгээний өргөн хэрэглэгддэг 3 хэлбэр бий. Өөрөө өөрийгөө үнэлэх, хамтын үнэлгээ, хөндлөнгийн үнэлгээ болно. Эдгээр үнэлгээний хэлбэрүүдийг алиныг нь ч дангаар, эсхүл бусадтай хослуулан хэрэглэж болно. Өөрийгөө үнэлэх, эсхүл хамтаараа, хөндлөнгийн үнэлгээ эсхүл хослуулан хэрэглэхдээ дараах асуудлыг анхаарах нь чухал:

- Үнэлгээний зорилго
- Үйл ажиллагааны цар хүрээ, үргэлжлэх хугацаа, нарийн төвөгтэй байдал
- Багшийн туршлага, мэдлэг
- Хариуцан тайлагнах гадаад оролцогч талууд, санхүүжүүлэгчид байгаа эсэх
- Бие даасан, шинэ хандлагын ашиг тусыг тухайн үйл ажиллагаа олж авсан эсэх
- Гурван талт мэдээллийн хэрэгцээ байгаа эсэх (жишээлбэл, үнэлгээний үр дүнг олон тооны эх сурвалж, арга зүй ашиглан баталгаажуулах)

Дүрэм ёсоор илүү цогцоор, хөндлөнгийн нүдээр үйл ажиллагааг үнэлэхэд анхаарал их шаардагдана. Олон талт үйл ажиллагаан дээр өөрийгөө үнэлэх нь үр дүнтэй байдаг ба хамтын болон хөндлөнгийн үнэлгээнд хувь нэмрээ оруулдаг. Хавсралт 8-д өөрийгөө, хамтын болон хөндлөнгийн үнэлгээний задаргаа, тэдний давуу болон сул талыг орууллаа.


¹¹⁴ Хүний эрхийн сургалтын үйл ажиллагааг үнэлэх нь: Хүний эрхийн сургагч багшийн гарын авлага; ХЭДКГ болон Эквитас; 2011 он, хуудас. 34–35.

¹¹⁵ Энэхүү хэмжүүр нь илүү урт хугацааны гүнзгийрүүлсэн үйл ажиллагаанд тохиромжтой.

Үнэлгээний олон арга зүй байдаг ба алийг нь хэрэглэх вэ гэдгийг шийдэх нь амаргүй ажил. Багшийн үүрэг бол тухайн үйл ажиллагааны хэлбэр, зорилт, үр дүн, хам сэдэв, эх үүсвэрийн боломж зэрэгтэй тохирохуйц үнэлгээний арга зүйг боловсруулах явдал юм. Заримыг нь дор жагсаав.

Тохиолдол шинжлэл	Бодит амьдрал дээрх нөхцөл байдлыг ойлгохын тулд үйл явдал, туршлагад шинжилгээ хийх
Тэмдэглэл	Тухайн үйл ажиллагааны үеэр тохиолдсон чухал үйл явдал, үйл ажиллагаа, үйл явцыг бичиж тэмдэглэх. Энэ нь үйл ажиллагаа болон оролцогчдын туршлагын талаарх мэдээллийг өгдөг.
Бүдүүвч зураг	Үйл ажиллагааны түүх, төлөвлөсөн болон гүйцэтгэсэн үйл ажиллагаа, үр дүнг илтгэн харуулах визуал бүдүүвч зураг.
Фокус групп	Тодорхой сэдвийн хүрээнд чиглүүлсэн хэлэлцүүлгээр дамжуулж хэлэлцүүлгийн жижиг бүлгүүдийг бий болгож болох ба илүү гүнзгий мэдээлэл цуглуулахад ашиглана. Хэлэлцүүлгийн үеэр тэд бүлгийн динамикийн үр дүн болон харилцаа холбооны талаарх баялаг мэдээллийг өгч чадна. Үндсэндээ чанарын мэдээлэл голчилно.
Ярилцлага	Гол оролцогч талуудтай бүтэцчилсэн, хагас-бүтэцчилсэн хэлэлцүүлэг хийх. Ярилцлагыг биечлэн, эсхүл утсаар, мөн ганцаарчлан, эсхүл олон хүнтэй зэрэг гэх мэтээр хийж болно.
Түүврийн шинжилгээ	Тухайн нөхцөл байдал, сэдвийн хүрээнд хэвлэгдсэн болон хэвлэгдээгүй материалыг цуглуулж, дүн шинжилгээ хийх
Зураглал	Үнэлгээнд хамрагдах фокус, хэлбэрүүдийн өөрчлөлтийг зураг, дүрслэлээр илэрхийлэх
Ажиглалт	Үзэх, сонсох замаар зан үйлийг баримтжуулах. Ажиглалтын тусламжтай хүмүүс юу хийж байна, хэзээ тэд хийж байна, хаана, хэрхэн хийж байгааг харах боломжтой.
Ярианы тэмдэглэл	Хувь хүн, бүлэг, хамт олны өөрчлөлт дээр анхаарлаа төвлөрүүлэх замаар үйл явцыг тусган авах.
Гэрэл зураг/Дүрсжүүлэлт	Тухайн цаг үед тохиолдсон нөхцөл байдал, сэдвийн өөрчлөлтийг гэрэл зургаар баримтжуулах
Статистик анализ	Тодорхой сэдэв, нөхцөл байдлын статистик мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх
Түүх яриа	Үйл ажиллагааны талаар ярьсан түүх. Тухайн үйл ажиллагааны хүчтэй болон сул талын талаарх чухал мэдээллийг тодотгох зорилготой.
Судалгааны асуулга	Үйл ажиллагааны зорилго, үр дүнтэй холбоо бүхий мэдээллийг цуглуулахаар бэлтгэсэн асуултуудын цогц. Асуулгын мэдээлэл нь тоон болон чанарын, байж болох ба мэдлэг, хандлага, зан үйл болон хариу үйлдлийг харж болно. Судалгааны асуулга нь ихэвчлэн бичмэл байдаг ч онлайнаар, ярилцлагаар, эсхүл цаасаар авч болдог.
Санал асуулга	Тоон үнэлгээ өгөх замаар оролцогчид үйл ажиллагааны бүрэлдэхүүн, түүний талаарх өөрсдийн үнэлгээг өгдөг.

Энэхүү гарын авлагын 4 дүгээр бүлэгт цаашдын илүү тодорхой үнэлгээний аргачлал, техникүүдийг багтаав. Хавсралт 9–д 4–р бүлэгт орсон хүний эрхийн боловсролын зарчмуудыг ашиглаж үйл ажиллагаа хэр зэрэг сайн загварчлагдаж, хэрэгжиж, үнэлэгдэж байгааг үнэлэх арга хэрэгслийг багтаав.



Гэрэл зургийг Жилл Крисп

3. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

Бүхий л үнэлгээ нь тодорхой сэдвээр, тодорхой хүмүүсийн зохион явуулсан тодорхой үйл ажиллагааны түүхийг өгүүлэх нэгдмэл зүйл юм. (ОНСНР/Equitas-ын гарын авлага)

Үнэлгээний эцсийн шат бол үр дүнг харилцан мэдээлэх. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны мөн чанар, зорилгоос хамааран хэнд үр дүнг нь хүргүүлэх, хэрхэн харилцан мэдээлэл дамжуулах нь олон янз байна. Ямар ч үед үнэлгээнд оролцсон хүмүүст үнэлгээний үр дүнг хүргүүлэх хэрэгтэй.

Үнэлгээний үр дүнг ямар ч хэлбэрээр, тухайлбал, мэдээлэл цуглуулах, хүснэгтлэх, график хийх, видео, хэвлэлийн мэдээ бэлтгэх, багц баримт бүрдүүлэх, гэрэл зураг авах гэх мэтээр баримтжуулж болно. Бүтээлч арга зүй, тухайлбал, гэрэл зураг, урлаг, хөгжим, жүжиг зэрэг нь хэрэв тохиромжтой бол маш хүчтэй нөлөө үзүүлж чадна. Мэдээллийг дамжуулах нийтлэг аргын нэг бол сүүлчийн, нэгтгэн дүгнэх үнэлгээг бичмэл хэлбэрээр тайлагнах явдал юм.

Мөн тохиромжтой хосолмол аргуудыг ашиглаж болно. Олон нийтэд үнэлгээг мэдээлэхдээ бүтээл хэлбэрээр, мөн тухайн хамт олны гишүүдийг оролцуулах зэрэг байж болох ба санхүүжлүүлэгчид өгөх үнэлгээг бичмэл тайлан хэлбэрээр хийж болно. Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар болон Эквитасаас тэмдэглэхдээ:

*Сургалтын бүрэн түүхийг илтгэх тайланг өөр өөр үзэгч, оролцогч талуудад бичих боломжтой. Цуглуулж байгаа мэдээллийг зохион байгуулах, тайлбарлахдаа та эерэг болон сөрөг туршлагаас тань бусад хүмүүс суралцах боломжийг олгож, бусад хүмүүст хүртээмжтэй байдлыг хангаж болно. Үнэлгээний тайланг бичих нь хүний эрхийн сургалтаар олж авсан амжилтыг тодотгох, нийгмийн томоохон өөрчлөлтийг хийх өөрийн хувь нэмрээ илэрхийлэх боломж юм.*¹¹⁶

Үйл ажиллагааны амжилтыг бүртгэлжүүлэхдээ түүний гарцаас илүүтэй үр дүнг нь баримтжуулахад төвлөрөх хэрэгтэй. Мэдээж гарцыг анхаарах нь чухал, тухайлбал хэдэн оролцогч хамрагдав, хэдэн хурал уулзалт хийгдэв, хэдэн байгууллага сүлжээнд хамрагдав, вэб сайтад хэдэн хүн зочлов гэх мэт.

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь үйл ажиллагааны үр дүнгээс ахиц дэвшил олж авахтай адилгүй. Үйл ажиллагаа нь үр дүндээ хүрсэн эсэх, хүний эрхийн нөхцөл байдалд амжилттай нөлөөлж чадсан эсэхийг мэдэж авах нь чухал.

¹¹⁶ Хүний эрхийн сургалтын үйл ажиллагааг үнэлэх нь: Хүний эрхийн сургагч багшийн гарын авлага; ХЭДКГ болон Эквитас; 2011 он, хуудас. 116.

Үр нөлөөг бүртгэлжүүлэх нь үйл ажиллагааны хэмжээнээс илүүтэй үр дүнг баримтжуулахад анхаарахыг шаарддаг. Логик загвар үр дүнгийн шалгууруудыг бий болгочихсон байх болно.

Үйл ажиллагаа	Гарцууд	Үр дүн
Түгээмэл нэгдсэн хэлэлцүүлэгт хувь нэмрээ хэрхэн оруулж болох тухай мэдээллийн товхимлыг загварчилж, түгээх	Тараасан товхимлын тоо	[No.] эмхэтгэлийг уншсаны үр дүнд Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн үйл явцад хувь нэмрээ оруулсан хүмүүс/байгууллагууд
Түгээмэл нэгдсэн хэлэлцүүлгийн тухай сургалт, семинар зохион байгуулах	Семинар, түүний оролцогчдын тоо	[No.] боловсролын үйл ажиллагааны үр дүнд өөрсдийн хүний эрхийн асуудлаа тодорхойлж, улмаар эдгээр асуудлаараа Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн үйл явцад хувь нэмрээ оруулсан хүмүүс/нийгэмлэгүүд/бүлгүүд
Түгээмэл нэгдсэн хэлэлцүүлгийн явцын талаарх боловсролын үйл ажиллагаа зохион байгуулах	Үйл ажиллагаа, түүний оролцогчдын тоо	[No.] семинарын үр дүнд Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн үйл явцын талаарх мэдлэг, мэдээлэл нь нэмэгдсэн хэмээн мэдээлж буй хүмүүс
Түгээмэл нэгдсэн хэлэлцүүлгийн үйл явцад дэмжлэх үзүүлэх сүлжээг ашиглах	Мэдээлэл дамжуулсан байгууллага, хүмүүсийн тоо	[No.] сүлжээгээр дамжуулж холбоо харилцаа тогтоосны үр дүнд Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн үйл явцад хувь нэмрээ оруулж байгаа хүмүүс/байгууллагууд

8 ДУГААР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хүний эрхийн боловсролын үнэлгээ нь тухайн үйл ажиллагаа өөрийн үр дүндээ чиглэж байгаа эсэх, цаашид ямар сайжруулалт хийж болохыг хэлж өгдөг. Энэ нь үйл ажиллагааны дундуур, эсхүл төгсгөлд нь хийгддэг.
- Хүний эрхийн боловсролыг үнэлэх шалгуур үзүүлэлтийн нийтлэг бүтэц нь:
 - Хамаарал
 - Зохист байдал
 - Үр нөлөө
 - Үр ашиг
 - Үр дагавар
 - Тогтвортой байдал
- Бүхий л үед эдгээр шалгуур үзүүлэлтийг бүгдийг нь хэрэглэхгүй.
- Үнэлгээг зохион явуулах олон арга зүй бий. Үйл ажиллагаа, хамрагдаж буй оролцогчдын нөхцөл байдалтай үнэлгээний арга зүй уялдаж байх нь чухал. Үнэлгээнд оролцсон хүмүүст үнэлгээний үр дүнг байнга мэдээлж байх нь зөв.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын үр дүнг үнэлэх нь; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2005 он

Дэвшилийг баталгаажуулж, Үр дүнг харуулах нь: Сургуулиас гадуурх хөтөлбөрийг үнэлэх нь; Харвард Гэр бүлийн судалгааны төсөл; 2002 он; Дэлгэрэнгүй мэдээллийг www.hfrp.org/publications-resources/browse-our-publications/documenting-progress-and-demonstrating-results-evaluating-local-out-of-school-time-programs

Хүний эрхийн сургалтын үйл ажиллагааг үнэлэх нь: Хүний эрхийн сургагч багшийн гарын авлага; ХЭДКГ болон Эквитас; 2011 он

Үнэлгээ ба үнэлгээний хэлбэрүүд; Шинжлэх ухааны үндэсний сан; 2000 он

Гадаад үнэлгээ: Бид зөв зүйл хийж байна уу? Бид уг зүйлсийг зөвөөр хийж байна уу?; Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны агентлаг; 2000 он

Төлөвлөлтийн гарын авлага, Хөгжлийн үр дүнгийн төлөө мониторинг ба үнэлгээ; НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр; Дэлгэрэнгүй мэдээллийг <http://web.undp.org/evaluation/handbook/ch7-4.html>

Мониторинг ба Үнэлгээ; CIVICUS Иргэний оролцооны дэлхийн холбоо; Дэлгэрэнгүй мэдээллийг www.civicus.org/new/media/Monitoring%20and%20Evaluation.pdf

Мониторинг ба Үнэлгээ; Дэлхийн банк; Дэлгэрэнгүй мэдээллийг <http://siteresources.worldbank.org/INTBELARUS/Resources/M&E.pdf>

Багц хэрэгслийг сайжруулах нь: 5 дахь хэсэг, Үнэлгээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх нь; Олон нийт, залуучуудын хөгжлийн Шинэчлэл төв; 2005 он; Дэлгэрэнгүй мэдээллийг www.theinnovationcenter.org/files/doc/B5/RI%20pp%2068%20Evaluation%20Methods.pdf

Боловсролын тогтолцоон дахь иргэний боловсролын ахицын тухай судалгаа: Аж үйлдвэржсэн орнууд дахь сайн туршлагууд; Аудрей Ослер, Хюг Старкей, Лийдс Их сургуулийн Иргэний ба хүний боловсролын төв, Лондоны их сургуулийн Боловсролын хүрээлэн; 2004 он

Мониторинг ба Үнэлгээний хүрээ; 1 дэх хэсэг; НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр; Дэлгэрэнгүй мэдээллийг http://web.undp.org/evaluation/documents/HandBook/part_1.pdf

Хамтдаа илүү Сайн: Хамтын ажиллагаа, Үнэлгээ ба тайлагналт; Анне Дэвис, Карен Камерун, Коллен Политано, Катлийн Грегори; 1992 он

Оролцоо бүхий үнэлгээнд залуучуудыг оролцуулах үр дүнтэй аргууд; Мер Гавлер, 2005 он; Дэлгэрэнгүй мэдээллийг www.artemis-services.com/downloads/tools-for-participatory-evaluation.pdf



БҮЛЭГ 9:

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ АЖИЛЛАХ НЬ¹¹⁷

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД:

- ХЭҮБ–ууд яагаад хэвлэл мэдээлэлтэй ажиллах ёстой вэ?
- ХЭҮБ–уудын хүний эрхийн боловсрол ямар үр дүнд хүрэх вэ?
- Хамт олны мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн асуудалд хандсан үйл ажиллагааг хөхиүлэн дэмжихийн тулд ХЭҮБ–ууд хэрхэн хэвлэл мэдээлэлтэй үр нөлөөтэй ажиллах вэ?
- Холбогдох талуудтай мэдээлэл солилцох, үйл ажиллагааг хөхиүлэн дэмжихийн тулд ХЭҮБ–ууд нийтийн мэдээллийн хэрэгслийг хэрхэн ашиглах вэ?



1. ТАНИЛЦУУЛГА

Хүний эрхэм чанар, шударга байдал болон нас, жендэр, нийгмийн байдлыг харгалзалгүй хүмүүсийг хүндэтгэх зэрэг хүний эрхийн тулгуур үндсэн дээр хүчтэй, бусдыгаа татан оролцуулсан хамт олон бий болдог тул хамт олон “хүний эрх” гэж юу болохыг ойлгож, өдөр тутмын амьдралдаа хэрхэн ашиглаж байгааг мэдэх нь чухал. Хэвлэл мэдээлэл¹¹⁸ бол олон нийтэд ойлголт бий болгох, нийгэм, улс төр, эдийн засгийн чиглэл тогтоодог тусгай арга хэрэгсэл юм. Нийтийн мэдээллийн хэрэгсэл хурдтай өсч тэлснээр хүмүүс, байгууллагуудыг нэг нэгэнтэй нь шууд холбох, мэдээлэл хуваалцах шинэ арга зам бүрдсэн ч тэр бүр интернэт ашиглах боломжгүй олон хүний хувьд уламжлалт мэдээллийн эх сурвалжаас үзэл бодол, мэдээлэл эрэлхийлсээр байна. Хэвлэл мэдээллийн удирдлага, эрхлэгч, сэтгүүлчид “мэдээлэл” юунд тулгуурлахыг шийддэг. Тэд асуудлуудыг шүүлтүүрдэн, хүрээг тогтоож, сурвалжилсан арга хэмжээгээ хүмүүст ойлгуулах үндсийг тавьдаг. Хэвлэл мэдээлэл бидэнд юу гэж бодох талаар хэлдэггүй боловч юуны талаар бодох тухайд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Хүний эрхийн асуудлууд улам мэдээллээс хамааралтай болж байна. Хэвлэл мэдээлэл “гагцхүү хүний эрхийн зөрчилд анхаарал хандуулалгүй хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах байгууламжийн бүтцэд” чиглэж байна.¹¹⁹ Оновчтой, мэдээлэл сайтай, тогтвортой байдлаар хүний эрхийн тухай, тодруулбал эрүү шүүлт, жендэрт суурилсан хүчирхийлэл, эсвэл дүрвэгсэдтэй харилцахтай холбоотой асуудлын талаар хэвлэл мэдээлэл цацаж ажиллавал хамт олны хандлага тогтох, эрх зүй, бодлого, туршлагын хувьд хууль ёсны өөрчлөлт хийхэд туслах боломжтой.

Нөгөө талаас зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хамт олны дунд нийгмийн сул тал, ялгаварлан гадуурхалтыг улам гааруулах хэвшмэл загварууд бэхжсээр байна. ХЭҮБ–ууд олон нийтийн зүгээс нүүр тулж байгаа хүний эрхийн асуудлуудын талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэхийн тулд “мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, мөн хэвлэл мэдээлэл хэрэглэх, ашиглах¹²⁰” хариуцлага хүлээдэг. Энэ үүргээ үр нөлөөтэй гүйцэтгэхийн тулд ХЭҮБ–ууд хэвлэл мэдээлэл хэрхэн ажилладаг, харилцан адилгүй ямар хүмүүст хүрдэг, зарим сэтгүүлчид хүний эрхийн талаар мэдлэг дулимаг байдаг, тодорхой асуудлыг сурвалжлахад сэтгүүлчдэд тулгарах олон төрлийн дарамт шахалт, “шуурхай” мэдээг эн тэргүүнд дамжуулах байнгын шаардлагатай тулгардаг зэргийг

¹¹⁷ Энэ бүлгийг АНДЧ–аас 2013 онд хэвлэсэн Хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан хэвлэл мэдээллийн гарын авлага боловсруулсан Жеймс Илiffe бичсэн болно.

¹¹⁸ Энэ бүлэгт “хэвлэл мэдээлэл” гэдэгт мэдээлэл цуглуулах, нийтлэх, түгээх эсвэл олон нийтэд мэдээлэлтэй холбоотой хөтөлбөр цацах өргөн хүрээний байгууллагуудыг ойлгоно. Мөн сонин, телевиз, радио, сэтгүүл, мэдээллийн агентлаг багтана. Эдгээр нь цахим байдлаар, эсвэл орон нутгийн, мужийн, үндэсний, олон улсын түвшинд ажилладаг байж болно.

¹¹⁹ Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн талаар илтгэхэд тулгарах бэрхшээл; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2002; 16 дахь тал.

¹²⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тунхаглалын 6 дугаар зүйл.

ойлгох шаардлагатай. ХЭҮБ-ууд олон нийттэй төрөл бүрийн аргаар холбоо тогтоох зуур хэвлэл мэдээлэл нь ХЭҮБ-уудаас боловсруулсан мэдээллийг хүргэх хамгийн нөлөөт дамжуулагч, “олон нийт болон байгууллагуудын хооронд ажиллах хамгийн хүчтэй хаалгач”¹²¹ юм.

ХЭҮБ-уудад тулгарах бэрхшээл нь хоёр талтай. Нэгдүгээрт, хэвлэл мэдээлэл санаачлагатайгаар хамтарч, оновчтой, сонирхолтой байдлаар хүний эрхийн асуудлууд танилцуулах болно. Хоёрдугаарт, хүний эрхийн талаар үндэслэлтэйгээр сурвалжлах явдлыг дэмжихийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бие даасан сэтгүүлчидтэй хамтран ажиллах билээ. “Өнөөдөр хүний эрхийн байгууллагууд эн тэргүүнд шинэ мэдээ боловсруулах эсвэл түүний найдвартай байдлыг хангах шаардлагагүй болжээ. Одоо итгэж болохуйц, маш хангалттай мэдээлэл урсаж байна. Дээрх байгууллагууд тус мэдээллийн дагуу юу хийсэн бэ гэдгээ ойлгох, сайжруулах нь тэргүүлэх чиглэл болсон байна.”¹²²

2. ХҮНИЙ ЭРХИЙН ТАЛААР ХАМТ ОЛНЫ ОЙЛГОЛТЫГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ

Гарч байгаа хүний эрхийн зөрчил, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх эхний үндсэн алхам бол хамт олны дунд хүний эрхийн талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, дэмжих юм. Үндэсний болон олон улсын хүний эрхийн хэм хэмжээ нь хувь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах талаар тодорхой стандарт тогтоож, төрийн зүгээс эдгээр эрхийг эдлүүлэхээр хүлээх хариуцлагыг заасан байдаг. Эдгээр стандартын тухай, мөн тэдний эрхийг хамгаалах үүрэгтэй механизмын талаар хамт олонд таниулж, сургах нь хувь хүмүүс:

- Өөрийн эрхээ улам сайн мэдэх;
- Бусдын эрхийн төлөө дуугарах, тэмцэх эрх мэдэлтэй болох;
- Засгийн газар, шийдвэр гаргагч нарын хийсэн үйлдэлд хариуцлага тооцох, хууль тогтоомж, бодлого, туршлагыг өөрчлүүлэхээр дэмждэг болно.

Парисын зарчмууд ХЭҮБ-уудаас “хүний эрхийн талаар болон аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахтай тэмцэж байгаагаа хичээл зүтгэлээ олон нийтэд таниулах”-даа “хэвлэл мэдээллийн бүх байгууллагууд ашиглах”-ыг шаарддаг¹²³.

Хэвлэл мэдээлэлтэй ажиллах нь олон тооны хүнд хүний эрхийн талаар мэдээлэл хүргэх, ялангуяа цөөнгүй ХЭҮБ-уудад тулгарч буй санхүүгийн бэрхшээлтэй үед маш үр нөлөөтэй арга байх боломжтой. Хэвлэл мэдээлэл “үнэгүй” биш тул гол төлөв сурталчилгааны эсвэл бараа үйлчилгээ сурталчилах зорилготой аяны үеэр түгээж байгаа мэдээллээс илүү найдвартайд тооцдог. ХЭҮБ-ууд дараах хоорондоо уялдаа холбоотой, өргөн хүрээг хамарсан зорилгоо хэрэгжүүлэхээр хэвлэл мэдээлэлд хандаж болно. Үүнд:

- Тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалт, эсвэл хүний эрхийн зөрчлийг нээн харуулах, тухайн асуудлаар хамт олны мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх;
- Хамт олон дунд орших, ялангуяа эмзэг эсвэл эрх мэдэлгүй, гадуурхагдсан бүлэгт хамаарах сөрөг шинжтэй хэвшмэл дүрүүдтэй тэмцэх;
- Хууль тогтоомж, бодлого, туршлагаа өөрчлүүлэхээр дэмжих, яагаад шаардлагатай болохыг тайлбарлах;
- Олон нийт тодорхой нэг асуудлаар арга хэмжээ авахыг урамшуулан дэмжих эсвэл тухайн ХЭҮБ-ын үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах.

¹²¹ Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн талаар илтгэхэд тулгарах бэрхшээл; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2002; 18 дахь тал.

¹²² Мөн тэнд. 17 дахь тал.

¹²³ Парисын зарчмуудын 3(g) хэсэг.



Малайз Улсын Хүний эрхийн комиссын дарга Тан Шри Хасми Агам хэвлэл мэдээлэлд ярилцлага өгч байна. Гэрэл зургийг Малайз Улсын Хүний эрхийн Комисс.

Шинэ эсвэл байгуулагдаад удсан эсэхээс үл хамааран ХЭҮБ олон нийтэд өөрийн хүлээх хариуцлага, чиг үүрэг, тэргүүлэх чиглэлээ тайлбарлахдаа хэвлэл мэдээлэл ашиглаж болно. Жишээлбэл, хүлээн авдаг хүний эрхийн гомдлын төрлөө тодорхойлох, хувь хүмүүс хэрхэн гомдол гаргах, тэдгээр гомдлоо шийдвэрлэх үйл явцын тухай байна. Өдөр тутам, байнга хэвлэл мэдээлэлтэй ажилласнаар тухайн ХЭҮБ-ын ажлын алдар хүндээ бэхжүүлэхэд туслахын зэрэгцээ хараат бус, хүндлэл хүлээсэн, итгэлтэй гэж олон нийтийн дунд итгэл төрүүлэхэд хувь нэмэртэй. Хэвлэл мэдээлэл нь олон нийтийн үнэт зүйлсийг тусгах, хэлбэржүүлэхэд гол үүрэг гүйцэтгэх зуураа нийгмийн болон хандлагын өөрчлөлт бий болгоход нөлөөлдөг нийгмийн харилцааны цогц тогтолцоон дахь нэг л хэсэг болохыг хүлээн зөвшөөрөх нь чухал. Өөрөөр хэлбэл хэвлэл мэдээлэл нь асуудлыг харуулах, түүх өгүүлэх, олон нийтийн мэтгэлцээнийг хөхиүлэн дэмжих төдийгүй тодорхой сэдвээр анхаарч ажиллавал хувь хүмүүсийн “сэтгэл зүрх, оюун санаа”-нд их зүйл өөрчилж чадна. ХЭҮБ-ууд хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллах нь олон талт, холимог шинжтэй, илүү өргөн хүрээний хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн нэг хэсэг юм.

ХЭҮБ-ууд хэвлэлийн эрх чөлөөнд аюул заналхийлсэн орчин дахь хэвлэл мэдээлэлтэй ажиллах нь тодорхой эрсдэл дагуулдаг болохыг мэдвэл зохино. Хэрэв олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээс хэвлэсэн эсвэл цацсан мэдээлэлд эргэлзэж байвал тухайн хэрэгслээр түгээсэн ХЭҮБ-ын үйл ажиллагааны талаарх мэдээлэлд эргэлзэнэ гэсэн үг. Мөн тухайн ХЭҮБ-ын хараат бус байдалд итгэх олон нийтийн итгэл сулрах боломжтой. Мэдээжийн хэрэг, ХЭҮБ-ууд хэвлэл мэдээлэлтэй ажиллах, бусад хүмүүс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.



3. МЭДЭЭНИЙ ҮНЭ ЦЭНИЙГ ОЙЛГОХ НЬ

Улсууд дахь мэдээний хэрэгсэл нь бүх ажилдаа тусгаагүй ч гэсэн ямар нэгэн байдлаар хүний эрхийн асуудлын талаар цацдаг байна. Сэтгүүлчид ХЭҮБ-уудаас хуваалцвал зохих түүх, мэдээллийг маш ихээр сонирхдог. Гэхдээ “аливаа зүйлийг хэтрүүлвэл тухайн түүх нь шинэ, урьдаас хүлээж байгаагүй, одоогийн асуудалд том, жижиг байдлаар нөлөөлж байгаа мэдээ эсэхэд анхаарахад хүрнэ.”¹²⁴

ХЭҮБ-ууд “мэдээ” гэж юу болохыг ойлгох, ямар нэгэн түүх сонины тэргүүн хуудаст нүүр дүүрэн хэвлэгдэх, эсвэл сонины аль нэг жижиг буланд байрлуулах уу гэдгээ тогтох нь хэвлэл мэдээлэлтэй хэр ажиллаж чадахыг харуулдаг онцлогтой.

Мэдээний үнэ цэнийг ойлгосноо ХЭҮБ-ууд өөрийн ажлаа эрхлэгч, сэтгүүлчдийн сонирхол татахуйц түүх байдлаар хүрээг нь тогтоох, өөрийн асуудлаа хэвлэл мэдээлэлээр цацахад тусалдаг.

3.1. Мэдээний шилдэг арван үнэ цэнэ

1.	Нөлөө	Тухайн арга хэмжээ, асуудал нь олон хүн хамарсан эсвэл нөлөөлсөн бол түүний мэдээний үнэлэмж улам ихэснэ.
2.	Цаг хугацааны байдал	Саяхан болсон арга хэмжээ байвал мэдээний үнэлгээ улам ихэснэ.
3.	Сөрөг шинж	Муу зүйлийн тухай мэдээ нь гол төлөв сайн мэдээнээс илүү цацагдана.
4.	Урьдаас хүлээгээгүй байдал	Хэвийн бус, урьдаас хүлээж байгаагүй, содон бол мэдээний хэрэгслийн анхааралд өртдөг.
5.	Товч тодорхой байдал	Тайлбарлахад хялбар арга хэмжээнд тайлбарлахад төвөгтэй асуудлаас илүү ач холбогдол өгдөг.
6.	Зөрчилдөөн	Харилцан адилгүй бүлэг эсвэл хувь хүмүүсийн хооронд эсрэгцэл, мөргөлдөөн үүсвэл олон хүн татах нөлөөтэй байдаг.
7.	Хувь хүншүүлсэн байдал	Уй гашуу, айдас, шаналал, баяр хөөр зэрэг хүчтэй сэтгэл хөдлөлтэй, хүний анхаарал татахуйц түүх нь олны таашаал хүртдэг.
8.	Хамааралт байдал	Мэдээний түүх нь үзэгчдийн үнэт зүйл, сонирхол, хүлээлттэй давхцах шаардлагатай.
9.	Чухал байдал	Соёлын хувьд нөлөөтэй хүн эсвэл газар хамарсан түүх нь мэдээний хөтөлбөрт давамгайлах магадлалтай.
10.	Харагдах байдал	Тухайн арга хэмжээг харуулсан эсвэл асуудлыг тайлбарлахад тусалж байгаа хүчтэй дүрслэл бүхий зураг эсвэл дүрс бичлэг нь мэдээний үнэлэмжийг нэмэгдүүлдэг.

Мэдээний үнэ цэнэ нь юуг мэдээ гэж сонгох, **тухайн түүхийн талаарх** чухал байдлыг үнэлэхэд тустай. Арга хэмжээ нь гол төлөв асуудлаас илүүтэйгээр улам мэдээний үнэлэмжтэй болдог.



¹²⁴ Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн талаар илтгэхэд тулгарах бэрхшээл; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2002; 17 дахь тал.

2012 оны 6 дугаар сард **Шинэ Зеландын Хүний эрхийн Комисс** өндөр настны халамжийн салбарт ажиллаж байгаа ажилтнуудын тэгш хөдөлмөрийн үнэлэмжийн талаар цохон тэмдэглэсэн “Caring Counts” гэсэн илтгэл гаргажээ. Тус илтгэлийг Ажил хөдөлмөрийн тэгш боломж хариуцсан комиссын гишүүн, доктор Жүди Мак Грегор бэлтгэсэн байна. Судалгааны нэг хэсэгт асрагч нараас бие махбодын болон сэтгэл санааны хувьд ямар зүйл хийлгэхээр шаарддаг талаар ойлголтой болохын тулд Др. Мак Грегор дүр эсгэж, өндөр настны халамжийн байгууллагад долоон хоног ажилласан юм. Илтгэл гарсны дараа сэтгүүлчид түүнээс асрагчийн хувьд олж авсан туршлагын л талаар сонсохыг хүсч байсан нь асуудлаа хувь хүнийхээ үүднээс тайлбарлахад тусалсан ба үүнийг ХЭҮБ-ын зүгээс судалгаа хийх онцгой хандлагад тооцсон болно. Олон нийтийн мэдлэг ойлголтыг улам нэмэгдүүлэх, Комиссын зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээлэл илүү өргөн хүрээнд цаашид анхаарч ажиллажээ.



4. ХҮЛЭЭЛТ БИЙ БОЛГОХ

Хэвлэл мэдээлэл бол санаагаа уралдуулах зах зээлийн талбар билээ. Өдөр бүр маш олон тооны байгууллага, ашиг сонирхлын бүлэг хэвлэл мэдээллийн анхаарал татах, олон нийтэд товч ойлголт эсвэл түүх “худалдах”-аар хичээдэг. Үүний хариуд хэвлэл мэдээллийн байгууллага гол төлөв өөрийн сонирхол татах мэдээ, түүхийг л сонгодог. Эндээс харвал хүний эрхийн асуудлын талаар хамт олны мэдлэг ойлголтыг бий болгох, хандлага өөрчлөхөд цаг хугацаа зарцуулах, тасралтгүй, тогтвортой байдлаар олон төрлийн харилцан адилгүй мэдээллийн хэрэгсэл ашиглах шаардлагатай. ХЭҮБ-ууд хөхиүлэн дэмжихээр хичээж байгаа асуудлаа хэвлэл мэдээллээр дамжуулан юунд хүрэх талаар бодит хүлээлттэй байх нь чухал.

Хүрэхээр хичээж **болох** зүйлд:

- Мэдээний хөтөлбөртэй болох, нийтийн хэлэлцүүлэгт хүрээ тогтоох;
- Тухайн асуудлын талаар хүмүүс бодох, ярихад хүрэх;
- Хувь хүмүүс эсвэл тодорхой бүлгээс тусгайлан үйл ажиллагаа хийхийг урамшуулан дэмжих;
- Шийдлээ дэмжих, сурталчилах, шийдвэр гаргагчдад нөлөөлөх багтана.

Хүрэхээр хичээж **болохгүй** зүйлд:

- Зорилтот бүх бүлэгтээ өөрийн бэлтгэсэн ойлголтоо түгээх;
- Өөрийн хөтөлбөрөө бүх хүнээр дэмжүүлэх;
- Хууль тогтоомж, хөтөлбөр, бодлого, хамтрагчдын дэмжлэггүйгээр нийгмийн болон хандлагын өөрчлөлт бий болгох.

5. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ХАНДАХААР ТӨЛӨВЛӨХ НЬ

Аливаа хүний эрхийн хөтөлбөртөө ХЭҮБ тодорхой хүний эрхийн асуудлын талаар хэвлэл мэдээлэл ашиглах замаар хэрэгжих богино болон урт хугацааны зорилт тавих нь чухал. Эн тэргүүнд ХЭҮБ хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллах **эцсийн зорилгоо** тодорхойлох шаардлагатай. Жишээлбэл:

- Хууль тогтоомж, бодлогод өөрчлөлт оруулахаар дэмжин сурталчлах;
- Төрийн эсвэл хувийн хэвшлийн байгууллагуудын туршлагад өөрчлөлт оруулахаар дэмжин сурталчилах;
- Тодорхой нэгэн хүний эрхийн асуудлын тухай хамт олны мэдлэг ойлголт бий болгох;
- Тодорхой нэгэн асуудлаар хувь эсвэл хамт олон арга хэмжээ авахыг урамшуулан дэмжих гэх мэт.

Эцсийн зорилгоо тодорхойлсноор ХЭҮБ хүрэх шаардлагатай шийдвэр гаргагчид, бусад зорилтот бүлгээ тодорхойлвол зохино. Асуух асуултаас дурдвал:

- Бидний цохон тэмдэглэж байгаа тусгайлсан асуудал маань юу вэ?
- Бид ямар шийдэл санал болгож байгаа вэ?
- Тухайн шийдлийг хэн бодит үйл хэрэг болгох вэ? Бидэнд хэний дэмжлэг, тусламж хэрэгтэй вэ?
- Бид шийдвэр гаргагчид, өөрсдийн зорилтот бүлгийн анхаарлыг татахын тулд юу хийх эсвэл юу хэлэх вэ?

5.1. Зөв мэдээллийн хэрэгслээ тодорхойлох

Хэвлэл мэдээлэл бол нэг хөтөлбөрийн дагуу ажилладаг ганц байгууллага гэсэн буруу ойлголт нийтэд түгсэн байдаг. Бодит амьдрал дээр мэдээний хэрэгсэл нь бидний хэрэгцээнээс хэтэрсэн шахуу мэдээллийн хэрэгсэл, хөтөлгчийг хамарч, телевиз, сонин, радио, мэдээний агентлагууд, сэтгүүл зэрэг “уламжлалт хэрэгсэл”-ийн хамт цахим сэтгүүл, Твиттерийн мэдээлэл, блогчид хүртэл багтдаг. Одоогийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаа нь хөндөж буй асуудлын төрөл, хүргэж байгаа арга зам, хүрч байгаа хүмүүсийн адил маш өргөн хүрээг хамардаг. ХЭҮБ-ууд өөрийн үйл ажиллагааг түгээдэг хэвлэл мэдээллийн харилцан адилгүй хэрэгсэл, сэтгүүлчдэд танигдсан байх нь маш чухал. ХЭҮБ-ууд мэдээллийн хэрэгсэл бүрийн хүрч чадах хүмүүс, өнгөрсөн хугацаанд хүний эрхийн асуудлаа дамжуулж цацсан арга замыг мэдэх хэрэгтэй. Энэ талаар мэдэх нь тухайн ХЭҮБ аль мэдээллийн хэрэгслээр ямар түүх илгээхээ тодорхойлоход тусалж, асуудлаа эерэг байдлаар түгээх боломжоо нэмэгдүүлнэ.

5.2. Зөв мессеж хүргэх нь

Үр нөлөөтэй харилцаа холбоо нь хүмүүсийн зөв бүлэгт зөв мессежээ хүргэхэд оршино. Гарааны цэг бол зорилтот бүлэг болохоос мессеж биш. Мессеж боловсруулахаас өмнө ХЭҮБ дараах зүйлийг мэдсэн байх ёстой. Үүнд:

- Тухайн асуудлын талаар зорилтот бүлэг юу мэдэж байгааг ойлгох;
- Тухайн асуудлын талаар зорилтот бүлэг юу бодож, мэдэрч байгааг танин мэдэх;
- Өөрийн зорилтот бүлэгтэй адил өнцгөөс тухайн асуудалд чиглэж ажиллах.

Хэрэв хүмүүс хэрхэн бодож, үйлдэж байгааг өөрчлөхийн тулд урамшуулан дэмжих зорилготой бол мессеж нь өөрчлөлтөд чиглэсэн эерэг сэдэл агуулсан байх хэрэгтэй. Зорилтот бүлгээс дэмжлэг авч, “толгой дохих” хариу үзүүлэхүйц байвал ХЭҮБ-ын байр суурь үндэслэлтэй, итгэж болохуйц ажээ гэж хүмүүс хүлээн зөвшөөрөх болно.

ХЭҮБ-ууд өөрийн хэлсэн зүйл эсвэл санал нь ямар нэгэн шүүмж дагуулах, эсэргүүцэлтэй тулгарахаа тооцох ба ямарваа нэгэн нийгмийн эсвэл бодлогын өөрчлөлт тэр даруй олонхийн дэмжлэг авдаггүй билээ. Мөн ямар бүлэг шүүмжлэлтэй хандаж болзошгүй, юу хэлж магадгүй талаар төсөөлөлтэй байх хэрэгтэй.

Зөрчилдөөн хэвлэл мэдээллийн анхаарал татдаг тул ХЭҮБ-ууд оновчтой бус, эсвэл шударга бус шүүмжлэлийг няцаах замаар хэлэлцэж буй хүний эрхийн асуудалдаа хамт олны анхаарлыг дахин татах завшаан хэмээн ашиглах боломжтой. ХЭҮБ-ууд өөрийн гол мессежээ дахин дурдах факт, түүх ашиглахдаа “өрсөлдөгч”-өө хэвлэл мэдээллээр дамжуулан дайрч болохгүй.

5.3. Хэзээ ажиллах, ажиллахгүйгээ мэдэх нь

Асуудлын талаар ХЭҮБ олон нийтийн өмнө ярихад тохиромжтой биш үе гарах болно. Эрх зүйн үндэслэл (жишээлбэл, шүүхээр хянан шийдвэрлэж байгаа, парламентад тайлангаа хүргүүлсэн) эсвэл нууцын зэрэглэлтэй хэлцэл, хүний эрхийн сургалтын тусгай хөтөлбөрөөр дамжуулан гарах үр дүн, шинэчлэлдээ анхаарах нь илүү үр нөлөөтэй байж магадгүй.

Ихэнх ХЭҮБ–ууд мэдээлэл авах, эсвэл ярилцлага хийх тухай сэтгүүлчийн хүсэлт хүлээн авах, шийдвэрлэхээ дотооддоо журамласан хэвлэл мэдээллийн бодлого боловсруулсан байдаг. Хэвлэл мэдээллийн бодлогодоо тодорхой сэдвүүдээр тухайн ХЭҮБ–ыг төлөөлж Комиссын аль гишүүн, ажилтан ярихаа тогтсон байх жишээтэй.



6. ҮР НӨЛӨӨТ ХАРИЛЦАА ХОЛБООНЫ БҮРДЭЛ ХЭСГҮҮД

Хүний эрхийн асуудлууд тайлбарлахад бэрх, олон зүйлээс бүрдсэн байж болно. Иймээс сэтгүүлчид ерөнхийдөө асуудал, эсвэл арга хэмжээний талаар “хар, цагаан” гэж цацах хүсэлтэй байдаг тул мэдээллийн хэрэгслээр дамжуулахад бэрхшээл тулгарч магад. Эрх зүйн, техникийн, маш олон товчлол бүхий хүний эрхийн хэл нь саадгүй харилцаа холбоо тогтооход хаалт үүсгэж болзошгүй. ХЭҮБ–ууд өөрийн үйл хэрэг, асуудлаа сэтгүүлчид, олон нийт ойлгохуйц, энгийн хүний амьдралд ойр байдлаар хөрвүүлэх, танилцуулах хариуцлага хүлээнэ.

Энгийн хэл ашиглах: Мэргэжлийн нэр томъёо, хэллэгээс зайлсхийж, энгийн ярих. Зорилтот бүлэг, тэдний үнэт зүйлсэд нийцэх байдлаар үгс ашиглаж, санаагаа уялдуулах. Жишээлбэл, “хүний эрх”–ийг “хүндэтгэх”, “тэгш эрх”–ийг “шударга ёс”, “хүнлэг харьцах”–ыг “нэр төртэй” гэж илэрхийлж болно.

Түүх өгүүлэх: Асуудлаа хүний оршихуйтай нягт холбох. Хувь хүмүүс, гэр бүл, хамт олны олж авсан туршлагаас хуваалцах. Хүмүүс тухайн асуудлыг сэтгэл хөдлөлөөрөө мэдрэх, бусдын оронд өөрийгөө тавьж үзэхэд туслах.

Зураг ашиглах: Амьдралд ойртуулах, хүмүүс өөрөөр харахад туслах гэрэл зураг, дүрс бичлэгтэй байх. Анхаарал татахуйц зураг удаан хугацаанд хүний санаанд үлддэг онцлогтой.

Шийдэл санал болгох: ХЭҮБ–ууд хүний эрхийн зөрчил, тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалтыг дэлгэн харуулах нь зүйн хэрэг. Үүний зэрэгцээ тэдгээр асуудалд мэдрэмжтэй, үндэслэлтэй шийдэл илэрхийлэх, дэмжин сурталчилах болно.

Хүмүүс үйлдэл хийхийг урамшуулан дэмжих: Хүний эрх хөхиүлэн дэмжих, хамгаалахын тулд хүмүүс ямар нэгэн зүйл хийж чадах бол тэднээс хийхийг хүсэх. Хүмүүсийг ХЭҮБ–тай холбоо тогтоох, бусад бүлгүүдтэй эсвэл орон нутгийн хамт олны дунд зохион байгуулдаг арга хэмжээтэй түншлэх хялбар зам олох.

Олон хүнд хүрэх хэвлэл мэдээллийн орон зайд өөрийн мессежээ сонсгох, ялангуяа үйл хэрэг болгох гол түлхүүр бол давталт юм. Хүний эрхийн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх явдлыг хөхиүлэн дэмжихээр хэвлэл мэдээлэлтэй ажиллах нь нэг удаагийн арга хэмжээ биш. Энэ нь төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтвортой хугацаанд байнга хөхиүлэн дэмжихийг ойлгоно.



7. ӨӨРИЙН ЦАЦАЛТАА ХЯНАХ НЬ

ХЭҮБ–ууд өөрийн гаргаж ирсэн хүний эрхийн асуудлуудыг харилцан адилгүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн цацаж байгааг хянах нь чухал. Мөн өөр бүлэг ижил асуудлын талаар юу ярьж байгааг анхаарах хэрэгтэй. Хэвлэл мэдээлэлд мониторинг хийснээр ХЭҮБ–уудад:

- **Хэвлэл мэдээлэл түүхийг хэрхэн дамжуулсныг харах** (таатай юу, шүүмжлэлтэй үү?);
- **Оновчгүй байдалд анхаарах** (ямар алдааг засах шаардлагатай вэ?);
- **“Холбоотон” болон “өрсөлдөгчид” юу хэлснийг жагсаах** (Тэдний санаа бодлыг хэрхэн цацсан бэ?);
- **Тухайн асуудлын талаар хамт олны сэтгэгдлийг сонсох** (Тэд дэмжсэн үү? Үгүй бол яагаад?);
- **Мессежээ сайжруулах** (Мессеж ойлгомжгүй байсан уу, эсвэл хамт олны санаа бодолтой зөрөлдсөн үү?);
- **Тухайн асуудлын талаар хийх дараагийн алхмаа төлөвлөх** (Эцсийн зорилгодоо хүрсний дараа нь юу хийх хэрэгтэй вэ?).

Хэвлэл мэдээлэлд мониторинг хийх нь цаг их зарцуулах боловч хэвлэл мэдээлэлтэй ажиллах мөчлөгийн хамгийн чухал хэсэг юм. ХЭҮБ–ууд хэвлэл мэдээлэлтэй үр нөлөөтэй ажилласан эсэхээ үнэлэх, асуудлаа хөхиүлэн дэмжихээ хэрхэн үргэлжлүүлэх, хамт олны ойлголт бий болгохоо төлөвлөхөд тусална.

8. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ЗОРИУЛЖ ХҮНИЙ ЭРХИЙН АГУУЛГА БИЙ БОЛГОХ НЬ

Аливаа ХЭҮБ–уудад тулгарч байгаа бэрхшээлийн нэг нь дэлгэн харуулж байгаа хүний эрхийн асуудлаа оновчтой сурвалжлагаар баталгаажуулах болно. Өөр нэгэн бэрхшээл бол тухайн асуудлуудын талаар хэвлэл мэдээлэл тасралтгүй цацах юм. Үүнийг шийдэхээр олон тооны ХЭҮБ–ууд телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллаж, хүний эрхийн “нэвтрүүлэг”, хөтөлбөр бэлдэх, бичих, цацах, ХЭҮБ–ын гүйцэтгэх үүргийн тухай хамт олны мэдлэг ойлголт нэмэгдүүлэхээ хөхиүн дэмжихээр ажилладаг. Энэ хандлага нь ХЭҮБ–ууд хэвлэл мэдээлэлд хүний эрхийн асуудлын тухай ярих, хамт олны сэтгэгдлийг хүлээн авах, хүмүүс өөрийн эрхээ эдлэх, бусдын эрхийг хамгаалахын тулд бодитой юу хийж чадахаа тодорхойлох өөрийн орон зайтай байхад тустай. Олон ХЭҮБ–ууд дээрх санаачлага нь өндөр настан, санхүүгийн улмаас тэр бүр очих боломжгүй газарт амьдардаг хүмүүс зэрэг харилцан адилгүй бүлэгт хүрэх үр нөлөөтэй гэж үздэг. Мэдээллээ радио, телевизээр хүргэх нь бичиг үсэг тайлагдаагүйн улмаас үүсэх саадыг давах үр нөлөөтэй, хүртээмжтэй арга юм.

Афганистан Улсын Хараат Бус Хүний эрхийн Комисс богино хугацааны мэдээллийн “нэвтрүүлэг”, хүний эрхийн асуудлын тухай арай удаан үргэлжлэх хөтөлбөр радио, телевизээр цацдаг. Хөтөлбөртөө эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зэрэг асуудлууд тусгаж, Комиссын гишүүд, ажилтнууд, иргэний нийгмийн бүлгийн төлөөлөл, хохирогчид, тэдний хамаатан садны ярилцлага оруулсан байх жишээтэй. Мөн тус улсын хүний эрхийн зөрчлийн бодит байдлыг харуулсан тохиолдол оруулдаг. Комисс Афганистан дахь олон телевиз, радиотой түншлэхээр тогтож, Комиссын хөтөлбөрүүдээ үнэ төлбөргүй цацдаг онцлогтой. Комиссын зүгээс бичиг үсэг тайлагдаагүй хүмүүсийн тоо өндөр байгаа энэ үед телевиз, радио нь хүний эрхийн мэдээллийг эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд хүргэх арга зам гэж үзсэн байна.





Уугуул хүмүүсийн асуудлаарх НҮБ-ын Байнгын чуулганы 11 дүгээр хурлын үеэр оролцогч ухаалаг гар утсаар гэрэл зураг авч байна. НҮБ-ын гэрэл зургийг Девра Беркович.

ХЭҮБ-ууд хэвлэл мэдээллийн эрхлэгчдэд зориулсан бага хэмжээний төсвөөр үйл ажиллагаа явуулах болсон өөрийн улсынхаа хувьсан өөрчлөгдөж байгаа хэвлэл мэдээллийн орчин болон мэдээний хэрэгсэлд зориулсан “хэвлэлд бэлэн” агуулга боловсруулах боломжийн талаар мэдэх шаардлагатай.

ХЭҮБ-ууд дижитал камер, ухаалаг утас, дүрс бичлэгийн камер, дуу хураагуур, эвлүүлэх програм хангамж зэрэг худалдан авах боломжтой, хүртээмжтэй, хэрэглэхэд хялбар технологиудаар дамжуулан, сэтгүүлчдэд зориулж цацах шаардлага хангасан материал бэлтгэх боломжтой болжээ.

Мөн ХЭҮБ-ууд хүний эрхийг улам хөхиүлэн дэмжих, хамгаалахын тулд эрхлэгчийн хувиар санаагаа тусгах боломжтой болдог. Жишээлбэл, улам ялгаварлан гадуурхах, өс хонзон төрүүлэхээс сэргийлж, хүний эрхийн зөрчил үйлдсэн хүмүүсийн зургийг харуулахгүй байх гэх мэт. Зарим сурвалжлагч, эрхлэгч тус материалыг хүлээн авч, ашиглахын зэрэгцээ ХЭҮБ-ууд эсвэл хүний эрхийн бусад бүлгийн бэлтгэсэн эх сурвалж нь өөрийн нөлөөлөл, сонирхлын үүднээс нэг талыг барьсан байж болзошгүй хэмээн ялгамжтай ашиглах үе бий.

Үүнд анхаарч ХЭҮБ “өөрийн зорилгоо, өгч байгаа материалынхаа нотолгоот шинжээ, мэдээлэл цуглуулахдаа ашигласан стандартаа ил тод байлгах¹²⁵” шаардлагатай.

9. НИЙГМИЙН СҮЛЖЭЭГЭЭ ДАМЖУУЛАН ХАМТ ОЛОНТОЙ ХОЛБОГДОХ НЬ

Facebook, Twitter, YouTube, Flickr, Google+, Storify зэрэг нийгмийн сүлжээний талбарууд хурдтай өссөнөөр ХЭҮБ-ууд уламжлалт мэдээллийн хэрэгслийг алгасч, шууд хамт олонтой холбоо тогтоох шинэ боломжтой болж байна.

Нийтэд түгсэн дээрх талбарууд нь ХЭҮБ-ууд мэдээлэл, түүх, дүрс бичлэг, гэрэл зураг хуваалцах, олон нийттэй шууд ярилцахад тусалдаг. Мөн хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахын тулд хамтын үйл ажиллагаанд хүмүүсийг татан оролцуулах, идэвхжүүлэх хүчтэй арга хэрэгсэл юм.

¹²⁵ Хэний мэдээ вэ? Хэвлэл мэдээллийн өөрчлөгдөж байгаа ба ТББ; Керрол Богерт, Хүний эрхийн манаач; 2011 оны 1 сар; 7 дахь тал.

Нийгмийн сүлжээг үр нөлөөтэй ашиглах нь хэдэн өдрийн зайтай шинэ сэтгэгдэл бичих, мэдээ тавихаас илүү ойлголт билээ. Тодорхой учир шалтгаантай, цогц шинжтэй стратегийн дагуу нийгмийн сүлжээг ашиглавал зохино. ХЭҮБ-ууд цахим хуудас шинэчлэх, сэтгэгдэлд хариулах этгээдийг томилж, байгууллагын хараат бус, халдашгүй байдлаа хадгалахын тулд нийгмийн сүлжээний бодлого боловсруулах шаардлагатай. Цахим орчинд тавьж байгаа мэдээлэл бүр “нийтийн сэтгэгдэл”-д хамаарах тул олон нийттэй харилцаж байна гэдгээ санах нь чухал. Боловсрол, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаатай адил нийгмийн сүлжээ ч гэсэн өөрийн гэсэн хязгаартай. Тухайн ХЭҮБ-ыг “дагаж байгаа” (“follow”) эсвэл “таалагдаж байна” (“like”) гэсэн хүмүүст л мессеж, түүх харагдана. Өөрөөр хэлбэл ХЭҮБ өөрийг нь дэмжиж байгаа хүмүүст хүрч чадна гэсэн үг. ХЭҮБ-ын талаар мэдэхгүй, эсвэл сонирхдоггүй, интернэт ашиглах боломжгүй, нийтийн сүлжээ ашигладаггүй олон хүмүүс байх тул тэдэнтэй харилцаа холбоо тогтоох шаардлага тулгарна. Олон янзын хүмүүст хүрэх, үүрэг хүлээгчийн хувиар хариуцлага хүлээж байгаа учир ХЭҮБ-ууд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллахаа үргэлжлүүлэхийн хамт нийгмийн сүлжээний ашиг тусыг хүртэх нь зүйн зэрэг.

10. СЭТГҮҮЛЧИД АЖЛАА ХИЙХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ НЬ

Хэвлэл мэдээлэл бол хамт олны хандлагыг бий болгох “хэв” төдийгүй маш хариуцлагатай үүрэг хүлээдэг. “Дөрөв дэх засаг” гэж ямагт нэрлэх хэвлэл мэдээлэл нь ард түмэн төрөөс хариуцлага шаардах үндсэн механизм гэж үзсээр ирсэн билээ. Хэвлэл мэдээлэл хүний эрхийн зөрчил, тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалтад анхаарал хандуулснаар олон нийтийн зүгээс эдгээр асуудлын талаар мэтгэлцэх, хамт олны мэдлэг ойлголт нэмэгдэх, төр, шийдвэр гаргагчдаас хариу арга хэмжээ авахыг шаардах болно. Гэхдээ Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөлийн¹²⁶ илтгэлд сэтгүүлчид хүний эрхийн тухай мэдээлэл түгээхдээ олон бэрхшээлтэй тулгардаг байна. Үүнд:

- **Хүний эрх гэж юу болохыг үл тоох.** Олон сэтгүүлч, эрхлэгчид бусад хүмүүсийн нэгэн адил Хүний эрхийн түгээмэл тунхаглал, хүний эрхийн олон улсын тулгуур стандартуудын талаар мэддэггүй.
- **Хүний эрх хаана байгаа талаар зөрүү ойлгох.** Хүний эрхийн зөрчил “өөр газар” тохиолдох зүйл гэж үзэх, хүний эрхийн олон улсын стандарт үйлчлэх эмэгтэйчүүд, уугуул хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, дүрвэгсэд, гей, лесби, бисексуаль, трансжендэр, интерсекс хүмүүстэй харьцах харилцааг дотоодын асуудал гэж анхаарахгүй орхих хандлага бий.
- **Хүний эрхийн хамрах хүрээний талаар дулимаг мэдлэг ойлголттой байх.** Олон нийт иргэний болон улс төрийн тодорхой эрхүүдийн талаар өргөн мэдлэгтэй ч орон сууцтай байх, эрүүл мэндээ хамгаалуулах, сурч боловсрох эрх зэрэг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх ойлголт маш муу байдаг.

Хүний эрхийн мэдлэг ойлголт дулимаг учир сэтгүүлчид хүний эрхийн чухал түүхийг “тоохгүй өнгөрөөх”, уг түүхийн хүний эрхийн шинж, онцлогийг олж хараагүйн улмаас боловсрол, тээвэр, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны сэдвээр мэдээлэл бэлтгэхгүй орхих боломжтой.

ХЭҮБ-ууд хүний эрхийн талаар оновчтой, итгэлтэй сурвалжлагч болж, хэвлэл мэдээллийг дэмжиж болно. Эн тэргүүнд анхаарах зүйл бол ХЭҮБ-ууд хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүдтэй чөлөөтэй ярилцаж, өөрсдийн харилцан адилгүй үүрэг, хариуцлагаа бүрэн мэдэж авах нь чухал.

¹²⁶ Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн талаар илтгэхэд тулгарах бэрхшээл; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2002; 113–117 дахь тал.

Энэтхэгийн Хүний эрхийн Үндэсний Комисс улсдаа хүний эрхийг хөхиүлэн дэмжихээр хэвлэл мэдээлэлтэй хэрхэн үр бүтээлтэй ажиллах талаар зөвлөгөө өгөх. Хэвлэл мэдээлэл, хүний эрхийн талаарх зөвлөх бүлэг байгуулжээ. Энэ бүлэгтээ цаасан болон цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээний агентлагын ерөнхий эрхлэгч, гүйцэтгэх захирлуудыг багтаасан байна. Комиссоос өөрийн бүрэн эрх, чиг үүргийн талаар хэвлэл мэдээллийн ажилтнуудад таниулах, хэвлэл мэдээлэлд хүний эрхийн асуудал тусгахын ач холбогдлыг онцлох зорилгоор сургалт хийжээ.



Жишээлбэл, ХЭҮБ-ууд хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчдийн бүлэгтэй хамтран дараах сэдвээр хэлэлцэхийн тулд уулзалт, семинар зохион байгуулж болно. Үүнд:

- Тухайн улс дахь хүний эрхийн талаар сурвалжлахад тулгарч байгаа бэрхшээл, асуудал;
- ХЭҮБ сэтгүүлчдийг хэрхэн хүний эрхийн талаар оновчтой, найдвартай мэдээлэл, эх сурвалжаар хангах боломжтой вэ?;
- Хараат бус сэтгүүл зүйд шаардлагатай эрх зүйн, улс төрийн, нийгмийн нөхцлийг бий болгохын тулд хэрхэн хамтран ажиллах боломжтой вэ?

Ази-Номхон далайн бүс дэх зарим ХЭҮБ-ууд хүний эрхийн асуудлын талаар гарамгай сурвалжилсан хэвлэл мэдээллийг хүлээн зөвшөөрөх, хөхиүлэн дэмжихээр шагнал гардуулдаг хөтөлбөр бий болгожээ.

Австралийн Хүний эрхийн Комисс 1987 оноос хойш жил бүр Хүний эрхийн медаль, шагнал гардуулах хөтөлбөрийнхөө дагуу тухайн хамт олонд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад үнэмлэхүй хувь нэмэр оруулсан явдлыг хүлээн зөвшөөрч иржээ. Тус хөтөлбөр нь шинжээчдийн хараат бус зөвлөлөөр нэр дэвшигчдээ үнэлэн ялагчийг тодруулж, хэвлэмэл сэтгүүл зүй, радио сэтгүүл зүй, телевизийн сэтгүүл зүй гэсэн ангиллаар Хүний эрхийн шагнал олгодог байна. Шагнал олгохдоо хүний эрхийн зөрчлийг дэлгэн харуулж, олон нийтийн анхаарлыг эдгээр асуудлуудад хандуулж, эерэг өөрчлөлт бий болоход тусалсан байх хэвлэл мэдээллийн маш чухал үүргийг хүлээн зөвшөөрдөг.



ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хэвлэл мэдээлэл олон нийтийн санаа бодлыг тусгах, бий болгох, нийгмийн, улс төрийн, эдийн засгийн хөтөлбөрийг тогтооход гол үүрэг гүйцэтгэдэг.
- Хүний эрхийн асуудлыг оновчтой, мэдээлэл бүхий, тогтвортой байдлаар хэвлэл мэдээллээр цацсанаар хамт олонд хандлага бий болгох, эрх зүй, бодлого, туршлага өөрчлөхөд хувь нэмэр оруулахад тусалдаг.
- ХЭҮБ–ууд хүний эрхийн асуудалдаа сэтгүүлчдийг татах, тэдгээр асуудлаа оновчтой, үнэмшихүйц байдлаар цацуулахын тулд хэвлэл мэдээлэл хэрхэн ажилладаг талаар мэдэх шаардлагатай.
- Хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх явдлыг хөхиүлэн дэмжихээр хэвлэл мэдээлэлтэй хамтрах нь нэг удаагийн арга хэмжээ биш. Энэ нь төрөл бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтвортой хугацаанд байнга хөхиүлэн дэмжихийг ойлгоно.
- ХЭҮБ–ууд хүний эрхийн талаар мэдээлэлтэйгээр сурвалжлах явдлыг дэмжихийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бие даасан сэтгүүлчидтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлвэл зохино.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Сэтгүүл зүй, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн талаар илтгэхэд тулгарах бэрхшээл; Хүний эрхийн бодлогын олон улсын зөвлөл; 2002;

Хүний эрхийн үндэсний байгууллагуудад зориулсан хэвлэл мэдээллийн гарын авлага; АНДЧ; 2013

Хэний мэдээ вэ? Хэвлэл мэдээллийн өөрчлөгдөж байгаа ба ТББ; Керрол Богерт, Хүний эрхийн манаач; 2011



БҮЛЭГ 10:

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТӨВ, СУРГУУЛИУД ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД:

- Хүүхдийн сурч боловсрох эрхтэй холбоотой олон улсын өмнө хүлээх ямар үүрэг байдаг вэ?
- Яагаад сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиуд хүний эрхийн боловсролд хамрагдах вэ?
- Хүний эрхийн боловсролын зарчмууд хэрхэн сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиудтай холбогдох вэ?
- Хүний эрхийн боловсролын ямар хандлага, арга сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиудад хэрэглэх боломжтой вэ?



Хүний эрхийн боловсрол нь суралцагчдад бодол санаагаа бүрэн хөгжүүлэх, шүүмжит байдлаар сэтгэх чадавх олгодог. Суралцагчид сургуулийн орчноос гадагш бусад суралцагчид, хамт олон, хүмүүсийн хэрэгцээний тухай эргэцүүлж чаддаг болно¹²⁷.



1. ОЛОН УЛСЫН ӨМНӨ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 29 дүгээр зүйлд заасны дагуу боловсрол нь:

- хүүхдийг бие хүн болгон төлөвшүүлэх, авьяас билэг, оюуны болон биеийн чадавхийг бүрэн төгс хөгжүүлэх;
- хүний эрх, үндсэн эрх чөлөө, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд заасан зарчмуудыг хүндэтгэх үзлийг хөгжүүлэх;
- өөрийн эцэг эх, соёлын онцлог шинж, хэл, үнэт зүйл, амьдарч буй эсвэл угсаа гарвалт улсынхаа үндэсний үнэт зүйл, өөрт үл хамаарах соёл иргэншлийг хүндэтгэх үзлийг хөгжүүлэх;
- харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, хүлцэн тэвчих, хүйсүүдийн эрх тэгш байдал, аливаа ард түмэн, угсаатны болон шашны бүлэг, нутгийн уугуул иргэдийг хүндэтгэх үзлийг хүүхдэд төлөвшүүлж чөлөөт нийгэмд хариуцлагатай амьдрахад бэлтгэх;
- байгаль орчныг хүндэтгэх үзлийг төлөвшүүлнэ¹²⁸.

¹²⁷ Найланд Коллеж, Шинэ Зеланд; Боловсролд хүний эрхийн хамт олныг бий болгох нь бүтээлээс – Хи Вакату Тика Тангата-а-Лви; Эмнести Интернэшнл (Шинэ Зеланд), Хөгжлийн эх сурвалжийн төв, Шинэ Зеландын Хүний эрхийн комисс, Хүүхдийн комиссарын газар, Энх тайвны сан; 2007.

¹²⁸ Сурч боловсрох эрх нь хүний эрхийн олон улсын гэрээнүүдэд заасан байдгаас онцолвол Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пакт (13, 14 дүгээр зүйл), Хүүхдийн эрхийн тухай конвенц (28, 29 дүгээр зүйл) байна. Мөн Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (5(e), 7 дугаар зүйл), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (10 дугаар зүйл), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц (24 дүгээр зүйл), НҮБ-ын БШУСГ-ын Боловсролоор ялгаварлан гадуурхахын эсрэг конвенц, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уугуул хүмүүсийн эрхийн тухай тунхаглалд (14 дүгээр зүйл) сурч боловсрох эрх дурдсан байдаг.

Боловсрол бол өөрөө хүний эрх төдийгүй хүний бусад эрхээ биелүүлэх салшгүй арга юм. Боловсрол хүний чадавхийг хөгжүүлэх, аливаа хүний эрхээ эдлэх, бусдын эрхийг хүндэтгэх тулгуур үндэс болдог. Эдийн засгийн болон нийгмийн хувьд гадуурхагдсан, эрх мэдэлгүй болсон хүүхэд, насанд хүрсэн хүмүүс боловсролоор дамжуулан өөрсдийгөө ядуурлаас гаргах, амьдран буй нийгэмдээ бүрэн дүүрэн оролцох арга замуудыг олж авдаг. Сурч боловсрох эрхэд эрх, хариуцлагын тухай сурч мэдэх багтана. Мөн хүчирхийлэх, дээрэлхэх, дарамтлахаас ангид, хувь хүнд хамаарах шинж болон олон янзат байдлыг хүндэтгэсэн, бүх хүн бүрэн дүүрэн оролцохуйц өндөр чанартай заах, сурах орчин бий болгох хамаарна. Сурч боловсрох эрх нь иргэний болон улс төрийн эрхүүдийн зэрэгцээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдийг онцлож үздэг¹²⁹. Аливаа хүүхэд, залуус “өөрсдийн сурах хэрэгцээнд нийцсэн байдлаар бүрэн дүүрэн, сайн боловсролын үр шимийг хүртэх, мэдэх, хийх, хамтдаа амьдрах, оршин байх тухай боловсрол эзэмших” эрхтэй¹³⁰. Эрх, хариуцлагын талаар олон улсын гэрээ, хууль тогтоомж, харилцаа холбоонд тусгасан байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос сурч боловсрох эрх нь “хүний бусад эрхээ биелүүлэх салшгүй арга” гэж тогтоосон байдаг¹³¹. Уг тодорхойлолт иргэний болон улс төрийн эрх болон эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хоорондын ангилалд аль алинд багтана¹³². Бүх оролцогч талууд (төрийн байгууллагууд, ТББ-ууд, багшийн боловсролын байгууллагууд, эвлэл, мэргэжлийн байгууллагууд, эцэг эх, суралцагчдын холбоо, ХЭҮБ-ууд, бизнесийн нэгдэл, шашны удирдагчид, хэвлэл мэдээлэл, уугуул болон угсаатны цөөнх бүлэг) хүүхэд, залуусын боловсрол эзэмших эрхийг хамгаалах, сахин хамгаалах үүрэгтэй. Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2004 онд хүний эрхийн боловсролын суурь зарчмууд, арга зүйн нийтлэг ойлголтыг хөхиүлэн дэмжих, үйл ажиллагааны хүрээгээр хангах зорилгоор Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр санаачилжээ. Үүнээс хойш үйл ажиллагааны хоёр төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.

Дэлхийн хөтөлбөрийн эхний (2005–2009) шатанд бага, дунд сургуулиудад анхаарч, хүний эрхийн боловсролыг үндэсний түвшинд хэрэгжүүлэх дөрвөн үе шаттай тусгай стратегиуд санал болгожээ. Хүний эрхийн тухай суралцахад хялбар байх үүндээс боловсролын бүх бүрэлдэхүүн, үйл явцад цогц байдлаар, эрхэд суурилан хандах явдлыг хөхиүлэн дэмжсэн юм. Дэлхийн хөтөлбөр анхаарах таван хүрээг тогтоосон нь:

- зохистой боловсролын бодлого боловсруулсан байхад анхаарах;
- эдгээр бодлогоо хэрэгжүүлэхээр төлөвлөх;
- хүний эрхийн талаар суралцахад таатай сурах орчныг баталгаажуулах;
- заах, суралцах үйл явцад анхаарах;
- багш, боловсролын бусад бие бүрэлдэхүүнд мэргэжлийн талаас хөгжих боломж олгох болно.

ХЭҮБ-ууд дээрх таван чиглэлд гүйцэтгэх үүргээ тодорхойлсон байна¹³³. Эдгээр зорилго санаачлагаа хэрхэн биелүүлсэн талаар хэлэлцүүлэг өрнөсөн ба Дэлхийн хөтөлбөрийн эхний шатанд төрийн зүгээс үзүүлсэн дэмжлэгийн түвшин, улсуудын хооронд гарсан онцлохуйц ялгаа гарчээ. Дэлхийн хөтөлбөрийн 2010 оноос эхэлсэн хоёрдугаар шат нь дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол, багш, сургагч, төрийн албан хаагч, хууль сахиулах байгууллагын албан хаагч, цэргийн бие бүрэлдэхүүнд зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөрт анхаарсан билээ. Сургуулийн өмнөх боловсрол, сургуулиудад анхаарахын хамт ХЭҮБ-ууд дээрх салбарууд дахь боловсролын үйл ажиллагааг үргэлжүүлэх хариуцлага хүлээсээр байна.

¹²⁹ Шинэ Зеланд дахь хүний эрх 2010 – Нга Тика Тангата О Аотэароа 2010; Шинэ Зеландын Хүний эрхийн комисс; 2010 (Бүлэг12. Сурч боловсрох эрх хэсгийг үзнэ үү).

¹³⁰ Дакарын үйл ажиллагааны хүрээ – Боловсролыг бүх нийтэд: Бидний хамтын хичээл зүтгэл нийцсэн нь; Дэлхийн боловсролын чуулга уулзалтаас баталсан; Дакар., Сенегал; 2000 оны 4 сарын 26–28; 3 дахь догол мөр.

¹³¹ Сурч боловсрох эрхийн талаарх Ерөнхий зөвлөмж No. 13 (1999); 1 дэх догол мөр.

¹³² E/CN.4/2001/52; 6 дахь догол мөр.

¹³³ Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг, хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010; 55–73 дахь тал.

2. СУРГУУЛИУД ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ

Суралцагчдын амьдарч байгаа нөхцөл, сургуульд ирэх бүртээ авч ирж байгаа тэдний амьдралын туршлагаас үүдэлтэй мэдлэгийн ач холбогдлыг анхаарахгүйгээр суралцагчдаа хүндэтгэх, дараагийн сургалтын үйл явцад гарах хүний эрхэм чанар, аажимдаа бий болох хувийн шинжийн тухай ярих боломжгүй.

Пауло Фрейри, Эрх чөлөөний сурганы арга зүй

Хүний эрхийн олон улсын конвенцууд дахь үнэ төлбөргүй, заавал эзэмших боловсролын тодорхойлолт нь “суурь боловсрол¹³⁴”-оор хязгаарлагдсан ч тус бүлэгт сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсролыг багтаан өргөжүүлсэн болно. Сургуулийн өмнөх боловсрол хүүхдийн ур чадварт нөлөөлж, цаашид боловсролын бусад түвшинд амжилттай оролцоход нөлөөлдөг талаар илэрхий нотолгоо бий. Сургуулийн хичээлийн хөтөлбөрүүд, туршлага, орчинд хүний эрхийг бий болгосноор оролцоог нэмэгдүүлж, өсвөр үе сургуулиа төгсөхдөө орон нутагтаа, дэлхий дахинд амьдрах, сурах, ажиллах ур чадвартаа итгэл төгс болсон байна.



Ангидаа байгаа бага сургуулийн хүүхдүүд, Харар, Этиоп. НҮБ-ын гэрэл зургийг Эскиндер Дебебе.

¹³⁴ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт; 13(2а) дугаар зүйл.

Сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол нь:

- боловсролоор хүний эрхийг буюу хичээлийн хөтөлбөрүүд, материалууд, арга, сургалт зэрэг бүх хэсэг, үйл явцдаа хүний эрхийн тухай мэдэх, сурах;
- боловсрол дахь хүний эрх буюу сургуулийн өмнөх боловсролын төвүүд, сургуулиудад хүн бүрийн эрхийг хүндэтгэх, эдлүүлэх явдлыг баталгаажуулна.

Хүний эрхийн сургагчийн зорилго бол сургуулийг бүхэлд нь хамарсан хүний эрхэд чиглэсэн хандлага тогтоохоор сургууль, түүний хамт олонтой ажиллахад оршино. Улсуудын туршлагаас харахад хүний эрхэд суурилсан сургуульд суралцсан хүүхэд, залуус:

- өөрийн эрхээ мэдэх;
- өөрийн хариуцлага, бусдын эрхийг ойлгох;
- өөртөө хангалуун байж, өөрийгөө хүндэтгэх;
- олон янзат байдлыг илүү хүлээн зөвшөөрөх;
- сурлагын чанараа дээшлүүлэх үр дүнтэй ажээ.¹³⁵

Багш нар илүү ардчилсан заах хэлбэр ашиглах, илүү эерэг ангийн зан үйлийн талаар илтгэх, заахдаа илүү их зарцуулах боломжтой.¹³⁶ Шинэ Зеландын сургуулийн өмнөх боловсролын арван төв, сургуульд хийсэн суурь судалгаагаар¹³⁷ хүний эрхийн боловсролын шилдэг туршлагатай болсон сургуулийн өмнөх боловсролын төв, сургуульд илэрсэн дараах онцлог шинжүүдийг тогтоосон байна. Үүнд:

- суралцагч, багш, удирдагч, эрхлэгч, захирагч нар хүний эрхийг үлгэрлэх төв/сургуулийг бүхэлд нь хамарсан хандлага;
- төв/сургуулийн хамт олны эерэг, идэвхтэй харилцаа;
- төв/сургууль эцэг эх, хамт олны гишүүд хүний эрхийг ойлгох, үлгэрлэхэд дэмжлэг үзүүлэх, урамшуулан дэмжих;
- төв/сургуулийн стратегийн зорилт, тэргүүлэх чиглэл, төлөвлөлт, төсөвлөлтөд хамт олноо төвлөрч харах;
- шийдвэр гаргахад хүүхэд, залуусын оролцоо;
- орон нутгийн, үндэсний, дэлхийн асуудалд бусдын адил анхаарахад хүүхэд, залуусаа урамшуулан дэмжих;
- хичээлийн бүх хөтөлбөртөө хүний эрхийн боловсролыг шингээж өгөх;
- сургуулийн бүх хамт олны дунд тасралтгүй даган мөрддөг суралцагчдын удирдлагын шинийг санаачилсан (нөхөн сэргээх байдлаар шударга ёс тогтоох зарчмууд, үе тэнгийнхэн зуучлах, суралцагчид оролцох санаачлага зэрэг) хандлага;
- олон янзат байдал, суралцагч төвтэй байдлыг тусгаж, дэмжсэн бодит орчин.

¹³⁵ Хэмпшир нутгийн зөвлөл, Нэгдсэн вант улс; Боловсролд хүний эрхийн хамт олныг бий болгох нь бүтээлээс – Хи Вакату Тика Тангата–а–Лви; Эмнести Интернэшнл (Шинэ Зеланд), Хөгжлийн эх сурвалжийн төв, Шинэ Зеландын Хүний эрхийн комисс, Хүүхдийн комиссарын газар, Энх тайвны сан; 2007.

¹³⁶ Жишээ үзнэ үү: 'LIFT OFF! Ирланд' (www.amnesty.org.uk/content.asp?CategoryID=748 –аас үзнэ үү); the RRR Санаачлага, Нэгдсэн вант улс (<http://hants.gov.uk/education/hias/childrensrights> –аас үзнэ үү) Хүүхдийн эрхийн төв, Канад (www.crin.org/resources/infodetail.asp?ID=4328 –аас үзнэ үү).

¹³⁷ Боловсролд хүний эрхийн хамт олныг бий болгох нь бүтээлээс – Хи Вакату Тика Тангата–а–Лви; Эмнести Интернэшнл (Шинэ Зеланд), Хөгжлийн эх сурвалжийн төв, Шинэ Зеландын Хүний эрхийн комисс, Хүүхдийн комиссарын газар, Энх тайвны сан; 2007.

3. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ЗАРЧМУУД БА СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ, СУРГУУЛИУД¹³⁸


Хүний эрхийн боловсролын зарчмууд нь ХЭҮБ-уудаас сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулийн хамт олон, боловсролын байгууллагуудад хийх ажлыг чиглүүлдэг. Хүний эрхийн боловсролын агуулгын хувьд сургагч сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулиудад хүний эрхийг мэдэх, хэрэгжүүлэх боломж олгож сэдэлжүүлдэг. Хүний эрхийн боловсрол олгохдоо сургагч өөрийн үйл ажиллагаандаа хүний эрхийн боловсролын зургаан зарчмыг ашигладаг.

Зарчим №1: Оролцогчдод хамааралтай байх

Сургуулийн өмнөх боловсролын төв, сургууль дахь оролцогч төвтэй хүний эрхийн боловсрол нь олон янзын түүхтэй, харилцан адилгүй суралцах хэлбэртэй, суралцах хэрэгцээ, чадал нь ялгаатай хүүхэд, залуус байгаа гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Эрх мэдэлгүй болгож, гадуурхахгүйн тулд давамгай “соёл” болон хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны орчинг хүлээн зөвшөөрөх, татан оролцуулах, дээрх ялгааг үнэлэх ёстой.

Уншиж сурч байгаа жаал хүү нэг өдөр сургуулиас гэртээ энэ шүлэг бичсэн зургийг авчирч гэнэ. Хүү ээж болон ээжийнхээ эмэгтэй хамтрагчтай амьдардаг байв. Түүний ээж нь гэр бүлдээ орлого олдог нэгэн ажээ. Хүүгийн сургууль, багш нь “Ээж” хүүхдээ асарч, “Аав” ажилдаа явдаг гетеросексуал харилцаатай цөм гэр бүл “хэвийн” гэж итгэдэг талаар хүү мэдэж авсан байна.

Хүү хэвийн биш байлаа.¹³⁹



Энэ бол аав. Энэ бол ээж.
Энэ бол би.

¹³⁸ Дөрөвдүгээр бүлэг дэх хүний эрхийн боловсролын зарчмуудын талаарх хэлэлцүүлгийг үзнэ үү.

¹³⁹ Шинэ Зеландын тохиолдол.

Зарчим №2: Хамтын ажиллагаатай байх

Сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол нь ганцаардсан, бусадтай ярилцаж чадахгүй нөхцөлд заасан бол үр дүнгүй. Өөрөөр хэлбэл хүний эрхийн тухай хичээл, эсвэл цуврал хичээл нь хүний эрхийг хүндэтгэдэггүй сургуульд заасан бол хүүхдэд ямар ч нөлөөгүй гэсэн үг. Дээрэлхэж, дарамталдаг, эсвэл ганцаардсан, гадуурхагдсан орчинд хүний эрхэм чанарын тухай ярихад хэцүү. Сургуулийн өмнөх боловсролын төв, сургууль дахь хүний эрхийн боловсролын амжилт нь багш, удирдлага, сургалтын ажилтан, суралцагчид, эцэг эх, боловсролын газар зэрэг сургуулийн бүх хамт олны хөгжүүлсэн үр нөлөөтэй хамтын харилцаанаас хамааралтай.

Зарчим №3: Оролцоог хангах

Хүүхэд, залуус бол тэдэнтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах, үйлчилгээгээ төлөвлөх, үзүүлэхдээ тэдний хэрэгцээг анхаарч, дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулагчид төдийгүй өөрсдийн амьдралаа хожим эхлэхэд тустай билээ. Тэдний оруулах хувь нэмэр, цоо шинээр хандах хандлагыг дорд үзэж болохгүй. Хүүхэд, залуус, гэр бүл бүхэн амьдралын сонголтоо хийх, өөрсдийгөө дэмжих, бусдын хэрэгцээг анхаарах, өөрсдийн бодсоноос илүүд хүрэх үр чадвар, боломжтой байх эрхтэй билээ.

Жон Коулан, Хүүхдийн үйлчилгээний захирал, Хэмпшир, Нэгдсэн вант улс

Суралцагчдын дуу хоолойг хүндэтгэх, оролцуулах нь Хүүхдийн эрхийн тухай конвенцын тулгын чулуу төдийгүй хүүхэд, залуус өөрт хамааралтай шийдвэрт оролцох эрхийг илэрхийлдэг¹⁴⁰. Хүүхэд бүр үзэл бодолтой байх, түүнийгээ бүх асуудлаар сонсгох эрхтэй. Хүүхэд, залуус хүний эрхийн талаар суралцахдаа идэвхтэй оролцогч, утга учиртай хувь нэмэр оруулагч гэж тооцвол зохино. Сургагч “чиглүүлэгч”-ийн үүрэг гүйцэтгэх ба давтуулан сургах хэлбэрээ харилцан идэвхтэй, хөдөлгөөнт үйл явцаар солино.

Зарчим №4: Ажиглан харах

Хүүхдүүдийн ангидаа харсан зүйлс нь түүний туршлага, өсч хөгжих үйл явцын нэг хэсэг болдог¹⁴¹.

Шри Ланкын Хүний эрхийн Комисс

Сургуулиудад зохион байгуулж байгаа хүний эрхийн боловсролын аргад ажиглан харах зарчим шууд хамаарна. Сургагч хүүхэд, залуус өөрийн хүний эрх, хариуцлагын тухай сурч мэдэх явдлыг урамшуулан дэмжих, сургалтаа тэдний сургууль, гэр, хамт олонтой уялдуулах, бусдын бодит амьдрал болон туршлагаас сурсан зүйлийг нь холбох, тэдний хандлага, зан үйлд одоо суралцаж байгаа зүйлсийг нь нөлөөтэй болгох зорилгоор оролцоог хангасан, хувийн туршлагад тулгуурласан үйл явц эрэлхийлэхэд хүрдэг.

Зарчим №5: Эргэцүүлсэн үйлдэл хийх

Анги эсвэл сургуулийн орчин бол хүний эрхийг хүндэтгэж, эсвэл зөрчиж болзошгүй харилцаа өрнөх хөдөлгөөнт, идэвхтэй газар билээ. Хүүхэд, залуус өөрийн үйлдлээ шүүмжлэх нөхцөл бүрдсэн тохиолдолд илүү их зүйл сурах таатай орчин бүрддэг онцлогтой. Тохиолдол шинжилснээр суралцагчид хүний эрхийн шилээр өөрийн зан үйл, орчноо тусгаж харах¹⁴² замаар өөрийн сурсан зүйл, зан үйлээ өөриймшүүлж үзэх, өөртэй, бусаддаа, дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүүхдэд илүү анхаарах, үе тэнгийнхэн, насанд хүрэгчидтэй үүссэн зөрчилдөөнөө шийдвэрлэхдээ өөрийгөө харуулахыг илүүд үзэхгүй хандлага ашиглах, бусдыг дээрэлхэхгүй байх, нийгэм дэх олон янзат байдал, ягшмал үзлийн эсрэг илүү эерэг хандлага барих зэрэг давуу талтай.

¹⁴⁰ Хүүхдийн эрхийн тухай конвенц; 48 12–17 дугаар зүйл.

¹⁴¹ Сургуулийн бүрэн эрх дэх хүний эрхийн боловсрол; Ширани Ражапакса, Шри Ланкын Хүний эрхийн комисс; www.hurights.or.jp/archives/pdf/education12/hreas-12-03-srilanka.pdf –аас үзнэ үү.

¹⁴² Хэмпшир нутгийн зөвлөл, Нэгдсэн вант улс; Боловсролд хүний эрхийн хамт олныг бий болгох нь бүтээлээс – Хи Вакути Тика Тангата–а–Лви; Эмнести Интернэшнл (Шинэ Зеланд), Хөгжлийн эх сурвалжийн төв, Шинэ Зеландын Хүний эрхийн комисс, Хүүхдийн комиссарын газар, Энх тайвны сан; 2007.

Зарчим №6: Эрх мэдэлжүүлэх

Эрх мэдэлжүүлэх зарчим нь хүний эрхийн сургагчдаас боловсролын агуулга, үйл явцаар дамжуулан өөрчлөлтийн төлөөх туршлага олгож, өөрийн амьдарч буй орчиндоо хүний эрхийг биелүүлэх нэгэн байхаар суралцагч бүрээ урамшуулан дэмжихийг шаарддаг. Үүний тулд хүний эрхийн боловсролоо итгэл төрүүлэхүйц, хүүхэд, залууст ээлтэй, аюулгүй, ялгаварлан гадуурхаагүй, ардчилсан орчинд олгох ёстой¹⁴³.

4. ХАНДЛАГУУД

Сургуулийн өмнөх боловсролын төв, сургуульд ажиллах төрөл бүрийн арга замуудыг дараах хэсэгт дурдсан ба Ази–Номхон далайн бүсийн ХЭҮБ–ууд маш их туршлага хуримтлуулсаар байна. Мөн Хүний эрхийн боловсролын тухай Тавдугаар бүлэг нь тус ажилтай холбоотой. ХЭҮБ–ууд хичээлийн хөтөлбөр, бодлого, туршлага, орчин зэрэг сургууль тэр чигээрээ хүүхэд, залуусаа өөрчлөлтийн төлөөх нэгэн болоход урамшуулан дэмжих төв гэж хүлээн зөвшөөрдөг. Хавсралт №10–т НҮБ–ын Хүүхдийн сангийн сургуулийн орчны хэсэг болсон хүний эрхийн түвшинг үнэлэхэд зориулсан хүрээг заасан байна.

5. АЗИ–НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ХЭҮБ–УУДЫН ШИНЖИЛСЭН ТОХИОЛДЛУУД

Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн мэдээллийн төвөөс Азийн сургуулиуд дахь хүний эрхийн боловсролд хийсэн жил бүрийн үнэлгээнээс¹⁴⁴ тухайн бүс нутгийн сургуулиудад хүний эрхийн үйл ажиллагаа ихээр явуулж байгааг харж болно.

АФГАНИСТАНЫ ХАРААТ БУС ХҮНИЙ ЭРХИЙН КОМИСС¹⁴⁵

Сургуулийн тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын талаарх анхаарах үндсэн чиглэлд:

- тухайн улсын хүний боловсролын болон академик төвүүдийн хичээлийн хөтөлбөрүүдэд хүний эрхийн асуудлыг тусгаж өгөх, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт бүхий хэсгийг хасах;
- дунд сургуулийн сурах бичиг дэх хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтын мэдээллийг нягтлан шалгаж, хянан засварлах, хүний эрхийн зарчмуудтай уялдуулах;
- Боловсролын яам, Дээд боловсролын яам, их сургуулиуд, багшийн сургалтын дээд боловсролын байгууллагуудтай түншлэн ажиллах.

**МЬЯНМАРЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС¹⁴⁶**

Хүний эрх нь Мьянмарын ерөнхий боловсролын сургуулиудын бага, дунд, ахлах ангийн хичээлийн хөтөлбөрт туслах хичээл байдлаар нэмж оруулсан байна.

Комисс болон Боловсролын яамны хамтын ажиллагааны үр дүнд тус санаачлага хэрэгжсэн байна. Комисс сургуулиуд олон жилийн тэртээх хүний үнэт зүйлсийн тухай мэдлэгийг заадаг ч хүний эрх нь тусдаа хичээл байдлаар заах нь чухал гэж тэмдэглэсэн юм. Сургуулиуд ангидаа хүний эрх заахын тулд тусламж, дэмжлэг шаардана.¹⁴⁷

¹⁴³ Сургуулийн тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын заавар; Ардчилсан байгууллагууд, хүний эрхийн газар; 2012.

¹⁴⁴ Азийн сургуулиуд дахь хүний эрхийн боловсрол; Ази, Номхон далайн Хүний эрхийн мэдээллийн төв; (Дугаар 12), 2009; www.hurights.or.jp/archives/human_rights_education_in_asian_schools –аас үзнэ үү.

¹⁴⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг www.hurights.or.jp/archives/pdf/education12/hreas-12-01-afghanistan.pdf.

¹⁴⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг www.asiapacificforum.net/news/myanmar-human-rights-to-be-added-to-school-curriculum.

¹⁴⁷ Дэлгэрэнгүй мэдээллийг www.hurights.or.jp/archives/pdf/education12/hreas-12-02-jordan.pdf.

Харилцан ойлголцох санамж бичгийн дагуу Боловсролын яамтай түншлэн ажиллаж, Төвийн зүгээс хүний эрхийн боловсролын талаарх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр анхаарч ажиллахдаа:

- Хичээлийн хөтөлбөр, сурах бичиг боловсруулах;
- Боловсролын яамны ажилтнуудад сургалт хийх, хүний эрх, ялангуяа хүний эрхийн сургагчдын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхэд зааварчлах;
- Тэмцээн, зуслан, зурагт хуудас гэх мэт хүний эрхийн талаарх хичээлийн бус хөтөлбөрийн үйл ажиллагаа зохион байгуулах;
- Сургуулиудад хүний эрхтэй холбоотой клубууд байгуулах;
- Телевизийн мэдээллийн хэрэгслээр боловсролын мэдээлэл түгээх.¹⁴⁸



Сургууль, их сургуулиудын суралцагчдад зориулсан Комиссын санаачлагаас дурдвал:

- Багш, суралцагчдад хүний эрхийн талаар үндсэн материал олгох зорилгоор 1996 онд хүний эрхийн сурвалж ном хэвлүүлсэн.
- Хүйс, каст, шашин, хөгжлийн бэрхшээлд тулгуурлан ялгаварлан гадуурхалт гэсэн багш, сургагчдыг дадлагдажуулахад зориулсан гарын авлага 2003 онд хэвлүүлсэн.
- Анхан суралцагчдад зориулсан хүний эрхийн боловсрол нэртэй ном 2005 онд хэвлүүлсэн.
- Бага, дунд, ахлах сургуулийн түвшинд ажиллаж байгаа Сурганы мэргэжилтнүүдэд зориулсан хүний эрхийн боловсролын талаарх модуль 2007 онд хэвлүүлсэн.
- Их сургууль, коллежид зориулсан хүний эрхийн хичээлийн загвар хөтөлбөр 2007 онд хэвлүүлсэн.

Хүний эрхийн асуудлын талаар дэлгэн харуулах зорилготой их сургууль/коллежийн суралцагчдад зориулсан дадлагын хөтөлбөр

- Эрх зүйн оюутнуудад зориулсан хүний эрхийн асуудлаарх шүүхийн мэтгэлцээний тэмцээн
- Сургуулиудын удирдлагад зориулсан хүний эрхийн асуудлаар дадлагдажуулах хөтөлбөрүүд

ШИНЭ ЗЕЛАНД УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН КОМИСС

2005 оноос хойш зохион байгуулсан үйл ажиллагаа:

- Шинэ Зеландын сургуулиуд дахь шилдэг туршлагын талаарх үндэсний суурь судалгаа;¹⁴⁹
- Сургууль, сургуулийн өмнөх боловсролын төвүүдийг хүний эрхийн хамт олон болгож хөгжүүлэх үйл ажиллагаа;¹⁵⁰
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний сурч боловсрох эрхийн талаарх судалгаа, сурвалжлага;¹⁵¹
- Сургууль дээр хүчирхийлэх, дээрэлхэх, дарамтлах үйлдлийн талаарх дүн шинжилгээ;¹⁵²

¹⁴⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг <http://nhrc.nic.in>.

¹⁴⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг www.hrc.co.nz/human-rights-environment/human-rights-education/education-projects.

¹⁵⁰ Мөн тэнд. Жишээ үзнэ үү: "Te Wairoa Reorua 2040" at www.hrc.co.nz/human-rights-and-the-treaty-of-waitangi/te-wairoa-re-orua-2040.

¹⁵¹ Дэлгэрэнгүй мэдээллийг www.hrc.co.nz/disabled-people/disabled-childrens-right-to-education.

¹⁵² Дэлгэрэнгүй мэдээллийг www.hrc.co.nz/hrc_new/hrc/cms/files/documents/01-Sep-2009_14-08-40_Human_Rights_School_Violence_FINAL.pdf.

ФИЛИППИН УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН КОМИСС¹⁵³

Сүүлийн хорин жилийн хугацаанд сургуулиудад хүний эрхийг хөхиүлэн дэмжихдээ:

- Байгууллага хоорондын хамтын ажиллагаа;
- Хүний эрх заах жишээ боловсруулах, үндэсний түвшинд хэрэгжүүлэх ажиллагаа;
- Багшийн сургалт, чадамж бий болгох ажиллагаа;
- Хүүхэд, эцэг эх, сургагчдыг эрх мэдэлжүүлэх хөтөлбөрүүд;
- Энх тайван, хүний эрхийн талаарх үндэсний залуусын форум зэрэг нэг удаагийн арга хэмжээ, үндэсний хэмжээнд хүүхдийн эрхийн талаар бага, дунд, ахлах ангийг хамарсан “Газар дээр нь зурах зургийн уралдаан”, хүний эрхийн талаар үндэсний сургагчдын хурал.

**КАТАРЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО¹⁵⁴**

2012 оны 3 дугаар сард сургуулиудад хүний эрхийн хөтөлбөр эхлүүлсэн. Тус хөтөлбөр нь:

- Харилцан адилгүй түвшний 12 сургууль хамарсан
- Хүний эрхийн соёл, ялангуяа хүүхдийн эрх, үнэнч байх, бусдаас хамаарах үнэт зүйлс, оролцоог хөхиүлэн дэмжихээр зорьсон
- Хүний эрхийн үндсэн ойлголт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын талаар сургуулийн суралцагчдад зориулсан олон тооны лекц
- Хүний эрхийн өдрөөр оролцогч сургууль бүр хүний эрхийн асуудлаарх зургийн, зохион бичлэгийн уралдаан, театрын жүжиг, “Катар дахь хүүхдийн эрх” сэдэвт панорама зураг
- Ялагчдыг алдаршуулах охидод зориулсан сургуулийн арга хэмжээг хамарна.

ШРИ ЛАНК УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН КОМИСС¹⁵⁵

Комисс сургуулийн өмнөх насны хүүхдүүд, сургуулийн хүүхдүүд (13–18 насны ангилалтай дунд, ахлах сургууль), сургагчид (сургуулийн захирал, багш, бусад ажилтан) зэрэг харилцан адилгүй бүлэгт анхаардаг. Тогтвортой байдлаар суралцагчдад боловсрол олгохын тулд төрөл бүрийн арга зүйг баталжээ. 2005 оноос:

- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг уялдуулах, багш, их сургуулийн оюутнууд, сургуулийн сурагчдад зориулсан хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн асуудлаар Боловсролын үндэсний хүрээлэнтэй хамтран ажилласан.
- Сургуулиудад хүний эрхийн нэгж танилцуулсан.
- Угсаатны олон бүлгийн суралцагчдын оролцоотойгоор драм, соёлын үйл ажиллагаа бүхий “Хүний эрхийн хуваагдашгүй байдал”-ын тухай концерт зохион байгуулсан.
- Энх тайван, адил тэгш харилцах тухай суралцагчдын санаа бодлыг харуулсан 500 бүтээл бүхий зургийн уралдаан, үзэсгэлэн, нээлттэй хэлэлцүүлэг
- Сургуулиудад хүний эрхийг хөхиүлэн дэмжихдээ олон улсын өдрийг ашиглаж байна.

¹⁵³ Дэлгэрэнгүй мэдээллийг www.hurights.or.jp/archives/pdf/education12/hreas-12-04-philippines.pdf.

¹⁵⁴ Катарын Хүний эрхийн Үндэсний хорооноос ирүүлсэн мэдээлэл.

¹⁵⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг www.hurights.or.jp/archives/pdf/education12/hreas-12-03-srilanka.pdf.

6. ОЛОН УЛСЫН САНААЧЛАГА, ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖУУД

Тус бүсийн гадна орших ХЭҮБ-ууд сургуулиуд дахь хүний эрхийн боловсролд зориулсан материал, эх сурвалжаар хангасан цөөнгүй санаачлага өрнүүлсэн байна.

- Эмнести Интернэшнлийн Сургуулиудын хөтөлбөрт хүний эрх¹⁵⁶, Ардчилсан байгууллага, хүний эрхийн газар¹⁵⁷ нь мэдлэг ойлголт, хандлага үнэт зүйлс, ур чадвар гэсэн хүний эрхийн боловсролын үндсэн гурван чадварт анхаардаг.
- Канадын Нова Скотиа дахь Кейп Бретонны Их сургуулийн коллеж дахь Хүүхдийн эрхийн төвөөс¹⁵⁸ заахын өмнөх болон дараах асуудлаар өргөн хүрээг хамарсан судалгаа хийжээ.
- Эквитас—Хүний эрхийн боловсролын олон улсын төв¹⁵⁹ 2004 оноос хүний эрхийн боловсролын арга, хөтөлбөр боловсруулж байгаа бөгөөд эдгээр хөтөлбөр нь хүүхэд, залуусын оролцоог урамшуулан дэмжих, мэдлэг ойлголтыг хөгжүүлэх зорилготой. Дунд сургуулийн насны хүүхдүүдэд зориулсан “Шударга тоглоцгоо” гэдэг албан бус хөтөлбөр нь сургуулийн дараах хөтөлбөр, зуны зусланд хүний эрхийн боловсрол түгээдэг. Уг хөтөлбөр “хүүхдүүдийн хүний эрхийн тухай мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, ялгаварлан гадуурхсан хандлага, зан үйлийн эсрэг тэмцэх ур чадвар олгох” зорилготой.
- **LIFT OFF! Хил дамнасан хүний эрхийн боловсролын санаачлага**¹⁶⁰ нь Хойд Ирланд, Бүгд Найрамдах Ирланд Улсын¹⁶¹ дунд сургуулиудад зориулсан санаачлага болно.
- МэлЖол¹⁶² нь Энэтхэгийн Мумбай хот, Махараштра мужийн зургаан дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг. Хүүхдийн эрхийн тухай конвенцоос өөрийн ойлголтын хүрээгээ тодорхойлсон ба зэрэгцэн оршин амжилтад хүрэх иргэний нийгэм бүтээх зорилготой. Хүүхдийн эрх, хариуцлагад анхаарах замаар хүүхдүүдийн дунд эрүүл хандлага төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх үзлийг бий болгох, иргэншлийн ур чадвар хөгжүүлэхээр ажилладаг. Харилцан адилгүй түүхтэй хүүхдүүдийн төрөл бүрийн хэрэгцээний талаар мэдлэг ойлголт нэмэгдүүлэхэд чиглэдэг. 1991 онд эхэлсэн МэлЖол Мумбайн сургуулиудтай хосолмол хөтөлбөр хэрэгжүүлж хамтардаг. Ихэвчлэн 10–15 насны хүүхдүүдэд чиглэн, төрийн өмчит дунд, ахлах ангийн болон багш сургах коллежуудтай хамтран ажилладаг.
- Хүний эрхийн боловсролын төлөөх ард түмний хөдөлгөөн¹⁶³ сургуулиудад анхаарлаа хандуулалгүй хүний эрхийн эх сурвалж, аргачлал боловсруулсан өргөн мэдээлэл бүхий цахим хуудас хөгжүүлдэг.
- Нэгдсэн Вант Улсын Хемпширийн “Эрх, Хүндэтгэл, Хариуцлага”¹⁶⁴ хүүхэд, залуусын сайн сайхан байдал, тэдний академик өсөлт дэвшилтэд анхаарч ажилладаг онцлогтой. Сургуулиуд дахь ёс суртахуун, үзэл санааны төвд Хүүхдийн эрхийн тухай конвенцыг тавьж, заах болон сурах үйл ажиллагааны хүрээг хүртэл илэрхийлдэг. Сургуулиа бүхэлд нь анхаарч үзэх хандлагаар хүний эрхийн ойлголтоо хичээл төлөвлөхтэй уялдуулсан багшид зориулсан төлөвлөгөөний жишээ, эцэг эхэд зориулсан материал, сургуулиудыг шинжилсэн тохиолдол зэргийг цахим хуудаснаас нь үзэх боломжтой.
- Суралцагчдын дуу хоолой төсөл¹⁶⁵ залуусын харах өнцөг, үйл ажиллагаанд анхаарах ба сургалт, бодлого, хөтөлбөр, агуулга, зарчмуудад нөлөөлөх суралцагчдын чадвар олгохоор зорьдог.
- НҮБ-ын Хүүхдийн сан¹⁶⁶ дэлхий дахинд эрх, хүндэтгэл, хариуцлагын чиглэлээр хөтөлбөрүүд боловсруулж, оройлон ажиллаж байна. (Хавсралт №10-ыг үзнэ үү.) Нэгдсэн Вант Улсад НҮБ-ын Хүүхдийн сан сургуулиуд

¹⁵⁶ Дэлгэрэнгүй мэдээллийг www.amnesty.org.nz/get-involved/human-rights-schools.

¹⁵⁷ Дунд сургуулийн тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын заавар; Ардчилсан байгууллагууд, хүний эрхийн газар; 2012.

¹⁵⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг www.cbu.ca/crc/sites/cbu.ca.crc/files/images/Art_Curriculum—English.pdf.

¹⁵⁹ Дэлгэрэнгүй мэдээллийг www.equitas.org/en.

¹⁶⁰ Дэлгэрэнгүй мэдээллийг www.liftoffschools.com.

¹⁶¹ Тус санаачлагад дараах байгууллагууд оролцсон болно. Үүнд: Ирландын Үндэсний багш нарын байгууллага, Улстерын багш нарын эвлэл, Эмнести Интернэшнл, Боловсрол Интернэшнл, Хичээлийн хөтөлбөр зөвлөх дэмжих үйлчилгээ, Хичээлийн хөтөлбөрийн зөвлөл, Боловсрол ба үнэлгээ, Хичээлийн хөтөлбөр, үнэлгээний үндэсний зөвлөл, Боловсролын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Ирландын Хүний эрхийн комисс, Хойд Ирландын Хүний эрхийн комисс.

¹⁶² Дэлгэрэнгүй мэдээллийг <http://meljol.net/india/>.

¹⁶³ Дэлгэрэнгүй мэдээллийг www.pdhre.org.

¹⁶⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг www3.hants.gov.uk/education/hias/childrensrights.

¹⁶⁵ Дэлгэрэнгүй мэдээллийг <http://student-voice-project.com>.

¹⁶⁶ Эрх хүндэтгэсэн сургуулиуд санаачлагын талаар дэлгэрэнгүй мэдээллийг http://e-activist.com/eacampaign/action.retrievestaticpage.do?ea_static_page_id=1362 —аас үзнэ үү.

дахь хүний эрхийн нөхцөлийг үнэлэх, аргачлал боловсруулах цогц хүрээг санаачилсан юм. Идэвхтэй, дэлхийн иргэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах бүрдэл хэсгүүд агуулсан стандартуудыг дөрвөн бүлэгт ангилан, сургуулиуд дээрх стандартыг хангасан бол шагнуулах байдлаар тогтолцоог бий болгожээ. Үүнд:

- Сургуулийн амьдралд Хүүхдийн эрхийн тухай конвенцын үнэт зүйлсийг шингээсэн манлайлал, захиргаа;
- Хүүхдийн эрхийн тухай конвенцын мэдлэг, ойлголт;
- Эрхийг хүндэтгэсэн ангиуд;
- Сургууль даяар шийдвэр гаргах үйл явц дахь суралцагчдын идэвхтэй оролцоо.



Сургуулийн хүүхдүүд НҮБ-ын Хүн амын сангийн БНСУ-ын Сөүл дэх төв байранд өөрсдийн урлагийн бүтээлээ үзүүлж байна. НҮБ-ын гэрэл зургийг Эван Шнейдер.

АРАВДУГААР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Хүүхдийн эрхийн тухай конвенцын 29 дүгээр зүйлд хүүхдийн сурч боловсрох эрхийн талаар тусгайлан заасан байдаг.
- Судалгаагаар хүүхэд, залуус хүний эрхэд суурилсан сургуульд өөрийн эрхээ мэдэх, өөрийн хариуцлага, бусдын эрхийг ойлгох, өөртөө хангалуун байж, өөрийгөө хүндэтгэх, олон янзат байдлын илүү хүлээн зөвшөөрөх, тэдний сурлагын чанар нэмэгддэг байна.
- Хүний эрхийн боловсролын зарчмууд нь ХЭҮБ-уудаас сургуулийн өмнөх боловсролын төв, сургуулийн хамт олон, боловсролын байгууллагууд дахь хийх ажлыг чиглүүлдэг.
- Ази-Номхон далайн бүсийн ХЭҮБ-ууд хүний эрхийн боловсролын чиглэлээр сургуулиуд, их сургуулиуд, боловсролын газартай идэвхтэй ажиллаж байна.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Хүүхдийн эрхийн мэдээллийн сүлжээ; Дэлгэрэнгүй мэдээллийг www.crin.org –аас үзнэ үү.

Компасито: Хүүхдэд зориулсан хүний эрхийн боловсролын зааварчилгаа; Будапешт дахь Европын Залуусын төв; www.eycb.coe.int/compasito/chapter_1/2_wha.html

Нэгдсэн Вант Улсын Эрх хүндэтгэсэн сургуулиудын шагналын НҮБ-ын Хүүхдийн сангийн үнэлгээ; Жүди Себба, Карол Робинсон; 2010

Дунд сургуулийн тогтолцоон дахь хүний эрхийн боловсролын заавар; Ардчилсан байгууллагууд, хүний эрхийн газар; 2012.

Шинэ Зеланд дахь хүний эрх 2010 – Нга Тика Тангата О Аотэароа 2010; Шинэ Зеландын Хүний эрхийн комисс; 2010

Хэрэгжүүлэх хууль: Шинэ Зеландын Аотэароа дахь эдийн засаг, нийгэм, соёлын эрх; Маргарет Бэджгүд, Крис Гледхил (эрх.), Шинэ Зеландын Хүний эрхийн сан; 2011

Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг, хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010

Эрх хүндэтгэсэн сургуулиудын санаачлага; НҮБ-ын Хүүхдийн сан; Дэлгэрэнгүй мэдээллийг http://e-activist.com/ea-campaign/action.retrievestaticpage.do?ea_stat-ic_page_id=1362

Урлагаар дамжуулан хүүхдийн эрхийг заах нь; Дианэ Люис Хүүхдийн эрхийн төв, Кейп Бретон их сургууль; 2007



БҮЛЭГ 11:

ЗӨРЧИЛДӨӨНТ БОЛОН ЗӨРЧИЛДӨӨНИЙ ДАРААХ НӨХЦӨЛ БАЙДАЛ
ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ¹⁶⁷

ТҮЛХҮҮР АСУУЛТУУД:

- Зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдалд хүний эрхийн боловсрол ямар ач холбогдолтой вэ?
- Зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдалд ХЭҮБ-уудын боловсролын үүрэг юу вэ?
- Ази-Номхон далайн бүсийн ХЭҮБ-ууд зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдалд одоогоор ямар санаачлага хэрэгжүүлж байна вэ?



Зэвсэгт хүчин хяналтаа тогтоож, хүмүүс эрхээ өдөр бүр зөрчүүлсээр хүний эрхэд итгэхээ болихын хамт бидний хэрэгжүүлж байгаа боловсролын хөтөлбөрүүдэд хүртэл нөлөөлж байгааг бид мартаж өсгүй¹⁶⁸.

1. ЗӨРЧИЛДӨӨНТ БОЛОН ЗӨРЧИЛДӨӨНИЙ ДАРААХ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮНИЙ ЭРХИЙН
БОЛОВСРОЛЫН АЧ ХОЛБОГДОЛ

- Боловсрол нь зөрчилдөөний нөлөөг багасгах, зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах бүс нутагт энх тайван тогтооход маш тустай.
- Боловсрол нь аль ч үед, маш хүнд хэцүү нөхцөлд ч эдлэх үндсэн эрх билээ. Энэ бол сургаал номлол төдий зүйл биш. Зөрчилдөөн дунд ч боловсрол олгосноор хүүхдээ зүй бус үйлдлээс хамгаалах чухал механизмаар хангах боломжтой.
- Боловсрол нь хүн хөгжүүлэх, ядуурлыг бууруулах үндсэн арга бөгөөд хүүхдэд боловсрол эзэмших боломж хоёр дахь удаа ховор тохиолддог. Зөрчилдөөний улмаас боловсрол эзэмших боломжоо алдвал хувь хүний хувьд боломж алдсанаар зогсохгүй нийгмийн баялаг, зөрчилдөөнөөс эргэн сэргэх нийгмийн чадавхаа алдаж байгаа гэсэн үг.
- Боловсрол асуудлын ч, шийдлийн ч хэсэг болж магад. Боловсролын тогтолцооны бүх түвшин дэх бодлого, туршлага нь зөрчилдөөнийг улам ноцтой болгох эсвэл хумих боломжтой эсэхийг задлан шинжлэх шаардлагатай¹⁶⁹.

¹⁶⁷ Энэхүү бүлгийн хэсгүүдийг Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг, хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010; Хүний эрхийн үндэсний байгууллагууд; Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, ХЭДКГ-ын хамтын ажиллагааны аргачлал; 2010 зэрэг бүтээлээс авсан болно.

¹⁶⁸ Палестины Хүний эрхийн хараат бус комиссын Ерөнхий захирал Ранда Синиора; АНДЧ 2012 оны 11 дүгээр сард хийсэн ярилцлагаас авав; www.youtube.com/watch?v=pNWUyU1Wajc&feature=youtu.be . –аас үзнэ үү.

¹⁶⁹ Зөрчилдөөн, энхийг сахиулах талаарх боловсролын нөлөө; Алан Смит; 2010 (Боловсролыг бүх нийтэд Дэлхий дахины мониторингийн тайланд зориулсан нийтлэл 2011).

2. ЗӨРЧИЛДӨӨНТ БОЛОН ЗӨРЧИЛДӨӨНИЙ ДАРААХ НӨХЦӨЛ БАЙДАЛД ХЭҮБ-УУДЫН БОЛОВСРОЛЫН ҮҮРЭГ

Харилцан адилгүй түүх, соёл, уламжлалтай улсуудад ХЭҮБ-ууд үйл ажиллагаа явуулдаг ч зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдлын улмаас тодорхой бэрхшээлтэй тулгарч байна¹⁷⁰. Дэлхий дахин дахь бүх ХЭҮБ боловсролын чиг үүрэг, бүрэн эрхийн дагуу ажилладаг ч зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдал дахь ХЭҮБ-уудын тэргүүлэх чиглэл ялгарч болзошгүй. Тэд “өөрсдийн нөхцөлд тохирсон онцгой үүрэг гүйцэтгэж, тулгарч буй нөхцөлдөө хариу арга хэмжээ авахаар энгийн хөтөлбөрийн чиг үүргээ өөрчлөх” боломжтой¹⁷¹.

Хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд саад болж байгаа, шүүмжлэхгүй байхын аргагүй зүйл бол зөрчилдөөнт нөхцөл байдлын гол цөмд хүний эрхэд ямагт халдаж байдаг¹⁷².

Зөрчилдөөнт нөхцөл байдлын үеэр ХЭҮБ-уудын боловсролын анхаарах чиглэл нь хамт олонд тулгуурласан сургалт, ялангуяа цөөнхийн эрхийг хүндэтгэх хэрэгцээтэй холбоотой байдлаар илүү анхаарал хандуулж болно. Эмэгтэйчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг хамгийн эмзэг бүлгүүд гол оролцогч бүлэг болж, иргэний болон улс төрийн эрхүүд зөрчигдөх магадлалтай эрхүүдэд тооцогдох боломжтой. Боловсролын аргуудад сайтар анхаарвал зохино. Зөрчилдөөн удаан үргэлжилсэн тохиолдолд боловсролын тогтолцоо сулран нурж, бичиг үсэг тайлагдаагүй хүмүүсийн тоо өсөх магадлалтай.

Зөрчилдөөний улмаас олон хүмүүс шилжин нүүсэн бол хүний эрхийн боловсрол нь хүмүүс шилжин нүүж очсон газар нутгийн хүн амаас тэдгээр хүмүүсийн нөхцөл байдал, тэдний эрхийг баталгаажуулах шаардлагатай тулгарна. Мөн хөрш улсуудын ХЭҮБ-ууд, бусад байгууллагууд дүрвэгсэдийн эрхийн талаар олон нийтэд зориулсан боловсролын үйл ажиллагаа зохион байгуулах жишээтэй¹⁷³. ХЭҮБ улс төрийн үзэл бодол ялгаатай эсвэл олонхитой адил соёлын, угсаатны, хэлний бүлэгт хамаарахгүй хүмүүсийн эрхийг хүндэтгэх шаардлагын улмаас хамт олонд тулгуурласан хүний эрхийн сургалт их зохион байгуулахаар зорьж болно¹⁷⁴.

Зөрчилдөөний дараах нөхцөл байдлын үеэр ХЭҮБ-ын боловсролын үйл хэрэг нь улам хүчирхийлэл үүсэхээс сэргийлэх, энх тайвныг тогтооход дараах байдлаар хувь нэмрээ оруулж чадна. Үүнд:

- Хүний эрх, хүлцэн тэвчих явдлыг хөхиүлэн дэмжих, хүчирхийллийн бус байдлаар орон нутгийн асуудлыг шийдвэрлэхээ баталгаажуулахад туслахыг хүндэтгэх;
- Өмнөх хүчирхийлэл, зүй бус үйлдлийг эцэслэх явдлыг чиглүүлэх үйл явц бий болгох;
- Хамт олон чиглэсэн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан дахин нэгдэх үйл явцыг дэмжих;
- Хүүхэд цэрэг, озлогдогчдод зориулсан тусгай санаачлага дэмжих:
 - Бэлгийн зүй бус үйлдэл зэрэг хүүхдийн туулж өнгөрүүлсэн туршлагаас үүдэлтэй сэтгэл зүйн гэмтлийг арилгахад чиглэсэн цогц шинжтэй хөтөлбөрүүд;
 - Хүүхдийн нас, бусад зүйлээс хамааран ангидаа эргэн суралцах боломжгүй тохиолдолд зориулсан тусгай боловсрол, сургалтын санаачлага;
 - Гэр бүлгүй хүүхдүүдэд зориулсан халамжийн хувилбарт үйлчилгээ бий болгох;
 - Хэдийгээр янз бүрийн шалтгааны улмаас эсэргүүцэлтэй тулгарсан ч эдгээр хүүхдээ эргүүлэн нийгэмшүүлэхэд чиглэсэн тусгайлсан хичээл зүтгэл¹⁷⁵.

¹⁷⁰ Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг, хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010; 38 дахь тал.

¹⁷¹ Мөн тэнд; 143 дахь тал.

¹⁷² Зөрчилдөөн шийдвэрлэх үйл ажиллагаа ба хүний эрх: Зөрчилдсөн үү эсвэл дэмжсэн үү; Бароны авхай Елена Кеннеди QC; 2001; Хүний эрхийн боловсролын багцад хэвлэсэн, Азийн бүсийн хүний эрхийн боловсролын эх сурвалжийн төв; 2003.

¹⁷³ Хүний эрхийн үндэсний байгууллагууд; Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, ХЭДКГ-ын хамтын ажиллагааны аргачлал; 2010; 61–62 дахь тал.

¹⁷⁴ Мөн тэнд; 62 дахь тал.

¹⁷⁵ Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010; 143–144 дахь тал.

ХЭҮБ–УУД, ТЭДНИЙ БОЛОВСРОЛЫН ЧИГ ҮҮРЭГТ ТУЛГАРЧ БАЙГАА БЭРХШЭЭЛ

Хүчирхийлэл, ноцтой асуудалд байсан улсын хувьд хүний эрхийн хүчтэй соёл хөгжүүлэхэд бэрх бөгөөд тухайн соёл ноцтой суларсан байж ч болно. ХЭҮБ–ууд ерөнхий байдлаар хүний эрхийн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх нь тэргүүлэх чиглэл байж болзошгүй. Дээр дурдсан сөрөг нөхцөлд удаан амьдарсан хүмүүсийн хувьд шинээр байгуулагдсан ХЭҮБ зэрэг албан ёсны механизмын талаар мэдэхгүй эсвэл итгэхгүй байж ч магад.

Энэ нөхцөлд ХЭҮБ–ууд юу хийдэг талаараа олон нийтэд таниулах, өөрийн итгэлтэй байдлыг бий болгохоор боловсролын хөтөлбөр хөгжүүлвэл зохино. ТББ–ын идэвхтнүүд зэрэг хүний эрхийн хамгаалагчид зөрчилдөөний үеэр байнга хохирогч болдог. Өөрсдийн үйл ажиллагааны улмаас олон хүн алагдаж, цөлөгдөж, бүр тэр даруй эргэн ирэхгүй байж магад. Энэ бол тухайн улсын хүний эрхийн соёлд гарч байгаа ноцтой хохирол бөгөөд ХЭҮБ–ууд зөрчилдөөний дараах нөхцөл байдалд ТББ–ууд бий болгохыг дэмжих, тэдний чадавхыг бэхжүүлэх тодорхой хэрэгцээг тогтоож болно. Олон зөрчилдөөн нь шашны, угсаатны, нийгмийн, соёлын, улс төрийн, эсвэл бусад цөөнхийн зовж шаналсан тэгш бус байдлын улмаас үүссэн эсвэл улам дордсон байдаг. Зөрчилдөөн үүссэн шалтгаантай уялдан зөрчилдөөний дараах нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулж байгаа ХЭҮБ–ууд цөөнхийн эрхийг ойлгох, хүндэтгэх явдлыг баталгаажуулахад чиглэсэн боловсролын тусгай хөтөлбөрүүдийг боловсруулна. Сахилга бат, хариуцлага хэвийн сахих боломжгүй, үл тоосон тохиолдолд ялангуяа зөрчилдөөний үеэр арми, цагдаагийн хүчин хүний эрхийн зүй бус үйлдэлд байнга оролцсон байдаг. Мөн энхийг сахиулах гэрээ эсвэл улс төрийн нөхцөл нь урьд тулалдаж байсан хүчнүүдийг татан оролцуулах шаардлага тулгарч магад. Бүхий л тохиолдолд, ялангуяа босогчдын хүчинг татан оролцуулсан бол арми, цагдаад зориулсан мэргэжлийн сургалт хийхээр зөрчилдөөний дараах нөхцөл байдалд ажиллаж байгаа ХЭҮБ–ууд тэргүүлэх чиглэлээ тогтоно¹⁷⁶.



НҮБ–ын Цэргийн асуудал хариуцсан мэргэжилтэн Зүүн Тиморын Фатумин дэр гэр бүлд аюулгүй байдлын тухай ярьж байна. НҮБ–ын гэрэл зургийг Мартине Перрет.

¹⁷⁶ Мөн тэнд; 44 дэх тал.

3. ЗӨРЧИЛДӨӨНТ БОЛОН ЗӨРЧИЛДӨӨНИЙ ДАРААХ НӨХЦӨЛ БАЙДЛААС ГАРСАН ХЭҮБ-УУДЫН ДУУ ХООЛОЙ

3.1. Палестин Улсын Хүний эрхийн Хараат Бус Комисс

Дараах мэдээллийг АНДЧ 2012 оны 11 дүгээр сард Палестины Хүний эрхийн Хараат Бус Комиссын Ерөнхий захирал Ранда Синиоратай хийсэн ярилцлагаас авсан болно.

Үйл ажиллагаагаа төвлөрлөөс гадагш чиглүүлэхэд анхаарах

Комиссын хөтөлбөрт орон нутгийн болон судалгааны ажилтан, бүсийн салбарын менежерүүд бол мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүмүүс юм. Төвлөрүүлэлгүй, олон жижиг хэсэгт хуваасан байдаг. Комиссын ажлын албаны 56 эсвэл 57 ажилтны бараг 30 орчим нь мэдлэг ойлголт нэмэгдүүлэх болон боловсролын хөтөлбөрүүдэд анхаарч ажилладаг.

Хоёр талын үйл явц

Комисс бүсүүдэд сонсгол хийх, уулзалт зохион байгуулах, хүний эрхийн асуудлууд хэлэлцэхээр нээлттэй өдөр төлөвлөх, өөрсдийн анхаарч ажиллахаар сонгосон тодорхой сэдвүүдэд чиглэж ажилладаг. Хоёр зүйлд чиглэсэн гэж харж болно. Бид мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, боловсролын хөтөлбөрөө хэрэгжүүлэхийн хамт тэдгээр хүмүүсээс гомдол хүлээж авна. Мөн ирүүлсэн гомдлоос хүний эрхийн зөрчил хаана гарч байгаа, юунаас үүдэлтэйг харж, өөрийн боловсролын хөтөлбөрөө чиглүүлэхэд хүрдэг.

Хэвлэл мэдээллийн хэрэглээ

Хэвлэл мэдээлэл бол хүн бүрт хүрэх, хямд мөртлөө чухал арга хэрэгсэл. Бид телевиз, орон нутгийн радио, ярилцлагын нэвтрүүлгийг их ашигладаг нь бусад хэрэгслээс илүү хэрэглэх боломжтой, хүн бүр үзэж, сонсдог, хүртээмжтэй байдагтай холбоотой. Улирал тутмын Хүний эрх сэтгүүлээ төрөл бүрийн хүний эрхийн асуудлуудад анхаарах гол зорилгоор араб хэл дээр бэлтгэдэг. Комисс Баруун эрэг болон Газын зурвас дахь гол хоёр сонинд тусгай булантай.

Эмзэг бүлэгт голчлон анхаарах

- Эмэгтэйчүүд, охид: Баривчлах, эрүүдэн шүүх, үндэслэлгүй саатуулах зэрэг эмэгтэйчүүдийн эсрэг зөрчил ихэссэн. Жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдэд шүүхийн тогтолцоо хүртээмжтэй байх, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо зэрэг асуудалд сургалт, мэдлэг ойлголт нэмэх, боловсролын хөтөлбөрүүд чиглэдэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс: Комисс анх удаа үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлмөрлөх эрхийн чиглэлээр хяналт шалгалт хийсэн. Сургалтаа мөн энэ асуудалд чиглүүлдэг.
- Хүүхэд: Комисс хүүхдийн эрхийн омбудсмантай байгууллагаа уялдуулах, хамтрахаар ажиллаж байна.

Тэргүүлэх чиглэлийн эрхүүд

- Хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх эрхийг дорд үзэх
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдэд мониторинг хийх, хөхиүлэн дэмжих чадавхаа улам бэхжүүлэхээр зорьж байна.

Хамтран ажиллах чиглэл

Палестин дахь эмэгтэйчүүдийн болон бусад байгууллага зэрэг ТББ-ын салбар идэвхтэй ажилладаг. Тэд манай хүний эрхийн нөлөөлөл, боловсролын олон хөтөлбөрт идэвхтэй оролцдог. Бид төрийн албан хаагчид өөрийн ажлыг гүйцэтгэхдээ хүний эрхийг хүндэтгэх явдлыг баталгаажуулахын тулд сургалт, чадавх бэхжүүлэх хөтөлбөрөө төлөвлөж байна.

Төрийн албан хаагчдын сургалтын хувьд шууд өөрчлөлт мэдэрнэ гэж бодохгүй байна. Жишээлбэл, аюулгүй албаны нэг хүн надад “Би урьд хүн эрүүдэн шүүдэг байсан... Таны сургалтын дараа би өөрийн гараа хэн нэгэн рүү далайхдаа, эрүүдэн шүүхдээ энэ бол миний хариуцлагын асуудал гэж санана. Цагийн уртад арилахгүй дээ” гэж хэлсэн юм. 2013 оны хувьд тушаал өгдөг өндөр албан тушаалтнуудыг тэргүүлэх чиглэлээр сонгосон.



Газын зурвас дахь хичээлийн эхний өдөр. НҮБ-ын гэрэл зургийг Шариф Сархан.

Боловсролын бодлого

Комисс ажлын албаны гишүүн бүрээ хүний эрхийг дэмжигч байж, боловсролын үйл ажиллагаанд оролцоно гэж тооцдог. Хүн бүр өөрийн мэргэшиж байгаа чиглэлээр Комиссын мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, сургах хөтөлбөрт оролцоно гэж найдаж байна.

3.2. Афганистан Улсын Хараат Бус Хүний эрхийн Комисс

Дараах мэдээллийг АНДЧ-ын 2012 оны 11 дүгээр сард Афганистан Улсын Хараат Бус Хүний эрхийн Комиссын гишүүн Ахмад Зиа Лангартай хийсэн ярилцлагаас авсан болно.

Комиссын боловсролын хөтөлбөр нь сургууль, цагдаа, Ерөнхий прокурорын ажлын албаны албан хаагчид, шүүгчид, ТББ-ын ажилтнууд, орон нутгийн шура буюу зөвлөл, тосгоны зөвлөлийн гишүүдэд чиглэдэг ба хэдэн салбар анхаардаг.

Хүүхдийн эрх


Комисс хүүхдийн эрх, хүүхэдтэй хэрхэн харилцах талаар сургуулийн багш нарыг сургадаг. Мөн энэ сэдвээр цагдаагийн албан хаагчдад сургалт хийдэг.

Сургууль, коллежуудад мэдлэг ойлголт нэмэгдүүлэх

Коллежуудын дунд хүний эрхийн зарчмууд нь Исламын эсрэг гэсэн буруу ойлголт бий. Бид сургалт, уулзалт хийсний дараа маш сайхан сэтгэгдэл хүлээн авч, оролцогчдоос хүний эрхийн зарчмууд болон Ислам адилхан юм байна гэж хэлэхийг сонсдог. Ислам шударга ёс, тэгш эрх хүсдэг бол хүний эрх ч шударга ёс, тэгш эрх хүсдэг. Зарчмын хувьд адилхан ч хандлага нь өөр байж болох юм. Коллежуудад мэдлэг ойлголт нэмэгдүүлэхээр бид зорьсон нь тэд хүмүүстэй ойр холбоо тогтоож, улсынхаа өнцөг булан бүрт хүрч чаддагтай холбоотой. Сүүлийн таван жилд хүний эрхийн мессежүүд сургуулийн 1–12 дугаар ангийн сурах бичигт оруулсан байна. Энэ бол маш сайн үр дүн. Яг одоо хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн ном оруулаач гэж Боловсролын ямааа ятгах маш хэцүү байдалд байна. Гэхдээ нийгмийн шинжлэх ухаан, гадаад сурах бичигт богино түүх эсвэл шүлэг байдлаар мессежүүдээ оруулчихсан байгаа. Комисс цөөнгүй их сургуулиудтай Хамтран ойлголцох санамж бичиг байгуулж, тэдний хичээлийн хөтөлбөрт хүний эрх хичээл оруулсан юм. Хуулийн сургуулиудад хүний эрхийг тусдаа хичээл байдлаар зааж байна.

Хүний эрхийн ерөнхий зарчмууд, хүний эрхийн болон исламын шашны зарчмуудын тохиромжит байдлыг ойлгох нь

Комиссын хөтөлбөрийг янз бүрийн коллежууд сайшаан хүлээж авсан. Асуудлаа номлол, мөргөлийн үеэр гаргаж ирдэг. Өдөр бүрийн эсвэл долоо хоногийн номлолын үеэр эмэгтэйчүүд, хүүхдийн эрх, хүний эрхийн ерөнхий зарчмуудаа гаргаж ирэх нь хүний эрхийн тухай энгийн хүмүүсийн ойлголт төсөөллийг өөрчлөхөд маш үр нөлөөтэй.



Хамт олныг хөгжүүлэх, энхийг сахиулах тухай сургалтын хөтөлбөрт оролцогчид, Нили, Афганистан.
НҮБ-ын гэрэл зургийг Эрик Каналштейн.

Хэвлэл мэдээллээр дамжуулан олон нийтэд хүрэх нь

Афганистанд олон хүн бичиг үсэг тайлагдаагүй тул телевиз, радио бол маш хэрэгцээтэй мэдээллийн хэрэгсэл юм. Тэдний хөтөлбөрүүд нь авиан болон дүрслэх хэлбэртэй тул хүн болгон ойлгох боломжтой. Ихэнх телевиз, радиогийн сувгууд хүний эрхийн хөтөлбөрийг үнэ төлбөргүй цацаж өгдөг. Комиссын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар сайн мессежтэй, хүн бүр үзээд ойлгох боломжтой богино хэмжээний телевизийн хөтөлбөр бэлтгэдэг. Хуульч, хүний эрхийн идэвхтэн, ТББ-ын ажилтан эсвэл хохирогчийг ярилцлагадаа оруулах тохиолдол бий. Хүүхдийн тухай хөтөлбөртөө жишээлбэл хүнд хөдөлмөр эрхэлж байгаа, аяга таваг угааж байгаа, машин засварын газар ажиллаж эсвэл гудамжинд гуйлга гуйх хүүхдүүдийн талаарх тохиолдлыг харуулж болзошгүй. Афганистанд золоор 30 гаруй телевизийн байгууллагууд идэвхтэй ажиллаж, ихэнх нь олон улсын хиймэл дагуулын тогтолцоотой холбогдсон тул Афганистан дахь олон хүн бидний хөтөлбөрийг үзэх боломжтой. Цахилгаан байхгүй хөдөө нутагт хүмүүс нарны зай хураагуур ашиглан гэртээ телевиз үзэж байна.

Сургалт

Хуульчид, ТББ-ын ажилтнууд, прокурор, сургуулийн багш, их сургуулийн багш зэрэг хүмүүст бид сургалт зохион байгуулдаг. Бид боловсролын хөтөлбөртөө хүний эрхээ иргэний хариуцлагатай холбож тайлбарладаг. Учир нь Афганистан дахь хүний эрхийн зөрчил, хүний эрхийг үл хүндэтгэхтэй холбоотой асуудлын нэг нь хүмүүсийн дунд иргэний хариуцлагын тухай ойлголт сул байх билээ.

АФГАНИСТАН ДАХЬ ЭНХИЙГ САХИУЛАХ САНААЧЛАГА

Ахмад Фахим Хахим хэлснээр олон жилийн дайн, цэргийн дэглэм, Талибаны хяналт нь хүчирхийллийн соёл бий болгож, тухайн улсын нийгэм болон улс төрийн амьдралын бараг бүх хэсэгт нөлөөлсөн юм. “Боловсролын хичээлийн хөтөлбөрөө дэс дараатай цэрэгжүүлсэн байгаагаас харж болно. Жишээлбэл, хүүхэд нэмэх, хасах, хуваах үйлдэл хийхдээ савтай сумаар жишээ татаж байна. Оюун сэтгэлгээ нь хүчирхийлэхэд чиглэснээр хүн бүр түрэмгий зан үйлээ харуулж, бусадтай харилцдаг.” Хамт олны түвшинд зөрчилдөөний улмаас газар эдлэх, усаар хангагдах, төрөхтэй холбоотой асуудлыг устгаж, үгүй болсон төдийгүй шура буюу орон нутгийн зөвлөл ч уламжлалт хэлбэрээр үр нөлөөтэй ажиллахаа больсон байна.

Ашгийн бус төрийн бус байгууллага болох Энх тайван, эв нэгдлийн төлөөх хамтын ажиллагаагаар (www.crau.org.af) дамжуулан, Фахим орон нутгийн анхан шатны нэгж дээр хүмүүс маргаанаа эвээр шийдэх, эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, угсаатнаар хуваагдах зэрэг тогтолцооны шинжтэй асуудалд хандах ур чадвар, мэдлэг, механизм бий болгохоор зорин ажиллаж байна. Энэхүү хандлагын гол үндэс нь нийгмийн бүх гишүүдээ татан оролцуулж, дуу хоолойг нь сонсох “энхийн зөвлөл” байгуулах юм. “Бид шийдэл санал болгох талаар хэзээ ч хичээж байгаагүй. Үүний оронд асуудлаа улам хурцатгадаг байсан тул одоо хамтдаа асуудалдаа анхаарах, зөрчилдөөнөө эв найртайгаар шийдэхэд юу хийж чадах вэ гэдэгт анхаарна” гэж Фахим хэлэв. “Би амьдрал нь сүйрэх дөхсөн хүмүүстэй ажиллаж байсан. Тэд эргэж ирээд “Би чадавхтай юм байна, бид энэ асуудлаа өөрсдөө шийдэж чадна” хэмээн хэлнэ гэж боддог. Энэ бол маш өдөөсөн, жинхэнэ хамт олон эрх мэдэлжиж байгаа явдал юм.” Тэрээр энхийг сахиулах санаачлага, хөгжлийн үйл ажиллагаа, хүний эрхийн нөлөөллийн ажил хоорондоо нягт холбоотой гэж нэмж хэллээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.asiapacificforum.net/news/ahmad-fahim-hakim-afghanistan.html –аас үзнэ үү.



АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ҮНДСЭН САНАА

- Зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах бүсүүд дэх боловсрол нь зөрчилдөөний нөлөөг багасгах, энх тайвныг сэргээхэд чухал.
- Зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах бүсүүдэд ХЭҮБ-ууд өөрийн нөхцөл байдалд тохирсон онцгой үүрэг гүйцэтгэх, нийгэм дэх харилцан адилгүй бүлгүүдэд тулгарч байгаа тусгай нөхцөл байдалд хариу арга хэмжээ авахаар энгийн хөтөлбөрийн чиг үүргээ өөрчлөх шаардлагатай тулгарч болно.



ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Зөрчилдөөн шийдвэрлэх үйл ажиллагаа ба хүний эрх: Зөрчилдсөн үү эсвэл дэмжсэн үү; Бароны авхай Елена Кеннеди QC; 2001;

Хүний эрхийн боловсролын багц; Азийн бүсийн хүний эрхийн боловсролын нөөцийн төв; 2003 он

Боловсрол, эвлэрүүлэх ажиллагаа: Зөрчилдөөнт болон зөрчилдөөний дараах нөхцөл байдлыг танин мэдэх нь; Жулиа Паулсон (хян.); 2011 он

Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Түүх, зарчмууд, үүрэг, хариуцлага; Мэргэжлийн сургалтын цуврал No. 4 (Хян. 1); ХЭДКГ; 2010 он

Зөрчилдөөнд өртсөн улсуудын чанарын боловсрол: Чиглүүлэгчийн зааварчилгаа; Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага; 2005;

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://unesdoc.unesco.org/images/0014/001433/143319E.pdf>

Зөрчилдөөн, энхийг сахиулах талаарх боловсролын нөлөө; Алан Смит; 2010 (Боловсролыг бүх нийтэд Дэлхий дахины мониторингийн тайланд зориулсан нийтлэл 2011 он)

Хүний эрхийн Үндэсний Байгууллагууд; Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, ХЭДКГ-ын хамтын ажиллагааны аргачлал; 2010 он





Дөрөвдүгээр хэсэг Арга, аргачлал



Бүлэг 1: Хүний эрх: үндсэн ойлголт

Бүлэг 2: Хүний эрхийн боловсрол: үндсэн ойлголт

Бүлэг 3: Хүний эрхийн үндэсний байгууллагууд ба хүний эрхийн боловсрол

ХЭСЭГ IV:

Дөрөвдүгээр хэсгийн танилцуулга

Зааварчилгааны энэ хэсэгт хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхдээ ашиглаж болохуйц эх сурвалж, арга, техникийг нэгтгэн орууллаа. Эдгээр нь олон төрлийн эх сурвалжаас эхтэй ба хаанаас авсан болохыг эшлэн оруулав.

Уг Зааварчилгааг хэрэглэж байгаа хүний эрхийн сургагч нарт үр ашгийг нь мэдэрсэн өөр эх сурвалж, нэмэлт арга байж болно.

Дор байрлах хүснэгтээр дээрх аргуудыг жагсааж, хүний эрхийн боловсролын тойргийн гурван шатны хаана хэрэглэж болохыг тодорхойлсон болно. Арга бүр ямар зорилготой, хэдий хугацаа зарцуулах талаар товч тайлбартай¹⁷⁷. Мөн хүснэгтээс тухайн аргыг ашиглах ур чадварын түвшинг тодорхойлсныг үзэж болох ба Гуравдугаар бүлэгт жагсаасан хүний эрхийн сургагчийн ур чадварт тулгуурласан юм.

Мэдлэгт хамаарах шаардлага

Хүний эрхийн талаарх мэдлэгт:

- Хүний эрхийн талаарх ерөнхий ойлголт, хөхиүлэн дэмжих, хамгаалах талаар
- Олон улсын болон дотоодын түвшинд эрхийг тодорхойлсон хүрээ, хүний эрх зөрчигдөх нөхцөл байдалд анхаарсан механизм зэрэг хууль тогтоомжид заасан механизм
- Хүний эрхэд суурилсан хандлага
- Үүрэг хүлээгч, эрх агуулагч, нөлөөлөгч нарт хүний эрх хэрхэн нөлөөлдөг талаар
- Хүний эрхийг биелүүлэхийн тулд нийгэм ямар чиг үүрэг гүйцэтгэдэг талаарх мэдлэгийг ойлгоно.

Боловсрол, сургалттай холбоотой мэдлэгт:

- Боловсролын онол, зарчмын талаар ерөнхий ойлголт, ялангуяа хүний эрхийн боловсролын талаар
- Албан болон албан бус орчинд, бүх насны төлөөлөлд хамаарах боловсролын арга зүй, үйл явц, аргын талаарх мэдлэгийг ойлгоно.

Техникийн болон мэргэжлийн туршлагатай холбоотой шаардлага

- Хүний эрхэд суурилсан хандлага ашиглах
- Албан болон албан бус орчинд, бүх насны төлөөлөлд хамаарах нөхцөл байдалдаа тохирохуйц хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх
- Мэдээлэл түгээх, сургах, чиглүүлэх, нөлөөлөх, харилцаа холбоо тогтоох, хамт олныг хөгжүүлэх зэрэг төрөл бүрийн хүний эрхийн боловсролын арга, аргачлал ашиглах
- Олон талт төлөөлөл бүхий бүлэг, хамт олонтой ажиллах ур чадварыг ойлгоно.

Хувь хүнд тавих шаардлага

- Мэргэжлийн туршлагадаа тусгах, сайжруулах ур чадвар
- Хувь хүний онцлог шинж, байр суурь, бусдад үзүүлэх нөлөөллийг хүлээн зөвшөөрөх ур чадвар
- Орон нутгийн болон дэлхий дахины түвшинд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах сэдэлтэй байна.

¹⁷⁷ Энд заасан цагийн хязгаарыг заавар гэж ойлгож болно. хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны хүрээ, оролцогчдын мөн чанараас хамаарч хугацааг нэмж, хасах боломжтой.

Нэр	Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хүчний талбайг задлан шинжлэх	Төлөвлөх, үнэлэх	Гарах үр дүнгээ тооцох, түүнд хүрэх стратегиа төлөвлөх арга	2 цаг–1 өдөр	Дунд
Хариу үйлдлийг үнэлэх шугам	Төлөвлөх, үнэлэх	Оролцогчдын өмнөх мэдлэгийг мэдэх, дасгал ажлын үр дүнд хэрхэн ахиц гарсныг үнэлэх арга	15 мин–1 цаг	Эхлэлийн
Гудамжны судалгаа	Төлөвлөх, үнэлэх	Ямар нэгэн нөхцөл байдлын талаар мэдэх эсвэл задлан шинжлэх, санал бодлыг сонсох, ямар нэгэн үйлчилгээг үнэлэх арга	Багадаа 1 өдөр	Туршлагатай
Шүрэн хадаар задлан шинжлэх	Төлөвлөх, хэрэгжүүлэх	Тодорхой нэг нөхцөлд харилцан адилгүй эрх мэдлийн харилцаа, олон янзын туршлагыг ойлгох арга. Тухайн нөхцөлд бусад хүмүүс хэрхэн нөлөөлөх эсвэл ямар туршлагатай болохыг тодорхойлоход тусалдаг.	1–2 цаг	Туршлагатай
Олоннийтийн зураглал хийх нь	Төлөвлөх, үнэлэх	Оролцогчид “орших газар” –таа (ажлын байр, сургууль, хамт олон, бүс нутаг, улс) нуу болж байгаа тухай түүхээ хэлэх боломж олгодог арга.	Харилцан адилгүй	Эхлэлийн
Зурган дуу хоолой	Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	Оролцогчид “орших газар” –таа (ажлын байр, сургууль, хамт олон, бүс нутаг, улс) нуу болж байгаа тухай түүхээ хэлэх боломж олгодог арга.	Харилцан адилгүй	Туршлагатай
Эрэмбэлэх	Төлөвлөх, хэрэгжүүлэх	Хүний эрхийн сургагч нарт (тохиромжтой бол оролцогчид) бүлгийн ажил дахь дасгалуудаа эрэмбэлэхэд ашиглана.	Харилцан адилгүй	Эхлэлийн
Зохион байгуулагч тойрог	Төлөвлөх, хэрэгжүүлэх	Хүний эрхийн сургагч нарт (тохиромжтой бол оролцогчид) бүлгийн ажил дахь дасгалуудаа эрэмбэлэхэд ашиглана.	Харилцан адилгүй	Дунд
Суралцахуйн давалгаа	Төлөвлөх, үнэлэх	Хүний эрхийн сургагч нарт (тохиромжтой бол оролцогчид) оролцооны шинжтэй дасгалыг чиглүүлэхдээ ашиглана. Дасгалын үр дүнд суралцсан зүйлээ тодорхойлох, ашиглах зорилготой.	Харилцан адилгүй	Эхлэлийн

Нэр	Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Чиглүүлэх техник	Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	Бүлэг хүмүүсийг чиглүүлэхэд ашиглах боломжтой аргачлалын жагсаалт. Янз бүрийн хүний эрхийн аргачлалд, төрөл бүрийн зорилгоор ашиглана.	Харилцан адилгүй	Бүх түвшин
Оюуны зураглал	Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	Үндсэн санаа, ойлголт, асуудлынхаа талаар эргэцүүлэхдээ ашигладаг арга	30 минутгаас 1 цаг хүртэл	Эхлэлийн
Модон диаграм	Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	Асуудал, тэргүүлэх чиглэлээ ойлгох, үр дүн, стратегиа боловсруулах зэрэг олон зорилгоор ашиглах арга.	Хоёр цаг түүнээс дээш	Дунд
Театр	Хэрэгжүүлэх	Драм, жүжиглэх, дүрдорх, хувирах, кино үзэх байдлаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн асуудал, нөхцөл байдлыг танин мэдэхэд ашигладаг	Харилцан адилгүй	Дунд – Туршлагатай
Дүрслэх урлаг	Төлөвлөх, үнэлэх	Асуудал, нөхцөл байдлаа танин мэдэхэд зураг зурах, баримал хийх, хэвлэх, гэрэл зураг авах, гараар урлах болон бусад харааны хэрэгсэл ашигладаг.	Харилцан адилгүй	Бүх түвшин
Хүний эрхийн түгээмэл тунхаглалын тухай жишиг уулзалт	Хэрэгжүүлэх	Харилцан идэвхтэй байдлаар Хүний эрхийн түгээмэл тунхаглалын талаар таньж мэдүүлэх жишиг болгох туршлага солилцох уулзалт.	2 цаг	Эхлэлийн
Туршлага солилцох уулзалтын тойм: Хүний эрхийн талаарх танилцуулга	Хэрэгжүүлэх	Харилцан идэвхтэй байдлаар дотоодын болон олон улсын хүний эрхийн талаар танилцуулдаг туршлага солилцох уулзалт.	2 цаг	Эхлэлийн
Туршлага солилцох уулзалтын тойм: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх танилцуулга	Хэрэгжүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай танилцуулах туршлага солилцох уулзалтын тойм.	2 цаг	Эхлэлийн
Туршлага солилцох уулзалтын тойм: Бэлгийн болон арьс үндсээр дарамтлах	Хэрэгжүүлэх	Бэлгийн болон арьс үндсээр дарамтлах талаар таниулдаг туршлага солилцох уулзалтын тойм.	2 цаг	Эхлэлийн

Нэр	Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Туршлага солилцох уулзалтын тойм: Дээрлэх, дарамтлах	Хэрэгжүүлэх	Дээрлэх, дарамтлах тухай туршлага солилцох уулзалтын тойм.	2 цаг	Эхлэлийн
Тэгш эрх: хэзрийн тоглоом	Хэрэгжүүлэх	Нийгэмд оршин буй тэгш бус байдлыг үлгэрлэн харуулах туршлагад тулгуурласан дасгал.	1–4 цаг	Туршлагатай
Дэлхийн кафе	Төлөвлөх, үнэлэх	Харилцан яриа өрнүүлэх, мэдлэг, санаагаа хуваалцах оролцооны дасгал	1–2 цаг	Дунд
Галт бөмбөг тоглоом	Хэрэгжүүлэх	Өмнө хэлэлцсэн асуудлаа давтах дасгал.	10–20 минут	Эхлэлийн
Үйл ажиллагааны тэмдэглэлийн дэвтэр	Төлөвлөх, үнэлэх	Урт хугацааны хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа, эсвэл төслийн үеэр тохиолдсон тэмдэглэхүйц үйл явдал, арга хэмжээг тэмдэглэх арга.	Үргэлжилнэ	Эхлэлийн
Үнэлгээний даргс	Үнэлэх	Дасгалаа үнэлэх оролцооны арга.	20–30 минут	Эхлэлийн
Саналын дугуй	Үнэлэх	Дасгалын аль ч хэсгийг үнэлэхэд бүлгээрээ саналаа хэлэх оролцооны арга	20–30 минут	Эхлэлийн

Арга № 1:

Хүчний талбайг задлан шинжлэх

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, үнэлэх	Гарах үр дүнгээ тооцох, түүнд хүрэх стратегия төлөвлөх арга	2 цаг–1 өдөр	Дунд

Хүчний талбайг задлан шинжлэх нь боловсролын үйл ажиллагааны онцлогоо үнэлэх, түүнийг төлөвлөх, хэлбэрийг тогтооход сургагчид тусалдаг. Үүгээр өнөөгийн нөхцөл (харьцуулах үндсэн мэдээлэл), зорилго, зорилгын эсрэг үйлчлэх эсвэл дэмжиж байгаа хүчин, зорилгодоо хүрсэн байдлыг тодорхойлдог. Уг аргыг хувь хүнд эсвэл бүлгээр ашиглах боломжтой. Цаас, эсгий бал, элсэн дээр татсан шугам, ширээн дээр ашиглах тэмдэглэлийн цаас, эсвэл компьютерын график оролцуулж болно. Энгийнээс хүнд рүү чиглэсэн хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны бүх аргуудыг төлөвлөх, боловсруулахад ашиглана.

Үйл явц

1. **Өнөөгийн байдал/агуулгаа** тоймлох, хэлэлцэх (6 дугаар бүлгийн “нөхцөл байдлын задлан шинжилгээг үзнэ үү). Босоо шугамын дээрх хэсэгт товч тодорхойлж бичих.
2. “Гол” **зорилго** эсвэл үр дүнгээ тодорхойлох. Босоо шугамын дээр бичих.
3. Зорилгодоо хүрэхэд **дэмжлэг үзүүлэх** хүчин зүйлсийн талаар эргэцүүлэх. Тухайн хүч, эсвэл түүний үзүүлэх нөлөөг урт, богино шугамаар илэрхийлэн зурах.
4. Зорилгодоо хүрэхэд **саад учруулах** хүчин зүйлсийн талаар эргэцүүлэх. Тухайн хүч, эсвэл түүний үзүүлэх нөлөөг урт, богино шугамаар илэрхийлэн зурах.
5. Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг дэмжигч хүчин зүйлсийг ихэсгэх, саад бологч хүчин зүйлсийг бууруулахаар бэлтгэнэ. Аль нэгэн дэмжигч хүчин зүйлсийг бэхжүүлэх эсвэл саад бологч хүчин зүйлийг бууруулах, сулруулахаа сонгоно.

ЖИШЭЭ:


- Ялтнуудад учрах хүний эрхийн зүй бус үйлдлийг бууруулах зорилгодоо хүрэхээр шоронд ажилладаг нэг төрийн бус байгууллагад зориулсан хүний эрхийн сургалт (дэмжлэг үзүүлэх хүчин зүйлийг ихэсгэх) болон/эсвэл ялтнуудад үзүүлэх хорих байгууллагын ажилтнуудын нөлөөг таниулах зорилготой тэдэнд зориулсан сургалт (саад учруулах хүчин зүйлийг бууруулах) байж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын талаар эх сурвалж бэлтгэх зорилгодоо хүрэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн туршлагыг ашиглах (дэмжлэг үзүүлэх хүчин зүйлийг ихэсгэх) болон/эсвэл тухай эх сурвалжаа хүртээмжтэй байхаар боловсруулах (саад учруулах хүчин зүйлийг бууруулах) байж болно.



Хүчний талбайн задлан шинжилгээг тухайн зорилгод хамаарах “өнөөгийн нөхцөл байдал”-ын хөдөлгөөнийг үнэлэх, тус хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх, саад учруулах нөлөөг тодорхойлох арга болгон ашиглаж болно. Энэ төрлийн задлан шинжилгээнд дараахь асуултыг ашиглана. Үүнд:

- Өнөөгийн нөхцөл байдал нь юу вэ?
- Өнөөгийн нөхцөл байдалд өөрчлөлт гарсан уу? Эцсийн зорилгод ойр байна уу, хол байна уу?
- Тухайн үйл ажиллагаа нь саад учруулах хүчин зүйлд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Тухайн үйл ажиллагаа нь дэмжлэг үзүүлэх хүчин зүйлд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Үнэлгээний үр дүнд ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?




Арга № 2:

Хариу үйлдлийг үнэлэх шугам

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, үнэлэх	Оролцогчдын өмнөх мэдлэгийг мэдэх, дасгал ажлын үр дүнд хэрхэн ахиц гарсныг үнэлэх арга	15 мин–1 цаг	Анхан

Хариу үйлдлийг үнэлэх шугамыг олон янзаар ашигладаг. Тодорхой нэг асуудал эсвэл сэдвийн талаар хүмүүсийн санаа бодлыг хэмжих замаар нөхцөл байдлыг шинжлэхэд мэдээлэл цуглуулж чадна. Сургалт эхлэхийн өмнө ямар түвшинд байсан, сургалтын дараа хэрхэн өөрчлөгдсөн бэ гэж үнэлж болно. Ганц удаа эсвэл тодорхой үеүдэд хийх боломжтой. Дор байрлах зурагт шугаман дээр хоёр асуулт бичсэн байна. Үүнд:



Оролцогчид өөрийгөө илэрхийлэх үг эсвэл тэмдэгтэй тэмдэглэлийн цаасаа шугам дээр байрлуулах замаар асуултад хариулсан байна. Анх долоо өдрийн сургалтын эхний өдөр хариулсан ба сургалтын үед, мөн төгсгөлд дахин хариулсан байна.



Гэрэл зургийг Жилл Крисп

Шугаман хэмжүүрийг гар дор байгаа нөөц бололцоог ашиглаж хаана ч хийж болно (элсэн дээрх шугам, хоёр модны хооронд, шал, цонх гэх мэт). Сургагч нар тухайн бүлэгт эсвэл дасгал ажилд хамаатай ямар ч асуултыг асууж болдог онцлогтой.

Арга № 3:

Гудамжны судалгаа¹⁷⁸

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, үнэлэх	Ямар нэгэн нөхцөл байдлын талаар мэдэх эсвэл задлан шинжлэх, санал бодлыг сонсох, ямар нэгэн үйлчилгээг үнэлэх арга	Багадаа 1 өдөр	Туршлагатай

Гудамжны судалгаа (эсвэл хамт олноос авах судалгаа, автобусны зогсоол дээрх судалгаа, зах дээр хийх судалгаа) нь олон төрлийн техник, эх сурвалж ашиглана. Үйл ажиллагааны онцлог, нөөц бололцоо, хүний эрхийн сургагчийн бүтээлч байдлаас хамаарч хамгийн зохистой судалгааны хэлбэрээ шийдэх жишээтэй. Шинэ Зеландын Хүний эрхийн комисс хамт олны зураглал, шугам, санал бодлоо бичих зэрэг аргыг гудамжны судалгаанд ашиглаж, хүний эрхийн гол асуудлуудаа тодорхойлсон байна. Тус аргаа хүртээмжтэй болгохын тулд “Юу шударга вэ? Юу шударга бус вэ?” гэж илэрхийлэх үгээ болгоомжтой сонгосон. Энэ аргад цаас, тэмдэглэлийн жижиг цаас, бал, хүний эрхийн мэдээлэл, эх сурвалж ашиглаж, хэд хэдэн сургагч, туслах ажилтны тусламжтай гүйцэтгэсэн байна.



Гисборны төв гудамж дахь гудамжны судалгаа. Шинэ Зеланд улс. Гэрэл зургийг Жилл Крисп

¹⁷⁸ Уг аргыг Шинэ Зеландын Хүний эрхийн комисс өөрийн үндэсний хүний эрхийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа ашигласан юм.

Арга № 4:

Шүрэн хадаар задлан шинжлэх¹⁷⁹

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, хэрэгжүүлэх	Тодорхой нэг нөхцөлд харилцан адилгүй эрх мэдлийн харилцаа, олон янзын туршлагыг ойлгох арга. Тухайн нөхцөлд бусад хүмүүс хэрхэн нөлөөлөх эсвэл ямар туршлагатай болохыг тодорхойлоход тусалдаг.	1–2 цаг	Туршлагатай


Шүрэн хадаар задлан шинжлэх арга нь хамт олны хөгжил, насанд хүрэгчдийн боловсролд түгээмэл ашигладаг сурганы арга юм. Бүлгийн хэлэлцүүлгийг өдөөхөд ашиглах ба бусад сурганы аргуудтай ашиглаж болно. Оролцогчид адил нөхцөл байдлыг ойлгох, ижил туршлагатай болохыг хичээж байгаа үед илүү үр нөлөөтэй. Ижил туршлага гэдэгт:

- Хүний эрхийн тодорхой нэг асуудалтай тулгарч байгаа хамт олон
- Ямар нэгэн үүрэг хүлээгч хүмүүсийн бүлэг, эрх мэдэлгүй гадуурхагдсан хүмүүсийн бүлэг, эсвэл хамтдаа оролцож байгаа сургалт зэргийг ойлгоно.

Асуулт:

1. Завин дээр хэн байна вэ? (Хувь хүнээс илүүтэй бүлэг хүмүүсийг бодоорой)
2. Завийг савчуулан байгаа давалгаа (асуудал) юу вэ?
3. Далайд хөвөх завийг хөмрүүлэх шахам давалгаалах давалгааг үүсгэж байгаа шүрэн хад юу вэ? (хүний эрхийн асуудалд нөлөөлж байгаа эсвэл хянаж байгаа хүчин зүйлсийг бодоорой)
4. Та өөрийгөө зургийн хаана харж байна вэ? Та бусдыг хаана харж байна вэ? Яагаад?
5. Хүмүүс яаж энэ завинд орчихов? (Колоничлол, олон улсын гэрээ, бусад улсад нэгдэх бодлого, цагаачлалын бодлого, эдийн засгийн бодлого, нийгмийн анги, төрсөн газар, жендэр, ур чадвар, бэлгийн баримжаа, насаар ялгаварлан гадуурхах зэргийг тооцоорой)
6. Энэ завь дээрх хүмүүс яаж амьд гарах вэ? Яавал амьд гарахгүй вэ?
7. Шүрэн хадаар задлан шинжлэхдээ зургийг тайлбарлах амархан байвал танд/танай байгууллагад/танай хамт олонд адилтгах боломжтой зүйл байна уу? Тодорхойлж өгнө үү.

¹⁷⁹ Олон янзат байдалд хариу үзүүлэх нь; Маурин Коллинз; 2006 он; www.muttart.org/sites/default/files/Collins_M_Responding%20to%20Diversity.pdf –аас үзнэ үү.



Арга № 5:

Олон нийтийн зураглал хийх нь¹⁸⁰

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, үнэлэх	Оролцогчид “орших газар”-таа (ажлын байр, сургууль, хамт олон, бүс нутаг, улс) юу болж байгаа тухай түүхээ хэлэх боломж олгодог арга.	Янз бүр	Анхан

Харааны мэдрэхүйд тулгуурласан (зураг, газрын зураг, гэрэл зураг гэх мэт) хамт олны зураглал нь:

- Хүмүүсийн олон янзын бүлэг нийлж, өөрсдийн хамт олон, бүс нутаг, улс оронд юу болж байгааг тодорхойлохыг дэмждэг
- Тухайн түүхийг олон хүнд тэр даруй зураглан үзүүлдэг учир маш хүчтэй гэж болно.

Зураглах нь хүмүүсийг маш сайн оролцуулж (дасгалыг гол төлөв орон нутгийн хүмүүс удирдаж, явуулдаг), бичиж тэмдэглэж авахын хамт ямар нэгэн аман харилцаанаас үүдэлтэй зааг гарвал түргэн шуурхай дүрсээр үзүүлж даван туулах боломжтой. Зураглах дасгал нь орон нутгийн эн тэргүүнд анхаарах, хүрэх зүйлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд ашиглаж болно. Төсөл хэрэгжүүлэх үедээ төслийг төлөвлөж байсан үеийн зураглал дахь өөрчлөлтийг тэмдэглэдэг. Төслийг үнэлэхдээ харьцуулах боломжтой зургуудаа ашиглаж өөрчлөлт гарсан эсэхийг нягтлах жишээтэй. Зураглалаа сургалтын үеэр, хамт олны уулзалтын дундуур, эсвэл хүмүүс цугладаг гудамж, автобусны зогсоолд хийдэг.



Шинэ Зеландын Гисборн хотын гудамж, гэрэл зургийг Жилл Крисп

¹⁸⁰ Уг аргыг Шинэ Зеландын Хүний эрхийн комисс өөрийн үндэсний хүний эрхийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа ашигласан юм.

Арга №6:

Зурган дуу хоолой¹⁸¹

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, үнэлэх	Оролцогчид “орших газар”-таа (ажлын байр, сургууль, хамт олон, бүс нутаг, улс) юу болж байгаа тухай түүхээ хэлэх боломж олгодог арга.	Янз бүр	Анхан

Зурган дуу хоолой нь хүний эрхийн талаар мэдлэгтэй хамт олныг хөгжүүлэхэд маш тохиромжтой арга юм. Оролцогчид өөрийн хамт олноо төлөөлөх, эсвэл өөрийн хүрээлэн буй орчин буюу тодорхой сэдвээр гэрэл зураг авч байгаа мэт байр суурь илэрхийлэхийг хүснэ. Хамтдаа хэлэлцэх, түүхээ өгүүлэхийн хамт зурагт юу харуулж байгааг ойлгож авна. Зурган дуу хоолой аргыг Каролин Ванг 1992 онд БНХАУ-ын Юннан мужийн хөдөөгийн тосгоны эмэгтэйчүүдийг хамруулсан төслийн үеэр олны хүртээл болгожээ. Энэхүү арга нь ямар хүчтэй тухай өгүүлэх олон жишээ бий.

Зурган дуу хоолойг ашигласан хамгийн алдартай жишээ бол 2005 онд АНУ-ын Академийн шагнал хүртсэн **“Эмсийн хүрээлэнд төрсөн нь”** кино билээ. Гэрэл зурагчин Зана Бриски Энэтхэгийн Калькута хотын улаан дэнлүүний гудамжинд амьдрах бэлгийн ажилтан, тэдний хүүхдүүдийн амьдралыг баримтжуулахын тулд хэдэн хүүхдэд камер өгч, өөрийн ертөнцөө зураглахыг хүсчээ. Хүүхдүүдийн мэдрэмжтэй, гайхалтай зургууд нь дээрх бүтээлийг төрүүлсэн ба Брискигийн үйл хэргийг үргэлжлүүлсэн **“Камертай хүүхдүүд”, “Хувь заяатай хүүхдүүд”**

(www.kids-with-cameras.org/home) санаачлага улам өрнөж, хамрагдсан олон хүүхдэд шинэ амьдралын хаалга нээсэн байна. **“Хүтонгоос өндөр байшин руу”** (<http://english.cri.cn/3100/2006/08/31/63@133236.htm>) төслөөр Бээжин хот дахь хүтонг оршин суугчид өөрийн амьдрах орчныг устгаж байгааг Зурган дуу хоолой аргаар эсэргүүцдэг. Хүтонг оршин суугчдын зарим гэр бүл хэдэн үеэрээ өөрийн байшиндаа амьдарсан ажээ. Нийтийн зориулалттай өндөр байрнуудад шилжин нүүсэн тэд өөр байшин мэдэхгүй, ямар нэгэн нийгмийн харилцаагүй амьдрах ба тэдний амьдрал улам дээшилсэн мэт бусад хүн төсөөлж байж. Тэд өөрсдийн амьдралын замнал, хүрээлэн буй орчин, устгагдаж байгаагаа ахуйгаа баримтжуулжээ.



Кино эсвэл аялан явах үзэсгэлэн нь илүү олон хүнд хүний эрхийн асуудлыг танилцуулах маш үр нөлөөтэй арга замын нэг байж болох юм. Гэхдээ ихэнх байгууллагын хувьд хэрээс хэтэрсэн нөөц шаарддаг.

Иймээс илүү уян хатан боломжийн хувьд гэрэл зургаа Flickr (www.flickr.com)-т, дүрс бичлэгээ YouTube (www.youtube.com/watch?v=3XsHJRj004)-д оруулах байдлаар цахим үзэсгэлэн байгуулж болно.


¹⁸¹ Зурган дуу хоолой аргын дэлгэрэнгүй тайлбар, хэрхэн ашиглах талаар Хамт олонд зориулсан аргачлалаас үзэх боломжтой: http://ctb.ku.edu/en/tablecontents/chapter3_section20_main.aspx.

Арга №7:

Эрэмбэлэх

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, хэрэгжүүлэх	Хүний эрхийн сургагч нарт (тохиромжтой бол оролцогчид) бүлгийн ажил дахь дасгалуудаа эрэмбэлэхэд ашиглана.	N/A	Эхлэлийн

Дасгалын мөн чанараас хамаарч, дараах төрлийн дасгалаа сонгож эсвэл бүгдийг нь ашиглаж болно.




Арга №8:

Зохион байгуулагч тойрог¹⁸²

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, хэрэгжүүлэх	Хүний эрхийн сургагч нарт (тохиромжтой бол оролцогчид) бүлгийн ажил дахь дасгалуудаа эрэмбэлэхэд ашиглана.	N/A	Дунд

Энэхүү аргаар хүний эрхийн боловсролын дасгалаа чиглүүлэхэд ашиглах алхамуудаа тоймлож болно. Сургалт, боловсрол, нөлөөлөл, хамт олны хөгжилд тохиромжтой.



¹⁸² Жо Ханн Тан, Розм Томатимасанг нарын “Зохион байгуулалтад орцгооё! Хамт олон зохион байгуулсан түүх, туршлага” номоос эшлэв. (мөн Дахин дуугарсан дуу хоолой; Азийн бүсийн хүний эрхийн боловсролын нөөцийн төв; 29 тал).


Арга №9:

Суралцахуйн давалгаа

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, үнэлэх	Хүний эрхийн сургагч нарт (тохиромжтой бол оролцогчид) оролцооны шинжтэй дасгалыг чиглүүлэхдээ ашиглана. Дасгалын үр дүнд суралцсан зүйлээ тодорхойлох, ашиглах зорилготой.	Харилцан адилгүй	Эхлэлийн

Энэ арга нь сургагч ямар нэгэн дасгалын агуулга, үйл явцыг нэгэн зэрэг үнэлэх, сургалтын арга хэмжээ болон оролцогчид амьдралдаа ашиглах санаа төрүүлэх зорилготой. Боловсролын ихэнх аргатай холбогдох ба суралцах нугалааны таван шатыг хангаагүй ч сургагч дасгалын хажуугаар гүйцэтгэж болно.

- 1. Илтгэх:** Дасгалд оролцоход хэрэгцээтэй мэдээллээ өгөх.
- 2. Хийх:** Дасгалаа чиглүүлэх.
- 3. Дүгнэх:** Дасгалд өөрийн дотор төрсөн сэтгэгдлээ оролцогчид илэрхийлэхэд дэмжлэг үзүүлэх, урамшуулах.
- 4. Тусгах:** Оролцогчид дасгалаас олж авсан, сурсан зүйлээ эргэцүүлэхэд дэмжлэг үзүүлэх, урамшуулах.
- 5. Хэрэглэх:** Оролцогчид өөрийн амьдрал/туршлага/зан үйлээ сурсан зүйлтэйгээ холбоход дэмжлэг үзүүлэх, урамшуулах.



Үйл хэрэгт суралцах давалгаа

Шат	АНДЧ-ы сургагчдын сургалт холимог сургалтын курс ¹⁸³	Нөлөөллийн төсөл	Туршлага солилцох уулзалтын дасгал “ХЭТТ-ын салхи” ¹⁸⁴
Илтгэх	Хөтөлбөр хэрхэн үйл ажиллагаа явуулах, оролцогчдоос юу шаардах талаарх тайлбар.	Бүлэг өөрт тулгарч болох хүний эрхийн хэлэлцэхээр уулзана. Тухайн асуудлын талаар зарим судалгаа хийхээр шийдвэрлэнэ.	Дасгалаа тайлбарлахдаа оролцогчдоос юу шаардлагатай байгааг мэдэгдэнэ.
Хийх	Дасгал, мэдээллээр хангана (цахим талбар, бүс нутгийн танхимын туршлага солилцох уулзалтаар дамжуулан).	Судалгаа хийсэн байна.	“ХЭТТ-ын салхи” тоглоом тоглоно.
Дүгнэх	Оролцогчдын эргэх холбооноос суралцсан өөрийн туршлагын талаар мэдэж авна (үнэлгээ/цахим чатны орчин).	Бүлэг ахиц дэвшил гарч байгааг нягтална.	Өөрийн гарт байгаа хэзрийг дасгалд ашигласан сэтгэгдлээ оролцогчид илэрхийлэх боломж олгоно.
Тусгах	Оролцогчдод өөрийн сургалтын талаар улам эргэцүүлэх хүрээ, аргачлал танилцуулна.	Бүлэг хангалттай мэдээлэл байгаа эсэхээ үнэлнэ.	Бүлгээр тоглоом тоглохдоо сурсан зүйлээ оролцогчид өнгийн хөзрөөр хуваагдан хэлэлцэнэ.
Хэрэглэх	Оролцогчид танхимын туршлага солилцох уулзалтын үеэр хийх танилцуулгаар “АНДЧ-ы Мастер сургагч” болох боломжийг таниулж, өөрийн сурснаа ажилдаа хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх буюу урамшуулна.	Бүлэг тухайн асуудалд чиглэсэн стратегия боловсруулахад ашиглахаар олж авсан мэдээллээ хэрэглэх эсэхээ шийдвэрлэнэ.	Оролцогчид өөрийн сурсан зүйлээ өөрийн улс/ажилтай хэрхэн холбогдох талаар хэлэлцэнэ.

¹⁸³ Дэлгэрэнгүй мэдээллийг www.asiapacificforum.net/support/training/training-of-trainers.

¹⁸⁴ Индонез Улсын Хүний эрхийн үндэсний комиссын Эка Кристинингсх Танлайн оруулсан юм.

Арга №10:

Чиглүүлэх техник¹⁸⁵

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, үнэлэх	Бүлэг хүмүүсийг чиглүүлэхэд ашиглах боломжтой аргачлалын жагсаалт. Янз бүрийн хүний эрхийн аргачлалд, төрөл бүрийн зорилгоор ашиглана.	Харилцан адилгүй	Бүх түвшин

Толь болох

Толь болох гэдэгт хүний хэлснийг хураангуй байдлаар давтахыг хэлнэ. Сунжрах шинжтэй хэлэлцүүлгийн хурдыг ихэсгэхэд ашиглах ба гол төлөв санаа бодлоо уралдуулахад хэрэглэдэг.

Санаа цуглуулах

Хэрэв удаан явцтай, хүмүүс хувь нэмрээ тэр бүр оруулахгүй бол, эсвэл хэтэрхий их хэлэлцүүлгийн улмаас бүлгийн идэвх суларсан бол даруй санаануудыг нь жагсаана. Энэ үе нь санаа цуглуулах болохоос тэдгээрээ хэлэлцэхгүйг анхаарна. Бүлэг анх удаа санаагаа жагсааж байгаа бол чөлөөтэй ярилцахад бага зэрэг хугацаа зарцуулаарай. Жишээлбэл, “Дараагийн дасгалаар би та бүхнээс өөрсдийн бодлоо маш бүтээлч, эсвэл нийтлэг бус байсан ч чөлөөтэй илэрхийлэхийг хүсч байна. Санаагаа илэрхийлэх болохоос шийдвэр гаргах үе биш болхыг анхаараарай. Бид жагсаалтаа гаргасны дараа хэлэлцэх болно” гэх мэт.

Орон зай бий болгох

Энэ аргачлал нь чимээгүй оролцогчдод дуугарах орон зай ямагт байгаа, чөлөөтэй сонголтоо хийж болно гэсэн ойлголт өгдөг. Чиглүүлэгч бүлэг дэх дуугүй гишүүдээ ажиглаж, тэдний биеийн хэл, царайны хувирлаас ярих хүсэлтэй байгаа эсэхийг тодруулна. Тэднийг урихдаа: “Та ямар нэгэн зүйл хэлэхийг хүсч байх шиг байна” гэж болно. Хэрэв татгалзвал хүчлэлгүй цааш үргэлжилж, бусад оролцогчдод анхаарна. Жишээлбэл, “Одоо нэг хүний бодлыг сонсьё. Абдул, танаас эхэлвэл ямар вэ?” Хэрэв оролцоо маш сул байвал хүн бүрт ярих боломж олгон, дахин тойрч болно.

Хүмүүс татаж гаргах

Хүмүүс өөрийн санаагаа тодотгох, тунгаахад дэмжлэг үзүүлэх буюу урамшуулдаг арга. Хүмүүс татаж гаргахад зориулсан маш нийтлэг аргачлал бол үг хэлсэн тухайн хүний мэдэгдлийг найруулсхийн өөрийн үгээр хэлж, нээлттэй болон чиглүүлээгүй байдлаар буюу “Танд өөр нэмэх зүйл байна уу?” гэж асууна.

Өөрийн үгээр ярих

Энэхүү сонсох чадвар нь тухайн ярьж байгаа хүмүүсийн санаа бол үнэ цэнэтэй гэсэн нөлөө үзүүлэх, баталгаажуулах боломжтой. Мөн яригч хүн өөрийн хэлсэн үгээ бусдад хэрхэн сонсогдсон талаар мэдэж чадна. Бусдын хэлснийг өөрийн үгээр ярихдаа “Таны хэлж байгаа зүйл нь ... –тай адил санагдлаа”, “Таны хэлснээс би ... гэж ойлголоо”, “Та ... гэж хэллээ” гэх мэтээр тухайн үг хэлсэн хүн ямар утга илэрхийлсэн талаар ойлгох хүртлээ лавлана.

¹⁸⁵ Оролцооны арга, аргачлал; Дэлхийн хүнсний хөтөлбөр; 2001; http://toolkit.ineesite.org/toolkit/INEEcms/uploads/1033/Participatory_Techniques_EN.pdf.

Өрөх

Олон хүн нэгэн зэрэг ярихыг хүссэн үед хүн бүр ярих боломж олгодог аргачлал юм. Мөн хүн бүр өөрийн ярих ээлжтэй болохыг ойлгуулна. Ярих цагаа булаацалдахын оронд хүмүүс анхаарлаа сарниулахгүйгээр чөлөөтэй сонсох болно.

Өрөх арга дөрвөн шаттай. Үүнд:

- Чиглүүлэгч хэн ярих хүсэлтэй байгаагаа гараа өргөж илэрхийлэхийг хүснэ.
- Гараа өргөсөн хүн бүрийг дугаарлах байдлаар ярих дараалал тогтооно.
- Хүмүүс дээрх дугаарын дагуу ярина.
- Сүүлийн хүн ярьж дууссаны дараа чиглүүлэгч дахин ярих хүсэлтэй хэн нэгэн байгааг тодруулж, тийм бол дахин нэг тойрно.

Мөрөө дагах

Олон хэлэлцүүлгийн үеэр нэгэн зэрэг маш олон санааг ярилцдаг. Учир нь ямар нэгэн асуудал маш олон зүйлийг хамарсан байдагтай холбоотой. Гэхдээ хүмүүс гол төлөв өөрийн сонирхлыг татсан зүйлд илүү их төвлөрдөг. Энэ арга нь хэлэлцэж буй сэдвийнхээ харилцан адилгүй бүрэлдэхүүнийг олж харах, бүгд адил тэгш нөлөөтэйг хүлээн зөвшөөрөхөд тусалдаг. Мөн хүмүүс өөрийнх нь санаанд бүлгийн зүгээс яагаад анхаарахгүй байна вэ гэсэн зовнил төрүүлэхээс сэргийлнэ.

Мөрөө дагах арга гурван шаттай. Үүнд:

- Чиглүүлэгч хэн нэгнээс харилцан ярианаас гарч, дүгнэх ёстойг хэлнэ.
- Чиглүүлэгч янз бүрийн харилцан яриаг нэгтгэнэ. Жишээлбэл, “Нэг яриа маань хүнс олгох тасалбарын тухай, өөр яриа хорооны талаар, мөн хүнсний хангамжийн талаар эцэст нь ярилаа” гэх мэт.
- Чиглүүлэгч тодруулах зүйл байгааг асууна. Жишээлбэл “Бид дээрх гурван зүйлийг хэлэлцсэн үү?”

Урамшуулах

Хэн нэгэнд үүрэг болголгүй хэлэлцүүлгийн өмнө нээлт хийх нь урамшуулах аргачлалын хэсэг болно. Уулзалтын үеэр хэд хэдэн хүмүүс хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохгүй байж магад. Бага зэрэг урамшуулснаар тухайн сэдвийн агуулга нь тэдэнд хамаатай болохыг мэдэж авдаг. Ялангуяа эрэгтэй, эмэгтэй холимог бүлгийг чиглүүлж байгаа үед маш чухал. Хэлэлцүүлгийн эхэн үед урамшуулах нь зэрэг нөлөөтэй. Хүмүүс улам оролцож эхэлмэгц урамшуулах шаардлагагүй болно.

Нийтлэг зүйлсээ мэдэхийн тулд сонсох

Тухайн бүлгийн гишүүд санал нийлэлгүй талуудад хуваагдсан тохиолдолд нөхцөл байдал улам хэцүү болдог. Гэхдээ ихэнх маргаанд зөвшөөрөх зүйл бий. Энэ арга нь бүлгийн санал зөрөлдсөн хэсгийг зөвшөөрч, тэд ямар нийтлэг зүйлтэйд анхаарал хандуулдаг. Нийтлэг зүйлсээ мэдэхийн тулд сонсох арга дөрвөн шаттай. Үүнд:

- Та бүлгийн ялгаатай болон ижил талуудыг нэгтгэн дүгнэх гэж байгаагаа хэлнэ. Жишээлбэл “Би та бүхнээс сонссон зүйлээ нэгтгэн дүгнэхийг зөвшөөрнө үү. Би олон ялгаатай байдлын зэрэгцээ ижил төстэй байдлыг сонслоо” гэх мэт.
- Ялгаатай байдлыг нэгтгэнэ. Жишээлбэл “Зарим бүлэг хоол хүнсээр хангах үйлчилгээг тосгоны захад байрлуулах, нөгөө хэсэг нь тосгоны төвд байрлуулахыг хүсчээ.”
- Нийтлэг хэсгийг цохон тэмдэглэнэ. Жишээлбэл “Хоёр бүлэг эрх мэдэлгүй, гадуурхагдсан гэр бүлд хоол хүнс хялбар хүргэх талаар санал нэгдэж байна гэж ойлголоо”
- Яв цав тохирсон эсэхээ нягтална. Жишээлбэл “Би зөв ярьж байна уу?” гэх мэт.

Тэнцвэржүүлэх

Хэлэлцүүлэг ихэнхдээ хэсэг хүмүүс ярьж, санаачлах байдлаар өрнөдөг. Тэнцвэржүүлэх аргачлалыг ашигласнаар чиглүүлэгч хэлэлцүүлэгт оролцож байгаа ч үзэл бодлоо илэрхийлээгүй хүмүүсийн байр суурийг сонсоход тусалдаг. Тэнцвэржүүлэх арга зарим хүн өөрийн санаагаа илэрхийлэхэд бага зэрэг туслахын хамт бүлэгт “Хүмүүс ямар байр суурьтайгаас эс хамаарч өөрийн бодлоо ярих нь хүлээн зөвшөөрөхүйц ажээ” гэсэн ойлголт төрүүлдэг онцлогтой. Доорх байдлаар лавлаж болно. Үүнд:

- За, хоёр хүн ямар байр суурьтай байгааг мэдэж авлаа. Өөр байр суурьтай хүн байна уу?
- Асуудлыг өөрөөр харах боломж байна уу?
- Үүнтэй хүн бүр санал нийлж байна уу? гэх мэт.

Зориуд дуугүй байх

Зориуд дуугүй байх нь хэдэн секунд түр завсарлах байдлаар ярьж байгаа хүнд юу хэлэхийг хүссэнээ олж авах нэмэлт цаг олгодог. Ярьж байгаа хүнд анхаарлаа хандуулсаар байх хэрэгтэй. Ямар нэгэн зүйл хэлэхгүй, толгойгоо дохиж, хөдөлгөж ч болохгүй. Тайван байдлаар анхаарлаа хандуулна. Шаардлагатай тохиолдолд бусад хүмүүст чимээгүй бай гэж гараараа дохино. Хэрэв хүмүүс эргэлзсэн, түгшсэн, анхаарал төвлөрөхгүй байвал чимээгүй болох нь тусалж магад. Жишээлбэл “Бүгдээрээ энэ бид бүхэнд ямар утгатай дотроо эргэцүүлэхээр нэг минут чимээгүй байцгаая” гэх мэт.

Санаа бодлоо уралдуулах¹⁸⁶

Санаа бодлоо уралдуулснаар чөлөөтэй сэтгэх боломж олгох ба өөрт төрсөн санаагаа хэлэлцэх тусам улам тодруулах ач тустай. Чөлөөтэй сэтгэх орчныг мэдэрснээр бүтээлч байдал нэмэгдэхийн зэрэгцээ асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай шинэ санаа гарч ирдэг. Заримдаа зөрчилдөөнийг бууруулж, оролцогчид өөр өнцгөөс харах, тухайн асуудлын талаарх өөрийн байр сууриа өөрчлөх, бүр хошигнох, нүүр хагарах боломжтой. Нөхцөл байдлаа задлан шинжлэх, асуудлаа шийдвэрлэх, шийдвэр гаргах, төлөвлөхийн өмнө олон төрлийн санааг цуглуулдаг.

¹⁸⁶ Оролцооны аргачлалын багц: Багш нарт зориулсан авлага; Никки Слокум; 2003; http://archive.unu.edu/hq/library/Collection/PDF_files/CRIS/PMT.pdf. –аас үзнэ үү.


Арга №11:

Оюуны зураглал

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	Үндсэн санаа, ойлголт, асуудлынхаа талаар эргэцүүлэхдээ ашигладаг арга	30 минутаас 1 цаг хүртэл	Эхлэлийн

Оюуны зураглал нь бодлуудаа холбож зураглахад ашигладаг аргачлал юм. Санаа, ойлголт, асуудал зэрэг хэдэн үгээ төв хэсэгт бичсэний дараа холбогдох санаа, ойлголтоо нэмнэ. Санаа бүр хоорондоо ямар нэгэн түүх өгүүлэх шижмээр холбоотой. Оюуны зураглал хийхдээ уулзалтын үеэр “ноорог” байдлаар тэмдэглэх, хананд хадсан цаасан дээр зурах, хангалттай цаг байвал илүү нарийвчлан зурах зэргээр ашиглаж болно. Оюуны зураглал хийхдээ дараах зааврыг ашиглаж болно. Үүнд:¹⁸⁷

1. Хамгийн багадаа гурван өнгөөр сэдвийнхээ зургийг төв хэсэгт зурж эхлэх.
2. Өөрийн оюуны зураглалдаа зураг, тэмдэг, нууц үг, хэмжигдэхүүн ашиглах.
3. Түлхүүр үгсээ сонгож, том болон жижиг үсэг хэвлэн ашиглах.
4. Үг/зураг бүрээ дангаар харуулж, холбогдох шугамд нь байрлуулах.
5. Төв хэсэгт байрлуулсан зургаас эхэлсэн шугам бүр холбогдох. Төвийн шугам өргөн эхэлж, цацрах байдлаар төвөөс холдох тусам нарийсах.



Хүн амын асуудлын талаарх оюутны зураглал www.learningfundamentals.com.au

6. Үг/зургийн доорх шугам нь үг эсвэл зурагтайгаа адил урттай байх.
7. Харахад ялгарч харагдах, бүлэглэхдээ олон өнгө ашиглах.
8. Өөрийн гэсэн оюуны зураглал хийх загвар боловсруулах.
9. Өөрийн оюуны зураглалдаа зарим зүйлээ цохон тэмдэглэх, холбоос тогтоох.
10. Цацрагаа нарийсгах, тоогоор эрэмбэлэх, мөчрүүдээ ерөнхийлөн тоймлох замаар зураглалаа ямагт тодорхой болгох.

¹⁸⁷ http://en.wikipedia.org/wiki/Mind_map –аас үзнэ үү.


Арга №12:

Модон диаграм

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	Асуудал, тэргүүлэх чиглэлээ ойлгох, үр дүн, стратегиа боловсруулах зэрэг олон зорилгоор ашиглах арга.	Хоёр цаг түүнээс дээш	Дунд

Мэдээллээ мод шиг загвараар зохион байгуулна. Гол асуудлаа модны гол хэсгээр илэрхийлж, холбогдох хүчин зүйлс, нөлөө, үр дүнг модны үндэс, мөчир байдлаар харуулдаг. Төсөл боловсруулж байгаа бол модон диаграммыг тогтолцоогоо боловсруулах, үнэлэх чиглэлээр ашиглаж болно.

Хувь хүн дангаар эсвэл бүлгээрээ хамтрах боломжтой. Хамт олон, орон нутгийн хүмүүсийн оролцоотой дасгалын хувьд модон диаграм нь тодорхой нэгэн асуудал үүсгээд байгаа шалтгааныг илрүүлэх, задлан шинжлэх, хийх үйл ажиллагааны зорилтоо эрэмбэлэх, хэмжихэд хүмүүст тусалдаг. Байгууллагын хувьд хүчин зүйлсийн хоорондын хамаарал, сүлжилдсэн байдлыг илэрхийлэхдээ “мод” байдлаар дүрсэлнэ. Мөн харилцан адилгүй талуудад зориулсан сургалт, туршлага солилцох уулзалтын үеэр оролцоог ханган төлөвлөхдөө ашиглах арга болгож ашиглах боломжтой.¹⁸⁸



Вейнийн Хүнсний санаачлага, логик загвар

¹⁸⁸ Оролцооны аргачлалын багц: Мэргэжилтэнд зориулсан заавар; Никки Слокум; 2003; http://archive.unu.edu/hq/library/Collection/PDF_files/CRIS/PMT.pdf –аас үзнэ үү.

Арга №13:

Театр

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Драм, жүжиглэх, дүрд орох, хувирах, кино үзэх байдлаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн асуудал, нөхцөл байдлыг танин мэдэхэд ашигладаг.	Харилцан адилгүй	Дунд–Туршлагатай

Театр бол хүний эрхийн боловсролд ашиглах маш үр нөлөөтэй арга болно. Драм, жүжиглэх, дүрд хувирах, кино үзэх нь:

- Хэлний улмаас тулгарах саадаа даван туулах
- Оролцогчид тухайн ойлголтоо улам гүнзгийрүүлэх
- Хүний эрхийн асуудал, нөхцөл байдлаа танин мэдэх, дээрх асуудалд чиглэсэн стратеги боловсруулахад ашигтай.

Хүний эрхийн боловсролд театр ашиглахад олон арга, аргачлал бий. Үүнээс зарим зүйлийг жагсааж оруулав. Үүнд:

Дүрд орох/хувирах¹⁸⁹

Хүлээн авсан дүрд тоглохдоо оролцогч өөрийн зан үйлээ өөрчлөх боломж олгодог сургалтын арга юм. Оролцогч нь урьдаас бэлдсэн тавилт бүхий онцлог шинжтэй, эсвэл байгууллагад ажилладаг дүр бүтээнэ. Дүрд орох нь аюулгүй, дэмжлэг бүхий орчинд “дотоосоо” дүрээ мэдрэх зорилготой. Уламжлалт, танхимын, нүүр тулсан сургалтад үр нөлөөгөө харуулж, нийтээр хүлээн зөвшөөрсөн төдийгүй цахим орчинд ашиглаж болно.

Сэргээн жүжиглэдэг театр¹⁹⁰

Сэргээн жүжиглэхдээ дээрэлхэх зэрэг нийгмийн асуудалд (сурагчид дээрэлхэх тухай өөрийн олж авсан туршлагадаа тулгуурлан түүх ярих, хүндэтгэл бүхий болон аюулгүй сургуулийн орчин бий болгох арга замаа тодорхойлох) анхаарах, эсвэл олон янзын туршлагаа солилцох хэлэлцүүлэг өрнүүлэхээр ашиглаж болно. Афганистан Улсад хэрэгжүүлсэн нэгэн төсөл (2010) хүчирхийллийн хохирогчдыг сургалтад хамруулж, хүний эрхийн зөрчлийн улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, эрхээ шаардах талаар нэг нэгнийхээ түүх дээр ажилласан байна.

Австрали Улсын Мельбурн хот дахь нэг төслөөр (2011) сургалтад хамрагдсан залуус дүрвэгч залуус цагдаатай, цагдаа дүрвэгч залуустай харилцаж байсан туршлагад тулгуурлан түүхээ өөрчилж үзсэн ба дээрх хоёр бүлэг нэг нэгнээ ойлгоход хувь оруулсан ажээ.

Зураглах театр¹⁹¹

Зураглах театрын үед хүмүүсийн харилцаа, сэтгэл хөдлөл, бодит харилцаа зэрэг хийсвэр ойлголтыг танин мэдэхэд “зураг байгаа” (хувь хүн, эсвэл бүлэг хүмүүсийн биеийн галбир, байрлал) зүйлс ашигладаг. Оролцогчид маш богино хугацаанд өөрийн эсвэл бусдын биеэр хандлага, сэтгэл хөдлөлөө харуулдаг. Хүнээр зурсан “зураг”-аа нийлүүлэн байрлуулж, амилуулдаг онцлогтой. Ялангуяа дотоод болон гадаад шинжтэй дарамт, ухамсарт бус бодол, мэдрэмжээ танихад байнга ашигладаг. Зураглах театр бол жүжиглэж байсан туршлагатай болон огт туршлагагүй хүмүүс хүртэл асуудал, хандлага, сэтгэл хөдлөлөө танин мэдэх уян хатан арга юм. Хэн ч үг цээжлэх, эсвэл бусдын өмнө “жүжиглэх” шаардлагагүй. Санаа, мэдрэмж, туршлагаа эсэргүүцэх биш, харин улам танин мэдэх болно.

¹⁸⁹ <http://en.wikipedia.org/wiki/Role-playing> болон http://en.wikipedia.org/wiki/Roleplay_simulation –аас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.

¹⁹⁰ http://en.wikipedia.org/wiki/Playback_Theatre –аас үзнэ үү.

¹⁹¹ <http://dramaresource.com/strategies/image-theatre> –аас үзнэ үү.

Кино фестиваль

Хүний эрх, эрхэм зэрэг, нэр төрийг хөхиүлэн дэмжих зорилготой кино фестивалийн тоо нэмэгджээ. Зарим хүний эрхийн үндэсний байгууллагууд сургалтын арга болохын хувьд хүний эрхийн кино фестиваль зохион байгуулах буюу эсхүл дэмжин ажиллаж байна.

Хүний эрхийн киноны сүлжээ¹⁹² нь фестивалиудын үйл ажиллагааг дэмжиж, шинэ талбар бий болгох, хамтарсан төсөл хэрэгжүүлдэг. Мөн дэлхий дахинд болж байгаа фестивалиудад хүний эрхийн сэдэвтэй кино түгээдэг гэж болно. Үүний зэрэгцээ шинэ фестиваль байгуулахад тусалдаг ба хүний эрхийн кино, энэ төрлийн бүтээл туурвигчдад ээлтэй, дэмжсэн олон улсын орчин бүрдүүлдэг.

Сесил Гуидоте Альварезын 1967 онд байгуулсан **Филиппинийн сурганы театрын холбоо** нь хувь хүний хувьд хөгжих, нийгмээ хувирган өөрчлөх хүмүүсийн соёлд тэмүүлж урлагт чин сэтгэлээ зориулсан бүтээлч, шүүмжлэлт зураач багш, соёлын ажилтнуудаас бүрдсэн байгууллага ажээ. Нийгмээ өөрчлөх, хөгжүүлэхээр театр арга сонгож, өөрийн гэсэн Филиппин хэв шинжтэй болсон ба уг байгууллагын тулгуур үндэс болжээ. Уг байгууллагын хувьд өөрийн дотор болон эргэн тойронд гарсан өөрчлөлттэй зэрэгцэн өсч хөгжиж ирсэн түүхтэй. Мөн сайн чанартай театр хийхээр зорихдоо урлагийн хэлбэрт баригдалгүй, илүү холын зорилгоор ашигладаг. Тодруулбал алсын хараагаа “Ард түмэн болон нийгмээ эрх мэдэлжүүлэх, хүчирхэгжүүлэхэд чиглэсэн гайхалтай театрын гоо зүй, сурганы арга зүй” гэж тодорхойлжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг <http://petatheater.com/about-peta> –аас үзнэ үү.



¹⁹² www.humanrightsfilmnetwork.org –аас үзнэ үү.

Арга №14:


Дүрслэх урлаг

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх, үнэлэх	Асуудал, нөхцөл байдлаа танин мэдэхэд зураг зурах, баримал хийх, хэвлэх, гэрэл зураг авах, гараар урлах болон бусад харааны хэрэгсэл ашигладаг.	Харилцан адилгүй	Бүх түвшин

Визуал урлаг/ хэвлэл мэдээллийн хэрэгслийг хүний эрхийн боловсролын хэрэглэгдэхүүн болгон ашиглах олон арга зам бий. Зарим жишээг дор оруулав.



Шинэ Зеландын Хүний эрхийн комиссоос 2006 онд зохион байгуулсан өөдсөн урлалын тэмцээний үеэр. Зургийг Жилл Крисп.



First-prized artwork in 6-9 age category, "My Little Brother Will have the Same Rights" by 6-year-old O. Myagmarsuren (Mongolia)

Австралийн Хүний эрхийн комиссын 2008 оны Нийгмийн шударга ёсны тайлангийн хавтас. Гэрэл зурагчин Пьер Пауликин хүчээр нүүлгэж байсан түүх, түүний үр нөлөөг санан дурсдаг 2008 оны 5 дугаар сарын 25-ны өдөр буюу Үндэсний уучлал гуйх өдөр авчээ.



Азийн бүсийн хүний эрхийн боловсролын эх сурвалжийн төвөөс 1998 онд зохион байгуулсан уралдаан. Фокусаа буулгасан нь, 1999 оны 3 дугаар сарын 15 дахь дугаар. Huriights Osaka www.huriights.or.jp/archives/focus/section2/1999/03/from-the-eyes-of-the-child.html –аас үзнэ үү.

Арга №15:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын тухай жишиг уулзалт¹⁹³

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Харилцан идэвхтэй байдлаар Хүний эрхийн түгээмэл тунхаглалын талаар таньж мэдүүлэх жишиг болгох туршлага солилцох уулзалт.	2 цаг	Эхлэлийн

Энэ бол Хүний эрхийн түгээмэл тунхаглалын (ХЭТТ) талаарх сургалтаа харилцан идэвхтэй байдлаар чиглүүлдэг жишиг болгох туршлага солилцох уулзалт юм.

1-р алхам: Хүний эрхийн тодорхойлолт, зарчмууд

1. Чиглүүлэгч оролцогчдод өөрийгөө танилцуулж, дасгал ажлын зорилго, зорилтоо тайлбарлана.
2. Чиглүүлэгч оролцогчдоос өөрийгөө танилцуулах, нэр, ажил, тус дасгал ажлаас юу хүлээж байгааг тодруулахын хамт хүний эрх гэж юу бодож байгааг лавлана. Оролцогчид өөрийн бодлоо самбарын цаасан дээр бичнэ.
3. Чиглүүлэгч хүний эрхийн тухай оролцогчдын ойлголтыг уншиж өгнө.
4. Power Point ашиглан, чиглүүлэгч хүний эрхийн ерөнхий ойлголт, ХЭТТ, хүний эрхийн зарчмуудыг танилцуулна.
5. Чиглүүлэгч нэг оролцогчийг ХЭТТ-ын оршил хэсгийг уншиж, ямар зорилготой баримт бичиг болохыг лавлана.

2-р алхам: ХЭТТ-д заасан хүний эрх

1. Сандлаа тойрог хэлбэрээр байрлуулна. Нийт сандлын тоо нь оролцогчдын тооноос нэгээр дутуу байна.
2. Чиглүүлэгч оролцогч бүрт нэг хүний эрхийн хөзөр өгнө. Хөзөр бүр нэг хүний эрх агуулна.
3. Чиглүүлэгч **"ХЭТТ-ын салхи"** тоглоомын дүрэм тайлбарлана.
 - Оролцогчид тойруулж тавьсан сандлуудаа тойрон зогсохыг хүснэ.
 - Хөгжим тоглуулах ба зогсмогц оролцогчид сандалд суух ёстой. Сууж чадаагүй оролцогч тоглоомын зааварлагч болно. Оролцогчид суусны дараа өөрийн зүүн болон баруун гар талд суусан хүмүүсийн эрхийг асууж, тогтоох ёстой.
 - Зааварлагч оролцогчдод гурван чиглэл хэлнэ.

"ХЭТТ-ын салхи баруун зүг үлээлээ!": Оролцогч бүр баруун гар талд сууж байгаа оролцогчийн хөзрөн дээрх хүний эрхийг хэлэх ёстой.

"ХЭТТ-ын салхи зүүн зүг үлээлээ!": Оролцогч бүр зүүн гар талд сууж байгаа оролцогчийн хөзрөн дээрх хүний эрхийг хэлэх ёстой.

"Шуурга дэгдлээ!": Зааварлагчийн хамт бүх оролцогчид босч шинэ сандал дээр суух ёстой. Өмнөх сандалдаа үлдэж болохгүй.
 - Сандал дээр сууж чадаагүй хүн шинэ зааварлагч болно. Гурван зааварлагч гарах хүртэл тоглоомоо дүрмийн дагуу давтана.

¹⁹³ Индонез Улсын Хүний эрхийн үндэсний комиссын Эка Кристинингсх Танлаин оруулсан юм.

4. Тоглоом дууссаны дараа оролцогчид суудалдаа эргэн сууж, чиглүүлэгч оролцогч бүр өөрийн хөзрөн дээрх хүний эрхээ хэлэхийг хүснэ.
5. Power Point танилцуулга ашиглан, ХЭТТ дахь бүх хүний эрхийг тайлбарлана.

3-р алхам: Эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон иргэний, улс төрийн эрх гэсэн хүний эрхийн үндсэн хоёр бүлэг

1. Чиглүүлэгч эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон иргэний, улс төрийн эрх гэсэн хүний эрхийн үндсэн хоёр бүлгээ тайлбарлана.
2. Оролцогчдоо хэд хэдэн бүлэгт хуваана. Бүлгүүдэд ХЭТТ-ын зүйлүүдийг тараана. Бүлэг бүрт харилцан адилгүй өнгөтэй (цэнхэр, ногоон гэх мэт) хоёр хөзөр өгнө. Бүлгүүд ХЭТТ-ын зүйлээ судалж, аль нь эдийн засаг, нийгэм, соёлын эрх, аль нь иргэний, улс төрийн эрх болох шийдвэр гаргана.
3. Бүлэг бүр үр дүнгээ танилцуулна.

4-р алхам: Нэгтгэн дүгнэх

1. Чиглүүлэгч туршлага солилцох уулзалтаа нэгтгэн дүгнэж, хэлэлцүүлэг өрнөвөл чиглүүлнэ.
2. Туршлага солилцох уулзалтаа үнэлэхдээ оролцогчдын анхны хүлээлтэд хүрсэн эсэхийг тодруулна.
3. Чиглүүлэгч арга хэмжээг хаана.

Арга №16:

Туршлага солилцох уулзалтын тойм:

Хүний эрхийн талаарх танилцуулга

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Харилцан идэвхтэй байдлаар дотоодын болон олон улсын хүний эрхийн талаар танилцуулдаг туршлага солилцох уулзалт.	2 цаг	Эхлэлийн

Зорилт

Туршлага солилцох уулзалтын эцэст оролцогчид:

- Хүний эрх, олон улсын хүний эрхийн хүрээтэй танилцсан
- Дотоодын хүний эрхийн эрхтэй зүйтэй танилцсан
- Өөрийн ажил/асуудалдаа хүний эрх ашиглах боломжтой болсон
- ХЭҮБ, түүний үүрэг, хариуцлага, үйлчилгээний талаар мэдсэн
- ХЭҮБ-ын гомдол шийдвэрлэх явцтай танилцсан байна.

Хугацаа

Хоёр цаг зарцуулах ч багасгаж, сунгаж болно.

Оролцогч

Хүний эрх, дотоодын хүний эрхийн хууль тогтоомж, ХЭҮБ-ын талаар бүрэн ойлголтгүй хүмүүст зориулсан юм.

Цагийн хуваарь	
00.00	Нээлт
00.10	<i>Аргачлалын багц дасгал:</i> Хүн бүр тус уулзалтын үеэр хувь нэмэр оруулж чадах нэг зүйл, мөн уулзалтаас олж авах нэг зүйлээ бичнэ. Бүлэгтээ үүнийг хуваалцана.
00.15	Туршлага солилцох уулзалтаа танилцуулна.
00.20	Хүний эрхийн тухай <i>санаа бодлоо уралдуулах дасгал</i>
00.30	<i>Зураглах дасгал:</i> Оролцогчид өөрийн төрсөн газар, бүс нутаг, ажлын газраа зурна. Ногоон, цэнхэр өнгөтэй тэмдэглэлийн цаас (наалддаг) ашиглаж, хамгийн мундаг гэсэн гурван зүйлээ, мөн шударга бус гэсэн гурван зүйлээ тодорхойлж бичнэ. Бүлэгтээ танилцуулна.
01.00	Хүний эрхийн хүрээний талаарх Power Point танилцуулга
01.20	Зураглах дасгалын үеэр гаргаж ирсэн асуудлуудаа хүний эрхийн хүрээтэй холбоно.
01.30	Тусгайлан сонгосон дотоодын болон олон улсын хүний эрхийн асуудалтай холбоотой тохиолдол шинжлэхээр тараана. Сонины хайчилбар, оролцогчийн туршлага, нөхцөл байдлын тухай мэдээлэл ашиглаж болно. Бүлэг бүлгээрээ хүний эрхийн асуудлаа хэлэлцэж, нийт оролцогчдын өмнө танилцуулна.
01.50	Үнэлгээ
02.00	Хаалт

Арга №17:

Туршлага солилцох уулзалтын тойм:

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх танилцуулга

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай танилцуулах туршлага солилцох уулзалтын тойм.	2 цаг	Эхлэлийн

Зорилт

Туршлага солилцох уулзалтын эцэст оролцогчид:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхтэй танилцсан
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход тулгарч буй ялгаварлан гадуурхалт, саад бэрхшээлийг тодорхойлсон
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцтой танилцсан
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нүүр тулж, мэдэрсэн ялгаварлан гадуурхалтыг бууруулах бодит арга замуудыг тооцсон
- ХЭҮБ-ын гомдол шийдвэрлэх явцтай танилцсан байна.

Хугацаа

Уулзалтаа оролцогчоос хамаарч зохион байгуулна. Зарим хүмүүст илүү их танилцах цаг зарцуулж, таатай орчин, соёлын хувьд ээлтэй нөхцөл бүрдүүлэх шаардлага тулгардаг. Зарим хүмүүс уулзалтын төгсгөлд өөрийн тодорхой нэг асуудлаа хэлэлцэх, ямар арга хэмжээ авахаар төлөвлөх тухай ярилцахад илүү их зарцуулж болно. Чиглүүлэгч хүн бүр идэвхтэй оролцох таатай орчныг бүрдүүлж, уулзалтын бүтэц, цагаа тооцвол зохино. Уулзалтаа 2–4 цагийн хугацаанд товлон боломжтой.

Оролцогч

Уулзалтаар Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц танилцуулна. Уулзалтын сэдэв нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх юм. Хөгжлийн бэрхшээлтэй болон бэрхшээлгүй бүх хүмүүст тохиромжтой. Жишээлбэл, үйлчилгээ үзүүлэгч нар, ажлын алба, тамгын газрын ажилтнууд Конвенцын талаар мэдэхийн зэрэгцээ өөрийн байгууллагын үйл хэрэг хэрхэн холбогдож байгааг мэдэх боломжтой.

Хандлага

Уулзалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдээллийг хүртээмжтэй, ойлгоход хялбар байдлаар түгээж эрх мэдэлжүүлэх зорилготой. Эдгээр эрхийн талаар илэрхий, энгийн үгсээр мэдээлэл өгч, юу хийхээ төлөвлөнө. Хийх зүйлийн тухайд тус уулзалтын дараа хэн нэгэнтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар ярилцах, эсвэл байгууллагын бодлогоо хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст улам ээлтэй болгох ажил байж болно. Том, жижиг ялгалгүй бүгд үр нөлөөтэй.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц амьдралын бүх хэсгийг хамардаг. Уулзалтын хурдаа оролцогчдын сонирхол, анхаарч буй зүйлтэй уялдуулна. Зарим хүн эсвэл бүлэг тэдэнд маш чухал гэж тооцсон дээрх эрхэд шууд төвлөрч эхэлдэг. Хугацаагаа тэдний өдөр тутмын амьдралд холбоотой асуудлаа хэлэлцэхэд хангалттай байдлаар товлон.

Арга №18:

Туршлага солилцох уулзалтын тойм:

Бэлгийн болон арьс үндсээр дарамтлах

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Бэлгийн болон арьс үндсээр дарамтлах талаар таниулдаг туршлага солилцох уулзалтын тойм.	2 цаг	Эхлэлийн

Зорилт

Туршлага солилцох уулзалтын эцэст оролцогчид:

- Ажлын байран дээрх бэлгийн болон арьс үндсийн талаар ярилцах хэл, дүр зураг, харилцаанд хандах өөрийгөө хандлагаа тодорхойлсон
- Хамт олны хүлээлтээс ялгардаг ямар нэгэн байгууллага дахь хамтын шинжтэй тогтсон хандлагаа эргэцүүлсэн
- Бэлгийн болон арьс үндсээр дарамтлах
- Бэлгийн болон арьс үндсээр дарамтлах тухай эрх зүйн асуудлууд, үйл явцтай танилцаж, эрх мэдлийн тэнцвэргүй байдлын талаар хэлэлцэж, асуудлаа задлан шинжилсэн
- Бэлгийн болон арьс үндсээр дарамталсан тохиолдол шинжилж, асуудлаа тодорхойлж, гаргах шийдвэрээ хэлэлцсэн
- Бэлгийн болон арьс үндсээр дарамтлахаас урьдчилан сэргийлэх, анхаарал хандуулах шилдэг туршлагатай хандлага тодорхойлсон байна.

Хугацаа

Уулзалтаа хоёр цагийн дотор дуусгах боломжтой. Гэхдээ чиглүүлэгч нэн даруй анхаарал хандуулахуйц асуудал илэрхийлсэн оролцогчидтой ганцаарчлан уулзах хангалттай цагаа тооцон сунгаж болно.

Оролцогч

Насанд хүрэгчдэд боловсрол олгож байгаа газар зэрэг төрөл бүрийн байгууллагын ажлын байранд хийнэ. Нууц хадгалах талаар эн тэргүүнд анхаарна. Уулзалтын үеэр дараах зүйлд санах хэрэгтэй. Үүнд:

- Ажлын байрны аюулгүй байдлын үнэлгээг сургалтын өмнө хийх ба зарим оролцогч бусдад мэдэгдэхгүй нууцаар бөглөхийг хүсч болно.
- Оролцогчид уулзалтын үеэр туулсан хувийн туршлагаа тэр бүр ярих шаардлагагүй.
- Чиглүүлэгч хэн нэгэн оролцогч хямарсан үед тайвшрах, нууцаа хадгалах тусдаа өрөөг бэлтгэсэн байна.

Хандлага

Уулзалт хурдан, харилцан идэвхтэй болно. Ажлын байран дахь бэлгийн болон арьс үндсээр хандах хандлага, дүр зураг, харилцааны тухай хувийн хандлагаа зарим талаар тусгах шаардлагатай тулгарна. Санал бодлоо уралдуулах/зан үйл, зураг, хэлийн тухай "хоёр хүний" дасгал хийж, бэлгийн дарамт, арьс үндсээр дарамтлах явдал байнга хянаж, хүндэтгэлтэй харьцах ёстой талаар мэдэж авна. Уулзалтаар аюулгүй ажлын байрт хэрэгтэй ил тод, зохистой бүтэц, үйл явцын тухай хувь хүний болон хамтын шинжтэй ойлголттой болсон байна.

Арга №19:

Туршлага солилцох уулзалтын тойм:

Дээрэлхэх, дарамтлах

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Дээрэлхэх, дарамтлах тухай туршлага солилцох уулзалтын тойм.	2 цаг	Эхлэлийн

Зорилт

Туршлага солилцох уулзалтын эцэст оролцогчид:

- Дээрэлхэх, дарамтлах үйлдэлтэй танилцсан
- Дээрэлхсэн, дээрэлхүүлсэн хүний хувиас дээрэлхэх, дарамтлах үйлдлийн нөлөөг тодорхойлсон
- Дээрэлхэх, дарамтлах үйлдэлтэй холбоотой эрх зүйн асуудал, үйл явцтай танилцсан
- Ажлын байран дахь дээрэлхэх үйлдлийн шинж тэмдэг тодорхойлсон
- Ажлын байран дахь дээрэлхэх, дарамтлах үйлдлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх талаар анхаарсан байна.

Хугацаа

Уулзалтаа хоёр цагийн дотор дуусгах боломжтой. Гэхдээ чиглүүлэгч нэн даруй анхаарал хандуулахуйц асуудал илэрхийлсэн оролцогчидтой ганцаарчлан уулзах хангалттай цагаа тооцон сунгаж болно.

Оролцогч

Уулзалтаа байгууллагын ажлын байранд хийнэ. Нууц хадгалах талаар эн тэргүүнд анхаарна. Уулзалтын үеэр дараах зүйлд санах хэрэгтэй. Үүнд:

- Ажлын байрны аюулгүй байдлын үнэлгээг сургалтын өмнө хийх ба зарим оролцогч бусдад мэдэгдэхгүй нууцаар бөглөхийг хүсч болно.
- Оролцогчид уулзалтын үеэр туулсан хувийн туршлагаа тэр бүр ярих шаардлагагүй.

Чиглүүлэгч хэн нэгэн оролцогч хямарсан үед тайвшрах, нууцаа хадгалах тусдаа өрөөг бэлтгэсэн байна.

Хандлага

Уулзалт хурдан, харилцан идэвхтэй болно. Оролцогчид ажлын байран дахь дээрэлхэх, дарамтлахтай холбоотой асуудлыг тодорхойлж, ач холбогдол өгнө. Оролцогчид өөрийн ажлын байрны аюулгүй байдлаа үнэлж, дээрэлхэх асуудлыг шийдвэрлэх хувь хүний болон хамтын шийдлээ тодорхойлсон байна.

Арга №20:

Тэгш эрх: хөзрийн тоглоом¹⁹⁴

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Нийгэмд оршин буй тэгш буй байдлыг үлгэрлэн харуулах туршлагад тулгуурласан дасгал.	1–4 цаг	Туршлагатай

Энэ арга нь хамт олныг хөгжүүлэх сургалт, боловсролын үйл ажиллагаанд ашиглах ба арав болон түүнээс дээш оролцогчид байх ёстой.

Шаардах цаг

Хөтөлбөрт заасны дагуу оролцогчид, зорилтоос хамаарч дасгал ажлын хугацааг 20 минутаас хэдэн цагаар тооцож болно.

Хэрэглэгдэхүүн

Танд хөзөр хэрэгтэй. Тавиас олон оролцогч байвал дахин нэг багц хөзөр шаардлагатай.

Зорилт

Нийгэмд оршин буй тэгш бус байдлыг мэдрүүлэх зорилготой тоглоом бөгөөд оролцогчид нийгмийн тэгш буй байдлыг илэрхийлсэн статус бүхий дүр авч, хоорондоо харилцана. Ялгаварлан гадуурхалт, тэгш бус байдлын асуудлын талаар ажиллаж байхад тохиромжтой.

Илтгэх

Оролцогч бүрт хөзөр өгч дөрвөн хүн бүхий бүлэг үүсгэнэ. Өнгө нь хүмүүс ямар бүлэгт орохыг илтгэнэ. Бундан, дөрвөлжин, цэцэг, гилбэр гэсэн бүлэг байх ёстой. Хөзөр бүр өөрийн гэсэн оноотой:

- Хөзрийн хүн аль ч өнгө болох боломжтой, 50 оноо авна.
- Тамга = 25 оноо
- Ноён = 13 оноо
- Хатан = 12 оноо
- Боол = 11
- Бусад хөзөр өөрийн тоогоор оноо авна 10 бол 10, 3 бол 3 гэх мэт.

1. Бүлэг дэх оролцогчдын тоог гаргана.

2. Оролцогчдын тоогоор хөзөр сонгоно. Таны сонгох хөзөр олон өнгийн, төрөл бүрийн оноотой байхаар тооцно. Мөн зарим хөзөр бүлэг үүсгэх, зарим нь боломжгүй байдлаар сонгоно. Жишээлбэл, бундантай гурван хөзөр оролцогчдод өгвөл дөрвөн хүнтэй бүлэг бүрдэхгүй гэсэн үг. Хөзрийн хүнийг заавал оруулна. Учир нь хамгийн өндөр оноотой төдийгүй дурын өнгөө сонгох боломжтой.

¹⁹⁴ Жилл Крисп. “Тоглоом” гэж “бодит амьдрал”-ыг зүйрлэн дүрсэлсэн болно. Оролцогчид бусдын эсвэл өөрийнхөө амьдралаа эргэн санах, илэрхийлэх хэцүү боловч таатай орчин бүрдүүлэхэд чиглүүлэгчээс ур чадвар шаарддаг.

3. Оролцогч бүрт хөзөр тараана. Хөзрөө харуулахгүй байхыг хүснэ.

Өөрийн амьдралдаа тэгш бус байдлыг аль хэдийнэ туулсан оролцогчид “өөрийнхөө” өмнөөс дүр бүтээх хөзөр өгөхгүй байхад анхаарна. Тодруулбал ялгаварлан гадуурхалтад өртөж байсан, эмзэг байдалд амьдардаг оролцогчдод бага оноотой хөзөр өгч болохгүй.



4. Оролцогч бүр хөзөр авсан хойно дүрмээ танилцуулна. Хожихын сэдэл төрүүлэхийн тулд ямар нэгэн зүйл хамаарна.

- Оролцогчид заасан хугацаанд (арван минут, нэг цаг гэх мэт) дөрвөн бүлгүүд байгуулах ёстой.
- Бүлэг бүр адилхан өнгөтэй, хамгийн өндөр байвал хожих ёстой.
- Оролцогчид хөзрөө харуулах эсэхээ шийднэ.
- Цаг дуусмагц бүлгүүд гараа барилцах, эсвэл зэрэгцэж зогсоох зэргээр бусад бүлгээс ялгарах ёстой.

Хийх

5. “Тоглоом эхэллээ” гэж зарлах. Цагаа сайн хянах. Хоёр минут дутуу байна, нэг минут дутуу байна гэж зарлаж, сүүлийн арван секундыг шууд тоолно. **Тэмдэглэл:** Зарим бүлэг маш хурдан бүрдэх тул завсарлах үе бий. Энэ тохиолдолд тоглоомоо дуусгах гэж яарах хэрэггүй. Оролцогчид бүлгээ задлах, өөр хэлбэр бүрдүүлэхээр оролдож болно. Юу ч болж болзошгүй!
6. Та юу болж байгааг ажиглана. Шаардлагатай бол тэмдэглэл хөтөлж болох ч тоглоомын эрч, хэмнэлд анхаарч хэн ч хүнд байдалд ороогүй байхад анхаарна. Та ажиглагч сонгож болно.
7. Цаг дуусмагц нэг ч оролцогч ганцаар зогсох ёсгүй.
8. Бүлгүүдийн оноог тоолно.

Дүгнэх

Бүлгээрээ юу болсон талаар ярилцаж, инээх, туних цаг гаргана. Оролцогчид өөрийн мэдрэмжээ хуваалцах нь чухал. Оролцогчид хөзрөө буцаан өгч “Би одоо хөзөр биш” гэж чангаар хэлнэ.

Тусгах

Оролцогчид дасгал ажлаас юу олж авсан, ямар зүйл сурсан, задлан шинжилсэн талаар хэлэлцүүлгээ чиглүүлэх. Тоглоомын үеэр юу болсон тухай эргэн ярихгүй байхад анхаарна. Жишээлбэл, хэлэлцүүлгээр:

- Юу болсон
- Өөрийн дүрээ юу гэж бодсон, түүндээ тулгуурлан юу хийсэн
- Тухайн дүрүүд “бодит ертөнц” дээр хэрхэн туссан
- “Бодит ертөнц” дээр хэн Хөзрийн хүн/Хоёр тамга/өндөр оноотой хөзөр вэ?

Хэрэглэх

“Тэгээд юу гэж?” Энэ нь ажиллаж, сурч, тоглож байгаа оролцогчдын амьдралд ямар утгатай вэ?

Арга №21:

Дэлхийн кафе¹⁹⁵

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх, үнэлэх	Харилцан яриа өрнүүлэх, мэдлэг, санаагаа хуваалцах оролцооны дасгал.	1–2 цаг	Дунд

Дэлхийн кафе бол харилцаа бүхий үйлдэл хийх боломжтой амьд сүлжээ бий болгохоор хамтдаа харилцан ярилцах, мэдлэг, санаагаа хуваалцах бүтээлч үйл явц юм. Ингэхдээ кафены уур амьсгал бүрдүүлж, тодорхой нэг асуулт эсвэл асуудлын дагуу оролцогчид кафены ширээний ард ярилцдаг. Оролцогчид заасан давтамжит хугацаанд багтаж шинэ ширээ рүү шилжинэ. Нэг ширээнд тайлбарлагч үлдэж, шинээр ирсэн ширээний зочдод өмнөх яриагаа дүгнэж хэлнэ. Ийм байдлаар оролцогчдын ярьсан ярианаас төрсөн санаагаа улам баяжуулна. Эцэст нь нэгдсэн хэлэлцүүлгээр гол санаануудаа дүгнэж, цаашид хийх боломжит үйл ажиллагаагаа хэлэлцэнэ.

Зорилго

Дэлхийн кафе арга нь:

- Том бүлгээр (12 хүнээс дээш) хоорондоо харилцан ярилцах
- Оруулах хувь нэмрээ тооцох, мэдлэгээ түгээх, шинийг сэдэж эргэцүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэх ажлаа тодорхойлох
- Бодит амьдрал дээрх асуудлыг тодорхойлох, боломжоо хэлэлцэх
- Хүмүүс анх удаа уулзсан, эсвэл урьд холбоотой байсан эсэхээс үл хамаарч хүмүүс бодит явдал дээр тулгуурлан ярилцах
- Стратегийн тулгуур асуудал, эсвэл боломжоо илүү гүнзгий судлах
- Тухайн бүлгийн хүмүүс харилцаагаа гүнзгийрүүлэх, гарах үр дүнгээ хамтдаа өөриймшүүлэх
- Чиглүүлэгч болон оролцогчдын дунд утга учиртай харилцаа тогтооход тустай.

Хандлага

Оролцогчид жижиг бүлгээр буюу “ширээгээр” ямар нэгэн асуудлыг танин мэдэхийн тулд нэгэн зэрэг удаа дараалан 20–30 минутын хугацаатай ямар нэгэн асуудлаа хэлэлцэх, зураглах болно. Оролцогчид өөр ширээн дээр гарсан санаануудаа “улам боловсруулах” –аар ярилцлага бүрийн эцэст ширээгээ солино. Уг арга хэмжээ нь нэгдсэн хурлаа чиглүүлэн үндсэн санаагаа цуглуулж, дүгнэлт хийснээр төгсөнө.

¹⁹⁵ Ихэнх мэдээллийг тус эх сурвалжаас авав: Дэлхийн кафе: Тулгамдсан асуудлын талаар яриа өрнүүлэх эх сурвалжийн удирдамж; Хуанита Браун; 2002; Оролцооны аргуудын багц: Мэргэжилтэнд зориулсан зааварчилгаа; Никки Слокум; 2003; http://archive.unu.edu/hq/library/Collection/PDF_files/CRIS/PMT.pdf –аас үзнэ үү.

Арга №22:

Галт бөмбөг тоглоом¹⁹⁶

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх	Өмнө хэлэлцсэн асуудлаа давтах дасгал.	10–20 минут	Эхлэлийн

Энэ арга бол ямар нэгэн сэдвээ үнэлэн дүгнэхэд ашигладаг. Чиглүүлэгч оролцогчдыг тойруулан зогсоож, тоглоомын дүрмийг тайлбарлана. Чиглүүлэгч “халуун бөмбөг” –өө нэг оролцогчид өгнө. Бөмбөг нь олон жижиг цаасаар хийсэн байна. Цас бүрт асуулт бичсэн байна. Хөгжмийн аяны дагуу оролцогчид бөмбөг дамжуулна. Хөгжим зогсоход бөмбөг барьж байгаа оролцогч нэг ширхэг цаас задлан авч, асуултад хариулна. Бүх асуултад хариулах хүртэл тоглоом үргэлжилнэ.

¹⁹⁶ Индонез Улсын Хүний эрхийн комиссын Эка Кристинингс оруулсан болно.

Арга №23:

Үйл ажиллагааны тэмдэглэлийн дэвтэр¹⁹⁷

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Хэрэгжүүлэх, үнэлэх	Урт хугацааны хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа, эсвэл төслийн үеэр тохиолдсон тэмдэглэхүйц үйл явдал, арга хэмжээг тэмдэглэх арга.	Үргэлжилнэ	Эхлэлийн

Төслийн тэмдэглэлийн дэвтэр бол төслийг хэрэгжүүлэх хугацаанд тохиосон чухал үйл ажиллагаа, арга хэмжээ, үйл явцын талаар бичгээр тэмдэглэдэг. Төсөл хэрэгжүүлж байгаа ажилтан төсөл төлөвлөх, хэрэгжүүлэхдээ өөрсдийн санаа бодол, туршлагаа баримтжуулах ба ирээдүйд гүйцэтгэх төслөө улам сайжруулахад дээрх санаа чухал тул цуглуулах, тусгах зорилготой. Тэмдэглэлийн дэвтэр төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох тухайн цаг үеийнхээ хэрэгцээтэй мэдээлэл, тусгал агуулж болно. Жишээлбэл, зарцуулах хугацаа, төсөв зэрэг нарийвчилсан мэлээлэл бүхий заавар байдлаар ирээдүйд гүйцэтгэх төслөө боловсруулахад ашиглахдаа тэмдэглэлийн дэвтэр ашиглана. Мөн төсөл хэрэгжүүлэх, завсарлах, зогсоох өчүүхэн жижиг зүйлс тодорхойлоход маш үнэ цэнэтэй. Төслийн төлөвлөгөөнд заагаагүй ч зайлшгүй анхаарвал зохих хамтрагчидтайгаа эрт уулзах зэрэг жижиг хүчин зүйлс багтана. Иймээс төслийн тэмдэглэлийн дэвтэр нь бүрэн бус, эмх цэгцгүй дурсамж эсвэл онигоо мэт нотлох баримтаас илүүтэйгээр төсөл хэрэгжүүлснээ үнэлэхэд тусалдаг мэдээлэл цуглуулдаг онцлогтой. Тогтмол хийдэг уулзалтын үеэр тэмдэглэлээ хөтлөх нь төслийн баг, бусад холбогдох талууд юун дээр сайн ажиллаж байгаа, юуг сайжруулах шаардлагатай, төслөө сайжруулахын тулд юу хийх ёстойг харуулж болно.

Тэмдэглэлийн дэвтрээ уламжлалт байдлаар “бичихийн” хамт цахим файл хэлбэрээр шинэчлэх боломжтой. Та хүмүүс сонгож төслөөс харсан ажиглалтаа тэмдэглэлийн дэвтэрт тэмдэглэх, өөрчлөлт хийхийг хүснэ. Сонгох шалгууртаа хүн ам зүй, мэдлэг, үнэт зүйлс зэргийг харгалзаж сонгох боломжтой төдийгүй харилцан адилгүй туршлагатай төлөөлөл оролцуулж болно.


¹⁹⁷ Хамт олныг тогтвортой оролцуулах үнэлгээний барцаас авав: http://evaluationtoolbox.net.au/index.php?option=com_content&view=article&id=34:project-diary&catid=19:formative-evaluation-tools&Itemid=141.

Арга №24:

Үнэлгээний дартс¹⁹⁸

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Үнэлэх	Дасгалаа үнэлэх оролцооны арга.	20–30 минут	Эхлэлийн

Үнэлгээний дартс нь сургалт, туршлага солилцох уулзалт, түүнтэй адил төстэй үйл ажиллагаа ямар болсон талаарх үнэлгээг оролцогчдоос хурдан хугацаанд, хялбар авдаг. Цавуутай цаасан цэг, зүүтэй тэмдэг зэргийг ашиглан “сэтгэл хангалуун”, “сэтгэл дундуур”, “санаснаас илүү”, “үр дүнгүй” гэх мэтчилэн оролцогчид самбар дээр үнэлдэг. Дартс нь ямар нэгэн задлан шинжилгээ, үйл ажиллагаа (үнэлгээний хуудас, асуулга бөглүүлэх гэх мэт) хийхгүйгээр оролцогчдын бодол санааг шууд дүрслэн харах боломж олгоно. Үнэлгээний дартс нь самбарын цаас, цагаан самбар эсвэл өөр ямар нэгэн зүйл дээр том дугуй зурж, тойргийн төвд “бухын нүд” болох тойрог зурна. Оролцогчид асуулт бүрээ илэрхийлэх хэсгүүдэд ямар нэгэн тэмдэглэгээ хийж хариулна. “Бухын нүд” –д ойртох тусам сэтгэл хангалуун болох ба төвөөс холдох тусам сэтгэл дундуур болох жишээтэй. Дор харуулсан жишээг үзнэ үү.



¹⁹⁸ Үнэлгээний багцаас ашиглав; <http://evaluationtoolbox.net.au> –аас үзнэ үү.



Арга №25:

Саналын дугуй

Хэзээ ашиглах	Зорилго	Хугацаа	Сургагчийн ур чадварын түвшин
Үнэлэх	Дасгалын аль ч хэсгийг үнэлэхэд бүлгээрээ саналаа хэлэх оролцооны арга.	20–30 минут	Эхлэлийн

Энэ аргыг янз бүрийн зорилгоор (жишээлбэл, нөхцөл байдлаа задлан шинжлэх, үйлчилгээг үнэлэх, төсөл эсвэл сургалтын талаар саналыг сонсох) харилцан адилгүй газар (жишээлбэл, гудамжинд алхаж байгаа хүмүүсээс бодлыг нь тэмдэглэх, эсвэл туршлага солилцох уулзалтын дараа хурлын танхимд) ашиглаж болно.

Саналын дугуй хийхэд цаас, бал байхад хангалттай. Дугуйн дотор зураасаа зурна. Зураас бүр сургалтын эцэст зорилгодоо хүрсэн байдал, чиглүүлэгчийн ур чадвар, өрөөний тохь тух, шинээр сурсан зүйл зэрэг асуултад хариулж байгаа хариултыг илэрхийлдэг. Дугуйн төв нь '0' (хамгийн бага), дугуйн гаднах хүрээ нь '10' (хамгийн их) гэсэн үнэлгээтэй. Оролцогч бүр дугуйн төвөөс тойргийн хүрээ хүртэл зураас татаж асуусан асуултад хариулах ба зураасын уртаар саналаа харуулна.



Гэрэл зургийг Жилл Крисп

ХЭРЭГЦЭЭТ ЭХ СУРВАЛЖ

Бүгд ялгаатай – Бүгд тэгш: Боловсролын багц; Европын зөвлөл; 1995 он

Эрхүүдийн тойрог: Эдийн засаг, соёл, нийгмийн эрхийн активизм – Сургалтын эх сурвалж; Хүний эрхийн нөөцийн төв, Миннесотагийн их сургууль; Дэлгэрэнгүй мэдээллийг www1.umn.edu/humanrts/edumat/IHRIP/circle/toc

Түншлэгч болсон иргэд: Бодлого боловсруулахад мэдээлэл, зөвлөгөөн, олон нийтийн оролцоо; Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн газар; 2001 он

Хамт олныг тогтвортой оролцуулах үнэлгээний багц; Дэлгэрэнгүй мэдээллийг <http://evaluationtoolbox.net.au>

Хамт олонд зориулсан аргачлал; Дэлгэрэнгүй мэдээллийг http://ctb.ku.edu/en/tablecon-tents/chapter_1001.aspx –аас үзнэ үү.

Crowd Wise (оролцоог хангасан байдлаар шийдвэр гаргахад зориулсан); Дэлгэрэнгүй мэдээллийг www.crowdwise.org –аас үзнэ үү.

Хүний эрхийн шинэ тактикууд; Дэлгэрэнгүй мэдээллийг www.newtactics.org –аас үзнэ үү.

Сургалт, нөлөөлөл: Хамт олны паралегалын сургалтын хөтөлбөр; Номхон далайн бүсийн эрхүүдийн нөөцийн баг www.rrrt.org/paged095.html –аас үзнэ үү.

Оролцооны аргуудын багц: Мэргэжилтэнд зориулсан зааварчилгаа; Никки Слокум, Баудөун хаан сан, Флемийн Шинжлэх ухаан, технологийн үнэлгээний хүрээлэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагын их сургуулийн хамтын бүтээл “Бүс нутгийг хамарсан харьцуулсан судлал” 2003 он

Оролцооны арга, аргачлал; Дэлхийн хүнсний хөтөлбөр; 2001 он

Хүчирхийлэлгүй амьдралыг зураглах нь: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эцэслэхэд чиглэсэн хэвлэл мэдээлэл, харилцаа холбооны стратеги; UNIFEM; 2001

Дахин дуугарсан дуу хоолой; Ази Номхон далайн бүсийн оролцооны аргуудын судалгаа; Ази–Номхон далайн бүсийн хүний эрхийн боловсролын нөөцийн төв; 2004 он

Олон янз байдалд хариу үзүүлэх нь; Маурин Коллинз; 2006 он;



ХУРААНГУЙ

1-р бүлэг: Хүний эрх: Тойм

- Хүний эрх гэж хүн бүрт заяагдсан үндсэн эрх, эрх чөлөөг хэлнэ. Тэдгээр нь хувь хүн нийгэмд болон бусад хүмүүстэй хэрхэн амьдрах, төр хувь хүний хооронд ямар харьцаа байх болон төрийн тэдний өмнө хүлээх үүрэг хариуцлагийг тогтоож өгдөг.
- 1900-ээд оны дунд үеэс хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нийтлэг стандарт, үйл ажиллагааг томъёолох үйл явц эхэлсэн хэдий ч түүнээс өмнө хүний эрх хүн төрөлхтөнтэй зэрэгцэн оршиж ирсэн. Дэлхийн ихэнх гүн ухаан, соёл урлаг, шашин шүтлэг хүний эрхийг хүлээн өвшөөрч, хөхиүлэн дэмждэг байна.
- Хамгийн анх батлагдсан хүний эрхийн олон улсын баримт бичиг бол 1948 оны Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал юм. Үүний дараа улс төр, иргэний, эдийн засаг, нийгэм, соёлын зэргээр олон улсын гэрээ байгуулагдсан.
- Төр иргэнийхээ хүний эрхийг хүндэтгэн сахих, хамгаалах, хөхиүлэн дэмжих, хангах үүрэгтэй.

2-р бүлэг : Хүний эрхийн боловсрол: Тойм

- Хүний Эрхийн Боловсрол бол хүний эрхийг хэрэгжүүлэх чухал хэрэглүүр юм. Энэ нь бүх нас, түвшин бүрд хамаарах сургалт, судалгаа, боловсролын бүх хэлбэрийг хамарсан үйл явц юм. Хүний эрхийн боловсрол нь нийтийн, хувийн, албан, албан бус зэрэг олон орчинд хэрэгжинэ.
- Хүний эрхийн боловсрол нь олон улсын хүний эрхийн гэрээ, тунхаглалд туссан байдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Боловсролын Тунхаглалаар эдгээр гэрээнүүдийн зарчим, стандартыг давтан баталгаажуулжээ.
- Хүний эрхийн боловсролын зорилго нь хүний эрхийн мэдлэг ойлголтыг түгээх, хүний эрхийг амьдралдаа ашиглах хүмүүсийн чадавх бий болгох, хүний эрхийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулах хувь хүн, хамт олныг бэхжүүлэхэд оршино.
- Хүний эрхийн боловсрол нь хүн бүрт хамаарна. Оролцогчдыг нь гурван өргөн бүлэгт хувааж үзэж болно: эрх эдлэгч, үүрэг хүлээгч, мөн нөлөөлөгчид.

3-р бүлэг: Хүний эрхийн үндэсний байгууллага болон хүний эрхийн боловсрол

- Хүний эрхийн боловсрол нь Парисын зарчим болон Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрт туссан Хүний эрхийн үндэсний байгууллагын нэг гол шалгуур юм.
- Чанартай хүний эрхийн боловсролын хөтөлбөр санал болгохын тулд хүний эрхийн үндэсний байгууллагад гурван зүйл шаардлагатай: төлөвлөлттэй, стратеги бүхий, нөөц бололцоо хангалттай хүний эрхийн боловсролын хөтөлбөр, чадварлаг хүний эрхийн боловсролын мэргэжилтнүүд, хүний эрхийн боловсролын зохистой материаллаг нөөц.
- Ази номхон далайн бүс нутагт хүний эрхийн үндэсний байгууллагууд олон тооны үр нөлөөтэй хүний эрхийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж байна.

4-р бүлэг: Хүний эрхийн боловсролын онол ба зарчим

Хүний эрх хэрэгжихэд хувь нэмэр болох тулд хүний эрхийн боловсрол нь дараах шинжийг агуулсан байх ёстой. Үүнд:

- Оролцогчдод холбогдолтой байх.
- Тохирох хувь хүн, бүлэгтэй түншлэх, хамтран ажиллах ажиллагааг хамарсан байх.

- Оролцогчид нь боловсролын үйл ажиллагааны чухал хувь нэмэр оруулагч гэдгийг, мөн боловсролын мэргэжилтнүүд бол “суралцагч” гэдгийг харгалзсан байх.
- Оролцогчын мэдлэг, туршлагыг гүнзгийрүүлж, бэхжүүлдэг байх.
- Давтлага болон үнэлгээний үйл явцыг хэвшүүлэх байдлаар үйл ажиллагаа, тусгалыг хослуулах.
- Хувь хүний болон нийгмийн түвшинд чадавхжуулах, шинэчлэхэд чиглэдэг байх.

5-р бүлэг. Хүний эрхийн боловсролын хандлага.

- Хүний эрхийн үндэсний байгууллага олон төрөл ялгаатай оролцогч, хам сэдэв, зориулалтад нийцэх хүний эрхийн боловсролын хамгийн зохистой хандлагыг тодорхойлох үүрэгтэй.
- Зургаан төрлийн өргөн арга барилыг агуулсан Multi-Method хандлага: Мэдээлэл солилцох, сургалт, зохицуулан хөнгөвчлөх, харилцааны менежмент, хүний эрхийн нөлөөлөл, хүй олны хөгжил.
- Multi-Method хандлаг нь гурван төрлийн бүтэц зохион байгуулалтаар бэхжүүлдэг байна. Үүнд: “4-А бүтэц”, хүний эрхэд тулгууралсан хандлага, *Пирамид сургалт*.

6-р бүлэг: Хүний эрхийн боловсролыг төлөвлөж загварчлах нь

- Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөж, загварчлах ажилд хүний эрхийн нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэх, тухайн нөхцөлд хүний эрхийн боловсролын ямар үйл ажиллагаа нөлөө үзүүлж болохыг шийдэх ажлууд орно.
- Логик загвар нь энэ зорилгод ашигтай арга хэрэгсэл болдог. Үүнд дараах дөрвөн элемент орно:
 - Нөхцөл байдлын шинжилгээ; хүний эрхийн нөхцөлд үнэлэлт хийх.
 - суурь оролтууд: үйл ажиллагаа явуулж үнэлгээ хийхэд шаардагдах нөөц бололцоо.
 - Үйл ажиллагааны гаралтууд; үйл ажиллагааны төрөл болон хамрагдах оролцогчид, буад талууд
 - Үр дүн; Үйл ажиллагаанаас гарах үр дүн.
- Логик Загвар нь хүний эрхийн боловсролын олон түвшинд ашиглаж болно. үндэсний, олон нийтийн, эсвэл байгууллагын үйл ажиллагаа, төслийн төлөвлөгөө, нэг цагийн семинар болно хувь хүний ажлын төлөвлөгөө гэх мэт.

7-р бүлэг: Хүний эрхийн боловсролыг хэрэгжүүлэх нь.

Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа явуулахад хүний эрхийн боловсрол эрхлэгчийн анхаарах хэдэн гол зүйл:

- Боловсрол эрхлэгчийн тодорхой үүргийг нарийн тодорхойлох
- Оролцогчдын олон ялгаатай сурах арга барилыг харгалзах, тэдгээрт тохируулах.
- Үр нөлөөтэй сургалтын орчныг бүрдүүлэх.
- Үйл ажиллагааны хурдыг оролцогчид болон сэдвийн агуулгатай тохируулах
- Ойлгоход хялбар, бүгдийг хамруулсан хэл ашиглах
- Өөрийн ажлын ачаалал болон бусад дарамтыг харгалзан, шаардлага гарвал дэмжлэг авах.

8-р Бүлэг: Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг үнэлэх нь

- Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг үнэлгээгээр үйл ажиллагаа үр дүндээ ойртож байгаа эсэх, чухам юуг сайжруулж болох вэ гэдгийг илэрхийлнэ. Үүнийг үйл ажиллагааны үеэр, эсвэл төгсгөлд нь хийж болно.
- Хүний эрхийн боловсролын үнэлгээ хийх нийтлэг багц шалгуурт:
 - Холбоо хамаарал
 - Тохиромж
 - Үр дүнтэй байдал
 - Үр өгөөж
 - Нөлөөлөл
 - Тууштай байдал

Эдгээр бүх шалгуурыг байнга хэрэглэхгүй байж болно.

- Үнэлгээ хийх маш олон арга байдаг. Үнэлгээний арга нь тухайн үйл ажиллагааны сэдэв агуулга, оролцох оролцогчдод тохиромжтой нь чухал юм.
- Үнэлгээний дүнг үнэлгээнд оролцсон хүмүүст байнга танилцуулж байх хэрэгтэй. Мөн санхүүжүүлэгч болон бусад талуудад мэдээлж байх нь зүйтэй.

9-р бүлэг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллах нь:

- Хэвлэлийн хэрэгсэл нь олон нийтийн санаа бодлыг тусган, хэвшүүлэх болон нийгэм, улс төр, эдийн засгийн асуудал сэдвийг тогтооход гол үүрэг гүйцэтгэнэ.
- Хүний эрхийг оновчтой, мэдээллийн шинжтэй, тогтмол хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр түгээснээр хүй олны хандлагаыг төлөвшүүлж, хууль зүй, бодлого, практикт өөрчлөлт гаргахад хувь нэмэр болдог.
- Хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний эрхийг асуудлыг сэтгүүлчдийн оролцуулж болохуй байдлаар илэрхийлэхийн тулд мөн оновчтой, бүрэн түгээхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн ажилладагийг ойлгодог байх хэрэгтэй.
- Хүний эрхийн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх хэвлэл мэдээллийн үйл ажиллагаа нь ганцхан удаагийн байж болохгүй. Үүнд тогтмол хугацаанд олон хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан уялдаатай хөхиүлэн дэмжих ажиллагаа шаардлагатай.
- Хүний эрхийн үндэсний байгууллага нь хүний эрхийн талаар тодорхой мэдээлэл түгээхийн тулд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчидтэй хамтран ажиллах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй.

10-р бүлэг: Сургуулийн өмнөх боловсролын төв болон сургууль дахь хүний эрхийн боловсрол

- Хүүхдийн эрхийн Конвенцийн 29 дүгээр зүйл тухайлан хүүхдийн боловсрол эзэмших эрхийн талаар анхаарсан.
- Хүний эрхэд суурилсан сургуульд сурдаг хүүхдүүд эрхийнхээ талаар мэддэг, өөрсдийн үүрэг хариуцлага, бусдын эрхийг ойлгодог, өөргийгөө хүндлэх үнэлэмж илүүтэй, олон төрөл ялгааг илүүтэй хүлээн зөвшөөрөх бөгөөд амжилт олох үзүүлэлт өндөртэй байдгийг судалгаагаар тогтоожээ,
- Хүний эрхийн боловсролын зарчмууд нь сургуулийн өмнөх боловсролын төв болон сургуулийн хамт олон, боловсролын газар, салбаруудтай хүний эрхийн үндэсний байгууллагын явуулдаг үйл ажиллагаанд удирдлага чиглэл болох ёстой юм.
- Сургууль, их сургууль, бусад боловсролын байгууллагатай Ази номхон далайн орнуудын Хүний эрхийн үндэсний байгууллагууд идэвхтэй хамтран ажиллаж байна.

11-р бүлэг: Зөрчилдөөний болон зөрчилдөөний дараах үеийн хүний эрхийн боловсрол.

- Зөрчилдөөний болон зөрчилдөөний дараах үеийн боловсрол нь зөрчилдөөн, мөргөлдөөний үзүүлэх нөлөөллийг багасгах, энхийг сэргээн тогтооход чухал үүрэгтэй.
- Зөрчилдөөний үе болон зөрчилдөөний дараах үед байгаа ХЭҮБ-уудад өөрийн өвөрмөц нөхцөл байдлаас үүдэлтэй үүрэг роль гүйцэтгэх энгийн хөтөлбөрийн үүрэг функцийг нийгэм дэх тодорхой бүлэгт тулгарч буй онцлог нөхцөл ажиллахад нийцүүлэн өөрчилдөг байх шаардлага гарч болно.

Ашигласан материалууд

1-р бүлэг: Хүний эрх: Тойм

International Human Rights and the International Human Rights System: A Manual for National Human Rights Institutions; APF; 2012

International Human Rights Milestones; New Zealand Human Rights Commission; 2008; available at www.hrc.co.nz/hrc_new/hrc/cms/files/documents/10-Mar-2009_10-14-19_International_Milestones_Final.pdf

"What are human rights?"; OHCHR; available at www.ohchr.org/en/issues/Pages/WhatareHumanRights.aspx

2-р бүлэг : Хүний эрхийн боловсрол: Тойм

Human Rights Education Pack; Asian Regional Resource Center for Human Rights Education; 2003 (2nd edition)

Understanding Human Rights: A Manual on Human Rights Education; Wolfgang Benedek, European Training and Research Centre for Human Rights and Democracy; 2012

Applying a Human Rights Based Approach; Danish Institute for Human Rights; 2007

The Human Rights Education Handbook: Effective Practices for Learning, Action, and Change; Nancy Flowers with Marcia Bernbaum, Kristi Rudelius-Palmer and Joel Tolman, Human Rights Resource Center, University of Minnesota; 2000

3-р бүлэг: Хүний эрхийн үндэсний байгууллага болон хүний эрхийн боловсрол

Assessing the Effectiveness of National Human Rights Institutions; International Council on Human Rights Policy; 2005

National Human Rights Institutions: History, Principles, Roles and Responsibilities; Professional Training Series No. 4 (Rev. 1); OHCHR; 2010

A Manual on National Human Rights Institutions; APF; 2013

4-р бүлэг: Хүний эрхийн боловсролын онол ба зарчим

"Human Rights Education as Empowerment: Reflections on Pedagogy" by Garth Meintjes in *Human Rights Education for the Twenty-First Century*; George J. Andreopoulos and Richard Pierre Claude, eds.; 1997

Human Rights Education for the Twenty-First Century; George J. Andreopoulos and Richard Pierre Claude, eds.; 1997

Human Rights Education Pack; Asian Regional Resource Center for Human Rights Education; 2003 (2nd edition)

"Maranga Mai! Human Rights Community Development" by Jill Chrisp in the *Australian New Community Quarterly* (Vol. 9, No. 1); Autumn 2011

Participatory Methods Toolkit: A Practitioner's Manual; Dr Nikki Slocum; joint publication of the King Baudouin Foundation and the Flemish Institute for Science and Technology Assessment, in collaboration with the United Nations University – Comparative Regional Integration Studies; 2003

Pedagogy of the Oppressed; Paulo Freire; 1968 (translated into English in 1970)

5-р бүлэг. Хүний эрхийн боловсролын хандлага.

Human Rights-Based Approach to Education for All; United Nations Children's Fund and the United Nations Educational, Scientific and Cultural Organization; 2007

Applying a Rights-Based Approach: An Inspirational Guide for Civil Society; Danish Institute for Human Rights; 2007

Practising Social Change, Practitioners Journal; Institute for Applied Behavioural Science, National Training Laboratories; available at www.ntl-psc.org

Right to Education Indicator based on the 4 A Framework: Concept Paper; Gauthier de Beco for the Right to Education Project; 2009

Right to Education Project; available at www.right-to-education.org

UN Common Learning Package based on the human rights-based approach; available at <http://hrbportal.org/archives/resource-types/learning-training-materials/>

6-р бүлэг: Хүний эрхийн боловсролыг төлөвлөж загварлах нь

A Human Rights-Based Approach to Education for All; United Nations Children's Fund and the United Nations Educational, Scientific and Cultural Organization; 2007

Assessing the Effectiveness of National Human Rights Institutions; International Council on Human Rights Policy; 2005

Enhancing Participatory Non-formal Education among Cambodian Human Rights NGOs; Richard Pierre Claude (for the Asia Foundation); 1999; available at www.hrea.org/erc/Library/research/TAFreport.html

Introduction to Health Promotion Planning; Health and Communication Unit, Centre for Health Promotion, University of Toronto; 2001

Qualitative and Quantitative Indicators for the Monitoring and Evaluation of the ILO Gender Mainstreaming Strategy; Tania Bastia; 2000; available at www.womeng.net/wp/library/Methodology%20Indicators.pdf

Situation Analysis: Module 1; United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific; available at www.unescap.org/stat/meet/rrg3/twsa-module1.pdf

Understanding Human Rights: A Manual on Human Rights Education; Wolfgang Benedek, European Training and Research Centre for Human Rights and Democracy; 2012 (3rd edition)

7-р бүлэг: Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа явуулах нь

All Different All Equal: Education Pack; Council of Europe; 1995

Community Organisers' Toolbox; Education and Training Unit for Democracy and Development; available at www.etu.org.za/toolbox/docs/building/webtraining.html

Enhancing Learning for Effectiveness; Train4Dev; 2011

Facilitation Skills for Interpersonal Transformation; Ron Kraybill, Berghof Research Center for Constructive Conflict Management; 2004

Facilitator's Toolkit; Action for the Rights of Children/Reach Out; 2005; available at https://icvanetwork.org/system/files/versions/ro_28_toolkit.pdf

Methodology for Human Rights Education for the Police; National Human Rights Commission of Korea; 2008

Reclaiming Voices: A Study on Participatory Methodologies in the Asia Pacific; Asian Regional Resource Center for Human Rights Education; 2004

Training for Transformation: A Handbook for Community Workers; Anne Hope and Sally Timmel; Books 1, 2 and 3 (1984) and Book 4 (1999)

We can teach the way we were taught, or we can teach the way people learn; Sierra Training Associates; 2007; available at <http://sph.bu.edu/otlt/teachingLibrary/Learning%20Theory/adultlearning.pdf>

8-р Бүлэг: Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг үнэлэх нь

Assessing the Effectiveness of National Human Rights Institutions; International Council on Human Rights Policy; 2005

Documenting Progress and Demonstrating Results: Evaluating Local Out-of-School Time Programs; Harvard Family Research Project; 2002; available at www.hfrp.org/publications-resources/browse-our-publications/documenting-progress-and-demonstrating-results-evaluating-local-out-of-school-time-programs

Evaluating Human Rights Training Activities: A Handbook for Human Rights Educators; OHCHR and Equitas; 2011

Evaluation and Types of Evaluation; National Science Foundation; 2000

External Evaluation: Are we doing the right things? Are we doing things right?; Swiss Agency for Development and Cooperation; 2000

Handbook on Planning, Monitoring and Evaluating for Development Results; United Nations Development Programme; available at <http://web.undp.org/evaluation/handbook/ch7-4.html>

Monitoring and Evaluation; CIVICUS World Alliance for Citizen Participation; available at www.civicus.org/new/media/Monitoring%20and%20Evaluation.pdf

Monitoring and Evaluation; World Bank; available at <http://siteresources.worldbank.org/INTBELARUS/Resources/M&E.pdf>

Reflect and Improve Tool Kit: Section 5, Development and Implementing an Evaluation Plan; Innovation Center for Community and Youth Development; 2005; available at www.theinnovationcenter.org/files/doc/B5/RI%20pp%2068%20Evaluation%20Methods.pdf

Study on the Advances in Civic Education in Education Systems: Good Practices in Industrialized Countries; Audrey Osler and Hugh Starkey, Centre for Citizenship and Human Rights Education, University of Leeds, and Institute of Education, University of London; 2004

The Monitoring and Evaluation Framework: Part 1; United Nations Development Programme; available at http://web.undp.org/evaluation/documents/HandBook/part_1.pdf

Together is Better: Collaboration, Assessment, Evaluation and Reporting; Anne Davies, Caren Cameron, Colleen Politano and Kathleen Gregory; 1992

Useful Tools for Engaging Young People In Participatory Evaluation; Meg Gawler; 2005; available at www.artemis-services.com/downloads/tools-for-participatory-evaluation.pdf

9-р бүлэг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй ажиллах нь:

Journalism, Media and the Challenge of Human Rights Reporting; International Council on Human Rights Policy; 2002
Media Handbook for National Human Rights Institutions; APF; 2013
Whose News? The Changing Media Landscape and NGOs; Carroll Bogert, Human Rights Watch; 2011

10-р бүлэг: Сургуулийн өмнөх боловсролын төвүүд болон сургууль дахь хүний эрхийн боловсрол

Children's Rights Information Network; available at www.crin.org
Compasito: Manual on human rights education for children; European Youth Centre in Budapest; available at www.eycb.coe.int/compasito/chapter_1/2_wha.html
Evaluation of UNICEF's UK's Rights Respecting Schools Awards; Judy Sebba and Carol Robinson; 2010
Guidelines for Human Rights Education in Secondary School Systems; Office for Democratic Institutions and Human Rights; 2012
Human Rights in New Zealand 2010 – Nga Tika Tangata O Aotearoa 2010; New Zealand Human Rights Commission; 2010
Law into Action: Economic, Social and Cultural Rights in Aotearoa New Zealand; Margaret Bedggood and Kris Gledhill (eds.), Human Rights Foundation of New Zealand; 2011
National Human Rights Institutions: History, Principles, Roles and Responsibilities; Professional Training Series No. 4 (Rev. 1); OHCHR; 2010
Rights Respecting Schools Initiative; UNICEF; available at http://e-activist.com/ea-campaign/action.retrievestaticpage.do?ea_static_page_id=1362
Teaching Children's Rights Through Art; Diane Lewis Children's Rights Centre, Cape Breton University; 2007

11-р бүлэг: Зөрчилдөөний болон зөрчилдөөний дараах үеийн хүний эрхийн боловсрол

Conflict Resolution and Human Rights: Contradictory or Complementary; Baroness Helena Kennedy QC; 2001; published in Human Rights Education Pack; Asian Regional Resource Center for Human Rights Education; 2003
Education and Reconciliation: Exploring Conflict and Post-conflict Situations; Julia Paulson (ed.); 2011
National Human Rights Institutions: History, Principles, Roles and Responsibilities; Professional Training Series No. 4 (Rev. 1); OHCHR; 2010
Quality Education in Conflict Affected Countries: Facilitator's Manual; United Nations Educational, Scientific and Cultural Organization; 2005; available at <http://unesdoc.unesco.org/images/0014/001433/43319E.pdf>
The Influence of Education on Conflict and Peace Building; Alan Smith; 2010 (paper commissioned for the *Education for All Global Monitoring Report 2011*)
Toolkit for collaboration with National Human Rights Institutions; United Nations Development Programme and OHCHR; 2010

ХЭСЭГ IV: Хэрэглүүр, арга техник

All Different – All Equal: Education Pack; Council of Europe; 1995

Circle of Rights: Economic, Cultural and Social Rights Activism – A Training Resource; Human Rights Resource Center, University of Minnesota; available at www1.umn.edu/humanrts/edumat/IHRIP/circle/toc.htm

Citizens as Partners: Information, Consultation and Public Participation in Policy-Making; Organisation for Economic Co-operation and Development; 2001

Community Sustainability Engagement Evaluation Tool Box; available at <http://evaluationtoolbox.net.au>

Community ToolBox; available at http://ctb.ku.edu/en/tablecontents/chapter_1001.aspx

Crowd Wise (for participatory decision-making); available at www.crowd-wise.org

New Tactics in Human Rights; available at www.newtactics.org

Training and Advocacy: Community Paralegal Training Programme; Pacific Regional Rights Resource Team; available at www.rrrt.org/paged095.html

Participatory Methods Toolkit: A Practitioner's Manual; Nikki Slocum, joint publication of the King Baudouin Foundation and the Flemish Institute for Science and Technology Assessment, in collaboration with the United Nations University – Comparative Regional Integration Studies; 2003

Participatory Techniques and Tools; World Food Programme; 2001

Picturing a Life Free of Violence: Media and Communications Strategies to End Violence Against Women; UNIFEM; 2001

Reclaiming Voices: A Study on Participatory Human Rights Education Methodologies in the Asia Pacific; Asia-Pacific Regional Resource Centre for Human Rights Education; 2004

Responding to Diversity; Maureen Collins; 2006

Нэр томъёоны тайлбар

Дараах тодорхойлолтууд хүний эрхийн боловсролтой холбогдохын хувьд энэ гарын авлагад ашигласан гол ойлголтуудыг тайлбарлаж байна.

Үйл ажиллагаа	Бага хэмжээний, нэг удаагийн арга хэмжээнээс эхлээд хүний эрхийн боловсролын бүх хэлбэрийн ажиллагааг оролцуулан өргөн хэмжээний төсөл хөтөлбөр хүртэлх бүхий ажил
Нөлөөлөгч	Нөлөөлөгч нь хувь хүн буюу бүлэгт тодорхой асуудлыг шийдвэрлэхэд нь дуу хоолой нэмэх буюу тэдэнд өөрсдийн дуу хоолойгоо гаргахыг нь урамшуулан дэмжиж өгдөг. Хүний эрхийн нөлөөлөгч этгээд нь хүний эрхийн боловсролд холбогдохын хувьд хүний эрхийн гүйцэтгэх үүрэг, үнэ цэнийг хөхиүлэн дэмжиж, бусдыг үйлдэл хийхийг урамшуулан дэмждэг.
Хандлага	Хүний эрхийн үйл ажиллагаанд хэрэглэж болох онол, зарчим, практикын тусгай багц.
Тохиолдол шинжлэл	Хүн, бүлэг, эсвэл үйл явдлын талаарх хураангуйлж, төлөвлөсөн мэдээлэл
Мэдээлэл холбогч	Мэдээлэл холбогч нь мэдээллийг тухайн үзэгч, сонсогчийн хувьд хамгийн үр нөлөөтэйгөөр хүлээн авж болохуйц байдлаар хүлээн авч, илгээдэг. Хүний эрхийн мэдээлэл холбогч нь хүмүүст нөлөөлж буй хүний эрхийн асуудлуудын талаар мэдээлэл хүлээн авахын зэрэгцээ хүний эрхийн тухай мэдээллийг түгээдэг.
Чадвар	Тодорхой үүрэг роль буюу даалгаварыг гүйцэтгэхэд шардлагатай мэдлэг, ур чадвар, дадал.
Хамт олныг хөгжүүлэгч	Хамт олныг хөгжүүлэгч нь олон янзын арга хэрэгсэл, үйл явцыг ашиглаж өөрсөддөө чухал асуудлуудыг тодорхойлон, шийдвэрлэж чадах өөртөө итгэлтэй хамт олныг урамшуулан дэмждэг. Хүний эрхийн хамт олны хөгжүүлэгчийн хувьд анхаарах гол зүйл нь тухайн хамт олны хүний эрхийн асуудлууд юм.
Үүрэг хүлээгч	Бусдын хүний эрхийг хүндэтгэн сахиж, хамгаалж, хангах үүрэг хариуцлага бүхий этгээд.
Үнэлгээ	Үр өгөөж, үйл явцыг нь тасралтгүй сайжруулахад тус нэмэр болгох зорилгоор хүний эрхийн үйл ажиллагааны дундуур болон дараа нь мэдээлэл цуглуулах.
Зохицуулан хөнгөвчлөгч	Зохицуулан хөнгөвчлөгч нь бүлэгт өөрийн асуудал болон шийдэлд хүрэх боломж олгодог. Хүний эрхийн зохицуулан хөнгөвчлөгч нь хүмүүст өөрсдөд нь болоод бусдад нөлөөлж байгаа хүний эрхийн асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг олох боломж олгодог олон үйл явц, арга хэрэгслийг ашигладаг.
Санал хүсэлт	Оролцогчид, эсвэл бусад талуудын хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд оролцсон талаараа өгсөн хариу. Энэ нь юу нь болж байгаа, юуг сайжруулж болохыг тодорхойлох зорилготой “бүтээлч санал хүсэлт” гэдэгт холбогдоно
Албан ёсны хүний эрхийн боловсрол	Бага насны хүүхдийн боловсролын төвүүд, сургууль их дээд сургууль дахь хүний эрхийн боловсрол.
Хүний эрх	Хүн бүрт заяагдсан суурь эрх, эрх чөлөө

Хүний эрхийн боловсрол	Хүний эрхийн тухай мэдлэг түгээх, амьдралдаа хүний эрхийг ашиглах хүмүүсийн чадварыг бий болгох, хүний эрхийг хэрэгжүүлэхэд хувь хүн болон хамт олныг бэхжүүлэх.
Хүний эрхийн боловсрол эрхлэгч	Хүний эрх ба боловсролын онол дадалд мэргэшсэн, түүнийгээ хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд ашигладаг хүн.
Хүний эрхийн энгийн боловсрол	Зохион байгуулаагүй, их төлөв санаандгүйгээр хувийн туршлагаас хүний эрхийн талаар сурах ойлгох.
Илтгүүр	Үйл ажиллагаа зорьсон үр дүндээ хэр сайн хүрч байгаа талаар мэдээлэл өгөх хэмжүүр. Илтгүүр нь тоон (тоо орсон) эсвэл чанарын (үйл ажиллагааны чанарыг илэрхийлсэн) байж болно.
Нөлөөлөгчид	Хүний эрхийн талаарх бусдын бодолд нөлөөлж, хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаанд урамшуулан дэмжиж чадах хувь хүн, бүлэг
Суурь оролтууд	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд хэрэгцээтэй нөөц бололцоо
Суралцах орчин	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа явах бодит ба хийсвэр орон зай
Суралцах хэв маяг	Хувь хүн хамгийн сайн суралцах арга
Логик Загвар	Боловсролын үйл ажиллагааны үндсэн элементүүдийг холбох системтэй арга зам
Арга зүй	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны дүн шинжилгээ, тайлбар
Үе шугам	Урт хугацаанд явуулах хүний эрхийн үйл ажиллагаанд хэрэглэдэг. Эдгээр нь үйл ажиллагааны туршид тодорхой өгсөн хугацаанд юу амжуулах ёстой вэ гэдгийг илтгэдэг.
Мониторинг	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа төлөвлөсөн үр дүндээ хүрч чадаж байгаа эсэхийг үнэлэх үйл явц.
Хүний эрхийн үндэсний байгууллага	ХЭҮБ нь хуулийн дагуу төрөөс хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилгоор байгуулсан албан ёсны хараат бус хуулийн байгууллага. Тэдгээрийг үндсэн хуульд тусган, эсвэл хууль батлан байгуулж төрийн болон трийн бус аливаа хүчний зүгээс улс төрийн нөлөөллөөс хараат бус байх баталгааг нь хангадаг. ХЭҮБ нь олон улсын наад захын стандарт болох Парисын зарчимд нийцсэн байх ёстой.
Сүлжээгээр нэвтрүүлэгч	Сүлжээ зохион байгуулагч нь нийтлэг зоригод хүрэхийн тулд хүмүүстэй буюу тэдний дунд харилцаа хөгжүүлдэг. Хүний эрхийн сүлжээ зохион байгуулагч нь тодорхойлсон хүний эрхийн нөхцөл байдлыг шийдвэрлэх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжихийн тулд зохих хувь хүн, бүлэгтэй буюу тэдний хооронд(эрх эдлэгч, үүрэг хүлээгч, эсвэл нөлөөлөгчид) харилцааг хөгжүүлж зохион байгуулдаг.
Мэдээний үнэ цэнэ	Мэдээний түүхийн сэтгүүлчид эсвэл тэдний үзэгч сонсогчдын сонирхлыг их буюу бага татахыг тодорхойлох шинж. Мэдээний үнэ цэнэ нь тухайн түүхийн бусад түүхтэй харьцуулвал хүчтэй байхыг тодорхойлдог.
Хүний эрхийн албан бус боловсрол	Албан боловсролын тогтолцооны гадуур явж буй боловсролын үйл ажиллагаа.

Парисын Зарчим	“Үндэсний байгууллагуудын статусын талаарх зарчмууд” нь хараат бус хүний эрхийн үндэсний байгууллага байгуулах, ажиллуулахад тавих олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн наад захын стандартыг тогтоосон байдаг.
Үр дүн	Хүний эрхийн үйл ажиллагаанаас хүлээсэн, бодит үр дүн.
Гаралт	Зорьсон үр дүнд хүрэхэд хувь нэмэр оруулах хүний эрхийн үйл ажиллагаа.
Оролцогч	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгаа хүн. Бусад талуудаас байж болно.
Хүний эрхийн боловсролын зарчим	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд баримтлах стандарт, мөрдлөг.
Хүний эрхийн боловсролын практик	Хүний эрхийн онол, зарчмыг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажил – хүний эрхийн боловсролыг үйл хэрэг болгох.
Тусгах практик	Хүний эрхийн боловсрол эрхлэгч үйл ажиллагааныхаа талаар хийх үнэлгээ.
Хяналт	Хүний эрхийн үйл ажиллагаа хэр явцтай байгааг үнэлэх үйл явц бөгөөд үргэлжлэх үйл ажиллагааг сайжруулахын тулд энэ үнэлгээ ашиглах
Эрх эдлэгч	Тодорхой эрх, хамгаалалт авах эрх бүхий хувь хүн, бүлэг
Нөхцөл байдлын шинжилгээ	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа төлөвлөхөд хэрэгтэй мэдээлэл цуглуулах. Үүгээр тодорхой нөхцөл байдалд холбогдох давуу тал, хэрэгцээ, дэмжлэг, саад бэрхшээлийг тодорхойлдог.
Холбогдох тал	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх буюу түүнээс нөлөө авч болоххүн, бүлэг, байгууллага. Холбогдох тал нь оролцогч, хүний эрхийн үндэсний байгууллага, эсвэл санхүүжүүлэгч зэрэг гадны байгууллага байж болно.
Арга техник	Хүний эрхийн боловсрол эрхлэгч тодорхой үр дүнд хүрэхийн тулд ашиглах үйл явц, эсвэл арга барил.
Хүний эрхийн боловсролын онолын бүтэц	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд мөрдлөг болох бүтэц бүхий онол, зарчмын нэгдэл
Хүний эрхийн боловсролын онол	Хүний эрхийн боловсролыг тайлбарласан үзэл, сургааль, ойлголт
Хэрэгслүүд	Хүний эрхийн боловсрол эрхлэгч амжилттай үр дүнд хүрэх боломжоо ихэсгэхэд ашиглах сургалтын хэрэглэгдэхүүн. Олон ялгаатай сурах хэрэгцээ шаардлага, оролцогчийн хэв маягт нийцүүлэхийн тулд олон янзын арга хэрэгсийг нийтлэг хэрэглэдэг.
Сургагч багш	Тодорхой даалгавар, үйл ажиллагаа гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, дадлыг хөгжүүлэхийн тулд хүмүүстэй ажилладаг хүн. Хүний эрхийн сургагч багшнь хүмүүс хүний эрх болон хүний эрхийн дадлын талаар мэддэг болоход анхаарна.



Хавсралтууд



Хавсралт 1:

Ази номхон далайн орнууд дахь хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд ашигласан Логик Загварууд 165

Хавсралт 2:

Хүний эрхийн боловсролын зохимжтой арга зүйг сонгох нь 174

Хавсралт 3:

Зорилтоо бичих нь 177

Хавсралт 4:

Логик Загварын хяналтын жагсаалт 178

Хавсралт 5:

Үр дүнтэй зохицуулан хөнгөвчлөх чадвар 180

Хавсралт 6:

Суралцах туршлага болон хэв маягийн дөрвөн ухагдахуун 182

Хавсралт 7:

Бодох хэв маягийн дөрвөн төрөл 183

Хавсралт 8:

Өөрийгөө үнэлэх, дотроо үнэлэх, гадны үнэлгээ 184

Хавсралт 9:

Хүний эрхийн боловсролын зарчмуудад тухайн үйл ажиллагаа нийцсэн эсэхийг үнэлэх чиглүүлэх асуултууд 185

Хавсралт 10:

Хүний эрхийг дээдэлдэг сургуулиудыг хөгжүүлэх UNICEF-ийн бодлого 186

Хавсралт 11:

Боловсролын “4-А” бодлого ба Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд 189

Хавсралт 12

Хүний эрхийн Боловсролын Нэгдсэнг Үндэстний Байгууллагын Тунхаглал 190

Хавсралт 1:


Ази Номхон далайн бүс нутагт хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа явуулахад ашиглах Логик Загвар

Дараах Логик Загварууд Олон–Арга барилт хандлага дахь арга барил тус бүрээс авч үзсэн бөгөөд Ази Номхон Далайн бүс нутаг дахь хүний эрхийн үйл ажиллагаанд ашигладаг.

Логик Загварын үйл явцын үр ашиг, өгөөж нь боловсролын мэргэжилтнүүд, ХЭҮБ, оролцогчид болон бусад талууд оролцож, эзэн болдог байхад оршиж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Доор дурдсан жишээ бүрэн бус ажлын жишээнүүд бөгөөд өргөн хүрээтэй хүний эрхийн боловсролын хөтөлбөрүүдийг Логик Загвар ашиглан хэрхэн төлөвлөж болохыг үзүүлэх зорилготой юм. Эдгээрээр боловсролын үйл ажиллагааны яв цав зөв зураглалыг үзүүлэхийг оролдоогүйн дээр нөхцөл байдлын шинжилгээний элементүүдийг оруулагүй юм.

Мэдээлэл солилцох

- Камбожийн Хүний эрхийн Төв; Эмзэг давхаргын олон нийтийн мэдээллийн хэрэгслийн төсөл.
- Сургалт
АНДЧ; Сургагч багш бэлтгэх холимог сургалтын хөтөлбөр.
- Зохицуулалт
Фемлинк; Фижигийн эмэгтэйчүүдийн хамт олны ради төсөл.
- Сүлжээний ажил
Шинэ Зеландын Хүний эрхийн Комисс, Ялгаатай байдлын үйл ажиллагааны хөтөлбөр
- Хүний эрхийн нөлөөлөл
Австралийн Хүний эрхийн Комисс; Хүний эрхийн боловсрол, нөлөөллийн хөтөлбөр.
- Хамт олны хөгжил
Филиппин Улсын Хүний эрхийн Комисс; Нутгийн уугуул хүмүүсийн төсөл.



ХАВСРАЛТ 1:
Логик Загвар: Мэдээлэл түгээх нь

Камбож Улсын Хүний эрхийн Төв — Эмзэг бүлгийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн төсөл¹⁹⁹

ОРЦ	ГАРЦ		ҮР ДҮН	
	ХЭБ-ын Үйл ажиллагаа	Оролцогчид	Богино хугацааны	Дунд хугацааны
Судалгаа Ажилтнууд, шинжээчид Сангууд Нийгмийн харилцааны хэрэгслүүд Програм хангамж, Дижитал аюулгүй байдлын хэрэгслүүд	Хүний эрхийн мэдлэг түгээх нийгмийн харилцааны хэрэгсэл бүтээх Нийт 40 сургагчид зориулсан 4 удаагийн сургалт зохион байгуулж, гарын авлагыг зөөврийн дискэд хуулж өгөв.	Олон нийтэд түшиглэсэн, орон нутгийн байгууллагууд, идэвхтнүүд Эхний шатанд 4 бүлэг тутмаас тус бүр 10 сургагч багш бэлтгэх зорилготой.	сургагч багш нар гарын авлагад буй Хүний эрхийн мэдээллийг түгээх	Камбожийн Хүний эрхийн төвийн хүний эрхийн талаар нийгмийн харилцааны хэрэгслүүд ашиглар, идэвхитэй оролцоог хангасан мултимедиа хэрэгслүүд бүрдүүлэх чадавхи нэмэгдэх
Жишээ болгох Үнэлгээний асуултууд ...				
Хэдий хэмжээний цаг хугацаа болон нөөц зарцуулсан бэ Нөөц хүрэлцээтэй байсан эсэх	Гарын авлага боловсруулсан эсэх Гарын авлагыг хэрхэн хэрэглэдэг вэ?	Сургалтад хэрхэн хэрэглэдэг вэ? Хэр үр дүнтэй байсан бэ? Тухайн програмыг ашиглахад ямар нэг хүндрэл гарсан уу Уг асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн бэ?	Тухайн програм, хэрэгслүүдийг сургагч нар ямар түвшинд ашиглаж байна вэ?	Хүний эрхийн мэдлэг, мэдээлэл түгээхэд, нийгмийн харилцааны хэрэгслүүдийг хэр түвшинд хэрэглэж байна вэ? Уг байдал нь хэр зэрэг үр дүнтэй байна вэ?
Жишээ болгох Шалгуур үзүүлэлтүүд				
Хүний тоо, цаг хугацаа Хүний нөөцөөс бусад зардлууд Түншүүд	Гарын авлагын сургалтад хамрагдсан хүний тоо Оролцогчдоос ирүүлсэн санал, хариу	Зохион байгуулсан сургалтын тоо Оролцогчдын тоо Оролцогчдоос ирүүлсэн санал, хариу	Сургалтын үр дүнд иргэдийн хэрэгжүүлсэн олон нийтийн мэдээлэл нэмэгдсэн эсэх	Хүний эрхийн үйл ажлагаа Фейсбүүк, Твиттер, Фликр, Ютуб зэрэг мэдээллийн хэрэгслүүдэд нийтлэг болсон эсэх

¹⁹⁹ Нэмэлт мэдээллийг дараах холбоосоор: <http://rising.globalvoicesonline.org/microgrants2013/finalist-the-cambodian-grassroots-social-media-project>.

Логик Загвар: Сургалт
АНДЧ – Сургагч багш нар бэлтгэх холимог сургалтын хөтөлбөр²⁰⁰

СУУРЬ	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРАЛТ					ҮР ДҮН		
Нөөц	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа	Оролцогчид/Бусад талууд	Богино хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд			
Албан хаагчид; судлаачид, зохиолчид, удирдагчид Сан Мэдээлэл, харилцааны технологи/цахим хуудас Логистик,	Хүний эрхийн сургалтын арга барилаар болон суралцагчдын танилцуулах хичээлийг оролцуулан онлайн (4 долоо хоног) болон биечлэн (1 долоо хоног) сургалтын хэлбэрээр таван долоо хоногийн холимог сургалт туршилтаар явуулах Өөрийн улс оронд хүний эрхийн сургалт явуулах, үнэлэх, тайлагнах замаар “АНДЧ–ны Мастер сургагч багш” болох боломж	Ази Номхон далайн бүс нутаг дахь ХЭҮБ–уудын хүний эрхийн сургагч багш нар ХЭҮБ–ууд, АНДЧ, бусад талууд	Оролцогчдын хүний эрхийн сургалтын талаарх мэдлэг нэмэгдсэн Сургагч багшийн холимог сургалтын загварыг туршиж, цаашид үргэлжлэх хөтөлбөрийн стратегийг боловсруулав	Оролцогчид эдгээр мэдлэгийг хүний эрхийн сургагч багшийн хувьд өөрийн оронд практикт ашиглаж байна	Ази Номхон далайн бүс нутаг дахь ХЭҮБ–уудын хүний эрхийн сургалтын практикт дэвшил гарав			
Үнэлгээний жишээ асуултууд ...								
Ямар хугацаа, нөөц бололцоо зарцуулсан бэ? Оруулсан нөөц зохистой байсан уу?	Хөтөлбөрийн талаарх тусгал ойлголт ямар байсан бэ? Онлайн хэлэлцүүлэгт оролцогчид хэр оролцоотой байв? Оролцогчдын тавьсан танилцуулга хэр үр дүнтэй байв?	ХЭҮБ–уудыг хөтөлбөрийг боловсруулахад хамруулсан уу? Тийм бол яаж? Хэдэн хүн оролцсон бэ? Хөтөлбөрийн талаар тэд ямар үнэлэлт өгсөн бэ? Хэд нь “АНДЧ–ны Мастер Сургагч” болсон бэ?	Оролцогчдын хүний эрхийн сургалтын талаар мэдлэг ямар хэмжээнд нэмэгдсэн бэ?	Хүний эрхийн гэгээрүүлэгчийн практикт ямар хэмжээнд ахиц гарсан бэ?	Ази Номхон Далайн бүс нутаг дахь ХЭҮБ–уудад хүний эрхийн сургалтын практикт ямар хэмжээнд ахиц гарсан бэ?			
Илтгүүрүүд, жишээ нь								
Хүн хүч, цаг хугацааны тоо хэмжээ Хүн хүчний бус өртөг Түншүүд	Оролцогчид, бусад талуудаас ирэх үнэлэлт сэтгэгдэл Оролцогчийн онлайнгаар оролцсон оролцооны хэмжээ Оролцогчийн тавьсан танилцуулгын чанар	Оролцогчдын хамрагдсан байдлын нотолгоо Оролцсон ХЭҮБ–ын тоо Оролцогчдын тоо	Хөтөлбөрийг дүүргэж гэрчилгээ авсан оролцогчдын тоо “АНДЧ–ны Мастер Сургагч багш” болж байгаа оролцогчийн тоо Туршилтын үр дүн	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанд оролцсон тоо бүхий оролцогчийн тайлан Оролцогчийн хариу үнэлэлт сэтгэгдэл	Ахицын талаарх мэдээлэл. ХЭҮБ–ын чадавхийн үнэлгээ. АНДЧ–ны сургалтын хэрэгцээний үнэлгээ			

²⁰⁰ Нэмэлт мэдээллийг дараах холбоосоор: www.asiacificforum.net/support/training/training-of-trainers.

Логик Загвар: Дэмжин холбох

Фемлинк – Фижигийн эмэгтэйчүүдийн хамт олны радиогийн төсөл²⁰¹

СУУРЬ		ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРАЛТ		ҮР ДҮН	
Нөөц	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа	Оролцогчид/Бусад талууд	Богино хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд
Судалгаа Албан хаагчид, олон нийтийн ажилтнууд, зохицуулагчид Сангууд/түншүүд Хөдөлгөөнт радио холбооны нэгж Соронзон хальс тоглуулагч Логистик; аялалын холбоо, семинарын хэрэглэгдэхүүн	Фижигийн хөдөө орон нутгийн иргэдийн дунд явуулсан семинарууд Оролцогч эмэгтэйчүүд: • Туршлага солилцож • холбогдох асуудлуудыг онцлон, Хоорондоо эдгээр зүйлсийн талаар ярилцаж, практик шийдлүүдийг эрэлхийлэн • радио хөтөлбөр бэлтгэдэг Радио дамжуулагчийн тусламжтайгаар, Эмэгтэйчүүд өөрсдийн туршлага болон шийдлийг нутгийн ард иргэддээ нэвтрүүлдэг	Фижигийн хөдөө нутгийн эмэгтэйчүүд Эмэгтэй оролцогчдын гэр бүл Өргөн хүрээтэй эмэгтэй хамт олон	Эмэгтэйчүүдийн өөрсдийнхөө хүний эрх, өөрсдөд тулгарч байгаа хүний эрхийн асуудлууд, боломжит шийдлийн талаарх мэдлэг нь дээшилсэн Эмэгтэйчүүдэд тохиолдож байгаа зүйл болон тэдний эрхийн талаар нутгийн хамт олны мэдлэг ойлголт нэмэгдсэн	Эмэгтэйчүүд энэ мэдлэгээ өдөр тутмын амьдралдаа хэрэглэдэг Гэр бүл/хамт олны гишүүд эмэгтэйчүүдэд хандах хандлагаа өөрчилж байна Эмэгтэйчүүдийн нутгийн хамт олонд оролцох орлоо хамдлага сайжирсан	Хүй олонд суурилсан, хөдөө нутгийн байгууллагууд, нутгийн идэвхтнүүд Эхний 40 оролцогчийг 4 бүлгээс тус бүр 10 хүн байхаар тооцож сургахад чиглэнэ
Үнэлгээний жишээ асуулууд ...					
Ямар хугацаа, нөөц бололцоо зарцуулсан бэ? Оруулсан нөөц зохистой байсан уу?	Хөтөлбөрийн талаарх тусгал ойлголт ямар байсан бэ? Эмэгтэйчүүд семинар, бүлгийн ярилцлагад хэр оролцоотой байв? Шторжууд хэр үр нөлөөтэй байв?	Оролцогчид хөтөлбөр боловсруулахад оролцсон уу? Тийм бол яаж? Хэдэн эмэгтэй оролцсон бэ? Гэр бүл, бусад талуудаас үзүүлсэн дэмжлэгийн түвшин?	Оролцогч эмэгтэйчүүдийн хүний эрхийн талаар мэдлэг ямар хэмжээнд нэмэгдсэн бэ? Гэр бүл/хүй олны мэдлэг ямар хэмжээнд нэмэгдсэн бэ?	Эмэгтэйчүүд өөрсдийн эрхийг ямар хэмжээнд илэрхийлж, шаардаж байна вэ? Үүрэг хүлээгчдийн зан төлөв ямар хэмжээнд сайжирсан бэ?	Тухайн хүй олонд эмэгтэйчүүдэд тохиолдож буй асуудлууд ямар хэмжээнд сайжирсан бэ?
Илтгүүрүүд, жишээ нь					
Хүн хүч, цаг хугацааны тоо хэмжээ Хүн хүчний бус өртөг Түншүүд	Оролцон эмэгтэйчүүд [ийн тоо] Эмэгтэйчүүдээс авсан үнэлэлт сэтгэгдэл Гэр бүл/хүй олноос сонссон хүмүүс [ийн тоо] Тэдгээрээс авсан үнэлэлт сэтгэгдэл	Оролцогчдын хамрагдсан байдлын нотолгоо; Эмэгтэйчүүд/гэр бүл/ хүй олны тоо хэмжээ	Мэдлэг/чадвар нь нэмэгдсэн болох нь илэрч байгаа эмэгтэйчүүд [ийн тоо]. Нэмэлт үр дүн	Зан үйлийн өөрчлөлийн нотолгоо Таагүй харьцаа, ялгаварлан гадуурхалтын хэмжээ буурсан үзүүлэлт	Сайжирсан нотолгоо Эмэгтэйчүүдийн аюулгүй байдал/оролцоо нэмэгдсэн байх

²⁰¹ Зохицуулагч Шарон Баган Роллстой хийсэн ярилцлагаас. Нэмэлт мэдээллийг дараах холбоосоор: www.femlinkracific.org.fj

Логик Загвар: Харилцааны менежмент

Шинэ Зеланд Улсын Хүний эрхийн Комисс – Олон Ялгаат Байдлын Үйл Ажиллагааны Хөтөлбөр²⁰²

СУУРЬ	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРАЛТ				ҮР ДҮН	Урт хугацаанд	
Нөөц	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа	Оролцогчид/Бусад талууд	Богино хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд		
Ажилтнууд; талбарын ажилтнууд, удирдагчид, Судлаачид, харилцаа холбооныхон, менежерүүд, Комиссын гишүүн Сангууд Түншүүд Мэдээлэл, холбооны тенолог	Эвлэн зохицсон арьс, үндэсний харилцааг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулахад байгууллагуудыг дэмжих, үүнд: - сүлжээний мэдээллийн хэрэглэгдэхүүн гаргах - Хувь нэмрээ оруулныг нь үнэлж гэрчилгээ гардуулах - форум, арга хэмжээ зохион байгуулах - оролцогч байгууллагуудын сүлжээ, байгуулж, хөгжүүлэн, нэгтгэх	"Соёлын олон талт ялгаа бүхий, эрх тэгш, харилцан эвтэй Шинэ Зеландын алсын хараатай, түүнд хүрэх бодит алхам хийж буй" Шинэ Зеландын байгууллагууд Бусад талууд: Шинэ Зеландын бүх нийт	Дотооддоо болон хүй олон дундаа арьс үндэсний эерэг харилцаа, арьс үндэсний тэгш байдал, соёлын олон талт байдалд хувь нэмэр оруулах төслүүдийг байгууллагууд хэрэгжүүлнэ	Үр дүнд нь оролцогч байгууллагуудад арьс үндэсний эерэг харилцаа, арьс үндэсний тэгш байдал, соёлын олон талт байдал сайжирна. Шинэ Зеландад арьсны хоорондын харилцааны талаарх мэдлэг ойлголт нэмэгдсэн байна	Шинэ Зеланд дахь арьс угсаатан хоорондын харилцаа сайжирсан		
Үнэлгээний жишээ асуулууд ...							
Ямар хугацаа, нөөц бололцоо зарцуулсан бэ?	Сүлжээний талаарх тусгал ойлголт ямар байсан бэ? Төслийн чанар ямар байв?	Оролцогчид хөтөлбөр боловсруулахад оролцсон уу? Тийм бол яаж?	Байгууллагуудын оролцоо ямар хэмжээнд ихэссэн бэ?	Байгууллага, хүй олон дундах арьс, угсаатан хоорондын харилцаа ямар хэмжээнд сайжирсан бэ?	Шинэ Зеланд дахь арьс угсаатан хоорондын харилцаа ямар хэмжээнд сайжирсан бэ?		
Оруулсан нөөц зохистой байсан уу?	Арга хэмжээнүүдийг хэр сайн дэмжсэн бэ? Дэмжлэгийн чанар ямар байв?	Хэдэн байгууллага оролцсон бэ? Бусад талуудаас үзүүлсэн дэмжлэгийн түвшин ямар байв?	Энэ оролцооноос ямар үр дүн гарсан бэ?	Шинэ Зеландад арьсны хоорондын харилцааны талаарх мэдлэг ойлголт ямар хэмжээнд нэмэгдсэн байна вэ?			
Илтгүүрүүд, жишээ нь							
Хүнхүнд хугацааны тоохэмжээ	Сүлжээнд бүртгэлтэй байгууллага, төслийн тоо Төслүүдийн үр дүн Форумд оролцож буй тоо Семинарын тоо Тогтвортой оролцож байгаа байгууллага Хөтөлбөрийн талаар хариу үнэлэлт сэтгэгдэл	Оролцогчдын тоо. Хариу үйлдэл үзүүлж буй талууд, түүний дотор мөн хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Төсөл хэрэгжүүлж буй байгууллагын өссөн тоо Төслийн үр дүнгийн мэдээ Нэмэлт үр дүн	Зан үйлийн өөрчлөлтийн нотолгоо Арьс үндсээр шалтгаалсан таагүй харьцааны тохиолдлууд Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээ Нутгийн идэвхтнүүдийн үйл ажиллагааны үзүүлэлт	Олон янзын ахиц дэвшил Арьс үндсээр шалтгаалсан таагүй харьцааны тохиолдлууд		
Хүн хүчний бус өртөг Түншүүд							

²⁰² Нэмэлт мэдээллийг дараах холбоосоор: www.hrc.co.nz/race-relations/te-ngira-the-nz-diversity-action-programme.

Логик Загвар: Хүний эрхийн нөлөөллийн ажиллагаа

Австрали Улсын Хүний эрхийн Комисс – Хүний эрхийн Боловсрол, Нөлөөллийн Сертификат²⁰³

СҮҮРЬ	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРЛТ				ҮР ДҮН		
Нөөц	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа	Оролцогчид/Бусад талууд	Богино хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд		
Сангүүд Ажилтнуудын цаг, сургагч багш, дэмжих баг TAFE–ийн дэмжлэг Нутгийн Хүй олны Хөгжлийн Ажилтнуудын (CDWs) ажлын цаг, зохион байгуулалтын дэмжлэг Дижитал техникчийн мэргэжлийн туслалцаа	Бусад талуудын оролцоо, зөвлөлгөө Судалгааны хураангуй Оролцогч элсүүлэх арга хэмжээнүүд Сургалтын материал, тараах материалын багц Сургалтын арга хэмжээнүүд Оролцогчийн дижитал түүхүүд Дижитал тайлан Төслийн тайлан Комиссын цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн дижитал материал	Мусульман эмэгтэйчүүдтэй ажилладаг иргэдэд тулгуурласан байгууллагууд Мусульман эмэгтэйчүүдийн байгууллагууд Мэргэжлийн боловсролын, дээд болон ахисан шатны боловсролын салбар	Нутгийн Хүй олны Хөгжлийн Ажилтнуудын дундах хүний эрхийн мэдлэг ойлголт, хүний эрхийг хүндэтгэн сахиу байдал нэмэгдэнэ Комиссын нутгийн иргэд болон Мусульман байгууллагуудтай харилцах харилцаа нэмэгдэнэ Дижитал мэдээллийн хэрэгслийг хүний эрхийн боловсрол, нөлөөллийн хэрэгсэл боловч хувьд ойлгох байдал нэмэгдэнэ	Нутгийн Хүй олны Хөгжлийн Ажилтнуудын мэдлэг ойлголт, хүний эрхийг хүндэтгэн сахиу байдал нэмэгдэнэ Дижитал мэдээллийн хэрэгслийг хүний эрхийн боловсрол, нөлөөллийн хэрэгсэл боловч хувьд ойлгох байдал нэмэгдэнэ Оролцсон нутгийн иргэд/Мусульманы байгууллагуудын дундах Комиссыг эергээр харах хандлага TAFE болон Нутгийн Хүй олны Хөгжлийн Ажилтнуудыг сургаж буй бусад байгууллагын худалдан авсан сургалтын багц	Тодорхойлон авсан сонсогчдод хүний эрхийн талаарх холбогдох мэдээллийг хүргэх үр нөлөөтэй арга зам Хүний эрхийн зөрчилд өртөх эрсдэлтэй болон зөрчилд өртөж буй хүмүүсийн хариу арга хэмжээ авах чадавх нэмэгдэнэ TAFE болон насанд хүрэгчдийн боловсролын салбар дахь гол оролцогч талуудтай шинэ харилцаа үүссэн байна Нутгийн иргэдийн хөгжил болон хүний эрх, бусад сургалтын хэрэгцээ шаардлагын хоорондын холбоог Комисс ойлгож авна		
Үнэлгээний жишээ асуулууд ...							
Хөтөлбөрийг хүргэхэд ямар нөөц ашигласан бэ? Ямар арга хэмжээ авсан бэ?	Хөтөлбөрийг хэр сайн хэрэгжүүлсэн бэ? Бусад талуудын оролцоо иргэдэд суурилсан байв уу, үүнд харилцан уялдаатай хамтын ажиллагааны чиглэл байсан уу? Бид насанд хүрэгчдийн сургалтын оролцооны арга зүйг хөгжүүлэх зэргээр Комиссын төсөлд хүний эрхэд суурилсан хандлагын загварыг хэр үр нөлөөтэй гаргасан бэ?	Хөтөлбөрийг хэр сайн хэрэгжүүлсэн бэ? Сургалтыг боловсруулан төлөвлөх, бусад талуудыг оролцуулахад хүний эрхэд суурилсан хандлагыг хэр хэмжээнд ашигласан бэ?	Хөтөлбөр ямар өөрчлөлт авчрав? Хөтөлбөр оролцогчдын хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг ямар хэмжээнд нэмэгдүүлсэн бэ? Хүний эрхийн нөлөөллийнх үү? Дижитал мэдээллийн хэрэгслийнх үү?	Хөтөлбөр ямар өөрчлөлт авчрав? Сургалт Нутгийн Хүй олны Хөгжлийн Ажилтнуудын болон тэдний байгууллагуудын хүний эрхийн нөлөөллийн арга барилыг ажилдаа ашиглан явуулах чадавхийг ямар хэмжээнд нэмэгдүүлсэн бэ?	Хөтөлбөр ямар өөрчлөлт авчрав? Туршилтын төслөөс цааш хэр тогтвортой үр дүнтэй байна вэ? Сургалтыг бусад нутгийн иргэд, байгууллагуудад хүргэж болох боломж хэр байна вэ?		

²⁰³ Нэмэлт мэдээллийг дараах холбоосоор: www.humanrights.gov.au/publications/community-partnerships-human-rights-what-projects-are-we-doing.

Илтгүүрүүд, жишээ нь				
Цагтаа болон төсөвт багтаасан байх	Элсүүлэх арга хэмжээний тоо	Оролцох ажилтнуудыг дэмжих зорилтод байгууллагын тоо	Дижитал болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийг нөлөөллийн зорилгоор ашиглах хэрэглээ нэмэгдсэн байх	Мусульманы хамт олны байгууллагуудын зүгээс бүхнийг өргөн хүрээтэй төслийн талаарх сэтгэл ханамж/хариу үнэлэлт сэтгэгдэл
	Сургалтын арга хэмжээний тоо	Оролцох ажилтнуудыг дэмжих зорилтод Мусульман байгууллагын тоо	Нутгийн Хүй олны Хөгжлийн Ажилтнууд нутгийн хамт олоны гишүүдийг ялгаварлан гадуурхалтын болон хүний эрхийн зөрчлийн талаарх гомдлоо Комисст гаргахад нь тусалж чаддаг байх	Зорилтод хамт олонтой харилцаа сайжирч, жижиг хэмжээний, өсөн гарч ирж буй Мусльманы эмэгтэйчүүдийн хамт олны байгууллагууд бүхий шинэ сүлжээнүүдэд хүрэх Комиссын хүрээ тэлсэн байна
Цагтаа болон төсөвт багтаасан байх	Оролцогчийн дижитал мэдээллийн хэрэгслийн объектийн тоо	Сургалтыг сонирхсон мусуьман оролцогчийн тоо	Оролцогчдын нутгийн олонтой харилцах болон ажиллахдаа хүний эрхийн асуудлаар болон хүний эрхийн төлөө идэвхтэй ажиллахад нь үзүүлсэн эерэг нөлөө	Игэдэд суурилсан байгууллагуудын хүний эрхийг хамрах үйл явц, бодлого өөрчлөгдсөн байна
	Сургалтынхаа зорилго, зорилтод нийцсэн тогтвортой, зөвөөрлөн түгээх боломжтой хүний эрхийн боловсролын болон нөлөөллийн өндөр чанартай сургалтыг боловсруулсан байх	Сургалтыг сонирхсон Мусульман оюутан/байгууллагын тоо	Сургалтын бүх бүрэлдэхүүн, даалгаварыг дуусгасан оролцогчийн эзлэх хувь хэмжээ.	Хүний эрхийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдснээр тодорхойлсон хэсгийн үйл ажиллагааг хөгжүүлэн дэмжинэ
Цагтаа болон төсөвт багтаасан байх	Дижитал болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийг сургалтын болон нөлөөтэй арга хэрэгсэл болгон ашигладаг байх	Сургалтын бүх бүрэлдэхүүн, даалгаварыг дуусгасан оролцогчийн эзлэх хувь хэмжээ.	Оролцогчид болон менежерүүд сургалтын талаар сэтгэл ханамжтай байх	Бусад талуудын хүний эрхийн боловсрол, нөлөөллийн сургалтыг өөр өөр хамт олон, TAFE-ийн хүрээнд авахыг хүссэн сонирхол
	Дижитал болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийг сургалтын болон нөлөөтэй арга хэрэгсэл болгон ашигладаг байх	Сургалтын бүх бүрэлдэхүүн, даалгаварыг дуусгасан оролцогчийн эзлэх хувь хэмжээ.	Оролцогчид болон менежерүүд сургалтын талаар сэтгэл ханамжтай байх	Дижитал түүхүүдийг боловсролын болон нөлөөллийн арга хэрэгслээр үргэлжлүүлэн ашиглана

Логик Загвар: Хүй олны хөгжил

Филиппинийн Хүний эрхийн Комисс – Нутгийн уугуул хүмүүсийн төсөл²⁰⁴

СУУРЬ	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГАРАЛТ			ҮР ДҮН	
Нөөц	Хүний эрхийн боловсролын үйл ажиллагаа	Оролцогчид/Бусад талууд	Богино хугацаанд	Дунд хугацаанд	Урт хугацаанд
Ажилтнууд; талбарын ажилтнууд, удирдагчид, Судлаачид, төслийн зохицуулагчид, Комиссын гишүүн Сангууд Логистик; Аялалын харилцаа холбоо Хурал уулзалтын хэрэглэгдэхүүн Оролцогчдын аялал гэх мэт	Гурван жил хэрэгжих хүний эрхийн иргэний хөгжлийн төсөлд: ● чөлөөт, урь даас мэдээлэл бүхий зөвшөөрөл авсны үндсэн дээр нутгийн уугуул түншүүдийг тодорхойлно ● ФХЭК–оос тохиромжтой багийг сонгон тодорхойлно ● Нүүр тулсан харилцаагаар холбоо тогтооно ● Олон төрлийн арга барилын тусламжтайгаар, мөн нутгийн уугуул хүмүүсийг чиглэл–заагч болгож төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх дэлгэрэнгүй хөтөлбөр	Нутгийн уугуул хүмүүс; Канкана а–эй (Кибунганы); Хигаонон (Агусан дель Сур, Эсперанзагийн); Сама Дипаут (Басилиан, Жоло, Сулу, Замбоангагийн) Төрийн байгууллагууд; орон нутгийн болон үндэсний Иргэний нийгмийн байгууллагууд; орон нутгийн болон үндэсний Олон улсын түншүүд бусад талууд	Зорилтот гурван нутгийн уугуул хамт олны хүний эрхийн тухай мэдлэг ойлголт болон хүний эрхийг шийдвэрлэхэд хэрхэн арга хэрэгсэл болж болох тухай мэдлэг нэмэгдэнэ Цагдаа, цэрэг, бусад төрийн бусад төрийн байгууллагуудын хүний эрхийн тухай ойлголт нэмэгдэнэ	Зорилтот гурван нутгийн уугуул хамт олон хүний эрхийн зөрчлийг тодорхойлж, баталгаажуулан, баримтжуулан, хянаж чаддаг болно Тодорхойлсон хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэх практик, бодитой алхамуудыг багтаасан иргэдэд суурилсан төслүүдийг эхлүүлнэ Цагдаа, цэрэг, бусад төрийн байгууллагууд өөрийн практик үйл ажиллагаанд хүний эрхийг тусгаж сурах бөгөөд түүндээ тохирсон стратеги төлөвлөж хэрэгжүүлнэ	Иргэдэд суурилсан төслүүд төлөвлөсөн үр дүндээ хүрсэн байна Цагдаа, цэрэг, бусад төрийн байгууллагууд хүний эрхийн үүрэг хариуцлагаа харуулсан санаачлагуудыг гаргаж хэрэгжүүлсэн байна ФХЭК–ын хүний эрхийн хамт олны хөгжлийн хөтөлбөрүүдээ зохион байгуулах чадавх нэмэгдсэн байна.
Үнэлгээний жишээ асуулууд ...					
Ямар хугацаа, нөөц бололцоо зарцуулсан бэ? Оруулсан нөөц зохистой байсан уу?	Иргэд хамт олон, төрийн байгууллага, иргэний нийгмийн оролцооны шинж чанар ямар байсан бэ? Төслүүдийн чанар, оролцогчдын гаргасан асуудлуудын хариуцах эзэн, стратегийн чанар, хуваарилсан нөөц, тайлагнасан үр дүн ямар байсан бэ? Талбар ажиллагааны багууд хэр зэрэг ажиллассан бэ? Хамт олны хөгжлийн үйл явцын чанар ямар байв?	Оролцогчид/бусад талуудыг хөтөлбөр боловсруулахад оролцуулсан уу? Тийм бол яаж? Жөндөр болон нас насны төлөөллийг хамруулж оролцуулсан уу? Хэдэн байгууллага оролцсон бэ? Бусад талуудаас дэмжлэг?	Хамт олны дунд хүний эрхийн мэдлэг ойлголт ямар хэмжээнд нэмэгдсэн бэ? Бусад талуудын дундах хүний эрхийн мэдлэг ойлголт ямар хэмжээнд нэмэгдсэн бэ ? ?	Иргэд, хамт олны төсөл хэр бодит байсан бэ? Тэдгээрийг боловсруулахад хан оролцсон бэ? Цагдаа, цэрэг, бусад төрийн байгууллага хүний эрхийн практикийг ашиглахдаа хэр эрмэлзэлтэй, чадамжтай байсан бэ?	Тухайн хамт олон хүний эрхийн асуудлуудыг ямар хэмжээнд тодорхойлсон бэ? Яаж? Цагдаа, цэрэг, бусад төрийн байгууллага зан үйлээ ямар хэмжээнд өөрчилсөн бэ? Яаж?

²⁰⁴ Энэ төслийн бодит үрд дүнгийн талаарх тойм зэрэг нэмэлт мэдээллийг дараах холбоосоор: www.hrc.co.nz/wp-content/uploads/2011/03/HRC_Building_Human_Rights_Communities_Web.pdf.

Илтгүүрүүд, жишээ нь					
Хүнхү-цаг хугацааны тоо хэмжээ Хүн хүчний бус өртөг Түншүүд	Хамрагдсан оролцогч/бусад талын тоо Оролцооны шинж/чанар Үйл явц, үр дүнгийн шинжилгээ	Оролцогчдын тоо Оролцогчдын хувийн мэдээлэл. Оролцсон төрийн байгууллагуудын тоо	Нутгийн хамт олны дунд хүний эрхйн үйл ажиллагаанд оролцсон нутгийн уугуул ард түмний тоо Төслүүдийн үр дүнгийн тайлан Бусад үр дүн	Мониторингийн үйл ажиллагаа Оролцогчдын тоо, олон ялгаат байдал; Эмэгтэйчүүд, залуучуудын оролцоо Орон нутгийн болон төвийн засаг захиргааны санаачлагууд	Иргэдэд суурилсан тогтвортой төслийн үр дүнгийн жишээ Цагдаа, цэрэг, бусад төрийн шинжтэй үүрэг хүлээгчийн санаачлагын жишээ Орон нутгийн идэвхтний ажиллагааны нотолгоо

Хавсралт 2:
Хүний эрхийн боловсролын зохистой аргыг сонгох нь

Аргачлал	Үйл ажиллагаа		Тайлбар
	Доор дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй		
Мэдээлэл солилцох	Хүний эрхийн талаар мэдээлэл өгөх		Хүний тоо хязгаарлагдахгүй
		Хүртээмж	“Мэдээлэгч”. Зорилтот бүлэгт хамгийн сайн хүрч болох аргаар хүний эрхийн талаарх мэдээллийг хүргэх
		Хугацаа	Өөрийн хяналтын доор. Оролцогчдын цаг шахуу, эсвэл тэд өөрсдийн боломжтой цагт мэдээлэл авах хүсэлтэй үед их үр дүнтэй.
		Агуулга/үйл явц	Бичмэл болон хэлсэн үг дээр ихэвчлэн тулууралдаг. Харилцан яриа өрнүүлэх боломж бага.
		Хүрэх үр дүн	Хүмүүст хүний эрхийн талаарх мэдээлэл хүрсэн байна. ХЭҮБ–ууд улс орон/орон нутгийн хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээлэлтэй болсон байна.
Сургалт	Хүний эрхийн мэдлэг, чадварыг өгөх	Хүртээмж	Хамрагдах хүрээ бага бөгөөд нэг удаагийн үйл ажиллагаагаар 1–20 хүн хамруулах боломжтой байдаг
		Сургагч багшийн үүрэг	“Сургагч/багш”. Сургагч багшийн бэлтгэсэн арга, аргачлал, эх сурвалж болон туршлага дээр тулгуурлан явуулах.
		Хугацаа	Тодорхой зорилт, үр дүнд хүрэхээр тооцоолон гаргасан тодорхой хугацаа байдаг. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд цагийг тодорхой заасан байдаг.
		Агуулга/үйл явц	Агуулгыг голлох. Хүний эрхийн мэдлэг, чадвар, мэргэшил зэргийг хамардаг.
		Хүрэх үр дүн	Хүний эрхийн талаар авсан мэдээлэлээ бататгах, хүний эрхэд “ээлтэй” үйлдлийг хийхийг үзүүлнэ.


Чиглүүлэг	Хүний эрхийн нөхцөл байдал сайжруулах үйлдэл хийхэд бусдад чиглүүлэх, бэхжүүлэх	Бүлэг хүмүүстэй ажиллаж, тэдгээрт тулгарч буй хүний эрхийн асуудал тодорхойлох, асуудлаа гаргаж тавихад дэмжлэг үзүүлж, зориг өгөх. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах олон арга, аргачлал байдаг, жишээ нь: 1) Залуучуудын дунд үйл ажиллагаагаа урлагийн үзэсгэлэн, тоглолт, бичлэгээр хүний эрхийн тухай ойлголт, мэдлэг түгээх хүсэлтэй залуучуудтай хамтран ажиллах 2) Орон гэрээр хантагдах асуудлаар гудамжны санал асуулга авах замаар гишүүдийнх нь үзэл бодлыг өдөөн гаргахад хамт олонд дэмжлэг үзүүлэх.	Хүртээмж	Ер нь үйл ажиллагаа тус бүр нь бага тооны хүн хамруулах бөгөөд тухайн бүлгийн болон бүлгийн ахлагчийн сурч, боловсорсон байдлаас хамааран олон тооны хүнийг хамруулах боломжтой юм.
			Сургагч багшийн үүрэг	“Чиглүүлэгч”. Энэ хэсэг нь багш дээр тулгуурлах нь бага бөгөөд багшийн гол үүрэг нь хүний эрхийн зарчмуудыг баримтлан хэрхэн зорилгодоо хүрэх тал дээр чиглүүлэхэд оршино.
			Хугацаа	Цаг хугацааны хязгаар тавилгүй, тавьсан зорилгодоо хүртэл оролцогчдоос ирэх санал хүсэлтийг үндэслэн нь илүү бодит байх болно. Гэсэн хэдий ч тодорхой цаг хугацааг мөх зааж болох юм.
			Агуулга/үйл явц	Хүний эрхийн агуулга дээр суурилан, үйл явцыг голлох.
			Хүрэх үр дүн	Оролцогчид нь тэдгээрт болон бусдад тулгарч буй хүний эрхийн зөрчлийг тодорхойлж, асуудлаа гаргаж чаддаг байх болно.
Харилцааны менежмент	Хүний эрхийн үр дүнд хамтран хүрэх хүмүүстэй хамтран ажиллах	Сүлжээ үүсгэ, Мэдээллийн хуудас, Дугуйн ширээний уулзалт, эрдэм шинжилгээний байгууллагууд, гүйцэтгэгч бүлэг	Хүртээмж	Хүний тоо хязгаарлагдахгүй байх боломжтой
			Сургагч багшийн үүрэг	“Сүлжээний зохицуулагч”. Хүний эрхийн асуудлууд тодорхойлж, мөн хоорондын харилцаа болон үйл ажиллагаанд зуучлан, тухайн бүлгээс асуудал дээр ажиллах чадвартай хүмүүстэй сүлжээ үүсгэнэ. Сургагч багш нь тухайн төслийг удирдах шаардлага гарч болзошгүй.
			Хугацаа	Янз бүр байх бөгөөд заавал цаг хугацаанд шахагдан ажиллах шаардлагагүй. Ер нь бол оролцогчид хоорондоо зөвшилцөн цаг, хугацаагаа тодорхойлж явдаг.
			Агуулга/үйл явц	Ихэвчлэн нэг асуудал дээр төвлөрөн ажилладаг бөгөөд уг асуудал нь өргөн хүрээний байж болдог. Энэ арга нь хүмүүс хоорондоо харилцан тохиролцон үр дүнтэй ажиллаж оролцуулах тал дээр ач холбогдол их өгнө.
			Хүрэх үр дүн	Хүмүүс, бүлгүүд болон салбарын хүмүүстэй бодит ба үр дүнд суурилсан нөхөрлөлийг бий болгож тодорхойлсон хүний эрхийн асуудал/нөхцөл байдалд нөлөөлсөн байх.

Хүний эрхийн сурталчилгаа	Хүртээмж	Ганцаарчилсан болон хязгааргүй тооны хүн
Хүний эрхийн үүрэг, үнэ цэнийг сурталчлах	Сургагч багшийн үүрэг	“Хамгаалагч”. Хамгийн эмзэг хэсгийн эрхийг хөхиүлэн дэмжихэд багш дэмжлэг үзүүлнэ. Мөн хүний эрхийн боловсролоор дамжуулан хүний эрхийн зорилгуудад хүрэх үйл ажиллагааг дэмжинэ. Багш нь мөн л тодорхой төслийн зохицуулагч болох шаардлага гарч магадгүй.
	Хугацаа	Хэлбэлзэх бөгөөд тодорхой хугацаанд шахаж хийж болно. Оролцогчид хоорондоо зөвшилцөн цаг, хугацаагаа тодорхойлж, тавьсан зорилгод хүрсэн эсэхээ шийдэх боломжтой.
	Агуулга/үйл явц	Нэг асуудлаар дагнах ба агуулга нь өндөр ач холбогдолтой. Гүйцэтгэх ажлын үйл явц нь үр дүнтэй байх шаардлагатай.
	Хүрэх үр дүн	Хамгийн эмзэг бүлэгт хамрагдаж буй хүмүүсийн эрхийг дээшлүүлэхэд бүтцийн болон тогтвортой үргэлжлэх өөрчлөлтүүд хийсэн байна.
	Хүртээмж	Цөөн тооны бүлэг болон их хэмжээний хүн хамрах боломжтой.
Нийгмийн бүлгүүдийн хөгжил	Сургагч багшийн үүрэг	Олон талт үүрэг, чадавх шаарддаг: мэдээлэгч, сургагч, багш, сүлжээний зохицуулагч, хамгаалагч зэрэг. Мөн төслийн, нөөцийн зохицуулагч байх шаардлагатай бөгөөд удирдах чадвар хөгжүүлсэн байх шаардлагатай.
	Хугацаа	Их хугацаа шаардагддаг. Оролцогчид хоорондоо зөвшилцөн цаг, хугацаагаа тодорхойлж, тавьсан зорилгод хүрсэн эсэхээ шийдэх боломжтой.
	Агуулга/үйл явц	Агуулга болон үйл явцад ач холбогдол өгнө.
	Хүрэх үр дүн	Тухайн нийгмийн бүлгийн хүний эрхийн зөрчлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийж, асуудлаа гаргаж тавьж, шийдвэрлэлтэд хяналт тавьж улмаар тухайн бүлгийн хүний эрхийн тэргүүлэх чиглэлийг гаргаж ирснээр бие даах чадвартай, харилцан хүнлэтгэсэн нийгмийн бүлгийг бий болгоно

Хавсралт 3

Зорилтоо бичих нь

Блумын Хүрдээр суралцах мужийг үйл үгс болон хологдох үйл ажиллагаатай холбодог. Үйл үгс нь тохируулж, хэмжиж болохуйц байхаар оруулсан.²⁰⁵



²⁰⁵ Бенжамин Блумын 1956 оны *Taxonomy of Educational Objectives: the Classification of Educational Goals; Handbook I: Cognitive Domain*, номоос авав.

Хавсралт: 4

Логик Загвар хяналтын хуудас

Логик загвар		Тийм	Үгүй
НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ: Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай мэдээлэл олж авах хүний эрхийн нөхцөл байдлын үнэлгээ.			
Та мэдэх үү ...			
1	Нөхцөл байдалд хүний эрхийн тэргүүлэх чиглэлүүд?		
2	Тухайн хам сэдэвт нөлөөлөх гадаад хүчин зүйлс?		
3	Хүний эрхийн асуудалаар ямар гол үйл ажиллагааг анхаарах ёстой вэ?		
4	Оролцож байгаа хүмүүс (тухайн үйл ажиллагаанд хэн оролцох вэ)?		
5	Оролцогч бүлгийн шинжүүд; үүрэг роль, туршлага, өмнөх мэдлэг, болзошгүй саад буюу хязгаарлалт, оруулах нэмэр тус?		
6	Оролцогч бүлгийн хүлээлт, хэрэгцээ, давуу тал?		
7	Тухайн асуудал, оролцогчидтой хамгийн их холбогдолтой байж болох хүний эрхийн үйл ажиллагааны төрөл?		
8	Холбогдох талууд (хүний эрхийн асуудалд эсвэл чиглэл сонирхолтой хүн) гэж хэн бэ?		
9	Холбогдох талуудын бүлгийн хүлээлт, хэрэгцээ, давуу тал?		
10	Бусад талууд? Хүний эрхийн энэ асуудлыг шийдвэрлэхэд өөр хэн оролцох вэ?		
11	Түншийн хувьд ашигтай хамтран ажиллаж болох хүн хэн байна вэ?		
СУУРЬ ОРОЛТ: Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулж, үнэлэхэд шаардлагатай нөөц			
Та шаардагдах нөөцийг тодорхойлсон уу?			
12	Хүний нөөц бололцоо – хэн оролцох вэ?		
	• хүний эрхийн боловсрол эрхлэгч?		
	• администраторууд?		
	• харилцаа холбооны хүмүүс?		
	• түншүүд?		
	• Бусад мэргэжилтэн ?		
	• бусад?		

13	Санхүүгийн нөөц		
14	Орчуулагч зэрэг дэмжлэг олгох тогтолцоо		
15	Судалгаа болон мэдээлэл		
16	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдалд зориулсан материал, тоног төхөөрөмж, арга хэрэгсэл.		
17	Шаардлагатай болон боломжит цаг хугацаа		
18	Орчны шаардлага, хүртээмжтэй газар, хүүхдийн асаргаа, сэргээх боломжууд, ажлын орон зай, бусад.		
19	Харилцаа холбооны нөөц		
Үйл ажиллагааны гаралт: Зохион байгуулах хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны төрөл, хамрагдах оролцогчид болон холбогдох талууд			
Үйл ажиллагааны хэв загварт дараах зүйлс орох эсэх ...			
20	SMART зорилго?		
	• Тодорхой?		
	• Хэмжиж болохуйц?		
	• Хийж болох?		
	• Холбогдолтой ?		
	• Цаг хугацааны хүрээтэй?		
21	Холбогдол бүхий агууллага		
22	Зохимжтой бүтэц		
23	Зохион байгуулах газар болон орчны төсөөлөл		
24	Логистикийн төлөвлөгөө		
25	Харилцаа холбооны төлөвлөгөө		
26	Хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө		
27	Оролцогч бүлэг үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулалтыг загварлахад оролцсон уу?		
28	Үйл ажиллагаа нь оролцогчдын хэрэгцээ, давуу талд анхаарч байна уу?		
ҮР ДҮН: Хяналт, үнэлгээ хийх хүний эрхийн боловсролын үйл ажиллагаанаас хүлээж буй үр дүн			
29	Үр дүн нь SMART байна уу?		
30	Амжилтыг хэмжихдээ тоон болон чанарын илтгүүр ашигладаг уу?		

Хавсралт 5

Үр дүнтэй дэмжлэг үзүүлэх ур чадвар^{206[1]}

Хүний эрхийн боловсрол, сургалтын эцсийн зорилго бол хувь хүн болон байгууллагын түвшинд өөрчлөлт хийхэд оршдог.

Тиймээс хүмүүсийн бодож, сэтгэх, шийдвэр гаргах, үйлдэх зэрэгт бодит болон тогтвортой өөрчлөлт хийх чиглэл олох хэрэгтэй юм. Энэ нь оролцогчид өөрсдөө сурах үйл явцын цөмд орсноор өөрчлөгдөх боломжтой байдаг.

Оролцоон дээр тулгуурласан сургалтын орчинд орсноор **оролцогч** нь:

- Сурах үйл явцад идэвхтэй оролцохоос гадна өөрсдийн сурах үйл явцад өөрсдөө хариуцлагатай хандана
- Өөрсдийн мэдлэг, туршлагаасаа бусадтайгаа хуваалцан хамтран суралцаж буй хүмүүсийн хамт бүлгийн мэдлэг бий болгоход хувь нэмэр оруулдаг байна.

Чиглүүлэгч нь энэхүү үйл явцыг дараах байдлаар дэмжинэ:

- Харилцан бие биенээ хүндэлсэн, үр дүнтэй сургалтын орчин бий болгох
- Оролцогч хоорондын харилцаа болон хэлэлцүүлгийг хөхиүлэн дэмжиж “мэдлэгийн дамжуулагч”-ийг үүргийг гүйцэтгэхээс илүүтэй “мэдлэгийн чиглүүлэгч”-ээр ажиллана.
- Оролцогч нарт сурах боломж олгох мөн хариуцлагыг өөрсдөд нь ноогдуулах.

Үр дүнтэй сургалтын орчин бий болгох

1. Итгэлцэл, эерэг хандлагын загвар бий болгох

Сайн чиглүүлэгчийн гол даалгавар бол оролцогч бүр өөрийн бодол санаа, асуулт, итгэл үнэмшил, хандлагаа бусадтай хуваалцах таатай, урамтай, найрсаг, аюулгүй орчин бий болгох юм. Тиймээс чиглүүлэгч харилцан хүндэтгэсэн, эерэг орчин бүрдүүлэхэд дараах зүйлс дээр анхаарна:

- Сургалтын турш хэлж, ярьсан зүйлсийг чандлан хадгалах талаар оролцогчид нарт ойлгуулах
- Оролцогч нарт оновчтой, дэмжсэн санал хүргэх
- Харилцааны өндөр чадварыг харуулах
- Сургалтын турш тайван, тэвчээртэй болон оролцоо хангаж байх
- Оролцогчдоос ирж буй саналыг хүлээн авч, нэгтгэх

2. Ач холбогдолтой сурах үйл явцыг чиглүүлэх

Оролцогч нар үйлдлээрээ суралцан. Чиглүүлэгч оролцогч нарын суралцах үйл явцад тэдгээрийн шинэ мэдлэг, ур чадвар, зан үйл болон хандлагыг хөгжүүлэхэд анхаарах зүйлс:

- Шинэ материал болон ойлголтыг ойлгож болохуйц, харилцан холбоотой үе шаттайгаар олгох бөгөөд танилцуулж буй мэдээлэл нь тодорхой, хялбар хэл зүй ашиглан, тогтмол хянаж шинэчлэж байх
- Сургах олон төрлийн стратеги, үйл ажиллагаа явуулан, оролцогч нарын бүх талын мэдрэхүй ажиллуулна(хараа, сонсгол, орчин тойрныг хүлээн авч буй байдал зэргийг ажиллуулна)
- Оролцогч нарт сургалтын материал олгох ба энэ нь тэдгээрт ча холбогдолтой ба амьдралд хэрэглэж болохуйц байна

²⁰⁶ [1] “Үр дүнтэй дэмжлэг үзүүлэх ур чадвар: 9 дүгээр эх сурвалжийн хуудас” – АНДЧ-ын Сургагч багш нарын 2012 оны сургалтаас

- Оролцогч нарын суралцсан бодит үр дүнг харах болон үзүүлэх боломжийг олгох
- Оролцогч бүр мэдлэгээ бэхжүүлэх болон ажил хэрэгч санал буцааж өгөх

3. Төлөвлөж буй сургалтын агуулгыг баримтлах

Сурах үйл явц нь хамтын ажил байх ёстой, тиймээс боловсролын болон сургалтын хөтөлбөр нь суралцах шаардлагыг хангаж буй бүхий л мэдээлэл, асуудлыг багтаах ба хуваарийн дагуу явагдан.

Чиглүүлэгч:

- Сургалт тус бүрийн эхэнд болон төгсгөлд товч агуулга, дүгнэлттэй явуулах. Гол санааг ахин дурдах нь сургалтын явцад аливаа сэдвийг орхиж, мартаагүйг нягтлан шалгах юм
- Сургалтын сэдвүүдийн хоорондох уялдааг хангаж, логик дэс дараалал байгааг оролцогч нар олж харж чадахуйц байдлаар сургалтыг зохион байгуулах
- Оролцогчдын зүгээс гаргасан сэдвүүдийг флип чарт болон самбар дээр бичиж, тэмдэглэх. Сургалтын эцэст цаг үлдвэл, эсвэл завсарлагааны үед уг сэдвийн дагуу ярилцаж, асуулт тавих талаар санал болгох

4. Оролцоогүй оролцогч нартай хэрхэн ажиллах талаар бодлоготой байх

Хэдийгээр дийлэнх оролцогч нар сурах сонирхолтой байх боловч, цөөн тооны хэд нь эсэргүүцэж, зарим нь хичээл тасалдуулж үймүүлэх, мөн зарим оролцогч нар таны чиглүүлэх чадварыг сорин үзэх гэсэн байр суурьтай байж болзошгүй байдаг. Тиймээс иймэрхүү байдалд сургалтын эрч хүч бууруулахгүй үүднээс хэрхэн яаж ажиллах талаар бодлого боловсруулсан байх шаардлагатай.

- Хичээлийн турш мөрдөх “үндсэн дүрмүүдийг” оролцогчдын хамт гаргах ба бүгдэд нь харагдахуйц газар байрлуулах боломжтой. Мөн дүрэм зөрчсөн этгээдүүдэд хариулцгаа тооцохоос та бүү эмээгээрэй.
- Хичээлийг саатуулаад байгаа оролцогчдыг сургалтын үйл явцад оролцуулах аргыг бодож олох, жишээ нь бүлгээр ажиллуулах ба тэдгээрийг бүлгийн ахлагч, илтгэгчээр томилох зэрэг.
- Шаардлагатай тохиолдолд саад учруулж буй оролцогчтой завсарлагааны үеэр нүүр тулан уулзаж асуудлаа тодорхойлж, боломжит шийдвэрийг олох.

Үр дүнтэй сурган хүмүүжүүлэгч болон багшийн шинж чанарууд^{207[2]}

Асуудлын талаар мэдлэгтэй байх	“Биен хэл” ашиглах
Оролцогчдыг танихад цаг зарцуулах	Ойлгомжтой болон тогтооход хялбар аргаар гол санааг өгөх
Шүүмжлэхгүй байх	Гол санаагаа жишээн дээр үзүүлэх
Үзэл бодлын болон амьдралын сонголтын ялгаатай байдлыг хүндлэх	Сургалтад хамрагдаж буй бүлгийн хэмнэлийг мэдрэх болон бүлгүүдийг удирдах чадвартай байх
Соёлын ялгаатай байдалд мэдрэмжтэй байх	Уян хатан байх
Өөрийгөө мэдрэх	Аливаа шинэ санаа, өөр байр суурь хүлээж авах чадвартай байх
Оролцоог хангах	Энэрэнгүй байх
Цог золбоотой, санаачлагатай, өвөрмөц байх	Санал хүсэлтийг хүлээн авах
Хоолойн ялгаатай өнгө аясыг ашиглах	Өөрсдийн сургах ажлыг тогтмол сайжруулах

²⁰⁷ [2] Training Works!; Jhpiingo; 2003 болон The Trainer's Handbook; Karen Lawson; 1998 номуудаас авсан болно

Хавсралт 6:

Сурах хэлбэр буюу туршлагын 4 ангилал^{208[3]}

Үйлдэгч

Сурах үйл явцад идэвхтэй оролцох дуртай байдаг ба сурсан зүйлсээ амьдрал дээр хэрхэн хэрэгжүүлж болох талаар мэдэхийг хүсдэг. Товч ба тодорхой мэдээлэлд дуртай.

Мэдрэгч

Хүмүүс рүү чиглэсэн, өөрийгөө илэрхийлэх, мэдрэмж болон сэтгэл хөдлөлд ач холбогдол өгдөг хүмүүс бөгөөд нээлттэй, тодорхой бүтэцгүй сурах орчинд амжилт гаргадаг.


Сэтгэгч

Логик болон шалтгаан дээр тулгуурлана, санаа, бодоо бусадтай хуваалцах, дүн шинжилгээ, үнэлгээ хийх дуртай ба бие даан ажиллах дуртай.

Ажиглагч

Үзэж, сонсох дуртай, бусдад нээлттэй байхыг хичээдэггүй бөгөөд болгоомжтой тул урьдчилан бэлтгэл хангана. Аливаа зүйлийг шинээр нээн суралцах нь илүү үр дүнтэй байдаг.

Сургах аргууд болон сурах төрлүүд



²⁰⁸ [3] The Trainer's Handbook; Karen Lawson; 1998 номоос авсан болно

Хавсралт 7:

Бодож, сэтгэх 4 төрөл²⁰⁹

	Тодорхой Дэс дараалалтай		
Тодорхой Санамсаргүй	ТОДОРХОЙ	ДЭС ДАРААЛАЛТАЙ	Дэс дараалалтай хийсвэр
	САНАМСАРГҮЙ	ХИЙСВЭР	
	Санамсаргүй хийсвэр		

Тодорхой дэс дараалалтайг аргаар бодох нь

- Бодит амьдрал дээр тулгуурлан
- Бодит мэдрэмж үүнд, хараа, хүрч, тэмтрэх, авиа, амт болон үнэр
- Жижиг зүйлс анзаарч, баримтуудыг тогтооно
- Суралцахад практикт суурилуулна
- Байгууллагын чадвар дээр суурилна

Тодорхой санамсаргүй аргаар бодох нь

- Туршилтууд, бусдаа ялгаатай бодож, сэтгэх
- “Туршилтын болон алдаатай” аргыг ашиглах сонирхолтой
- Аливаа зүйлийг өөрийнхөөрөө хийхийг эрмэлздэг
- Асуудлыг шийдвэрлэх аргаар юм сурдаг
- Өөртөө хугацаа зааж ажилладаг

Санамсаргүй хийсвэр аргаар бодох нь

- Мэдрэмж болон сэтгэл хөдлөлийг ашигладаг
- Санаа бодол, мэдээлэл болон сэтгэгдлийг өөртөө шингээж өөрт нь хэрхэн яаж тусаж буйгаар ойлголтоо цэгцэлдэг
- Аливаа мэдээлэл нь бодит хүнээр авсан байвал илүү сайн ойлгодог
- Бусадтай хамтран ажиллах чадвартай
- Дүрс мэдээлэл илүүтэй ашигладаг

Дэс дараалалтай хийсвэр аргаар бодох нь

- Үндсэн санааны талаар бодож, авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх дуртай
- Агуу философичид болон эрдэм шинжилгээний судлаачид байдаг
- Гол санаанууд дээр анхаарлаа төвөггүй төвлөрүүлж чаддаг
- Ганцаардчлан суралцах нь хагийн үр дүнтэй байдаг
- Сургалтын үйл явц нь логик дэс дараалалтай, зүй зохистой болон оюун ухаан ажиллуулж байвал хамгийн тохиромжтой

²⁰⁹ Энтони Грегорч болон Кейтлин Батлер нар хөгжүүлсэн ба дэлгэрэнгүй мэдээллийг http://en.wikipedia.org/wiki/Anthony_Gregorc холбоосоор авна уу

Хавсралт 8:

Өөрийгөө болон бусдыг үнэлэх, мөн гаднаас үнэлгээ хийх

Төрөл	Тайлбар	Давуу тал	Сөрөг тал
Өөрийгөө үнэлэх	Хүний эрхийн сургагч багш, сургагч багш нарын бүлэг болон ХЭҮБ-ууд өөрсдийн явуулж буй хүний эрхийн боловсролын үйл ажиллагааг өөрсдөө үнэлнэ. Дотроосоо болон гаднаас чиглүүлэгч оролцуулах боломжтой. ^{1[1]}	Сургагч багш эсвэл ХЭҮБ нь үнэлгээ хийх идэвхтэй оролцогч Хяналт шинжилгээ явуулах мөн үр дүнд үнэлгээ хийх болон эдгээрийг шийдвэрлэх сэдлийг нэмэх боломжтой Сургалтын доторх үйл явцад байснаараа илүү мэдээлэлтэй байна Бага хэмжээний нөөц ашиглан гүйцэтгэх боломжтой Сургалтын явц дунд хийж гүйцэтгэх боломжтой бөгөөд шаардлагатай өөрчлөлтийг сургалтандаа оруулах боломжтой байдаг Дүгнэх дадал бий болгодог	Үнэлгээ хийж буй хүн дотроос нь хэт ойроос асуудлыг хардаг тул асуудлыг бүхэлд нь тод харахад бэрхшээлтэй байдаг Субъектив байх магадлал өндөр байдаг Гаднын байгууллагууд болон хамтран ажилладаг байгууллагуудын хувьд (санхүүжүүлэгч) хийсэн мониторинг болон үнэлгээнээс гарсан үр дүнгийн үнэ цэнд төдийлөн хүрэхгүй байж болно
Бусдаар үнэлүүлэх	Бусад хүний эрхийн сургагч багш нар (эсвэл байгууллагын түвшинд авч үзвэл өөр ХЭҮБ эсвэл бүс нутгийн зохицуулах байгууллага байж болно)	Тухайн нөхцөл байдлыг ойлгодог хүмүүс хийнэ Хяналт шинжилгээ болон үнэлгээ хийж байх явцад бусад нь сайн туршлагаасаа санал болгож өгөх боломжтой байдаг Үнэлгээ хийж байгаа болон хийлгүүлж байгаа тал аль аль нь шинэ соргог зүйл сурч мэдэх боломжтой	Үнэлгээ хийж буй болон хийлгүүлж буй 2 талын харилцаа нь үнэлгээний үйл явц болон үр дүнд нь нөлөөлөх магадлалтай Гадны байгууллагууд болон хамтран ажилладаг байгууллагуудын хувьд (санхүүжүүлэгч) хийсэн мониторинг болон үнэлгээнээс гарсан үр дүнгийн үнэ цэнд төдийлөн хүрэхгүй байж болно
Гаднаас үнэлгээ хийх	Үйл ажиллагаа явуулж буй хүн болон бүлэг бус гаднаас хийгдэх болно Гаднаас үнэлгээ хийж байгаа тохиолдолд тэд өөрийгөө болон бусдаар үнэлгээ хийлгэж байхад цуглуулсан материал болон өөрсдийн нэмж цуглуулсан материал дээр үндэслэдэг байгаа	Тодорхой хэмжээний объектив байдлыг хангадаг байгаа Шинэ санаа, төлөвлөгөө гарч ирдэг Өөрийгөө үнэлэх болон бусдаар үнэлүүлсэн мэдээллийг нэгтгэдэг Зарим тохиолдолд гадны байгууллагуудын итгэлийг илүү хүлээдэг байдаг, энэ санхүүжүүлэгч байгууллага мөн орно.	Дотоодын хүн шиг мэдээлэлгүй тул мэдээлэл н бодит байдлаас зөрөх магадлалтай Өндөр үнэ өртөгтэй байдаг Тухайн цаг үеийн нэг хэсгийг харуулсан “зураглал” байдаг Агуулгыг нарийн, бодитой ойлгоогүй байж болзошгүй Үйл ажиллагаанд хамрагдаж буй хүмүүсийн оролцоог арай бага хангах магадлалтай

Хавсралт 9:

Тухайн үйл ажиллагаа нь хүний эрхийн боловсролын зарчмуудад хэрхэн нийцэж буйг тодорхойлох үнэлгээний зарим чиглүүлэх асуултууд

Зарчмууд	Үнэлгээний явцад тавих асуултууд [Эдгээр асуултууд явцын үнэлгээ болон дүгнэлт үнэлгээ хийхэд ашиглах боломжтой]
Зарчим 1. Оролцогчдод хамааралтай байх Хүний эрхийн боловсрол нь оролцогчид руу чиглэсэн тэд нарт хэрэгцээтэй байх	1. Үйл ажиллагаа нь оролцогч нарт тулгарч буй асуудал, тэдгээрт шаардлагатай тэргүүлэх чиглэлийн асуудал мөн үү? 2. Сургалт нь оролцогчдын бие мах бодийн ялгаатай байдал, сурах хэлбэр болон цаг хугацааны хязгаарыг харгалзан оруулсан уу? 3. Оролцогчдын үндсэн суурийг харгалзан үзсэн үү?
Зарчим 2. Хамтран ажиллах Хүний эрхийн боловсрол нь түншлэл болон хамтын ажиллагаагаар сайжирч байдаг	1. Оролцогчид болон бусад талууд үйл ажиллагаанд цаашид үргэлжлүүлэн оролцох боломжтой байдаг уу? 2. Оролцогчидийг түнш шиг авч үздэг үү?
Зарчим 3. Оролцоо Хүний эрхийн боловсрол бол оролцогчийг багш гэж үздэг	1. Сургалт нь оролцогчдын туршлагыг гаргуулж бусдад хуваалцаж чадсан уу? 2. Энэ нь оролцогчдын оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэхэд болон хүндлэл төрүүлж байна уу? 3. Оролцогчид нь сурах болон мэдлэгийг хөгжүүлэх үйл явцад идэвхтэй хамрагдаж байна уу? 4. Хүний эрхийн сургагч багшийн хувьд та боловсролын эх үүсвэр байхаас илүүтэй сургалтын туршлага болж үлдэж чадаж байна уу?
Зарчим 4. Судалгаа Хүний эрхийн боловсрол нь мэдлэг туршлагаа гүнзгийрүүлж байдаг	Сургалт нь оролцогчдыг дараах зүйлсийг хийхэд түлхүүр болж өгч чадаж байна уу: 1. Өөрсдийн мэдлэг болон туршлагад шүүмжтэй хандах? 2. Бусдын туршлага, өөр эх сурвалжид байдаа мэдлэгийг өөртэй харьцуулан дүгнэлт гаргах? 3. Шалтгаан, үр нөлөөний талаар судлах 4. Өөрийн туршлагыг дахин нээж харах ба түүний талаарх ойлголтоо дахин нэмэх?
Зарчим 5. Бодлоготой үйл ажиллагаа хийх Нийгмийн өөрчлөлтийг мэдээллээр хангагдсан үйлдлээр хийгддэгийг хүний эрхийн боловсрол хүлээн зөвшөөрдөг	Үйл ажиллагаа нь: 1. Шүүмжтэй бодох үүднээс цаг хугацаа болон үйл явцыг оруулж уу? 2. Шүүмжтэй сэтгэж бодох болон асуудал шийдвэрлэхэд түлхэц болж өгч байна уу? 3. Хүний эрхийн стандартууд болон зарчмуудыг баримтлан хэрэгжүүлэх?
Зарчим 6. Эрх мэдэлжүүлэх Хүний эрхийн боловсрол нь хувьсан өөрчлөгдөж байдаг	1. Оролцогчдыг доорх зүйлээр дэмжих үүднээс ямар нэгэн арга, хэрэгсэл болон үйл явц хэрэглэсэн үү: – Хүний эрхийн талаар ойлголтоотой болсон? – Тэдгээрт тулгарч буй эсвэл тэдгээрийн хариуцлага хүлээсэн хүний эрхийн асуудлуудыг тодорхойлж чадсан уу? – Оролцогчдод тулгарч буй асуудлыг хүний эрхийн нүдээр харуул? – Асуудлуудыг шийдвэрлэх стратеги боловсруулах? 2. Үйл ажиллагаа нь хүний эрхийн зөрчилд хамгийн эмзэг болон өртөмтгий бүлгүүдэд ашигтай байж чадах уу?

Хавсралт 10.

Эрхийг хүндэлсэн сургуулийг хөгжүүлэх ЮНИСЕФ–ийн тогтолцоо

Асуудал 1:	
Удирдлага болон менежмент: Сургуулийн амьдралд Хүүхдийн эрхийн тухай конвенцийн үнэ цэнийг ойлгуулан нэвтрүүлэх	
Сургуулийн заалтууд?	Баталгаажуулалт/нотлох баримт шаардлагатай юу?
- Эрх хүндэлсэн сургууль нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийг сургуулийн үндсэн үнэ цэндээ оруулдаг. - Эрх хүндэлсэн сургууль хөгжүүлэх үйл явц: - Сургуулийн зохицуулалт хийхээр төлөвлөгөө, хөгжил болон үнэлэх явцыг мэдээлэлж байх - Хүүхдийн эрх түгээмэл гэдгийг хүлээн зөвшөөрүүлэх мөн бусдын эрхийг сургуулийн хэмжээнд болон дэлхийн хэмжээнд дэмжихэд бэлтгэх - Сурагчдыг аливаа хэлбэрийн зөрчил, дарамтаас хамгаалах тогтолцоогоор сургуулийг хангах.	Сургуулийн удирдлагын багийн зүгээс Хүүхдийн эрхийн тухай конвенцын үндсэн санааг нь шаардлагатай бүх түвшний баримт бичгүүддээ оруулан мөрдөж байгаа.
	Сургууль нь нээлттэй, ил тод болон эрхэд суурилсан үнэлгээний үйл ажиллагааг явуулдаг ба энэ нь заншил болсон байдаг. Сурагчид нь ч энэ үйл явцад өөрсдийн хувь нэмрийг оруулдаг.
	Багш нар нь тухайн орон нутгийн болон дэлхийн хэмжээний асуудлуудаар, энэ нь хүүхэд, хүний эрхтэй ямар холбоотой байдаг талаар өөрсдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах боломжтой байдаг.
	- Сургуулийн бүхий л түвшний харилцаанд харилцан бие биенээ хүндэтгэх, бусдын эрхийг хүндэтгэх соёлтой байх талаар сурагчид тайлан гаргана. - Сурагчид нь өөрчлөлт хийх эрх хэмжээтэй байх бөгөөд Хүүхдийн эрхийн тухай конвенци дэлхийн хэмжээнд хүүхдүүдийн амьдралд ихээхэн өөрчлөлт оруулах нэгэн чухал хэрэгсэл гэдгийг мэддэг. - Сургуулийн материаллаг орчин нь эрх дээдэлсэн сургуулийн нэгэн илрэл болно.

Асуудал 2:

Багш нар, бусад насанд хүрэгчид болон сурагчид ХЭТК-ийг мөн сургуулийн ёс зүй болон хөтөлбөртэй хэрхэн холбоотойг мэддэг

Сургуулийн заалтууд?	Баталгаажуулалт/нотлох баримт шаардлагатай юу?
- Сургууль өргөн бүрэлдэхүүнээрээ (эцэг эх болон асрагч нар мөн үүнд орно) ХЭТК болон сургууль яагаад үүнийг хэрэгжүүлж байгаа талаар өргөн хэмжээний ойлголттой байна. - Сургалтын хөтөлбөр нь сурагчдын мэдлэгийг бүрэлдүүлэх, ХЭТК-ийн ойлголтыг нэмэгдүүлэх боломж олгодог ба тухайн хүүхдийн чадвараас хамааран 4 төрлийн байдлаар хүргэдэг байна: - Өдөр тутмын амьдрал дээр бие биенийхээ эрхийг хүндлэх - Дэлийн шударга ёсыг бэхжүүлэх ажил - Ялгаатай байдлыг үнэлэх - Хүрээлэн буй орчны тогтвортой байдал	1. Эцэг эх болон сургуулийн хамт олон 42 дугаар зүйлийн мэддэг байх – ХЭТК-ийн талаар мэдлэгтэй, ойлголттой байх – мөн энэ нь тухайн сургууль, улс орон болон дэлхийн хэмжээнд ач холбогдолтой байдаг.
	2. ХЭТК-ийн талаар сурагчдын мэдлэг ойлголтыг нэмэх зорилгоор хичээлээс гадуур болон хөтөлбөрт хичээлүүдийг нэгтгэх боломжийг нэмэгдүүлэх.
	3. Орон нутгийн түвшин болон дэлхийн хэмжээнд хүүхдийн эрхийг хүндэтгэх, хөхиүлэн дэмжихэд сурагчид оролцох.
	4. ХЭТК-ийн талаар түүний агуулгыг сурагч бүр мэддэг байх бөгөөд конвенц нь тэдгээрт, сургуульд болон дэлхийн хэмжээнд ямар ач холбогдолтой, хамааралтайг ойлгодог.
	5. Сурагчид нь эрхийн зарчмууд болон тэдгээрийн холбоог сургалтын хөтөлбөрт, хичээлд болон салбарт зааж өгч болдог
	6. 29 дүгээр зүйлийн заалтууд сургуулийн хичээлийн хөтөлбөр, хөгжлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичиг болон алсын хараандаа оруулсан байх.

Асуудал 3:

Эрхийг дээдэлсэн ангид хичээл заах, хичээл сурах

Сургуулийн заалтууд?	Баталгаажуулалт/нотлох баримт шаардлагатай юу?
Анги доторх үйл ажиллагаанд дараах зүйлүүд ХЭТК-ийн үнэ цэнийг агуулсан байна: - Хүүхдүүдэд хамааралтай шийдвэрийг тэдгээрийн оролцоог тогтмол хангах - Хүүхдүүд чөлөөтэй бодож, түүнийгээ чөлөөтэй илэрхийлж чаддаг байх - Ангийн уур амьсгал нь олон талт үзэл бодлыг илэрхийлэхийг зөвшөөрөх бөгөөд үзэл бодлоо илэрхийлэхдээ эрхэм чанараа алдахгүй байна - Бүгдэнтэй нь шударга, эрх тэгш харьцах - Өөрийн анги, нийгмийн бүлэг болон нийгэмдээ идэвхтэй хувь нэмэр оруулах талаар хүүхдүүдэд зааж өгөх	1. Нийт багшлах бүрэлдэхүүн нь эрхүүдийг загвар болгон харуулах, эрхийг дээдлэх ангийн чухал ач холбогдолтойг хүлээн зөвшөөрөн хэрэгжүүлэх.
	2. Нийт багшлах бүрэлдэхүүн нь өргөн хүрээний заар, сургах арга аргачлал хэрэглэх бөгөөд үүндээ оролцоог хангах болон сурагчдын хооронд дахь харилцааг сайжруулах.
	3. Нийт багшлах бүрэлдэхүүн сурагчдад сургалтын хөтөлбөрийн дагуу орж буй хичээлийн сонголт олгох боломжийг хангах. Тэгснээр сургалтын хөтөлбөрт тавигдаж буй шаардлага болон сурагчийн сонирхол давхцах болно.
	4. Сурагчид багш нартаа бодит, үндэслэлтэй санал хүсэлт хүргүүлэх боломжтой байх.
	5. Багш бүр өөрийн хичээлдээ дэлхийн хэмжээний болон шаардлагатай бол хүүхдийн эрхийн асуудлыг оруулна. Энэ нь ажиллах схемд орсон байдаг.
	6. Сурагчид асуудал шийдвэрлэхдээ эрхийг дээдлэх аргачлал ашиглан.

Сэдэв 4: Сургуулийн хэмжээнд сурагчид шийдвэр гаргахад оролцоно	
Сургуулийн заалтууд?	Баталгаажуулалт/нотлох баримт шаардлагатай юу?
1. Сургуулийн хамт олны дунд сурагчдын оролцоог ханган шийдвэр гаргах талаар зохицуулалтууд орсон байх	1. Ардчилсан хэв маягаар сургуулийг удирдан явуулахад сурагчдын оролцоог хангах талаар өөрийн тогтолцоонд болон дүрэм журамдаа оруулсан байдаг \12 болон 13 дугаар зүйл\.
2. Сургууль сурагчдад мэдээллээр ханган, мэдээлэл дээр үндэслэн шийдвэр гаргуулах \13 болон 17 дугаар зүйл\.	2. Сурагчид өргөн хэмжээний үйл ажиллагаанд орон нутгийн, үндэсний болон дэлхийн хэмжээнд оролцох.
3. Сургуулийн хамт олон нь бусдын эрхийг тухайн газар нутагт, улсын болон олон улсын хэмжээнд дэмжих талаар зохицуулалт оруулах.	3. Сурагчид өөрсдийн бодол, зөвлөгөөг сургуулийн удирдлагад тогтмол хүргүүлэх боломжтой байх.
4. Сургуулийн хамт олон нь өөрсдийн хариуцлагаа ойлгож байгаа бол бүгд сурагчдыг сонсох үүрэгтэй.	4. Сурагчид боловсон хүчин шалгаруулан авах үйл явцад оролцох.
	5. Сургуулийн Зөвлөлд сонгогдох \энэ нэгдэл нь сургууль дахь ХЭТК-ийн элчин сайдуудын үүргийг гүйцэтгэнэ\.
	6. Сургуулийн материаллаг орчин нь эрх дээдэлсэн сургуулийн нэгэн илрэл болно.

Хавсралт 11:

Боловсролын “4–А” бүтэц ба олон улсын хүний эрхийн баримт бичгүүд

- Эдийн Засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай Олон Улсын Пакт, 1978 (ЭЗНСЭТОУП)
- Арьс, үндсээр ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 1972 (АҮЯГБХУТК)
- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц, 1985 (ЭЭХБХУТК)
- Хүүхлийн эрхийн тухай Конвенц, 1993 (ХЭТК)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц, 2007 (ХБХЭТК)
- Нутгийн уугуул хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын Тунхаглал, 2006 (НУХЭТНҮБТ)

“4–А” framework International human rights instruments

“4–А” бүтэц	Олон улсын хүний эрхийн баримт бичгүүд
Боломжит байдал	ЭЗНСЭТОУП: 13, 14 дэх зүйл ХЭТК: 28(1a), 28(1b) зүйл ХБХЭТК: 4–р зүйл НУХЭТНҮБТ: 1, 14–р зүйл
Хүртээмж	ЭЗНСЭТОУП: ХЭТК: 23(1); 28(1a), 28(1b) дэх зүйл ЭЭХБХУТК: 10(d) дэх зүйл АҮЯГБХУТК: 5(e), 5(v), 7 дахь зүйл ХБХЭТК: 4–р зүйл НУХЭТНҮБТ: 1, 14 дэх зүйл
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	ЭЗНСЭТОУП: 13(1) дэх зүйл ХЭТК: 23(1), 29(1a), (1c) дэх зүйл АҮЯГБХУТК: 5(e), 5(v), 7 дахь зүйл ХБХЭТК: 4–р зүйл НУХЭТНҮБТ: 1, 14, 15–р зүйл
Тохирох байдал	ЭЗНСЭТОУП: 13(1) дэх зүйл ХЭТК: 23(1), 29(1a) дэх зүйл АҮЯГБХУТК: 5(e), 5(v), 7 дахь зүйл ХБХЭТК: 4–р зүйл НУХЭТНҮБТ: 1, 14, 21, 44–р зүйл

Хавсралт 12:

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ТУНХАГЛАЛ

Нэгдсэн Үндэстний Байгууллага

А/гез/66/137

Ерөнхий Ассемблейн тогтоол

2012 оны 2 дугаар сарын 19

Ерөнхий Ассемблей,

Хүний эрхийн зөвлөл 2011 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 16/1 дугаар тогтоолоор²¹⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалыг баталсан явдлыг *сайшааж*,

1. Тус тогтоолд хавсаргасан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалыг *баталж*,
2. Уг тунхаглалыг түгээх хичээл зүтгэлээ улам эрчимжүүлэх, түгээмэл байдлаар хүндэтгэх, ойлгох явдлыг хөхиүлэх дэмжихийн тулд Нэгдсэн Үндэстний Байгууллагын тогтолцооны засгийн газар, агентлаг, байгууллагууд, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудыг урьж, Хүний эрх Олон улсын гэрээний эмхэтгэлийн дараагийн дугаарт энэхүү Тунхаглалын бичвэрийг оруулахыг Ерөнхий нарийн бичгийн даргаас *хүсч байна*.

89 дүгээр нэгдсэн хурал

2011 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Хавсралт

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ТУНХАГЛАЛ

Ерөнхий Ассемблей,

Арьс үндэс, хүйс, хэл, шашин зэрэг ямарваа нэгэн ялгаваргүйгээр хүний бүх эрх, суурь эрх чөлөөг хүндэтгэхийг хөхиүлэн дэмжих, урамшуулан зоригжуулах Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн зорилго, зарчмуудыг *дахин баталж*,

Хүний эрх, суурь эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжихийн тулд сургалт, боловсролоор дамжуулан хүн бүр, бүхий л нийгмийн байгууллага хичээх хэрэгтэйг *дахин баталж*,

Хүн бүр сурч боловсрох эрхтэй төдийгүй тухайн боловсрол нь хүний хувийн мөн чанар, хүний өөрийн нэр төр буюу эрхэм зэргийн мэдрэмжийг бүрэн дүүрэн хөгжүүлэхэд чиглэсэн байх нь бүх хүн чөлөөт нийгэмдээ идэвхтэй оролцох боломжийг олгож, аливаа үндэстэн, аливаа арьс үндсийн, угсаатны, шашны бүлгүүдийн хоорондын ойлголцол, хүлцэн тэвчихүй, нөхөрлөлийг хөхиүлэн дэмжихийн зэрэгцээ энх тайван, аюулгүй байдлыг тогтоох, хөгжил болон хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын үйл ажиллагааг улам гүнзгийрүүлэхийг *дахин баталж*,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал², Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт³, хүний эрхийн бусад олон улсын гэрээнд заасны нэгэн адил боловсрол нь хүний эрх, суурь эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэхэд чиглэсэн байхыг баталгаажуулах үүргийг Улсууд хүлээсэн болохыг *дахин баталж*,

²¹⁰ Ерөнхий Ассемблейн албан ёсны тэмдэглэл, 66 дугаар чуулган, 53 дугаар нэмэлт, (А/66/53), I бүлгийг үзнэ үү.

Хүний эрхийн боловсрол, сургалтын тулгуур ач холбогдол нь хүний бүхий л эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, идэвхтэйгээр биелүүлэх болохыг *хүлээн зөвшөөрч*,

Нийтлэг ойлголттой болох, хүний эрхийг түгээмэл байдлаар хэрэгжүүлэхээ бэхжүүлэхийн тулд харах өнцгөө өөрчлөх зорилгоор Вена хотноо 1993 онд болсон Хүний эрхийн талаарх дэлхийн хэмжээний хурлаас бүх сургалтын байгууллагын хичээлийн хөтөлбөрт хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүй, ардчилал, эрх зүйт ёсны тухай оруулах, мөн олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн олон улсын гэрээнд заасны дагуу хүний эрхийн боловсролд энх тайван, ардчилал, хөгжил, нийгмийн шударга ёсны талаар багтаахыг аливаа Улсууд болон байгууллагуудад зориулсан уриаг *дахин баталж*⁴

Төрийн болон Засгийн газрын тэргүүнүүд бүхий л түвшинд хүний эрхий боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжсэн төдийгүй Хүний эрхийн боловсролын Дэлхийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, үүнтэй холбогдуулан аливаа Улсууд санаачлага өрнүүлэхийг урам зоригжуулсан Дэлхийн дээд хэмжээний 2005 оны чуулга уулзалтын үр дүнг *дахин баталж*⁵,

Бүх сонирхогч талуудын хамтын санаачлагаар дамжуулан хүний эрхийн боловсрол, сургалтын аливаа хичээл зүтгэлийг бэхжүүлэхийн тулд олон улсын хамтын нийгэмлэгт хүчтэй дохио өгөх хүслээр *өдөөгдөж*, дараахь зүйлсийг *тунхаглаж байна*. Үүнд:

1 дүгээр зүйл

1. Хүн бүр хүний эрх, суурь эрх чөлөөний тухай мэдээлэл мэдэх, хайх, хүлээн авах эрхтэй бөгөөд хүний эрхийн боловсрол, сургалтад хамрагдана. ^{211 212 213 214}
2. Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүний эрхийн түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай байх зарчимд заасны дагуу хүний бүх эрх, аливаа хүний суурь эрх чөлөөг түгээмэл байдлаар хүндэтгэх, мөрдөх явдлыг хөхиүлэн дэмжихэд амин чухал болно.
3. Хүний бүх эрхийг үр нөлөөтэй эдлүүлэх, ялангуяа сурч боловсрох, мэдээлэл авах эрхийг эдлэх нь хүний эрхийн боловсрол, сургалтад хамрагдах боломжийг олгоно.

2 дугаар зүйл

1. Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүний бүхий л эрх, суурь эрх чөлөөг түгээмэл байдлаар хүндэтгэх, мөрдөхөд чиглэсэн төдийгүй хүмүүсийн мэдлэг, ур чадвар, ойлголтоор дамжуулан, өөрийн гэсэн хандлага, зан үйлээр хүний эрхийн зөрчил, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгох, хөхиүлэн дэмжихэд хувь нэмэр оруулах хүртэл тэднийг эрх мэдэлжүүлэх боловсролын, сургалтын, мэдээллийн, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, сурах бүх үйл ажиллагаанаас бүрдэнэ.
2. Хүний эрхийн боловсрол, сургалт нь:
 - а. хүний эрхийн хэм хэмжээ, зарчим, тодорхойлох үнэт зүйлс, хамгаалах механизмийн талаарх мэдлэг, ойлголтыг багтаасан хүний эрхийн тухай боловсрол;
 - б. сургагч, суралцагч нарын эрхийг нэгэн зэрэг хүндэтгэх замаар сургаж, заадаг онцлогтой хүний эрхээр дамжуулсан боловсрол;
 - в. өөрийн эрхийг эдлэх, хэрэгжүүлэхийн хамт бусдын эрхийг хүндэтгэх, хамгаалахад хүмүүсийг эрх мэдэлжүүлсэн хүний эрхэд чиглэсэн боловсролоос бүрдэнэ.

²¹¹ Тогтоол 217 А (III).

²¹² Тогтоол 2200 А (XXI), хавсралт.

²¹³ А/СО⁴Р.157/24 (I хэсэг), III бүлэг, хэсэг, 79, 80 дахь догол мөр.

²¹⁴ Тогтоол 60/1, 131 дугаар догол мөр.

3 дугаар зүйл

1. Хүний эрхийн боловсрол, сургалт нь бүх насныханд хамаарах насан туршийн үйл явц юм.
2. Хүний эрхийн боловсрол, сургалт нь сургуулийн өмнөх, бага, дунд болон академик эрх чөлөөг эдэлж болохуйц дээд боловсролын зэрэг нийгмийн бүх хэсэгт, аливаа түвшинд чиглэж, төрийн болон хувийн хэвшлээс үл хамааран, албан болон албан бус, сайн дурын шинжтэй боловсролын бүх хэлбэрийг хамарна. Мөн мэргэжлийн сургалт, ялангуяа сургагч, багш, төрийн албан хаагчдын сургалт, насанд хүрэгчдийн боловсрол, нийтийн боловсрол, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаанууд багтана.²¹⁵

4 дүгээр зүйл

Хүний эрхийн боловсрол, сургалт нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон холбогдох гэрээ, олон улсын баримт бичгийн зарчмуудад тулгуурлахдаа:

- a. хүний эрхийн түгээмэл шинжтэй стандартууд, зарчмуудын зэрэгцээ хүний эрх, суурь эрх чөлөөг хамгаалах олон улсын, бүс нутгийн, үндэсний баталгаануудын талаар мэдэх, ойлгох хүлээн зөвшөөрөх явдлыг нэмэгдүүлэх;
- b. хүн бүр өөрийн эрхийн талаар мэдэхийн хамт бусдын эрхийг хүндэтгэх өөрийн хариуцлагыг ойлгох хүний эрхийн түгээмэл соёлыг боловсруулж, мөн чөлөөт, амар амгалан, олон ургальч, татан оролцуулсан нийгмийн хариуцлагатай гишүүний тухайд хувь хүний хөгжих явдлыг хөхиүлэн дэмжих;
- c. хүний бүх эрхийг үр нөлөөтэй биелүүлэхээр зорин, хүлцэн тэвчихүй, үл ялгаварлал, тэгш эрхийг хөхиүлэн дэмжих;
- d. ямар нэгэн ялгаварлан гадуурхалтгүйгээр чанартай хүний эрхийн боловсрол, сургалтад хамрагдах боломжийг хүн бүрт баталгаажуулах;
- e. хүний эрхийн зөрчил, зүй бус үйлдлээс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулах, ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэр, арьс үндсээр ялгаварлах үзэл, хэвшмэл тулгасан хэв загвар, үзэн ядалт, хор хөнөөлт хандлага, ухвар мөчид явдалтай тэмцэх, арилгахад анхаарна.

5 дугаар зүйл

1. Хүний эрхийн боловсрол, сургалт нь төрийн эсвэл хувийн хэвшлийн төлөөлөгчдөөс үл хамааран тэгш эрх, ялангуяа охид болон хөвгүүд, эмэгтэйчүүд болон эрчүүдийн тэгш эрх, хүний нэр төр буюу эрхэм зэрэг, татан оролцуулах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмуудад тулгуурлана.
2. Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүн бүрт хүртээмжтэй, боломжтой байхаас гадна эмзэг, хүнд нөхцөл байгаа хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зэрэг бүлэг этгээдийн хэрэгцээ, хүлээлт, ялангуяа тэдэнд тулгарч байгаа бэрхшээл, саадыг анхаарах бөгөөд эрх мэдэлжих, хүний хөгжлийг хөхиүлэн дэмжих, нийгмээс гадуурхах, эрх мэдэлгүй болоход хүргэж байгаа шалтгааныг арилгах, хүн бүрийн бүхий л эрхийг эрхээ эдлэх боломж олгох зорилготой.²¹⁶
 1. Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүн бүрийн бүх эрхийг хангах нийтлэг зорилгыг өөрийн болгох явдлыг зоригжуулахын тулд орон нутгийн санаачлагыг хөхиүлэн дэмжихийн зэрэгцээ харилцан адилгүй эдийн засаг, нийгэм, соёлын нөхцөл байдалд анхаарна.

²¹⁵ Хүний эрхийн боловсрол, сургалт нь зорилтот бүлэгт тохирсон хэл, арга зүйг ашиглах бөгөөд тэдний тусгай хэрэгцээ, нөхцлийг тооцно.

²¹⁶ Хүний эрхийн боловсрол, сургалт нь соёл иргэншлүүд, шашин соёлууд, харилцан адилгүй улс орнуудын уламжлалыг угтан авч, улам баяжуулахын зэрэгцээ сэдэл санаа төрдгийг хүний эрхийн түгээмэл байдалд тусгалаа олсон болно.

6 дугаар зүйл

1. Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүний бүх эрх, суурь эрх чөлөөг хөхиүлэн дэмжихийн тулд мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологиудыг мэдээллийн хэрэгслийн адил онцлон, ашиглана.
2. Урлагийн төрлүүдийг хүний эрхийн салбарын сургалт болон мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэрэгслээр ашиглахыг дэмжинэ.

7 дугаар зүйл

1. Улсууд болон зохих холбогдох төрийн эрх мэдлийн байгууллага нь оролцоо, татан оролцуулах, хариуцлагын мөн чанарыг шингээн боловсруулж, хэрэгжүүлсэн хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үндсэн үүрэг хүлээнэ.
2. Улсууд нь хүн бүрийн хүний эрх, суурь эрх чөлөө, хүний эрхийн боловсрол, сургалтын чиглэлээр ажиллах иргэний нийгэм, хувийн хэвшил, холбогдох бусад сонирхогч талууд, мөн үйл явцад хамрагдсан этгээдүүдийг бүрэн хамгаалсан ажиллах аюулгүй, боломж олгосон орчинг бий болгоно.
3. Улсууд нь дангаар болон олон улсын тусламж, хамтын ажиллагааг дамжуулан өөрийн боломжит эх сурвалжийг бүрэн ашиглах замаар хуулийн болон захиргааны арга хэмжээ авах, бодлого батлах зэрэг зохистой арга хэрэгслийн дагуу хүний эрхийн боловсрол, сургалтыг ахиц дэвшилттэй байдлаар хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах алхамуудыг хийнэ.^{217 218} боловсролын Дэлхийн хөтөлбөр, үндэсний болон орон нутгийн тусгай хэрэгцээ, тэргүүлэх чиглэлийг анхаарна.
 1. Дээрх стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө, бодлого, хөтөлбөрүүдийн үзэл баримтлал, хэрэгжилт, үнэлгээ нь хувийн хэвшил, иргэний нийгэм, хүний эрхийн үндэсний байгууллага зэрэг холбогдох бүхий л сонирхогч талуудыг оролцуулахын хамт олон талт сонирхогч этгээдийн санаачлагыг боломжтой бол хөхиүлэн дэмжинэ.

8 дугаар зүйл

1. Улсууд нь зохих түвшинд стратеги, бодлогыг хөгжүүлэх, тохиромжтой бол хүний эрхийн боловсрол, сургалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг сургуулийн болон сургалтын хичээлийн хөтөлбөрт нийлүүлэх замаар боловсруулах буюу хөхиүлэн дэмжинэ. Үүнийг хийхдээ Хүний эрхийн

9 дүгээр зүйл

Шаардлага гарах үед мэдлэг ойлголт нэмэгдүүлж, холбогдох нийтийн болон хувийн этгээдүүдийг хөдөлгөн, хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжиж зохицуулах зэрэг чухал үүрэг гүйцэтгэдгийг нь харгалзан үзэж төр хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын талаарх Зарчимд (Парисын Зарчим) нийцүүлэн үр нөлөөтэй, хараат бус хүний эрхийн үндэсний байгууллага байгуулах, хөгжүүлэх, бэхжүүлэх алхамыг хөхиүлэн дэмжих үүрэгтэй.

10 дугаар зүйл

1. Боловсролын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, гэр бүлүүд, орон нутгийн хүмүүсийн нэгдэл, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хүний эрхийн хамгаалагчид, хувийн хэвшил зэрэг

²¹⁷ Улсууд болон зохих холбогдох төрийн эрх мэдлийн байгууллага нь төрийн албан хаагчид, шүүгч, хууль хяналтын байгууллагын албан хаагчид, цэргийн бие бүрэлдэхүүнд олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, олон улсын эрүүгийн эрх зүйг зохистой байдлаар оруулсан хүний эрхийн тохирох сургалтыг баталгаажуулах ба багш, дасгалжуулагч, бусад сурган хүмүүжүүлэгчид болон төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах хувийн бие бүрэлдэхүүнд зориулсан хүний эрхийн тохирох сургалтыг хөхиүлэн дэмжинэ.

²¹⁸

нийгэм дэх төрөл бүрийн этгээд нь хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжих, хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

2. Иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, холбогдох бусад сонирхогч талууд нь өөрийн албан хаагч, бие бүрэлдэхүүнд зориулсан тохирох хүний эрхийн боловсрол, сургалтыг баталгаажуулах явдлыг дэмжинэ.

11 дүгээр зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын болон бүс нутгийн байгууллагууд нь өөрийн энгийн албан хаагчдад болон тэдний бүрэн эрхийн хүрээнд ажиллаж байгаа цэргийн болон цагдаагийн бие бүрэлдэхүүнийг хүний эрхийн боловсрол, сургалтаар хангана.

12 дугаар зүйл

1. Бүх түвшин дэх олон улсын хамтын ажиллагаа нь боломжтой бол орон нутгийн түвшин хүний эрхийн боловсрол, сургалтыг хэрэгжүүлэх зэрэг үндэсний хичээл зүтгэлийг дэмжиж, тусална.
2. Олон улсын, бүс нутгийн, үндэсний, орон нутгийн түвшин дэх бүх талын, удирдан чиглүүлсэн хичээл зүтгэл нь хүний эрхийн боловсрол, сургалтыг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулж болно.
3. Хүний эрхийн боловсрол, сургалтын чиглэлээрх төсөл, санаачлагад зориулсан сайн дурын санхүүжилтийг дэмжинэ.

13 дугаар зүйл

1. Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизм нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд өөрийн үйл ажиллагаанд хүний эрхийн боловсрол, сургалтыг анхаарна.²¹⁹

14 дүгээр зүйл

Улсууд нь энэхүү Тунхаглалыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, мөрдөх явдлыг баталгаажуулахаар зохистой арга хэмжээ авах ба үүний тулд шаардлагатай эх сурвалжийг бүрдүүлнэ.

²¹⁹ Улсууд нь холбогдох хүний эрхийн механизмд илгээх өөрийн илтгэлдээ боломжтой бол хүний эрхийн боловсрол, сургалтын талаар авсан арга хэмжээний тухай мэдээллээ оруулахыг дэмжинэ.



ASIA PACIFIC FORUM
ADVANCING HUMAN RIGHTS IN OUR REGION

Ази Номхон Далайн бүс нутгийн Хүний эрхийн Үндэсний Байгууллагуудын Чуулган

Шуудангийн хайрцаг 5218
Сидней Эн Эс Дабью 1042
Австрали

E: apf@asiapacificforum.net
W: www.asiapacificforum.net

ХУДАЛДАН БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.
УЛААНБААТАР ХОТ. 2015 ОН

ISBN 999623361-6



9 789996 233616